

Монгол улс

Монгол Улсын
бизнесийн орчны суурь судалгаа
эцсийн тайлан

2018 оны 11 сар

Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага
(ЖАЙКА)

Экси Идеа ХХК
Алмек Корпораци
Эй Ай Нетворк ХХК

3R
JR
18-010

Гарчиг

Зургийн жагсаалт	iii
Товчилсон үгийн тайлбар	v
1 Судалгааны агуулга	1-1
1.1 Судалгааны үндэслэл	1-1
1.2 Судалгааны зорилго, үр дүн	1-2
1.3 Судалгааны хэрэгжилтийн хугацаа, агуулга	1-3
2 Монгол улсын бизнесийн орчны өнөөгийн байдал.....	2-1
2.1 Бизнесийн орчны хууль эрх зүй.....	2-1
2.2 Холбогдох бодлого, тогтолцоо, төлөвлөлт	2-16
2.3 Холбогдох байгууллагын бүтэц үйл ажиллагаа.....	2-22
2.4 Монголын аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл болон ижил төстэй судалгаа.....	2-24
3 Зээлийн мэдээллийн хяналтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал.....	3-29
3.1 Монгол улсын санхүүгийн тогтолцооны өнөөгийн байдал.....	3-29
3.2 Банкны зээлийн мэдээллийн хяналт өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал.....	3-56
3.3 Банк бус санхүүгийн байгууллага дахь зээлийн мэдээллийн хяналтын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал.....	3-74
3.4 Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хөгжлийн түүх, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал.....	3-79
3.5 ЗМС-аас бусад зээлийн мэдээлэл агуулсан мэдээллийн сан	3-84
3.6 ЗЭМС нэвтрүүлэх боломж.....	3-88
3.7 ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлснээр гарах үр нөлөө	3-107
3.8 ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал, чиглэл.....	3-111
3.9 Зээлийн эрсдлийн мэдээллийн санг нэвтрүүлэхэд чиглэсэн ерөнхий зураглал.....	3-113
3.10 ЗЭМС нэвтрүүлэх боломжийн талаарх судалгаа.....	3-121
4 Компанийн засаглалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал	4-122
4.1 Монгол улсын компанийн засаглал	4-122
4.2 Компанийн засаглалын өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудал	4-123
4.3 ЖДҮ, бичил бизнесийн компанийн засаглалын бодит байдал, асуудал (асуулга судалгаа)	4-135
4.4 Компанийн засаглалын өөрийн үнэлгээ	4-145
4.5 ЖДҮ болон бичил аж ахуйн нэгжид “компанийн засаглал”-ыг нэвтрүүлж, сайжруулах ба түүний чиг хандлага	4-170
5 Нэгдсэн дүгнэлт: Монгол улсын бизнесийн орчныг сайжруулах арга хэмжээ, зөвлөмж	5-179

5.1	Зээлийн мэдээллийн хяналтын цаашдын чиг хандлага	5-179
5.2	Компанийн засаглалын салбарын цаашдын чиглэл	5-183

Зургийн жагсаалт

Зураг 3.1	Монголбанкны бүтэц зохион байгуулалтын зураг	3-30
Зураг 3.2	Сангийн яамны бүтэц зохион байгуулалт	3-37
Зураг 3.3	Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц.....	3-43
Зураг 3.4	ЗБДС-ийн зээлийн эцсийн үлдэгдэл өөрчлөлт.....	3-51
Зураг 3.5	Инфляцийн түвшин, бодлогын хүүгийн өөрчлөлт	3-57
Зураг 3.6	Зээлийн мэдээллийн сангийн загвар (аж ахуй нэгж).....	3-82
Зураг 4.1	Монголын компанийн засаглалын үнэлгээ.....	4-122
Зураг 4.2	Компанийн засаглалын холбогдох дүрэм, журамтай аж ахуйн нэгж.....	4-137
Зураг 4.3	Банкнаас зээл авахад тулгарсан дарамт.....	4-139
Зураг 4.4	Компанийн засаглалын журам, дүрэмтэй компаниуд (хэмжээ тус бүрээр).....	4-140

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1	Судалгааны багийн бүрэлдэхүүн	1-6
Хүснэгт 2.1	Бизнесийн орчны холбогдох хуулиуд	2-1
Хүснэгт 2.2	ЖДҮ-ийн бизнесийн орчны холбогдох хуулиудаас	2-6
Хүснэгт 2.3	Зээлийн мэдээлэлтэй холбогдох хуулиуд	2-7
Хүснэгт 2.4	Компанийн засаглалын холбогдох хуулиуд.....	2-13
Хүснэгт 2.5	ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт .	2-18
Хүснэгт 2.6	Аж ахуйн нэгжийн тоо (салбараар)	2-24
Хүснэгт 2.7	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, салбараар	2-25
Хүснэгт 2.8	Хөдөлмөр эрхлэгчдийн тоо, салбараар	2-26
Хүснэгт 3.1	Санхүүгийн байгууллагуудын зээлийн эцсийн үлдэгдэл болон зээлдэгч	3-48
Хүснэгт 3.2	Банк санхүүгийн байгууллагын чанаргүй зээлийн дүн зээлдэгчийн тоо	3-48
Хүснэгт 3.3	Байгууллагын зээлийн зээлийн эцсийн үлдэгдэл, зээлдэгчийн тоо	3-49
Хүснэгт 3.4	Байгууллагын чанаргүй зээлийн зээлдэгчийн тоо	3-50
Хүснэгт 3.5	Иргэн/ ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдэл, зээлдэгчийн тоо.....	3-50
Хүснэгт 3.6	Иргэн/ ЖДҮ-ийн чанаргүй зээлийн дүн	3-50
Хүснэгт 3.7	МБ-ны Активын хугацааны үзүүлэлтээр дүгнэж ангилах.....	3-67
Хүснэгт 3.8	Арилжааны банкны зээлийн хүсэлт гаргах, зээлийн мэдээллийн хяналтын талаарах харицуулалт	3-70
Хүснэгт 3.9	Хувийн хэвшилд олгосон зээлийн эцсийн үлдэгдэл	3-89
Хүснэгт 3.10	Иргэн / ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдэл	3-89

Хүснэгт 3.11	Хамтарсан ажлын хэсгийн уулзалтын тойм	3-95
Хүснэгт 3.12	ЗЭМС-ийн системийг нэвтрүүлэхтэй холбоотой голлох харилцагчид.....	3-103
Хүснэгт 3.13	ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал ба авах арга хэмжээний чиглэл.....	3-112
Хүснэгт 4.1	Компанийн засаглалын агуулга.....	4-123
Хүснэгт 4.2	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат.....	4-125
Хүснэгт 4.3	Засаглалын үнэлгээний түвшин	4-128
Хүснэгт 4.4	Компанийн засаглалын сургалтын байгууллагууд	4-129
Хүснэгт 4.5	Компанийн засаглалын үнэлгээ.....	4-132
Хүснэгт 4.6	Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хяналт	4-142
Хүснэгт 4.7	Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийн ил тод байдал.....	4-143
Хүснэгт 4.8	G20/ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчимын агуулга.	4-147
Хүснэгт 4.9	Компанийн засаглалын кодексийн агуулга	4-150
Хүснэгт 4.10	Гэр бүлийн компаний засаглалын дүн шинжилгээ	4-152
Хүснэгт 4.11	“Сайн засаглалын тэмцээний” өөрийн тайлангийн хуудасны агуулга.	4-157
Хүснэгт 4.12	Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн Компани өөрөө өөрийгөө үнэлэх маягтын агуулга.....	4-159
Хүснэгт 4.13	Судалгааны хүрээнд боловсруулсан өөрийн үнэлгээний асуулгын агуулга.....	4-162
Хүснэгт 4.14	Компанийн Засаглалын воркшопын хөтөлбөр.....	4-166
Хүснэгт 4.15	ЖДҮ-ийн санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний жишээ.....	4-172
Хүснэгт 4.16	Зөрчлийн тухай хуульд заагдсан торгууль шийтгэл.....	4-173
Хүснэгт 4.17	Хүснэгт4.4-т зааснаас бусад “Компанийн Засаглал”-тай хамаарал.....	4-178

Товчилсон үгийн тайлбар

ADB	АХБ	Азийн хөгжлийн банк (Asian Development Bank)
AML		Мөнгө угаахтай тэмцэх (Anti Money Laundering)
AQR		Хөрөнгийн чанарын хяналт (Asset Quality Review)
ARDP	ХАХТ	Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төсөл (Agricultural and Rural Development Project)
ASB		Жижиг бизнесийн зөвлөгөө (Advice for Small Business)
BOM	МБ	Монголбанк (Bank of Mongolia)
BAS		Бизнесийн зөвлөх үйлчилгээ (Business Advisory Service)
CG		Компанийн засаглал (Corporate Governance)
CGDC	КЗХТ	Компанийн засаглалын хөгжлийн төв (Corporate Governance Development Center)
CGFM	ЗБДС	Зээлийн батлан даалтын сан (Credit Guarantee Fund of Mongolia)
CIB	ЗМТ	Зээлийн мэдээллийн төв (Credit Information Bureau)
CIDB	ЗМС	Зээлийн мэдээллийн сан (Credit Information Data Base)
CLO	ЗБХЭ	Зээлийн барьцаа хөрөнгийн эрх (Collateralized Loan Obligation)
CRD	ЗЭМС	Зээлийн эрсдэлийн мэдээллийн сан (Credit Risk Database)
CSR	КНХ	Компанийн нийгмийн хариуцлага (Corporate Social Responsibility)
DBM	МУХБ	Монгол улсын Хөгжлийн Банк (Development Bank of Mongolia)
DICOM	ХДК	Хадгаламжийн даатгалын Корпораци (Deposit Insurance Corporation Of Mongolia)
EBRD	ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (European Bank for Reconstruction and Development)
EFF	ӨСХ	Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (Extended Fund Facility)
ESG	БОНЗ	Байгаль орчин нийгмийн засаглал (Environment Society Governance)
FRC	СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо (Financial Regulatory Commission of Mongolia)
GAIPSR	УБООЕГ	Улсын бүртгэл, оюуны өмчийн ерөнхий газар (General Authority for Intellectual Property and State Registration)
GDP	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн (Gross Domestic Products)
GIZ	ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (The Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit)
IFC	ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци (International Finance Corporation)
IMF	ОУВС	Олон Улсын Валютын Сан (International Monetary Fund)
IFRS	СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (International Financial Reporting Standards)
JICA	ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Japan International Cooperation Agency)
LTV		Зээлийн өрийн хэмжээ (Loan to Value)
MASD	МУЦАЭХ	Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (Mongolian Association of Securities Dealers)
MBA	МБХ	Монголын Банкны Холбоо (Mongolian Bankers Association)
MECS	БСШУСЯ	Боловсрол, Соёл Шинжлэх Ухаан, Спортын яам (Ministry of Education, Culture and Science)
MEF	МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (Mongolian Employers Association)

MNT		Төгрөг (Mongol Tugrug)
MNCCI	МУХАУТ	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (Mongolian National Chamber of Commerce and Industry)
MOF	СЯ	Сангийн яам (Ministry of Finance)
MOFALI	ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (Ministry of Food, Agriculture and Light industry)
MONICPA	ММНБИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт (Mongolian Institute of Certified Public Accountants)
MOU		Харилцан ойлголцлын санамж бичиг (Memorandum of Understanding)
MP	ЕТ	Ерөнхий төлөвлөгөө (Master Plan)
MSE	МХБ	Монголын хөрөнгийн бирж (Mongolian Stock Exchange)
MSME	БЖДААН	Бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжийн (Micro, Small, Medium Enterprise)
NBFI	ББСБХ	Банк бус санхүүгийн байгууллагын холбоо (Nonbanking Financial Institution)
NCCG	КЗҮЗ	Компанийн засаглалын үндэсний зөвлөл (National Council on Corporate Governance)
NDA	ҮХГ	Үндэсний Хөгжлийн Газар (National Development Agency)
OT	ОТ	Оюу Толгой ХХК (Oyu Tolgoi LLC)
PD		Дефолтын магадлал (Probability of Default)
PPP	ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл (Public-Private Partnership)
PSDC	ХХХЗ	Хувийн хэвшлийн хөгжлийн зээл (Private Sector Development Credit)
SCC	ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо (Savings and credit cooperative)
SDR	ЗТЭ	Зээлжих тусгай эрх (Special Drawing Rights)
SME	ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл (Small and Medium Enterprises)
TAM		Өөрчлөлтийн менежмент (Turn Around Management)
TDB	ХХБ	Худалдаа хөгжлийн банк (Trade and Development Bank of Mongolia)
TSL		Хоёр үе шаттай зээл (Two Step Loan)
UB	УБ	Улаанбаатар (Ulaanbaatar)
USAID	АНУ-ын ОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (United States Agency for International Development)
WB	ДБ	Дэлхийн Банк (World Bank)

1 Судалгааны агуулга

1.1 Судалгааны үндэслэл

Монгол Улс уул уурхайн хөгжлийн нөлөөгөөр 2006-2013 онд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ ойролцоогоор 4 дахин өссөн бөгөөд бодит ДНБ-ний өсөлт 2011 онд 17.3% гэх эдийн засгийн өсөлтийг бий болгосон. Гэвч сүүлийн жилүүдийн дэлхийн зах зээл дэхь ашигт малтмалын үнийн уналт болон баялгийн үндсэрхэг үзлийн хөдөлгөөн эрчимжсэнээр гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах хууль тогтоомж гаргах зэргээр улс төрийн эрсдэл нэмэгдсэн. Түүнчлэн экспортын 80%-ийг эзэлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширсны улмаас Монгол улсын эдийн засгийн өсөлт мөн адил огцом удааширсан байна. 2017 оны 5-р сард Олон Улсын Валютын Сан (ОУВС) төсөв болон эдийн засгийн хямралд орсон Монгол улсад 3 жилийн хугацаатай 430 сая ам. долларын өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг (EFF) хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ба Монгол улсын Засгийн газар ОУВС тэргүүтэй олон улсын дэмжлэгтэйгээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахаар хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Богино хугацаанд эдийн засгийг сэргээхийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд уул уурхайн салбараас хараат үйлдвэрлэлийн бүтцийн шинэчлэл, өсөлт уналт давтагдах мөчлөгийг даван туулахын тулд эдийн засгийн тогтвортой бөгөөд жигд өсөлтийг бий болгохоор аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлагатай бөгөөд бизнесийн орчныг сайжруулах асуудал нь томоохон сорилт болж байна. Тухайлбал, Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 64.301 аж ахуй нэгжийн 97% буюу 61.909 нь 50-аас доош ажилтантай ЖДҮ (2015 оны байдлаар) байдаг тул Монгол улсын хувьд аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд ЖДҮ-ийн үүрэг ихээхэн чухал гэж хэлж болно.

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) нь “Монгол улсын хөрөнгө оруулалтын орчныг дэмжих суурь судалгаа”-г 2015 оны 11-р сараас 2017 оны 3-р сар хүртэл хэрэгжүүлсэн ба судалгааны дүнд, 1) аж ахуй нэгжийн зээлийн мэдээлэл (тэр дундаа бизнес эрхлэгч, хувьцаа эзэмшигч, бизнесийн цар хүрээ, санхүүгийн мэдээлэл) цуглуулахад хүндрэлтэй, үүнээс шалтгаалан ЖДҮ-ийн хөрөнгийн эх үүсвэр хязгаарлагдмал, 2) компанийн засаглал хангалтгүйгээс мэдээллийн тайлагнал, ил тод байдал, ТУЗ-ийн үүрэг хариуцлага зэрэг компанийн үндсэн засаглал хэрэгжихгүй байгаа нь шийдвэрлэх асуудал болж байна гэж үзсэн. Түүнчлэн Японы аж ахуй нэгжийн зүгээс харахад Монголын аж ахуй нэгж байгууллагын зээлийн мэдээлэл, бизнесийн соёлын ялгаа нь хамтран ажиллахад саад болдог гэж үзсэн байна.

Аж ахуй нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлж, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгохын тулд бизнесийн орчныг сайжруулах шаардлагатай.

Энэхүү судалгаагаар өмнөх судалгааны дүнд тодорхойлогдсон асуудлыг шийдвэрлэхээр бичил, ЖДҮ, хувиараа бизнес эрхлэгчдэд гол анхаарлаа хандуулан аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны бодит байдлыг гүнзгийрүүлэн судалснаар Монголын аж ахуй нэгж байгууллагын “зээлийн мэдээллийн хяналт” болон “компанийн засаглал”-ын талаар илүү анхааран мэдээлэл цуглуулан шинжилж, аж үйлдвэрийг төрөлжүүлэн эрчимжүүлэхэд чиглэсэн бизнесийн орчныг сайжруулах оновчтой арга хэмжээг санал болгох зорилготой.

1.2 Судалгааны зорилго, үр дүн

(1) Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар ЖДҮ, бичил аж ахуйн нэгж (хувиараа бизнес эрхлэгчид)-ийн “Зээлийн мэдээллийн хяналт”, болон “Компанийн засаглал”-ийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн, аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг санал болгох зорилготой юм.

(2) Судалгааны хамрах газар

Монгол улсын нийт нутаг дэвсгэр (судалгааны төв Улаанбаатар хот)

(3) Холбогдох байгууллагууд (холбогдох мэргэжилтэн)

Энэхүү судалгаагаар хамтран ажиллагч байгууллагыг тусгайлан тодорхойлоогүй хэдий ч дараах төрийн болон олон нийтийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан болно.

- Сангийн Яам (СЯ)
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)
- Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ)
- Монголбанк (МБ)
- Зээлийн мэдээллийн сан (ЗМС: Монголбанкны зээлийн мэдээллийн сан)
- Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)

- Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)
- Монголын Банкны Холбоо (МБХ)
- Компанийн засаглалын хөгжлийн төв (КЗХТ)
- Компанийн засаглалын үндэсний зөвлөл (КЗҮЗ)
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) зэрэг

Дээр дурдсан байгууллагуудаас гадна арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага зэрэг банк санхүүгийн салбарын байгууллагууд, Монголд үйл ажиллагаа явуулж буй Япон компаниудтай уулзалт ярилцлага хийх замаар мэдээлэл цуглуулсан. Түүнчлэн компанийн засаглалын семинар зохион байгуулж олон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон.

1.3 Судалгааны хэрэгжилтийн хугацаа, агуулга

(1) Судалгааны хэрэгжилтийн хугацаа

2018 оны 2 сараас 11 сар (Монгол дахь судалгаа 2-6 сар)

(2) Судалгааны хэрэгжилтийн агуулга

Энэхүү судалгаагаар Монголын 1) бизнесийн орчны нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийснээр 2) зээлийн мэдээллийн хяналт болон 3) компанийн засаглал гэсэн 2 төрлийн судалгааг хэрэгжүүлсэн.

1) Бизнесийн орчны өнөөгийн байдал

Монголын бизнесийн орчны өнөөгийн бодит нөхцөл байдлыг дараах байдлаар мэдээлэл цуглуулж, цэгцэлсэн.

- Бизнесийн холбогдох хууль дүрэм журам
- Голлох бодлого, тогтолцоо, төлөвлөгөө
- Холбогдох байгууллагын бүтэц зохион байгуулалт
- Аж ахуй нэгжийн тойм

Түүнчлэн бизнесийн орчны өнөөгийн байдал үнэлгээ хийхэд дараах мэдээллийг нэгтгэсэн.

- Японы компаниудын бизнесийн хөгжлийн байдал, асуудлын тухай ойлголт

- Японы хамтын ажиллагааны чиг хандлага

- Олон улсын байгууллагууд (Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк гэх мэт.) хамтын ажиллагааны чиг хандлага

2) Зээлийн мэдээллийн хяналт

Санхүүгийн байгууллагуудын мэдээллийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй ЖДҮ, бичил аж ахуйн нэгжийн (хувиараа бизнес эрхлэгчид) санхүүгийн хүртээмжийн асуудлыг (ашиггүй зээл, хэт их өндөр зээлийн шалгуур г.м.) шийдвэрлэх арга зам болгон дараах хоёр системийг нэвтрүүлэх боломж, орчны талаар судалгааг хийж, Монгол улсад цаашид зээлийн эрсдэлд суурилсан санхүүжилтийг (барьцаагүй, батлан даалтгүй) нэвтрүүлэх боломжтой эсэхийг судлахад хувь нэмэр оруулах зорилгоор мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлнэ.

i) “Зээлийн эрсдэлийн мэдээллийн сан (CRD:Credit Risk Database) бий болгох”

ii) “Үнэлгээний загвар (Scoring model)” боловсруулах

Монголбанкнаас банкуудад активын чанарын үнэлгээг (AQR) хийх чиг хандлагыг анхааран үзэхийн зэрэгцээ дараах асуудалд онцгой анхаарал хандуулан дүн шинжилгээ хийнэ.

- Монголд нэвтрүүлснээр гарах ач холбогдол давуу болон сул талуудыг тодорхой болгох

- Бусад зээлийн судалгаа хийх аргуутай харьцуулан судлах

- ЗЭМС цогцоор нь бий болгох, хянах, үйл ажиллагааг эрхлэн явуулах байгууллага нь юу байх вэ гэдгийг тодорхойлох зэрэг системийг нэвтрүүлэх боломж бололцоог эхний байдлаар баталгаажуулах

- Ирээдүйд зээлийн лавлагааны үйл ажиллагааг өргөжүүлэх боломж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тал дээр үр дүн, нөлөөллийн шинжилгээ дүн шинжилгээ хийх.

【семинар хэрэгжилт】

Энэхүү салбарын арга хэмжээний хувьд банк санхүүгийн байгууллагууд дахь үнэлгээний загварт (Scoring model) чухал ач холбогдолтой зээлийн эрсдэлийн мэдээллийн сангийн (CRD:Credit Risk Databas) тухай ойлголт ач холбогдлын талаарх тайлбар, санал солилцох зорилгоор холбогдох төр засгийн байгууллага, хувийн хэвшлийн салбарынханд зориулан семинарыг тус тус зохион байгуулсан.

3) Компанийн засаглал

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, томоохон компаниудын компанийн засаглалын хувьд хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр үнэлгээ хийж байгаа боловч жижиг дунд, бичил бизнес эрхлэгчид (хувиараа бизнес эрхлэгчид) нарын хувьд системтэй хийгдсэн судалгаа хязгаарлагдмал байдаг тул эдгээр компаниудад түлхүү анхаарч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- i) ЖДҮ, бичил бизнес эрхлэгчид (хувиараа бизнес эрхлэгчид) түлхүү анхаарч Монголын аж ахуйн нэгжүүдийн компанийн засаглалын өнөөгийн байдлыг тодорхой болгох
- ii) Компанийн засаглалын нөхцөл байдлыг өөрсдөө үнэлэх боломжтой “өөрийгөө шалгах хуудас буюу Self-check sheet” боловсруулах.
- iii) Компаниудад “компанийн засаглалыг сайжруулах” семинар зохион байгуулах замаар бизнесийн орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулах үр дүнтэй арга хэмжээг авах.

【Бодит нөхцөл байдлын судалгаа, семинарын хэрэгжилт】

Энэхүү судалгааны хүрээнд компанийн засаглалын бодит байдлын асуулга судалгаа (туслан гүйцэтгэгчээр) хийснээс гадна бодит байдлын тайлан, өөрийгөө шалгах хуудсыг ашиглах тухай сургалт зохион байгуулсан.

Асуулга судалгааг аж үйлдвэрлэлийн төрөлжилтөд бодит хувь нэмэр оруулах нөөц бололцоотой дараах аж үйлдвэрлэлийн салбарын (уул уурхай, үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн салбараас бусад) аж ахуйн нэгжүүдээс сонгон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ (хувиараа бизнес эрхлэгч) зэрэг нийт 500 компанийг хамруулсан.

- a) Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн сургалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллага (500 орчим компани)
- b) Монголын хөрөнгийн биржийн I, II ангилалд бүртгэгдсэн компаниуд (300 орчим компани)
- c) Хөгжлийн албан ёсны зээл: ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн зээлд хамрагдсан компаниуд (ойролцоогоор 780 төсөл)
- d) МҮХАҮТ-ын гишүүн компани (ойролцоогоор 3,400 компаниуд)

(3) Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийг бүрэлдэхүүнийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1.1 Судалгааны багийн бүрэлдэхүүн

Овог нэр	Харьяалал	Хариуцсан салбар
Масаюки ИШИДА	Экси Идеа ХХК	Судалгааны багийн ахлагч Бизнесийн орчин хариуцсан зөвлөх
Нацуки ШИМЭГИ	Экси Идеа ХХК	Судалгааны багийн дэд ахлагч Бизнесийн орчин хариуцсан зөвлөх
Кэита ИНОУЭ	Эй Ай Нэтворк ХК	Бизнесийн эрх зүй/менежмент хариуцсан зөвлөх
Хироши МАЦУОКА	Алмек Корпораци	Санхүү/ зээлийн эрсдэлийн менежмент хариуцсан зөвлөх
Гомбо ЭНХЖАРГАЛ	Алмек Корпораци	ЖДҮ-ийн хөгжил хариуцсан зөвлөх

2 Монгол улсын бизнесийн орчны өнөөгийн байдал

2.1 Бизнесийн орчны хууль эрх зүй

(1) Монгол улсын бизнесийн орчны холбогдох хууль

Бизнесийн орчны холбогдох хууль, эрх зүйн актад Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль (хуучнаар Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль), Аж ахуйн нэгжийн бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Зээлийн мэдээллийн тухай, Оюуны өмчийн тухай (Зохиогчийн эрх, оюуны өмч) Дампуурлын тухай, Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хуулиуд хамрагдана.

Бизнесийн орчны холбогдох хуулиудыг нэгтгэн, голлох хуулиудын талаар шинэчилсэн найруулгын дагуу нэгтгэн харуулав.

Хүснэгт 2.1 Бизнесийн орчны холбогдох хуулиуд

Хууль	Батлагдсан он сар өдөр	Нэмэлт өөрчлөлт	Агуулга	Холбогдох яам, тамгын газар
Дампуурлын тухай	1997 /11/ 20	2015 /12/ 4	Дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбодох харилцааг зохицуулна	ХЗДХЯ
Технологи дамжуулах тухай	1998/5/7	2015/12/4	Технологи дамжуулах үйл ажиллагааны зарчим, технологийн түвшний үнэлгээ хийх, технологи дамжуулах	БСШУСЯ
Хөдөлмөрийн тухай	1999/5/14	2017/4/21	Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлно	ХНХЯ
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	2001/2/1	2017/5/11	Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах	ХЗДХЯ, Улсын бүртгэлийн газар, Оюуны өмчийн газар
Иргэний тухай	2002/1/10	2017/5/18	Эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах	ХЗДХЯ
Хөрөнгө оруулалтын тухай	2013/10/3	2016/11/10	Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн	Гадаад Харилцааны Яам, Үндэсний Хөгжлийн Газар

			байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох, холбогдох бусад харилцааг зохицуулах	
Компанийн тухай	2011/10/6	2015/12/4	Компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцаа	ХЗДХЯ
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	2015/1/29	2017/11/9	Хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах	ХЗДХЯ
ЖДҮ-ийн тухай	2007/7/27	2016/2/4	Төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.	ХХААХҮЯ
Банкны тухай	2010/1/28	2018/6/22	Банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банк болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Сангийн яам, Монголбанк
Банк бус санхүүгийн байгууллагын тухай	2002/12/12	2017/5/18	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.	Санхүүгийн Зохицуулах Хороо
Гаалийн тухай	2008/5/20	2017/5/18	Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна	Сангийн Яам, Гаалийн Ерөнхий Газар
Гаалийн тариф, гаалийн татварын тухай	2008/5/20	2017/7/6	Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	Сангийн Яам, Гаалийн Ерөнхий Газар
Онцгой албан татварын тухай	2006/6/29	2007/11/30	Эх орны үйлдвэрийн болон импортоор авсан зарим бараа, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног	Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар

			төхөөрөмж болон энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд онцгой албан татвар ногдуулах, түүнийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	2015/6/9	2016/2/5	Нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид “албан татвар” гэх)-ыг ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, буцаан олгох, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна	Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	2006/6/29	2017/11/10	Аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.	Сангийн яам, Татварын Ерөнхий газар
Өрсөлдөөний тухай	2010/6/10	2017/5/18	Аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулна.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай	2005/12/10	2017/6/9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.	Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар
Нягтлан бодох бүртгэлийн тухай	2015/6/19	2017/2/2	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.	Сангийн яам
Аудитын тухай	2015/9/16	2015/12/4	Аудитор, аудитын стандарт, аудитын үйл ажиллагаа, Зохицуулах байгууллагын үүрэг, хариуцлага гэх мэт холбогдох зүйл заалт	Сангийн яам
Үнэт цаасны зах зээлийн тухай	2013/5/24	2017/5/18	Үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна	Санхүүгийн Зохицуулах Хороо
Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай	2009/7/9	2016/1/19	Үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/-ны гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулна	Улсын бүртгэлийн газар
Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн	2015/6/2	2016/8/30	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгийн эргэлт, санхүүгийн хүртээмжийг	Улсын бүртгэлийн газар

барьцааны тухай			нэмэгдүүлнэ.	
Эвлэрүүлэн зуучлалын тухай	2012/5/22	2015/12/4	Эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоох, эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	ХЗДХЯ
Зээлийн мэдээллийн тухай	2011/10/20	2015/12/4	Зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, хэрэглэгчид зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна	Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголбанк
Зээлийн мэдээллийн сангийн дүрэм	2005/3/19	2018/5/6	Арилжааны банк, ББСБ, иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, батлан даалт, зээлийн нөхцөл, зээлийн карт, зээлийн эргэн төлөлт болон барьцаа хөрөнгөтэй холбогдох мэдээллийг цуглуулан, боловсруулах, хадгалах журам тухай журам.	Монголбанк
Зээлийн батлан даалтын сангийн тухай	2012/2/10	2015/12/4	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	ХХААХҮЯ, Санхүүгийн Зохицуулах Хороо
Зөрчлийн тухай	2017/5/11	2018/6/27	Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлнэ	ХЗДХЯ

Эх сурвалж: legalinfo.mn ЖАЙКА-ын судалгааны баг боловсруулав.

(2) ЖДҮ-ийн бизнесийн орчны холбогдох хууль

ЖДҮ-ийн бизнесийн орчны хууль эрх зүйд хуулийн этгээд бүртгэгдсэн цагаас нягтлан бодох болон татварын тухай, дампуурлын тухай, ЖДҮ-ийн тухай зэрэг олон хууль хамрагдана. Ялангуяа хамгийн их хамааралтай болох ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.48.2-д “ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах, УИХ-ын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтын 186-д “Жижиг, дунд үйлдвэрийн тухай шинэчилсэн найруулга”-ыг боловсруулахаар тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно. Түүнчлэн, Хууль зүй, Дотоод Хэргийн яамны “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн

давхардал, хийдэл, зөрчлийн талаарх судалгааны тайлан”-д тусгагдсан дүгнэлттэй уялдуулан, нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчилсэн найруулгыг батлуулахаар ажиллаж байна.

Шинэчилсэн найруулгын төсөлд, хуулийн нэрийн өөрчлөлтөөс гадна жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангиллыг тодорхой болгон шинэчлэх асуудлыг зохицуулахаар оруулсан. Үүнд, гарааны болон бичил бизнес эрхлэгч, ЖДҮ эрхлэгчдийг тодорхойлон, 4 ангилахаар санал оруулсан байна. ЖДҮ-ийн ангиллыг тодорхой болгосноор төрөөс үзүүлж буй дэмжлэгийг тухайн аж ахуйн нэгжийн ангилал, хэрэгцээ шаардлагад тохирсон оновчтой хуваарилах боломж бүрдэнэ. Улмаар ЖДҮ-ийн өрсөлдөх чадвар, үйлдвэрүүдийн хорших чадвар буюу үйлдвэрүүд кластераар хөгжих, нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын тоо нэмэгдэх, үйл ажиллагаагаа өргөтгөх боломж бий болно.

Бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд татварын дарамтыг бууруулах, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл, мэдээллийн хүртээмж, сургалт, зөвлөгөөний цар хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй шуурхай болгох, үйлдвэрлэл технологийн төв байгуулах, зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатайг дурдсан. Иймд ажилчдын тоо нэмэгдэх тусам ажил олгогчдын төлөх татвар, шимтгэлийн хэмжээг шатлан буурулдаг зохицуулалт, гарааны болон бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ангилал тус бүрт дэмжлэгийн хэлбэрийг оновчтой тогтоох шаардлагатай хэмээн санал оруулсан.

Хүснэгт 2.2 ЖДҮ-ийн бизнесийн орчны холбогдох хуулиудаас

Хуулийн заалт		Агуулга
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль батлагдсан: 2015/1/29 нэмэлт өөрчлөлт: 2017/11/9	Зорилт	Хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах
ЖДҮ-ийн тухай 2007/7/27 2010/1/28	Зорилт	Төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.
Дампуурлын тухай батлагдсан 1997/11/20 нэмэлт өөрчлөлт: 2015/12/4	4 дүгээр зүйл	Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно.
	5 дугаар зүйл	Шүүх дараах үндэслэлээр дампуурлын хэрэг үүсгэнэ:
	5.1.1	үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан;
	5.1.2	хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан.
	5.3	Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийг төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтооно.
7 зүйл 7.1.1	Дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл, хүсэлтэд тавих шаардлага:сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл;	
Нягтлан бодох бүртгэлийн тухай батлагдсан: 2015/6/19 нэмэлт өөрчлөлт: 2017/2/2	Зорилт	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001/2/1 2017/12/14	4.1 зүйл	Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх;
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	Зорилт	Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006/6/29 2017/11/10	Зорилт	Аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Аудитын тухай 2015/6/19 2015/12/4	10.1-10.4	Дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэнэ: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллага; нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага; өөрчлөн байгуулагдаж байгаа болон татан буугдаж байгаа, эсхүл бүх хөрөнгөө дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага;
Зөрчлийн тухай 2017/5/11 2018/6/27	Зорилт	Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.
	10.11	Компанийн тухай хууль зөрчих
	11.1.8	санхүүгийн тайлангийн аудит, эсхүл санхүүгийн тайланг нягтлах ажил, эсхүл бусад баталгаажуулах ажил /аудитын үйлчилгээ үзүүлэх/-ыг нэг аж ахуйн нэгж байгууллагад дараалсан таван жилээс илүү хугацаанд үзүүлсэн

Эх сурвалж: Монгол Улсын хуулиас ЖАЙКА судалгааны баг

(3) Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж

Энэхүү судалгааны нэг багана болох банк, санхүүгийн байгууллагын зээлийн мэдээллийн хяналтад холбогдох хууль тогтоомжийн тухайд банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны агуулга буюу мэдээллийн нууцлалын асуудал чухал бөгөөд ач холбогдол өндөр хууль тогтоомжийн агуулга, анхаарах зүйлсийн талаар дараах хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 2.3 Зээлийн мэдээлэлтэй холбогдох хуулиуд

Хуулийн заалт	Агуулга	
Банкны тухай 2010/1/18 2018/6/22	1.4	Банкны хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, банкны төрөл
	5.1	Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монголбанк, төрийн бусад байгууллага банкны үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд удирдлага, шийдвэрт нь хууль бусаар нөлөөлж болохгүй. Монголбанкны банкны хяналтад холбогдох хууль, эрх зүйн актыг хавсралтаар оруулав.
	6 зүйл	Банкны эрхлэх үйл ажиллагаа Банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо хийх, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа; зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ
	7.2	Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг хуулинд зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно.
	10.1	Зээл : Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно. Банк хугацаандаа төлөгдөөгүй зээл, хүүгийн төлбөрт зээлдэгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгө, хувьцаа, түүний ногдол ашгийг гэрээ болон шүүхийн шийдвэрийн үндсэн дээр авч болно.

	12	Баталгаа, батлан даалт гаргах Банк энэ хуулийн 17.1-17.3-т заасан хязгаарлалтын хүрээнд гуравдагч этгээдэд гэрээний дагуу баталгаа, батлан даалт гаргаж болно.
	18-28	Банк байгуулах, банкнийг өөрчлөн байгуулах
	29-34	Банкны удирдлага, зохион байгуулалт
	35-41	Банкны хөрөнгө, санхүүгийн тайлан
	43-46	Банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрх 43.1 Холбогдох банк, санхүүгийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь өөрсдийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримт материал, тайлан бүртгэл, мэдээ, мэдээлэл холбогдох бусад баримт бичгийг Монголбанкны шаардсанаар гарган өгөх үүрэгтэй.
	47-61	Банкны тогтворжуулалт, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө
	62-67	Банкны тогтворжуулалтын сан, Сангийн хөрөнгө, өр төлбөр, банкны сангийн хөрөнгийг бүрдүүлэх онцгой төлбөр, гадаад хамтын ажиллагаа,
	68-75	Банкийг таган буулгах
Төв Банк /Монголбанк/-ны тухай 1996/9/3 2018/1/12	1 зүйл	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг Төв Банк /Монголбанк/-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
	2-3	Төв Банк Монголбанк ны тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, Төв Банк Монголбанк ны эрх зүйн байдал
	4 зүйл	Монголбанкны үндсэн зорилт 1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. 2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
	5 зүйл	Монголбанкны үйл ажиллагааны чиглэл
	6-9	Монгол улсын мөнгөн тэмдэгт, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрх, мөнгөн тэмдэгтийн нэгж, хэлбэр
	10-11	Мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх
	14 зүйл	Хүүгийн нэгдсэн бодлого явуулах
	19 зүйл	Банкны үйл ажиллагаанд хяналт тавих 1913ээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих 1. зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар зохицуулна.
	25 зүйл	Монголбанкны хянан шалгагчийн бүрэн эрх 4. хуулийн этгээд, иргэний банкны үйл ажиллагаатай холбогдох баримтыг шалгаж үзэх;
	25 ³	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.
	27 ³	Мөнгөний бодлогын хороо 4.2 мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох
	31 ¹	Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороотой харилцах
32 зүйл	Монголбанкнаас банктай харилцах	

<p>Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай 2005/11/17 2018/1/18</p>	<p>Зорилт</p>	<p>Энэ хуулийн зорилт нь Санхүүгийн зохицуулах хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>
<p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай 2002/12/12 2017/5/18</p>	<p>Зорилт</p>	<p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>
	<p>1-4</p>	<p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p>
<p>Зээлийн мэдээллийн тухай 2011/10/20 2015/12/4</p>	<p>Зорилт</p>	<p>Зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, хэрэглэгчид зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>
	<p>хууль</p>	<p>Хуулийн актыг бүрэн эхээр нь хавсралтад оруулав.</p>
	<p>23 зүйл</p>	<p>Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 23.1 зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанк олгоно. 23.2 зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ: 23.2.1 зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагад ажиллах хүмүүсийн болон хувьцаа эзэмшигчдийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, утас, цахим шуудангийн хаяг; 23.2.2 тухайн хуулийн этгээдийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч тус бүрийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ; 23.2.3 зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагад ажиллах хүмүүсийн мэргэжил, боловсрол, ажлын дадлага туршлага, ял шийтгэлтэй байсан эсэх, хугацаа хэтэрсэн аливаа зээл, төлбөргүй болохыг нотлох баримт; 23.2.4 бизнес төлөвлөгөө; 23.2.5 зээлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хамгаалах бүх шаардлагыг хангахуйц мэдээллийн системийн програм хангамж, техник хэрэгслээр хангагдсаныг нотлох баримт; 23.2.6 хэрэглэгч зээлийн мэдээллийн санд хандаж мэдээлэл солилцох журам, түүний эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон гэрээний загвар; 23.2.7 байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагааны зарчим, хариуцлагыг тусгасан ёс зүйн дүрэм; 23.2.8 өөрийн хөрөнгийн доод хэмжээ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагад нийцэж байгааг нотлох баримт; 23.3 Монголбанк энэ хуулийн 23.2-т заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч ажлын 30 хоногийн дотор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө. 23.4 Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, үйлчилгээний хөлс тогтоох журмыг Монголбанк тогтооно. 23.5 Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээд “зээлийн мэдээллийн сан” гэсэн нэр хэрэглэхийг хориглоно.</p>

		(Энэхүү заалт нь өнөөг хүртэлх Монголбанкны Зээлийн Мэдээллийн Санд (CIDB 1) хуримтлагдсан мэдээллийг ашиглан хувийн Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах нөхцлийг тодорхойлсон. Одоогоор энэхүү нөхцөлийг ханган тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байхгүй. Гэхдээ зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг ил тод болгоогүй байна.)
Зээлийн мэдээллийн сангийн журам	Зорилго	Банк болон банк бус санхүүгийн байгууллагаас хувь хүн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцааны талаарх мэдээллийг Зээлийн Мэдээллийн Санд төвлөрүүлэн цуглуулах, боловсруулах, хадгалах, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудыг мэдээллээр хангахад үүсэх харилцааг зохицуулна.
	1,2,4 бүлэг, хавсралт	Энэхүү судалгаанд холбогдох заалтыг хавсралтад нэгтгэв.
Зээлийн батлан даалтын сангийн тухай 2012/2/10 2015/12/4	Нийтлэг үндэслэл	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж, зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн байдал
Байгууллагын нууцын тухай 1995/5/16 2016/12/1	1-3	Байгууллагын нууцын тухай хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, нийтлэг үндэслэл
	3.1	"байгууллагын нууц" гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.
	3.2	Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.
	5 зүйл	1. Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. 2. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө. 3. Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална.
	6 зүйл	Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй: тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;
	7.2	Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.
	8, 9	Шүүхэд гомдол гаргах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

¹ Энэхүү тайланд Монголбанкны Зээлийн Мэдээллийн Санг зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх Зээлийн Мэдээллийн Сан ХК (CIB LLC.) тай ялгахын тулд CIDB (Credit Information Data Base) гэнэ.

<p>Хувь хүний нууцын тухай</p> <p>1995/4/21 2015/12/13</p>	1-3	Хуулийн зорилт, хувь хүний нууцын тухай ойлголт, холбогдох хууль тогтоомж
	4 зүйл	<p>Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:</p> <p>1/захидал харилцааны нууц; 2/эрүүл мэндийн нууц; 3/хөрөнгийн нууц; 4/гэр бүлийн нууц; 5/хуулиар тогтоосон бусад нууц.</p> <p>Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:</p> <p>1/захидал харилцааны нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг; 2/эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг; 3/хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг; 4/гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг.</p> <p>3.Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.</p>
	5 зүйл	<p>1.Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.</p> <p>2.Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.</p> <p>3.Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.</p> <p>4.Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.</p>
	6 зүйл	Монгол Улсын баглан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/ -ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно.
	7 зүйл	Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд өөрийнх нь нууцыг бусдад задруулсан гэж үзвэл хувь хүн энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.
	8 зүйл	<p>8.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>8.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>
	<p>Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам 2017/7/1</p>	<p>зорилго</p> <p>бүрэн эхээрээ</p>

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай 2009/7/9 2016/1/19	зорилт	үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/-ны гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
	33 зүйл	Үл хөдлөх хөрөнгийг давхар барьцаалах 33.1. барьцаалуулагч нь барьцааны зүйлийг бусад этгээд давхар барьцаалах эрхтэй. 33.2 Энэ хуулийн 33.1-д заасан тохиолдолд барьцаалагчийн шаардлагыг улсын бүртгэлд бүртгэсэн дарааллаар хангана.33.3. Өмнөх барьцааны гэрээнд дараачийн барьцааны гэрээний нөхцөлийг тусгасан бол дараачийн барьцааны гэрээг байгуулахдаа уг нөхцөлийг заавал тусгана. 33.4. Энэ хуулийн 33.3-г заасныг зөрчиж байгуулсан гэрээг дараачийн барьцаалагч урьдчилан мэдэж байсан эсэхээс үл хамааран шүүх өмнөх барьцаалагчийн нэхэмжлэлээр дараачийн барьцааны гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцно. 33.5. Хэрэв өмнөх болон дараачийн гэрээний барьцаалагч, барьцаалуулагч нь нэг этгээд байвал энэ зүйлд заасан журам хамаарахгүй.

Эх сурвалж : Монгол Улсын хуулиас ЖАЙКА судалгааны баг

(4) Компанийн засаглалын холбогдох хууль тогтоомж

Компанийн засаглалын холбогдох хууль тогтоомжийн ихэнх нь бизнесийн орчны холбогдох хуулиудтай холбогдох бөгөөд ялангуяа Компанийн тухай, Үнэт цаасны тухай, Компанийн засаглалын кодекс өндөр ач холбогдолтой.

2011 оны Компанийн тухай хууль шинэчлэгдэн, хүснэгт 2.4 дурдсанчлан 75.8 болон 79.2 заалтад компанийн засаглалын талаар тодорхой дурдсан. Эдгээр заалтыг зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 10.11.6 заалтын дагуу хувь хүн 500,000 төгрөг, хуулийн этгээд 5,000,000 төгрөгийн торгууль ногдоно.

Түүнчлэн Үнэт цаасны тухай хуульд хүснэгт 2.4 дурдагдсанчлан уг хуулийн 20.1.10 заалтад Үнэт цаас гаргагчид компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх тухай тусгагдсан бөгөөд энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10.3 заалтаар хуулийн этгээд 20,000,000 төгрөгийн торгууль ногдоно.

Мөн Компанийн засаглалын кодекс 2007 оны 12 сарын 26-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны 210 дугаар тогтоолоор батлагдсан ба 2014 оны 5 сарын 7-ны өдрийн СЗХ-ны 162 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан.

Нөгөөтэйгүүр СЗХ-ны 2015 оны 12 сарын 17-ны өдрийн 443 дугаар тогтоолын дагуу “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.3.2.6-д үнэт цаас гаргагч СЗХ-оос

баталсан Компанийн Засаглалын кодексийг мөрдөж буй эсэх талаарх үнэлгээг жилийн тайланд тусгах заалт ооруулснаас гадна 2016 оны 1 сарын 29-ний өдрийн СЗХ-ны 34 дүгээр тогтоолын дагуу энэ жилийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн КЗҮЗ-өөс хэрэгжүүлдэг компанийн засаглалын үнэлгээний дүнг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй болсон.

Монголын Хөрөнгийн Биржийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдан “Үнэт цаас бүртгүүлэх журам” ын 11.1.6 зааснаар Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн шалгуурт 1 дүгээр ангиллын үнэт цаас гаргагч 2 дотоодын болон олон улсад итгэмжлэгдсэн компанийн засаглалын үндсэн концептыг дагаж мөрддөг байх, 2 дугаар ангиллын үнэт цаасны бүртгэлийн шалгуурт компанийн засаглалыг дагаж мөрддөг байх, үгүй бол тайлбар гэсэн³ аргаар зохицуулагдсан байна. Гэхдээ 3 дугаар ангилалд тухайн шалгуур тусгагдаагүй байна.

Эдгээрээс гадна Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд ч компанийн засаглалын үндсэн зарчим тусгагдсан заалтууд орсон байна. Түүнчлэн 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд өмнө дурдсанчлан аливаа хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд авах торгууль, арга хэмжээний талаар тодорхой дурдсан бөгөөд хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан тохиолдолд ч улсын төсөв бүрдүүлэх талаас хуулийг чанд мөрдөх асуудал эрчимжиж байна.

Дээрх асуудалтай холбогдох хуулиудыг товч болон энэхүү судалгаанд ач холбогдол бүхий заалтыг дараах хүснэгтэд цэгцэлж харуулав.

Хүснэгт 2.4 Компанийн засаглалын холбогдох хуулиуд

Хуулийн заалт		Агуулга
Компанийн тухай 2011/10/6 2015/12/4	2 бүлэг 3 зүйл	Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ. Компанийн хэлбэр: хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани, хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай, компанийн нэгдэл, тусгай зориулалтын компани
	2 зүйл 9	Компани болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага Компанийн өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг даган мөрдөнө. Хувьцаа эзэмшигчийн эрх : Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч

² 2018 оны 7 сарын байдлаар I ангилалд 9 компани, II ангилалд 42 компани, III ангилалд 169 компани бүртгэлтэй байна.

³ Засаглалын үндсэн зарчимг мөрдөх, үгүй бол учир шалтгааны тодорхой тайлбарлах арга

		<p>нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.</p> <p>Компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагч, түүний эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн уг зардлыг нэхэмжлэн авах, эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.</p> <p>Компани нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдийн шаардсанаар түүнд танилцуулах үүрэгтэй.</p>
	3 бүлэг 11,12,13	Компани байгуулах, үүсгэн байгуулагч
	4 бүлэг	Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өрийг хувьцаагаар солих Хувьцаа эзэмшигчийн эрх
	5 бүлэг	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаас
	6 бүлэг	Ногдол ашиг, хогдол ашиг хуваарилах нөхцөл, компанийн өмчийг шилжүүлэх
	7 бүлэг	Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах, хувьцааг нэгтгэх болон хуваах
	8 бүлэг	Хувьцааны хяналтын багцыг худалдан авах
	9 бүлэг	Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлага
	9 бүлэг 75.8	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
	9 бүлэг 79.2	Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан компанийн хувьд хараат бус гишүүнд тухайн компанийг удирдах мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нэрийг компанийн сайн засаглалыг дэмжих зорилготой төрийн бус байгууллагаас дэвшүүлэх саналаа тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороонд ирүүлж болно.
	10 бүлэг	Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага
	11 бүлэг	Их хэмжээний хэлцэл
	12 бүлэг	Сонирхлын зөрчилтэй хэлцэл
	13 бүлэг 94, 95, 96, 97	Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт, компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн баримт бичгийг хадгалах
	14 бүлэг 100	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай</p> <p>2013/5/24 2018/1/18</p>	1 бүлэг	Үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцаа
	2 бүлэг	Үнэт цаас гаргах, үнэт цаас гаргах журам, үнэт цаасыг нийтэд санал болгох, үнэт цаасыг зах зээлд худалдах, тайлагнах 17 зүйл. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани гадаад улсад үнэт цаас гаргах 18 зүйл. Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах

	2 бүлэг 20.1.10	Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх.	
	3 бүлэг	Компанийн хувьцааг бүхэлд нь буюу түүний хяналтын багцыг худалдан авах	
	4 бүлэг	Зохицуулалттай үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл олгох	
	5 бүлэг	Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл, Зохицуулалттай этгээдийн мэдээлэл, Хөрөнгө оруулагчийн мэдээлэл, Хорооны мэдээлэл, Хороо бусдаас мэдээлэл шаардах эрх	
	6 бүлэг	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, үнэт цаасны зах зээл дэхь төрийн зохицуулалт	
	7 бүлэг	Үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа	
	9 бүлэг	Бусад зүйл	
	Компанийн засаглалын кодекс (СЗХ-ны журам) 2007/12/26 2014/5/12	1 бүлэг	Компанийн засаглалын кодекс: Компанийн засаглалын тогтолцоог бий болгоход анхаарах зүйл, хууль эрх зүйн актын компанийн засаглалд үзүүлэх нөлөө болон хууль хэрэгжилтийн ил тод байдал, эрх бүхий этгээд хоорондын үүрэг хариуцлагын хуваарилалт, хяналт зохицуулалт
		2 бүлэг 2 зүйл	Хувьцаа эзэмшигчдийн эрх
3 бүлэг 1 зүйл		Мэргэжлийн хөрөнгө оруулагчид	
4 бүлэг 5 зүйл		Хувьцаа эзэмшигчдийн хурал: хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх, хурал хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурлын шийдвэр	
5 бүлэг 9 зүйл		Төлөөлөн удирдах зөвлөл: ТУЗ-ийн үүрэг, ТУЗ-ийн бүрэн эрх ба түүний бүтэц, гишүүдийг сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн хороод, аудитын хороо, сонирхлын зөрчил ба нэгдмэл сонирхолтой этгээд хоорондын хэлцлүүд	
6 бүлэг 1 зүйл		Гүйцэтгэх удирдлага: гүйцэтгэх удирдлагын эрх	
7 бүлэг 3 зүйл		Санхүүгийн тайлагнал, хөндлөнгийн аудит, мэдээллийн ил тод байдал	
8 бүлэг нийт 1 зүйл		Дотоод хяналтын тогтолцоо: Дотоод хяналт, дотоод аудитын тогтолцоо	
9 бүлэг 3 зүйл		Эрсдлийн удирдлага: Төлөөлөн удирдах зөвлөл нь гадаад ба дотоод үйл ажиллагааны бүхий л эрсдэл, санхүү ба хуулийн хэрэгжилт болон бусад эрсдлийг эрсдлийн менежментээр хангах, удирдлагын ба эрсдлийн удирдлагын журам, дүрмийг боловсруулан, хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналтгавих асуудлыг хариуцана.	
10 бүлэг 6 зүйл	Оролцогч талууд: ажилчид, зээлүүлэгчид, харилцагчид, ханган нийлүүлэгчид, орон нутгийн иргэд, ард иргэдээс бүрдэх оролцогч талуудын эрхийг хүндэтгэн, компанийн төлөвлөгөө, тайлан гэх мэт мэдээллүүдтэй танилцах боломжоор хангасан байна. Компани ажилчид, зээлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, худалдан авагчид, үйлчлүүлэгчдийн сонирхол болон байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлуудыг харгалзан гаргах гэж буй шийдвэрүүд нь оролцогч талуудад нөлөөлөх эсэхийг харгалзан шийдвэр гаргадаг байх ёстой.		

Эх сурвалж: Монгол Улсын хуулиас ЖАЙКА-ийн судалгааны баг

2.2 Холбогдох бодлого, тогтолцоо, төлөвлөлт

(1) Бизнес орчны холбогдох бодлого, тогтолцоо, төлөвлөлт

2016 оны 2 дугаар сард УИХ-аар батлагдсан “Монгол улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030”-д 2030 он хүртэлх хөгжлийн 10 үндсэн зорилт, эдгээр зорилтод хүрэх 4 тэргүүлэх бодлогыг тодорхойлсон. Эдгээрийн нэг болох “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийг хангахын тулд “Бизнесийн таатай орчин” бүрдүүлэх асуудал төлөвлөгдсөн.

“Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т эдийн засгийн хүндрэлийг даван туулахын хамт эдийн засгийг тогтворжуулах бодлогыг тусган, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжин, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчид дэмжлэг үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100⁴” үндэсний хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”, “Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөр”, “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих хөтөлбөр” зэрэг нийт 65 үндэсний хөтөлбөрийг шинээр боловсруулан хэрэгжүүлнэ. Түүнчлэн “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах хөтөлбөр”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”, “Орон сууцны ипотекийн зээл” хөтөлбөр зэрэг 14 үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Үүнд, ЖДҮ-ийн бизнесийг дэмжих бодлогын хүрээнд голлох хөтөлбөр болох ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр ийг боловсруулж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн төсөлд дээрх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, болон “Засгийн газрын 2016 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсанаар 2018-2019 он хүртэл 1 үе шат, 2020-2021 он хүртэл 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. ЖДҮ-ийн ДНБ-д оруулах хувь хэмжээг өсгөх, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 1) ЖДҮ, бизнес эрхлэлтийг татвар, тарифын бодлогоор дэмжих, 2) зээлийн хүүг бууруулах, 3) үндэсний зөвлөхүүдийг хөгжүүлэх, дэмжих, 4) инноваци болон техник, технологийн нэвтрүүлэлтийг эрчимжүүлэн, стандартын шаардлагыг нэмэгдүүлэх, 5) төрөөс дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх, 6) Нэг сум-нэг бүтээгдэхүүн аяныг хөгжүүлэх зэрэг зорилт оруулахаар төлөвлөж байна.

⁴ 21 аймагт ЖДҮ-ийг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжин хөгжүүлэх үндэсний хөтөлбөр.

Эдгээр зорилтод хүрэхийн тулд холбогдох хууль эрх зүйн орчин, бодлого хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх нь чухал. Тухайлбал, дараах зүйлүүд дээр анхаарах хэрэгтэй.

1) Татвар, тарифын бодлогын тухайд, гарааны бизнесийг дэмжих, ЖДҮ-ийг үе шаттайгаар дэмжих асуудал хөндөгдсөн байгаа хэдий ч Татварын хуулийн шинэчлэлд зохицуулах заалт оруулах шаардлагатай болно. Одоогоор Татварын хуулийн шинэчлэлийн төсөлд үүнтэй холбогдох заалт хараахан тусгагдаагүй байна. Холбогдох байгууллагатай хуулийн шинэчлэлийн хэлэлцүүлгийг сайтар явуулах хэрэгтэй.

2) Зээлийн хүү бууруулах, хугацааг уртасгах замаар санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бий болгох тал дээр Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл тусламжийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, мөн арилжааны банкуудын зээлийн хүүг бууруулах зэрэг зорилт тавигдсан байна. Хэрэгжилтийн тухайд Сангийн Яам зэрэг холбогдох байгууллагуудын бодлогын уялдаа болон хууль эрх зүйн үндэслэлийг харгалзан үзэх шаардлагатай. Зээлийн хүүг бууруулах тухайд Засгийн газрын 2018 оны үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Сангийн Яам, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Газар хамтарсан ажлын хэсэг байгуулагдан “Зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулан, оролцогч талуудтай хэд хэдэн удаа хэлэлцүүлэг хийсний дараа 2018 оны 6 сарын 12-нд батлуулсан. Зээлийн хүүг бууруулах макро эдийн засгийн орчныг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах, үр ашиг болон засаглалыг сайжруулахад 11 чиглэл бүхий стратегийн зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү стратегийг хэрэгжүүлснээр тодорхой уялдаа холбоо, хууль эрх зүйн үндэслэл бий болж ЖДҮ-ийн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэх боломжтой болсон гэж найдаж байна.

3) Үндэсний зөвлөхүүдийг хөгжүүлэх, дэмжих тухайд менежмент, стратеги, мэдээллийн технологи, маркетинг, хүний нөөц, компанийн засаглал, санхүү, бүртгэл, татвар, аудит, байгаль орчин, чанарын удирдлагын тогтолцоо, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, инженерингийн чиглэлээр зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах зорилготой, цаашид сургалтын дотоод агуулга, хэрэгжилт дээр анхаарал тавих шаардлагатай.

4) Нэг сум-нэг бүтээгдэхүүн аян хөгжүүлэх тухайд төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх тухай дурдагдсан байгаа ч үүний тулд холбогдох байгууллага, хөтөлбөртэй уялдуулах асуудлыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал, ХХААХҮЯ голлон боловсруулсан “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” үндэсний хөтөлбөр болон Үндэсний хөгжлийн газар боловсруулахаар төлөвлөж буй “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-той уялдуулан, хэрэгжүүлэх

шаардлагатай.

ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр (төсөл)-д тусгах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2.5 ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2017 он ХБГ	Зорилтот түвшин 2021 он
1	Идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрийн тоо	тоо	45,911	67,612
2	Жижиг дунд үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо	тоо	260,000	290,000
3	Инкубатор, дэмжих төвүүдэд хамрагдсан аж ахуйн нэгжийн нийт тоо өснө.	тоо	180	280
4	Сургалт, семинарт хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн тоо	тоо	8,917	11,380
5	ДНБ-д эзлэх хувь	хувь	17.8	21
6	Экспортод ЖДҮ-ийн эзлэх хувь	хувь	2.3	5.3

Эх сурвалж: ХХААХҮЯ, ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр (төсөл)

Түүнчлэн экспортыг дэмжих хүрээнд Засгийн газраас 2003 онд батлагдсан Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрт уул уурхайн бус экспортыг 30 хувьд хүргэх зорилт тавьсан ч өнгөрсөн оны байдлаар нийт экспортын 79.5 хувийг эрдсийн, 20.5 хувийг уул уурхайн бус салбар эзлэн хөтөлбөрийн зорилт биелэгдэж чадаагүй байна. Иймд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэх Монгол экспорт хөтөлбөрийг (төсөл) боловсруулан, олон нийтийн санал авч эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийн агуулгыг харахад өмнөх хөтөлбөртэй ижил уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилт тавин, 2018-2022 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эхний үе шат болох 2018-2019 он хүртэлх хугацаанд хууль эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнээс гадна үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмж, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилт тавьсан байна.

2 дахь үе шат болох 2020-2022 онд уул уурхайн бус салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмж, экспортын худалдааг хөнгөвчлөх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн үйл ажиллагаа тусгагдсан байна. Хүлээгдэж буй үр дүнгийн хувьд ноос, ноолуур, арьс шир, хөдөө аж ахуйн бусад түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг бий болгож, боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэнэ. Хөдөө аж ахуй, хүнсний салбарын экспортын орлогыг 2021 он хүртэл 50 хувиар нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 9 хувь байгааг 15 хувьд хүргэхээр зорьжээ. Түүнчлэн экспортод уул уурхайн бус бараа

бүтээгдэхүүний тоо 150 байгааг 225 болгож нэмэгдүүлэхээр тусгасан байна.

Эдгээр зорилгоос харахад өмнөх хөтөлбөрийг үргэлжлүүлэх хэрэгжүүлэх бодлого гэж харагдаж байгаа хэдий ч энэ удаагийн хөтөлбөрт ноос, ноолуур зэрэг ХАА гаралтай бараа бүтээгдэхүүнд ихээхэн ач холбогдол өгч, мах сүү, чацаргана⁵ зэрэг барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар экспортыг дэмжих боломжтой гэж тооцсон байна.

Үүний тулд хөдөө орон нутагт хорио цээрийн тусгай бүс байгуулах, үйлдвэр лабораторийн бүтээн байгуулалтыг гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлд хамруулан дэмжих, үйлдвэрлэгчдийг дэмжихийн тулд экспортын чиглэлийн худалдаа, үйлдвэрлэлийн сүлжээ бий болгохоор төлөвлөж байгаа зэрэг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн гүйцэтгэх үүрэг их байна. Түүнчлэн БНХАУ-ын зах зээлээс хараат байдлыг зайлсхийн, Европын Холбоо, АНУ, Канад, ОХУ-ын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээний судалгаа хийх зэрэг шинэлэг санаанууд багтжээ. Гэхдээ цаашид хөгжлийн нөөц бололцоо бүхий салбар тухайлбал аялал жуулчлалын салбарыг татвар болон бусад хөшүүргээр дэмжих асуудал хөндөгдөөгүй, мөн зах зээл өргөн, хэрэглэгч олонтой технологийн салбар, инноваци шингэсэн бүтээгдэхүүнийг бодитоор дэмжих асуудал, ЖДҮ-ийн бизнес орчин сайжруулах талаас нь дахин бодолцож үзэх нь чухал.

Иймэрхүү олон тооны төрийн бодлого, хөтөлбөр боловсруулагдаж байгаа хэдий ч хэрэгжих боломж, оновчтой байдлыг авч хэлэлцэх шаардлагатай. Тухайлбал ЖДҮ рүү чиглэсэн санхүүгийн тогтолцоо болох бага хүүтэй зээлийн тогтолцоо байгаа хэдий ч одоогийн ЖДҮ-ийн тухай хуулиар жилийн орлого 150 тэрбум төгрөгөөс дор орлоготой ЖДҮ хамрагдахаар заагдсан байгаа тул олон жилийн бизнесийн түүхтэй жижиг дунд бизнес эрхлэгчид, аж үйлдвэрийн төрөлжилтөд хувь нэмэр оруулах бололцоотой компаниуд үйл ажиллагаагаа тэлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх зэрэгт хөрөнгө шаардлагатай хэдий ч иймэрхүү хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжгүй. Нөгөөтэйгөөр одоогийн хуульд заагдсан хөнгөлөлттэй зээлд хамрагдах ЖДҮ-ийн хувьд зээл авах арилжааны банкны зээлийн шалгуур болох бизнесийн тогтвортой байдал, барьцаа хөрөнгө зэрэг шалгуурт хүрэхгүйн улмаас зээл авч чадахгүй тохиолдол цөөнгүй.

Цаашид иймэрхүү үндсэн суурь асуудлыг сайтар судалж, цэгцлэх шаардлагатай бөгөөд өнөөгийн ЖДҮ-ийн тухай хуульд өөрчлөлт, тодотгол хийхээр ажиллаж байгаа нь цаг үеэ олсон

⁵ Монголд ургадаг *Elaeagnaceae* овгийн бутлаг ургамлын үр жимс юм. Амндэмээр баялаг тул хүнс, гоо сайхан, эрүүл мэндийн бүтээгдэхүүн болгож боловсруулагддаг.

ажил болж байна. Түүнчлэн хэлэлцэх агуулгын хувьд бодит байдлыг тусгасан арга хэмжээг нэмэгдүүлж байна гэж үзэж байна. Өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн ч олон нийтийн хэлэлцүүлэг зэргээр бизнес эрхлэгчид болон мэргэжлийн холбоодын санал хүсэлт, хэлэлцүүлгийн үр дүнг бодлогод тусган, оновчтой цогц бодлого хэрэгжүүлэх нь чухал билээ.

(2) Зээлийн мэдээллийн хяналтын бодлого, тогтолцоо, төлөвлөлт

Монгол улсад 1990 оны сүүлээр Монголбанканд зээлийн мэдээллийн сан байгуулагдан, үйл ажиллагаа явуулж ирсэн. Өнөөгийн тогтолцоо нь арилжааны банк болон банк бус байгууллагууд зээлийн мэдээллийг “Зээлийн мэдээллийн сангийн журам” (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 131-р тогтоол) бусад хууль журмын дагуу Төв банкны (Монголбанк) Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх үүрэгтэй. Банк, санхүүгийн байгууллагууд хуулийн дагуу эргэн төлөлт 90-ээс дээш хоног хэтэрсэн чанаргүй зээлийн талаар Монголбанкинд мэдээлж, Монголбанк эдгээр мэдээллийг нэгтгэн зээлийн болон дефолтын (чанаргүй зээл) талаарх мэдээллийг сар бүр шинэчлэн оруулдаг. Дээрх журмаас гадна 2011 онд Зээлийн Мэдээллийн тухай хууль батлагдсан. Уг хуулиар зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, аюулгүй байдал, хамгаалал, мэдээллийн ашиглалт хуулийн дагуу тодорхойлогдон, зээлийн мэдээллийн санг эрхлэх аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлага тодорхой дурдагдсан.

Зээлийн мэдээллийн тухай хууль батлагдахаас өмнө 2009 оноос Монголын Банкны Холбооны санаачилгаар АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр Зээлийн мэдээллийн төв ХХК-ийг байгуулсан. Зээлийн мэдээллийн Төв ХХК нь 2014 онд Интерактив ХХК-д зээлийн мэдээллийн систем хөгжүүлэлтийн ажлыг захиалан, зээлийн онооны систем нэвтрүүлэхээр зорьж байна. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл Зээлийн мэдээллийн тухай хуулийн (2011 оны 10 сар) 23-р зүйлийн дагуу зээлийн мэдээллийн сан эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд 3 (Зээлийн мэдээллийн төв ХХК орсон) байсан бөгөөд одоогоор үйл ажиллагааны эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна ⁶. Уг хуулийн 23-р зүйлд үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигч, бизнес төлөвлөгөө, техник хэрэгсэл (программ хангамж), мэдээллийн хяналт, ёс зүйн дүрэм, хөрөнгийн доод хэмжээ зэрэг заагдсан байна. (Одоогоор ямар нөхцөл шаардлага хангагдаагүйн улмаас тусгай зөвшөөрөл олгогдоогүй талаар тодорхой мэдээлэл байхгүй хэдий ч албан бус мэдээллээр Монголбанкнаас хуульд заагдсан нөхцөл шаардлага хангагдаагүй гэсэн дүгнэлт гарсан гэх таамаглал байна.)

⁶ Энэхүү тайлангийн 3.5-р “ЗМС-аас бусад зээлийн мэдээлэл агуулсан мэдээллийн сан” хэсгийн “1.Нэр нь тодорхой мэдээлэл, хувийн хэвшлийн ЗМС -д дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Сүүлийн үед Олон улсын санхүүгийн байгууллага Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн систем шинэчлэл хийх шаардлага, зөвлөмж гаргасан байна. Зээлийн мэдээллийн хяналттай холбогдох банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн талаар 3 дугаар бүлэгт тодорхой дурдана.

(3) Компанийн засаглалын холбогдох бодлого, тогтолцоо, төлөвлөлт

Монгол улс ардчилсан системд шилжсэний дараа 1999 онд шинээр батлагдсан Компаний тухай хуульд компанийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг тусгасан төдийгүй Компанийн Засаглалын зарчмуудыг тусгасан. Компанийн тухай хууль батлагдан гарсантай холбогдон УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Компанийн засаглалын ажлын хэсэг байгуулагдсан. Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн чиглэл удирдамжийн дагуу Үнэт цаасны хороо 2000 оны 10 дугаар сараас нийт бүртгэлтэй ХК-уудад үзлэг шалгалт хийх удирдамж баталж, 2002 он хүртэл үзлэг хийж гүйцэтгэсэн.

Үүний дараа 2007 онд ЭЗХАХБ-ын компанийн засаглалын зарчмуудад суурилсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг батлан гаргасан⁷. 2011 онд “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 69 дүгээр тогтоолоор баталсан.

Компанийн засаглалын талаарх дэлгэрэнгүйг 4 дүгээр бүлэгт дурдав.

⁷ 2014 оноос компанийн засаглалын кодексийг шинэчлэн хэрэгжүүлж байна.

2.3 Холбогдох байгууллагын бүтэц үйл ажиллагаа

(1) Бизнесийн таатай орчин бүрдүүлэх

Энэхүү салбар өргөн хүрээтэй тул холбогдох мэргэжлийн холбоод олон, тус бүрийн асуудлын талаар холбогдох яам, тамгын газарт санал тавих бүтэц тогтолцоотой. Үүнд санхүүгийн салбарын хувьд Монголын Банкны Холбоо, Банк бус санхүүгийн байгууллагын холбоо зэрэг мэргэжлийн холбоодоос гадна бүхий л салбарыг хамарсан Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн Танхим (цаашид МҮХАЖТ) , CEO клуб, гадны хөрөнгө оруулалттай British Council, American Chamber of Commerce, Японы худалдаа, аж үйлдвэрийн холбоо, Монголын бизнесийн зөвлөл зэрэг байгууллагуудыг дурдаж болно.

Мөн Засгийн газрын хувьд хүнд үйлдвэрийн салбарыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийг ХХААХҮЯ, хөрөнгө оруулалтыг дэмжих талыг Үндэсний хөгжлийн газар тус тус хариуцан ажиллаж байна. Жижиг дунд үйлдвэр болон бусад салбарын үйл ажиллагааг голлон хариуцдаг эдийн засгийн байгууллага болох МҮХАҮТ, хөрөнгө оруулалтын цогц бодлого болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг хариуцдаг Үндэсний хөгжлийн газрын талаар дор дурдав.

1) Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)

Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн Танхим (МҮХАЖТ) 1960 онд байгуулагдсан. Өнөөгийн байдлаар 3,226 аж ахуйн нэгж гишүүнтэй, үүнээс 70 хувийг ЖДҮ эзэлж байна. Гишүүдийн 3-ны 1 хувь нь Улаанбаатар хотод байрладаг, 21 аймагт салбартай, 42 улсад төлөөлөгчийн газартай (12 улсад өргөмжит төлөөлөгчтэй). Ашгийн бус байгууллага бөгөөд а) бизнесийн орчныг сайжруулахад төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх, б) бизнесийн холбогдох хууль тогтоомж, бодлогын бичиг баримтад бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, в) гишүүд ба бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, г) гишүүд болон бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг мэдээллээр хангах, д) бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, е) танхимын засаглал, менежментийг сайжруулах, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, нөөцийг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

2) Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ)

Үндэсний хөгжлийн газар (цаашид ҮХГ) нь 2016 оны шинэ Засгийн газрын бүрдүүлэхэд Ерөнхий сайдын шууд удирдлага дор Засгийн газрын тохируулагч агентлаг хэмээн

байгуулагдсан. Газрын даргын удирдлага дор 55 ажилтны бүрэлдэхүүнтэй, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс, Бүртгэл, мэдээлэл, сурталчилгааны хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтсээс бүрдэх бөгөөд эдгээр дотор Судалгаа, шинжилгээний алба, Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн алба, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба гэсэн 3 албатай. Үйл ажиллагааны тухайд хөгжлийн бодлого, хөтөлбөр, бүсчилсэн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого, хөгжлийн бодлогын мэдээллийн санг хариуцаж ажилладаг. Тухайлбал, хөгжлийн бодлого, хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, саналыг нэгтгэн судлах, салбарын хөгжлийн бодлогын уялдааг хангах, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, холбогдох хууль тогтоомжийн санал боловсруулах, гадаадын хөрөнгө оруулагч нарт мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого боловсруулах, холбогдох судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн санг эрхлэн хөтлөх зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

(2) Зээлийн мэдээллийн хяналт

Банк, санхүүгийн салбарын хувьд зээлийн мэдээллийг эрхлэх асуудлыг өнөөг хүртэл Зээлийн мэдээллийн санг эрхэлж ирсэн Монголбанк хариуцан ажилладаг. Түүнчлэн эдийн засаг, санхүүгийн бодлогын асуудал хариуцдаг Сангийн Яам болон ХХААХҮЯ Зээлийн мэдээллийн санг ашиглахаас гадна өөрсдийн бие даасан мэдээллийн сантай, зээлийн мэдээллийн хяналт, эрхлэлтийн нэг хэсгийг гүйцэтгэж байна. Түүнчлэн Засгийн газрын хувьд Банк бус санхүүгийн байгууллагын хяналтыг хариуцдаг Санхүүгийн Зохицуулах Хороо мөн зохицуулалтын хүрээнд холбогдоно. Арилжааны банкуудын эрх ашгийг илэрхийлэх Монголын Банкны Холбоо нь одоогийн Монголбанкны Зээлийн Мэдээллийн Сангийн мэдээлэлд тулгуурласан хувийн хэвшлийн Зээлийн мэдээллийн төв байгуулахаар ажиллаж байна. Түүнчлэн банк бус санхүүгийн байгууллагын холбоо нь гишүүд байгууллагууд руу хандсан төрөл бүрийн мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна. Эдгээр голлох байгууллагуудын талаар 3 дугаар бүлэгт дурдана.

(3) Компанийн засаглал

Компанийн засаглал дотор хуулиа дээдлэх болон мэдээллийн ил тод байдлын тухайд санхүүгийн талаас Сангийн Яам санхүүгийн давхар тайланг үгүй хийх болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заагдсаны дагуу олон улсын стандартад нийцүүлэх гарын авлага, зөвлөмж гаргах хүсэлтэй байна. Засгийн газрын идэвх зүтгэлээр батлагдсан 2007 оны

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, мэдээлэл, сурталчилгаа зэргийг Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Компанийн засаглалын хөгжлийн төв зэрэг байгууллагууд идэвхитэй явуулж байна. Түүнчлэн МҮХАҮТ болон мэргэжлийн холбоод гишүүддээ хандсан мэдээлэл түгээх, сургалт явуулах зэргээр ажиллаж байна. Голлох байгууллагуудын талаар 4 дүгээр бүлэгт дурдав.

2.4 Монголын аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл болон ижил төстэй судалгаа

(1) Монголын аж ахуйн нэгж болон ажиллагсдын тоо

Монголын Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээс харахад 2017 онд эцсийн байдлаар улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 150,000 гаруй байгаа хэдий ч үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж үүний талаас хэтрэхгүй. 2017 оны байдлаар 155,065 аж ахуйн нэгж бүртгэгдсэн, үүнээс 78,585 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуйн нэгжийн тоог өнгөрсөн 7 жилийн хугацаагаар, салбар тус бүрээр дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.6 Аж ахуйн нэгжийн тоо (салбараар)

Салбар	2011/4	2012/4	2013/4	2014/4	2015/4	2016/4	2017/3
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	3,514	4,765	5,360	6,374	6,661	7,078	7,500
Уул уурхай	513	691	728	945	1,155	1,259	1,429
Боловсруулах үйлдвэр	5,853	7,425	8,044	9,188	9,934	10,406	10,981
Цахилгаан, хий, ус хангамж	239	280	320	381	344	346	357
Барилга	4,226	5,430	6,529	8,940	10,496	11,430	11,911
Бөөний болон жижиглэн, гэр ахуйн бараа засвар	26,504	41,123	44,590	48,865	54,303	60,171	63,645
Зочид буудал, зоогийн газар	2,344	2,967	3,097	3,254	3,349	3,632	3,783
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	3,182	4,039	4,336	5,063	5,529	6,217	6,708
Санхүүгийн гүйлгээ	2,167	1,754	1,839	2,069	1,920	1,946	2,045
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	6,543	8,951	10,251	11,642	12,656	14,183	15,092
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал	1,428	1,387	1,390	1,433	1,434	1,435	1,450
Боловсролын салбар	3,016	3,186	3,293	3,598	4,209	4,844	5,097
Эрүүл мэнд, нийгмийн халамж	2,770	2,993	3,114	3,472	3,831	4,071	4,214
Бусад үйлчилгээ	5,093	5,528	6,698	8,353	10,715	14,460	16,035
Нийт	67,392	90,519	99,589	113,577	126,536	141,478	150,247

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, 2017

Хүснэгт 2.7 Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, салбараар

Салбар	2011/4	2012/4	2013/4	2014/4	2015/4	2016/4	2017/3
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	2,507	2,877	3,178	3,409	3,351	3,539	3,802
Уул уурхай	383	430	401	608	655	690	738
Боловсруулах үйлдвэр	4,143	4,492	4,177	4,996	5,190	5,303	5,679
Цахилгаан, хий, ус хангамж	219	242	256	297	251	242	246
Барилга	2,831	3,135	3,541	4,770	5,390	6,074	6,308
Бөөний болон жижиглэн, гэр ахуйн бараа засвар	15,897	20,430	21,640	22,793	24,194	27,744	29,860
Зочид буудал, зоогийн газар	1,899	1,965	1,994	2,018	1,951	2,167	2,263
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	1,895	1,812	1,901	2,294	2,282	2,592	2,838
Санхүүгийн гүйлгээ	1,564	896	927	915	1,037	1,065	1,155
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	5,092	5,609	5,899	6,045	6,121	6,944	7,398
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал	1,407	1,387	1,390	1,433	1,434	1,435	1,450
Боловсролын салбар	2,790	2,528	2,553	2,659	2,973	3,344	3,490
Эрүүл мэнд, нийгмийн халамж	2,569	2,525	2,659	2,900	3,122	3,271	3,364
Бусад үйлчилгээ	4,873	3,597	4,404	4,681	6,326	7,748	8,470
Нийт	48,069	51,925	54,920	59,818	64,277	72,158	77,061

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, 2017

Дээрх мэдээллээс харахад бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн бараа засвар, үл хөдлөх, түрээс, барилга, боловсруулах үйлдвэрийн аж ахуйн нэгжийн тоо олон байгааг харж болно. Түүнчлэн хөдөлмөр эрхлэгчдийн тоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2.8 Хөдөлмөр эрхлэгчдийн тоо, салбараар

Салбар	2011	2012	2013	2014	2015	2016
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	342,768	369,961	329,057	310,719	327,560	348,487
Уул уурхай	45,116	46,696	50,274	40,927	42,641	38,203
Боловсруулах	65,781	64,895	80,988	85,497	81,279	86,105
Цахилгаан, хий, агааржуулалт	11,938	14,495	13,826	15,454	15,621	16,162
Усанхангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдал	5,136	6,679	7,905	7,140	5,883	6,031
Барилга	51,963	59,204	72,350	81,127	88,118	71,485
Бөөний, жижиглэн худалдаа	152,468	131,341	155,980	170,234	178,239	172,668
Тээвэр, агуулах	75,833	56,092	65,891	69,815	72,679	65,931
Зочид буудал, зоогийн газар	26,386	30,235	31,714	36,552	37,805	32,141
Мэдээлэл холбоо	11,532	14,741	16,750	17,796	15,974	18,132
Санхүү, даатгал	16,580	17,373	20,907	22,914	23,815	21,863
Үл хөдлөх	322	1,208	773	1,081	969	767
Шинжлэх ухаан, технологи	11,422	11,342	13,591	12,527	14,107	12,676
Төрийн удирдлага	9,208	13,335	15,019	12,010	15,990	15,042
Батлан хамгаалах, нийгмийн даатгал	55,611	62,919	65,280	66,143	68,093	74,179
Боловсрол	85,478	86,271	89,820	89,552	89,091	94,989
Эрүүл мэнд	36,356	37,528	40,368	37,487	38,199	40,982
Урлаг, уран сайхан	7,810	7,357	9,247	10,602	12,333	10,090
Үйлчилгээ	21,750	19,785	20,194	20,105	20,170	19,751
Бусад	1,812	1,318	1,457	1,407	950	1,059
Нийт	1,035,270	1,052,775	1,101,391	1,109,089	1,149,516	1,146,743

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, 2017

Дээрх статистик мэдээллээс харахад ХАА, ан агнуур, ойн аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, боловсрол, боловсруулах салбарт хөдөлмөр эрхлэгчдийн тоо их байгаа нь харагдаж байна. Салбар тус бүрээр нь харахад ялангуяа ХАА, ан агнуур, ойн аж ахуй, худалдаа, боловсролын салбарт хөдөлмөр эрхлэгчид төвлөрсөн шинжтэй байна.

(2) Бизнесийн орчинд хийгдсэн өмнөх ижил төрлийн судалгаа

3) МҮХАҮТ хийсэн Монголын бизнесийн орчны судалгаа

2.3-т дурдсанчлан Монгол улсын хамгийн томоохон эдийн засгийн байгууллага болох МҮХАҮТ нь 2017 онд МУИС-тай хамтран үндэсний хэмжээнд буюу нийт 21 аймаг, нийслэлийн 9 дүүргээс түүвэрлэсэн нийт 1573 аж ахуйн нэгжийн судалгаа хийн, бизнес орчинд нөлөөлөх сөрөг хүчин зүйлд шинжилгээ хийн цаашид сайжруулах арга хэмжээг тодорхойлсон байна. Бизнесийн орчны үнэлгээг 1) Дэд бүтэц, технологи, 2) Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа, 3) Эдийн засгийн орчин, 4) Нийгэм, соёл, 5) Засаглал, хууль эрх зүй гэсэн үндсэн үзүүлэлтээр үнэлсэн. Бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийн нарийвчилсан үнэлгээг а) Монгол улсад бизнес эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэл, б) Гадаад худалдаа эрхлэхэд гардаг нийтлэг хүндрэл гэсэн 2 төрлөөр авч үзсэн байна. Судалгааны дүнд Монгол улсын бизнесийн орчин бүхэлдээ муу үнэлгээг авсан байна. Гол учир шалтгаан нь засаглал, хууль эрх зүйн хэрэгжилтээс шууд хамааралтай байна. Тухайлбал, санхүүгийн зах зээл, татварын орчин, бизнесийн эрх зүйн орчин зэрэг үзүүлэлт хангалтгүй үнэлгээ авсан байна. Түүнчлэн хөрөнгийн эх үүсвэр болон бизнес эхлүүлэх зардал хамгийн их хүндрэл үүсгэдэг болох нь тодорхой болсон бөгөөд эдгээр хүндрэлийг бууруулахад бизнесийн төслийн үр ашигтай байдалд үнэлгээ хийж, барьцаа хөрөнгө шаардахгүй байх, бага хүүтэй зээлийг урт хугацаагаар олгох асуудал хэрэгцээтэй байгаа нь харагдсан. Татварын орчны хувьд татварын хувь хэмжээний шатлалыг дахин нягталж үзэх, шинээр эхэлж буй бизнесийг эхний жилүүдэд татвараас чөлөөлөх асуудлыг санал болгон дэвшүүлсэн байна.

Гадаад худалдаа эрхлэх тал дээр тээвэрлэлтийн зардал болон тээвэрлэх хугацаа, мэргэжлийн хяналтын дүгнэлт авах процесс хамгийн их хүндрэл үзүүлдэг болох нь тодорхой болсон. Эдгээрийг шийдвэрлэхэд татварын дарамтыг багасгах, оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлдэг байх, зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк, санхүүгийн зээл авах процессыг хялбаршуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, авлига, хээл хахууль, хүнд суртлыг арилгах, шударга өрсөлдөөн, тогтвортой төрийн бодлого явуулах, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлууд тавигдсан байна. Мөн ДНБ-ний 17.8%, нийт ажил эрхлэгчдийн 57% буюу 80 гаруй мянган ажлын байр бий болгож, Монголын нийт аж ахуйн нэгжийн 86% эзэлж буй 67,612 ЖДҮ-ийг дэмжсэн тусгайлсан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дурдсан байна.

2) Монголбанкнаас хийсэн ЖДҮ-ийн түүвэр судалгаа

ЖДҮ-ийн хувьд Монголбанк 2014 оноос эхлэн жил бүр ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн судалгаа явуулж байна. 2017 онд хийгдсэн судалгааны дүнгээс харахад нийт улсын эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан эргэлтийн хөрөнгөөр дутагдах, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх, цаашид үйлдвэрлэлээ өргөтгөхөд санхүүжилтийн бэрхшээл тулгарч байгаа нь тодорхой болсон байна. Түүнчлэн ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй бус, олдоц бага байгаа тул ихэвчлэн арилжааны банкнаас зээл авдаг байна. ЖДҮ эрхлэгчид 1-5 жилийн хугацаатай 10-50 сая төгрөгийн санхүүжилт авах сонирхолтой байдаг байна. Тулгамдаж буй асуудлын тухайд макро эдийн засгийн орчны зүгээс валютын ханш болон инфляц, нийгмийн орчны зүгээс ядуурал болон ажилгүйдэл, хуулийн орчны зүгээс хуулийн сул хэрэгжилт болон төрийн байгууллагын үйлчилгээ хамгийн их хүндрэл учруулдаг болох нь харагдаж байна.

Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд 1) Төр, хувийн хэвшлийн харилцааг хууль, журмын хэмжээнд явуулж, хүнд суртлыг бууруулах, авилгыг арилгах, 2) Хөнгөлөлттэй зээлд хамрагдах тэгш байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олгох явцыг ил тод болгох, ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийг салбаруудад төрөлжүүлэх, 3) шинээр бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны эхний үе шатанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж үйл ажиллагаа нь тогтворжсон үед татвар ногдуулах, 4) Дотоодод үйлдвэрлэх бүрэн боломжтой хэдий ч импортоор авч хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүний хувьд татварын болон бусад зохицуулалт арга хэмжээг авч хэрэгжүүлэн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих, 5) Валютын ханшийн хэлбэлзлийг бууруулахад төрийн бодлого чиглэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна

3 Зээлийн мэдээллийн хяналтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

3.1 Монгол улсын санхүүгийн тогтолцооны өнөөгийн байдал


(1) Банк/ санхүүгийн байгууллагуудын өнөөгийн байдал

1) Монголбанк

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкыг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Монголбанк Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

- Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах
- Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших

Зураг 3.1.1-т Монголбанкны бүтэц зохион байгуулалтыг үзүүлэв.



Эх сурвалж: Монголбанк 2017 оны Жилийн тайлан

Зураг 3.1 Монголбанкны бүтэц зохион байгуулалтын зураг

Зээлийн мэдээллийн хяналттай холбоотой үйл ажиллагаа явуулдаг хяналт шалгалтын газар (Supervision Department, Division of Monitoring and Financial Services), Судалгаа, статистикийн газар (Research and Statistics Department Research Division), Мэдээлэл технологийн газар (Information Technology Department) тус бүрийн үүрэг, үйл ажиллагааны талаар доор дурдав⁸.

(i) Хяналт шалгалтын газар, Мониторинг санхүүгийн үйлчилгээний хэлтэс

Хяналт шалгалтын газар нь банкны байгууллагын үйл ажиллагаанд тавих Монголбанкны хяналтыг хэрэгжүүлж, Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, удирдлага, үйл ажиллагаанд нь тавих шаардлага, санхүү төлбөрийн чадварын зохистой харьцааг тогтоох замаар санхүүгийн системийн үйл ажиллагааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Банкны тухай хууль тогтоомж, төрийн мөнгөний бодлого болон Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр, баталсан журам, зааврыг банкны байгууллага хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийх, үйл ажиллагаа, санхүү төлбөрийн байдалд нь үнэлэлт дүгнэлт өгч, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авах.
- Банкны байгууллага, түүний нэгж байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хүссэн иргэд, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч хянах, энэ талаар болон тэдгээрийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон асуудлаар санал дүгнэлт боловсруулж удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Санхүүгийн байгууллагуудын зохион байгуулалт, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны ажиглалт, санхүүгийн тайлангийн мэдээллийн судалгаа шинжилгээ хийх. Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага, холбогдох байгууллагуудаас гаргасан мэдээлэл, тайлангийн судалгаанд үндэслэсэн эдийн засгийн дүн шинжилгээ, тандалтыг хийдэг.
- Зээлийн мэдээллийн санд мэдээлэл хүлээн авч хянах, мэдээллийг холбогдох байгууллагад зохих журмын дагуу хүргүүлэх, сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийг нь баяжуулах арга хэмжээ авах, программ хангамж, техник тоног

⁸ Монголбанкны цахим хуудаснаас (<https://www.mongolbank.mn/>)

төхөөрөмжийг сайжруулах талаар саналаа холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

- Хяналт шалгалтын ажлын үр өгөөж, чанарыг дээшлүүлэх, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд мэдээлэх ажлыг холбогдох газартай хамтран зохион байгуулах.
- Банкны үйл ажиллагааны талаарх харилцагч, хадгаламж эзэмшигчийн өргөдөл, гомдлыг барагдуулах, цагдаа, хууль хяналтын байгууллагын удирдлагын хүсэлтээр шалгалт хийх , шинжээчээр ажиллан дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Хяналт шалгалттай холбогдсон асуудлаар олон улсын банкны байгууллагуудтай хамтран ажиллах

(ii) Судалгаа статистикийн газар

Судалгаа, статистикийн газар нь Монголбанкны статистикийг боловсруулж олон нийтэд мэдээлэх, Монголбанкны бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц эдийн засаг, санхүүгийн салбарын холбогдолтой судалгааны ажлыг гүйцэтгэх үндсэн үүрэгтэй дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

- Монголбанкны бодлого боловсруулах, мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бодлогын суурь судалгаа болон эмпирик судалгааг хөгжүүлэх
- Гадаад, дотоодын эдийн засгийн орчин, мөнгөний бодлого, валютын ханш, төлбөрийн систем, гадаад секторын тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдал зэрэг чиглэлээр өргөн хүрээнд судалгаа, шинжилгээний ажил хийх, судалгааны тоон мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, баяжуулах
- Судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэсэн бодлогын зөвлөмжүүд боловсруулах, Монголбанкны бодлогын хэрэгжилтийн үр нөлөөнд шинжилгээ-үнэлгээ хийхэд чиглэсэн судалгаа хийж, санал боловсруулах
- Төлбөрийн тэнцлийн төсөөллийг гүйцэтгэх, Статистикийн хэлтэстэй хамтарч түүвэр судалгаа хийх

- Зөвшөөрөгдсөн судалгааны ажлуудыг хэвлэн нийтлүүлэх, илтгэл хэлбэрээр хурал, зөвлөгөөнд танилцуулах, зөвлөмж байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлэх
- Судалгааны чиглэлээр гадаад, дотоодын холбогдох байгууллагатай хамтран ажиллах

(iii) Мэдээллийн технологийн газар

Монголбанкны мэдээллийн технологийн бодлого, чиглэлийг тодорхойлох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, найдвартай ажиллагааг ханган ажиллах, банкны системийн мэдээллийн технологийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн заавар, зөвлөгөө боловсруулах зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Банкны системийн мэдээллийн технологийн хэтийн чиглэлийг тодорхойлох, зөвлөмж, стандарт, шаардлагуудыг гаргах
- Монголбанкны мэдээллийн технологийн бодлого болон хэтийн чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх
- Монголбанкны хэрэгцээнд програм хангамж боловсруулах, шинэ технологи судлах, нэвтрүүлэх болон холбогдох сургалтыг зохион байгуулах
- Монголбанкинд ашиглагдаж байгаа сүлжээний найдвартай ажиллагаа, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, нууцлалыг хариуцах
- Монголбанкны компьютерийн техник хангамжийн захиалга, суурилуулалт, туршилт, тэдгээрийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцах

Дээр дурдсан гурван газраас хяналт шалгалтын газар нь одоогийн зээлийн мэдээллийн сангийн систем болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж⁹ буй ЗМС-ийн аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл бусад холбогдох бүхий л үйл ажиллагааг хариуцна. Мэдээллийн технологийн газар нь зээлийн мэдээллийн сангийн техникийн хангамж системийн үйл ажиллагааг хариуцдаг. Энэхүү судалгаагаар зээлийн мэдээллийн хяналтын талаар мэдээлэл солилцох, санал солилцох зорилгоор хамтарсан ажлын хэсэг (JWT) байгуулж хамтран ажилласан. Ажлын хэсгийг

⁹ Зээлийн мэдээллийн тухай хуулийн 3-р бүлэгт ЗМС-ын үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаа, эрх, үүргийг талаар дурдсан байгаа. Тэр дундаа үйл ажиллагаа эрхлэх, зээлийн мэдээлэл цуглуулах, ЗМС-ийн баазыг бий болгон үйл ажиллагааг явуулах, зээлдэгчийн эргэн төлөх чадавхын үнэлгээ, зээлийн мэдээллийн холбогдох эдийн засгийн дүн шинжилгээ, зах зээлийн судалгаа, болон бусад Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд зээлийн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааны талаар зааж өгсөн байна.

байгуулахтай холбогдуулан зээлийн мэдээллийн сантай нягт хамааралтай газраас сонгож өгөх хүсэлтийг Монголбанкнд тавихад дээрх гурван газрыг санал болгосон (хамтарсан ажлын хэсгийн хийсэн 4 удаагийн уулзалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн хэсэгт дурдана).

2) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь салбарын үйл ажиллагааны бодлогыг боловсруулахаас гадна, харьяа газрын бодлого хэрэгжилтийг хянах, төсвөөр хангах үйл ажиллагаатай холбоотой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЖДҮ-ийн бодлогыг хариуцсан Жижиг дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газар байдаг. Жижиг дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн зорилтын хүрээнд ЖДҮ-ийн санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд ач холбогдол өгч ажиллаж байгаагаас гадна чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангууд нь ХХААХҮЯ-ны харьяа эрх бүхий байгууллага юм.

ХХААХҮЯ-нд энэхүү судалгааны зорилготой нийцэх ЖДҮ-ийн мэдээллийн сантай юм. ЖДҮ, хоршооллын бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд ЖДҮ-ийн эрхлэгчдийн хүсэлтийг үндэслэн ЖДҮ гэдгийг батлах гэрчилгээг олгодог ба бүрдүүлэх баримт бичигт ЖДҮ эрхлэгч ААН-ийн мэдээлэл тусгагдсан байдаг тул тэрхүү мэдээллүүд нь хуримтлагдсан байдаг. ЖДҮ-үүд өөрсдийн хүсэлтээр ЖДҮ эрхлэгч мөн гэдгээ нотлохын тулд гэрчилгээ авах хүсэлтийг гаргадаг.

3) Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан нь 1993 онд АНУ-аас Монгол улсад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тусламж үзүүлэх тухай хэлэлцээрийн дагуу ХХААХҮЯ-ны жижиг дунд үйлдвэрийн хэлтэс нэртэйгээр байгуулагдсан. 2000 онд Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Үйлдвэр, худалдааны сайдын тушаал Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг өөрийгөө санхүүжүүлж, бие даасан хэлбэрээр ажиллуулахаар шинэчлэн зохион байгуулснаар өнөөдрийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эхлэл тавигдсан гэж үздэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2009 оны 1 тоот тушаалаар “Хүнс, хөдөө аж ахуй,

хөнгөн үйлдвэрийн яам”-ны “ЖДҮ-ийг хөгжүүлэх сан” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан¹⁰.

Тус сан нь одоогоор санхүү, хөрөнгийн хэлтэс, тамгын хэлтэс, зээл, төслийн хэлтэс гэсэн гурван хэлтэстэй 25 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. ЖДҮ-ийн тухай хуульд заасан хөдөө аж ахуйн салбараас гадна бусад салбарын хувиараа бизнес эрхлэгч, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжид санхүүжилт олгодог. Уул уурхай, тамхи, архи, ус, ундааны үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, төрийн бус байгууллага санхүүжилтэд хамрагдахгүй. Сум Хөгжүүлэх сан нь барьцаа хөрөнгө хүрэлцэхгүйгээс болоод санхүүжилт авах боломжгүй ЖДҮ-т гадна 20 сая хүртэлх төгрөгийн санхүүжилт олгодог бичил санхүүгийн сан юм. 2011 онд 84 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 2017 оны 140 тэрбум болж өссөн байна.

4) Сангийн яам

Сангийн яам нь Монгол Улсын санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийнхээ амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэн мянганы хөгжлийн зорилт, үзүүлэлтийг биелүүлж, цаашдаа хөгжингүй орнуудын дундаж жишигт хүргэх алсын хараатайгаар ажилдаг. Сангийн яам нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангах эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.


- Алсын хараа, эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд нэн тэргүүнд хийх үйл ажиллагаа доор харуулав.
- Санхүү, төсвийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах.
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсонгүй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг

¹⁰ ЖДҮ хөгжүүлэх сангийн цахим хуудас (<http://smefund.gov.mn/en/news/15/single/31>)

дээшлүүлэх

- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх.

Сангийн яамны бүтэц зохион байгуулалтын зургийг Зураг 3.1.2-д харуулав.



Тайлбар: Зураг дээрх тоо нь 2018 оны 3-р сарын байдлаар ажиллагсдын тоо

Зураг 3.2 Сангийн яамны бүтэц зохион байгуулалт

Сангийн яам нь санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлт, тэр дундаа бодлогын хувьд шаардлагатай санхүүгийн байгууллага, санг үүсгэн байгуулах зэрэг санхүүгийн бодлогын хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зээлийн мэдээллийн хяналт, санхүүгийн байгууллагуудын хяналыг хэрэгжүүлэх үүргийг Монголбанк хариуцан ажилладаг.

1960 оноос одоог хүртэл аж ахуй нэгж байгууллагууд санхүүгийн тайлангаа Сангийн яаманд тушааж байгаа. Сангийн яамны санхүүгийн тайлангийн мэдээллийн сан, Монголбанкны зээлийн мэдээллийн санг ирээдүйд нэвтрүүлэх системтэй холбогдох боломжтой талаар дараагийн хэсэгт дурдах болно.

5) Монголын Банкны Холбоо (МБХ)

Монголын Банкны Холбоо нь 2000 онд Монголбанкнаас албан ёсоор зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм. Тус Холбоо нь Монгол Улсын банкны салбарын хөгжлийг дэмжих, санхүүгийн салбарын дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор банкны салбарыг төлөөлөн салбарын ашиг сонирхол, бодлогын талаар хэлэлцэж, гишүүддээ салбарын холбогдох бодлогын талаарх мэдээлэл солилцох боломжоор хангах зорилгоор үүсгэн байгуулагдсан¹¹. Монголын Банкны Холбоо нь 24 гишүүнтэй ба арилжааны 14 банк¹², Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Сумитомо Мицуи банкны корпорацийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Токио Мицүбиши банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Банк оф Чайна Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Юнион Пэй Интернейшнл, Зээлийн мэдээллийн төв ХХК, Банк санхүүгийн академи, Монголын ипотекийн корпораци ХХК зэрэг компаниудыг эгнээндээ нэгтгэсэн. Монголын Банкны Холбоо нь Монголын банкны салбарыг хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор дараах байгууллагуудтай хамтран санхүүгийн салбарын бодлогын орчин, дэд бүтцийг бий болгох чиглэлээр хамтран ажиллаж байна.

- Банк, санхүүгийн академи The Banking and Finance Academy
- Зээлийн батлан даалтын сан (The Credit Guarantee Fund)¹³
- Зээлийн Мэдээллийн Төв ХХК (Credit Information Bureau CIB LLC)
- Монголын Ипотекийн Корпораци (Mongolian Mortgage Corporation)

Сүүлийн жилүүдэд Монгол улсад хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй санхүүжилтийн (environmentally and socially (E&S) finance) бодлогыг хэрэгжүүлэхээр 2015 “Монгол Улсын

¹¹ Монголын Банкны Холбоо HP <http://mba.mn/what-is-mba/>

¹² Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Сумитомо Мицуи банкны корпорацийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Токио Мицүбиши банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Банк оф Чайна Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Юнион Пэй Интернейшнл, Зээлийн мэдээллийн төв ХХК, Банк санхүүгийн академи, Монголын ипотекийн корпораци ХХК зэрэг компаниуд

¹³ Монгол улсын санхүүгийн салбарын дэд бүтцийн суурь судалгаанд “Зээлийн батлан даалтын сагаас гадна засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монгол ажил олгогч эздийн холбоо хамтран 2012 оны 11 сард зээлийн батлан даалтын санг LGF байгуулсан гэж бичсэн байсныг зээлийн батлан даалтын санд хийсэн уулзалтын үеэр тодруулахад CGFM-ын тухай бичсэн байсан цахим хуудас нь LGF нэртэй байсан.

Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөр”-ийг Mongolian Sustainable Finance (ТоС) Principles хэрэгжүүлэх шийдвэр гарснаар банкны зээлийн шийдвэр гаргалтад хүрээлэн буй орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийг илүү анхааран үзэх болсон. Энэхүү үзэл баримтлалтай холбогдуулан монголын банкны холбоо нь “Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого”-ыг хөгжүүлэн дэмжих зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам болон холбогдох байгууллагатай хамтран Монгол улсын бусад холбогдох байгууллагуудтай хамтран Монгол улсын анхны Ногоон зээлийн санг байгуулахаар ажиллаж байна¹⁴.

Монголын банкны холбооны одоогийн тэргүүнээр Голомт Банкны Гүйцэтгэх Захирал Ганзориг ажиллаж байгаа ба гүйцэтгэх захирал нарын бичгийн даргаар Монголбанкны ерөнхийлөгч асан Ж.Үнэнбат ажиллаж байгаа. Дашрамд дурдахад энэхүү судалгааны хүрээнд зохион байгуулсан компанийн засаглалын семинарын модератор, панелистаар оролцож хамтран ажилласан болно.

б) Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)

Зээлийн батлан даалтын сан нь 2010 онд үүсгэн байгуулагдсан хэдий ч “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль” батлагдсанаар 2013 оноос эхлэн албан ёсоор үйл ажиллагааг явуулж эхэлсэн¹⁵ ба одоогоор 35 ажилтантай. Зээлийн батлан даалтын санг Монгол Улсын засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран барьцаа хөрөнгийн дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд батлан даалт гаргах зорилготойгоор ашгийн төлөө бус байгууллагаар үүсгэн үүсгэн байгуулагдсан. Тус сан нь улсын төсвөөс 50 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр санхүүжиж одоогоор нийт 536 аж ахуй нэгжид зээлийн батлан даалтыг гаргасан байна¹⁶. Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын хүсэлт гаргахад шаардлагатай материал 1) батлан даалтын санд хамрагдах хүсэлт, ЗБДС-тай гэрээтэй банкаар дамжуулан гаргах, 2) Жижиг дунд үйлдвэрлэгчийн гэрчилгээ, тодорхойлолт, шаардлагатай бичиг баримт (барьцаа хөрөнгө 40% ба түүнээс дээш байх, эргэн төлөх чадавх), 3) Банкны зээл олгох шаардлагыг хангасан зээлийн төслийг зээлийн батлан даалтын санд шилжүүлэн хүсэлт гаргана (Шаардлагатай баримт бичгийг хавсаргав), 4) Зээлийн батлан даалтын сан хүлээн авсан баримт бичгийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны чиглэл (Газар дээрх үзлэг хийдэг), барьцаа хөрөнгө (Банкны шаардлагад) зээлийн зорилгыг харгалзан

¹⁴ <http://mba.mn/projects-and-initiatives/>, <http://mba.mn/mongolian-sustainable-finance-mongolia/>

¹⁵ Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 оны 2 сарын 10-с хэрэгжиж эхэлсэн ба Зээлийн батлан сан нь 2012 оны 11 сард албан ёсоор үүсгэн байгуулагдсан.

¹⁶ 2018 оны 3 сарын 15 ний өдөр Зээлийн батлан даалтын сангийн батлан даалт зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэнтэй хийсэн уулзалтаас.

үзэж эцсийн шийдвэрийг гаргадаг. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд батлан даалтын дүн нь зээлийн дүнгийн 60%-аас хэтрэхгүй байх, барьцаа хөрөнгийн дутагдлыг батлан даана гэж заасан байна. Сангийн яам, ХХААХҮЯ тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд барьцаа хөрөнгийн 60%-ийг 80% болгон нэмэх талаар хэлэлцэж байгаа. Батлан даалтын нөхцөл нь ЖДҮ-ийн өгсөн барьцаа хөрөнгийн харьцаа (40% эсвэл 60% хүртэлх) үл хамааран батлан даалтын нөхцөл нь өөр өөр байдаг. Зээлийн батлан даалтын сангаас гаргасан бичиг баримтаас үзэхэд дагуу ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжид саад болж буй зүйлсийг дараах байдлаар онцолсон байна.

- ЖДҮ-үүд барьцаа хөрөнгийн дутагдалтай
- Банкуудын санал болгож буй урт хугацааны зээлийн хэмжээ хангалтгүй
- Банкууд урт хугацааны зээл олгох санхүүгийн чадавх хязгаарлагдмал
- Зээлийн мэдээллийн бааз хангалтгүй
- Зээл авах шалгуур өндөр
- ЖДҮ нь санхүүгийн мэдлэг дутмаг
- Банкнуудын зээл судлах, гаргах чадвар дутмаг

Улаанбаатар хотод арилжааны банкнуудтай хийсэн уулзалт судалгаанаас үзэхэд эдийн засгийн хямралын дараа бага зэрэг өөрчлөлт гарсан хэдий ч Монголын арилжааны банкнууд Оюу толгой зэрэг томоохон аж ахуй нэгжтэй ханган нийлүүлэх гэрээ хэлэлцээр хийсэн аж ахуй нэгжид олгох зээлээс бусад бүх зээлийг барьцаа хөрөнгө, батлан даалттайгаар олгодог. Үүнээс гадна ЖДҮ-ийн санхүүгийн тайлангийн үнэн зөв бодитой байдал муутай, санхүүгийн бодит байдлыг тодорхойлж, сайтар ойлгоход цаг хугацаа, зардал шаардагдах болно. Ер нь арилжааны банкууд ЖДҮ-ийн хэрэгцээ шаардлагад нийцсэн урт хугацааны санхүүжилт, санхүүжилтийн талаар болгоомжтой хандаж байдаг.

АХБ-аас зээлийн батлан даалтын санд хэрэгжүүлж байгаа техникийн хамтын ажиллагаа (9000 MON) болон (Loan 3338 MON) хөнгөлөлттэй зээлийн зорилго нь ЖДҮ-ийн санхүүжилтэд чиглэсэн байдаг. Өмнө нь зээлийн батлан даалтыг барилгын салбарын ЖДҮ-д түлхүү олгодог, бусад салбарын ЖДҮ-д гаргах батлан даалтын хэмжээ өсөхгүй байна гэсэн асуудал их гарч байсан. 2015 онд АХБ-тай техникийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан ч ОУВС-ийн

эдийн засгийг дэмжих өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэлэлцээр¹⁷, АХБ-ны нөхцөл, шаардлагыг хангасан арилжааны банктай хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг асуудлуудаас шалтгаалан хойшилж 2017 оноос батлан даалтын ажил эхэлсэн.

АХБ-аас ЗБДС-тай хамтарсан техникийн хамтын ажиллагааны төслийн үндсэн зорилго нь барилгын салбараас бусад салбар болон ЖДҮ-г чиглэсэн батлан даалт гаргах үйлчилгээг өргөжүүлэх хөгжүүлэх бөгөөд 2017 оны 9-р сараас Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хас банк, Хаан банк Капитал банктай хамтран ажиллаж эхэлсэн. Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын гэрчилгээ нь арилжааны банкнуудад учруулах эрсдэлийг багасган сайжруулах, энэхүү төслөөр нийт 60 сая ам долларын төсөвтэй, батлан даалтын хөрөнгийг арилжааны банкинд урьдчилан хадгалуулах ба зээлийн хэмжээний 10% буюу 6.6 сая ам.долларыг улс баталгаа гаргана.

ЗБДС нь одоогоор хоёр төрлийн батлан даалт гаргах үйлчилгээг үзүүлж байгаа. ЖАЙКА-ийн хоёр үе шаттай хөнгөлөлттэй зээл, ЖДҮ хөгжүүлэх сангийн зээл зэрэгт ашигладаг батлан даалтын гэрчилгээ олгодог хуучин батлан даалтын үйлчилгээний хэлбэр, АХБ-ны техникийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж буй батлан даалт нь хуучнаасаа илүү сайн нөхцөлтэй 5-10 жилийн хугацаатай жилийн 12-15% хүүтэй зээл олгодог батлан даалтын хэлбэр юм. Зээлийн нийт дүнгийн 60%-тай тэнцэх батлан даалтыг гаргадаг тал дээр өмнө нь байсан хэлбэртэй адилхан. Нийт 60 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэх ба дээр дурдсанчлан ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэлэлцээртэй холбоотойгоор бага зэрэг хоцорсон. Одоогийн байдлаар 92 ЖДҮ эрхлэгчдэд 32 тэрбум төгрөгийн зээлийн 16,7 тэрбум төгрөгийн батлан даалтыг (60-70% ААН, 78% нь УБ хот, үлдсэн 22% нь орон нутгийн ЖДҮ эрхлэгч) хийсэн. Батлан даалтын зээлийн саналын доод хэмжээ 10 сая төгрөг бол батлан даалтын хэмжээ 5 сая төгрөг юм байна.

ЗБДС-ийн батлан даалт нь барьцаа хөрөнгийн дутагдалтайгаас санхүүгийн байгууллагаас зээл, хөрөнгө оруулалт авах боломжгүй ЖДҮ-ийн санхүүгийн байдлыг сайжруулах зорилготойгоор эхлүүлснээс хойш, банк санхүүгийн байгууллагаас ЗБДС-ийн батлан даалт гаргуулсан ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлт хоцорч, ЗБДС-аас эргэн төлөлтийн хэрэгжилтийг нэхэмжлэх тохиолдолд, ЗБДС нь батлан даалтыг хэрэгжүүлэх хүсэлт гаргаснаас хойш гомдол их гарсан.

¹⁷ 2016 оны хоёрдугаар хагасаас хойш Монгол улсын засгийн газар Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэлэлцээр хийж эхэлсэн ба 2017 оны 2-р сарын 19-нд дэмжлэг үзүүлэх шийдвэр гарсан.

АХБ-ны техникийн хамтын ажиллагааны зээл нь банкны эрсдэлийг багасгах зорилготойгоор зээлийн батлан даалтын сангаас арилжааны банканд урьдчилан батлан даах үнийн дүнг шилжүүлдэг.

ЗБДС нь ЖДҮ-ийн барьцааны хомсдолыг нөхөх зорилгоор батлан даалтын гаргадаг тул үндсэндээ барьцаа хөрөнгө шаарддаггүй ч барьцаа хөрөнгө тавих тохиолдолд барьцаа хөрөнгийн эзэмшигч нь зээлдэгч дангаараа эзэмшиж өөр хэн нэгэнтэй хамтран эзэмшээгүй байх, зээл олгох дарааллыг чанд мөрдөхийг удирдлага болгож байна.

Батлан даалтын дээд хязгаарыг 60%-аас 80% болгон нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн саналыг боловсруулан 5-р сарын 4-ний өдөр УИХ-д ХХААХҮЯ-наас өргөн барьсан боловч Сангийн Яамны ажлын хэсгийн ажил бага зэрэг удаашралтай байгаа. Батлан даалтын хязгаарыг 80% болгон нэмэгдүүлснээр хамрагдах ЖДҮ-ийн тоо ихээхэн өснө гэж үзэж байгаа боловч нөлөөллийн талаарх тооцоолол хийгээгүй байна. 2017 оны 11-р сараас хойш нийтдээ 712 ААН -ээс батлан даалт гаргуулах хүсэлт гаргасан боловч, 3/2 нь банкны зээлийн судалгааны шаардлагыг хангаагүйн улмаас түдгэлзүүлсэн байна.


7) Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) нь 2006 онд СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд үндэслэн үүсгэн байгуулагдсан ба үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага зэрэг 1000 гаран компанид хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Монголбанкнаас хяналт тавьдаг арилжааны банкнуудаас бусад бүх санхүүгийн байгууллагад хяналт тавьдаг. Үнэт цаасны зах зээлтэй холбогдох МХБ, Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТ), үнэт цаасны компани (брокер дилерийн компани (брокер)-ийн үйлчилгээ, арилжаа (дилер) үйл ажиллагаа, арилжаа (андеррайтер)-ийн үйл ажиллагаа), даатгалын компани, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үнэлгээний компани гэх мэт өргөн хүрээтэй. СЗХ-ны хэрэгжүүлэх чиг хүрээнд өнөөгийн байдлаар дараах үйл ажиллагааг явуулж байна.

- Үнэт цаасны зах зээлийн дүрэм, стандарт, журмууд зэрэг хууль эрх зүйн орчин бүрдүүлэх
- Хөрөнгийн биржид хувьцаагаа гаргах гэж буй компани, үнэт цаасны компани зэрэг санхүүгийн тайланг цуглуулах, дүн шинжилгээ хийх, зохистой байдлыг шалган хянах

- Үнэт цаасны зах зээл дэх хууль эрхзүйн зохицуулалтын нийцлийн байдлыг хянах (Хэрэгжилтийн судалгаа)
- Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хасах
- Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах
- Маргаан шийдвэрлэх
- Компанийн засаглалыг сайжруулах ажлыг хөхүүлэн дэмжих
- Санхүүгийн зах зээлийн оролцогч хөрөнгө оруулагч нарт зориулсан сургалт

СЗХ-ны бүтэц зохион байгуулалт зургийг зураг 3.1.3-д үзүүлэв.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.3 Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц

СЗХ нь 10 төрлийн тусгай зөвшөөрлийг олгодог ба 537 зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гаргаснаас 480 аж ахуй нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа (Үүнд; Факторинг, валют арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ААН хамаарна). СЗХ нь тусгай зөвшөөрөл олгосон банк бус санхүүгийн байгууллагын харилцагчийн зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд мэдээлэх шаардлагыг тавьж байгаа хэдий ч орон нутгийн интернет, дэд бүтцийн орчин бүрдээгүй зэрэг асуудлаас шалтгаалан нийт ББСБ-ийн 80% нь мэдээлдэг.

2018 онд бүх банк ББСБ-ыг зээлийн мэдээллийн сантай холбохоор зорин ажиллаж байгаа.

Банк бус санхүүгийн байгууллагын чадавхийг сайжруулахаар 1) Нийт хөрөнгийн доод хэмжээг 2,5 тэрбум (2016 оны байдлаар) болгон нэмэгдүүлэх, 2) Зээлийн хүүг бууруулах, 3) Өрсөлдөх чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 зорилт тавьж ажиллаж байна.

8) Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо

Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо нь 2002 онд үүсгэн байгуулагдсан ба банк бус санхүүгийн байгууллагууд сайн дураар нэгдсэн, төрийн бус бие даасан, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилж эрх ашгийг хамгаалах зорилготой төрийн бус байгууллага. Тус холбоо нь 2002 онд үүсгэн байгуулагдсан боловч 2007 оноос идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. СЗХ-нд даатгал, хадгаламж зээлийн хоршооны холбоог хариуцан чиглэл өгдөг. Тус холбоонд зөвхөн ББСБ хамааралтай байдаг. Одоогоор Монгол улсад 534 банк бус санхүүгийн байгууллага бүртгэлтэй байдаг ба 230 аж ахуй нэгж ББСБ-ын тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан байна.

Банк бус санхүүгийн байгууллагад СЗХ-оос хяналт тавин ажилладаг ч холбоо нь салбараа төлөөлөн СЗХ-той санал солилцох, харилцан зөвлөлдөх, холбооны гишүүд байгууллагуудын үйл ажиллагаа явуулах орчин, чадавхыг сайжруулахаар харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Харилцан ойлголцлын санамж бичигт ББСБХ нь дараах 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар СЗХ-той зөвшилцсөн. 1) банк бус санхүүгийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох, 2) Холбооны гишүүдийн хууль ёсны эрх ашгийг бодлого зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагын өмнө хамгаалж оролцох, 3) Банк бус санхүүгийн байгууллагуудын ажилтныг сургах, давтан сургах сургалтыг зохион байгуулах.

Дээрх гурван үйл ажиллагаанд зээлийн аргачлалын талаар дэлгэрэнгүй зааварчилгааг ББСБХ-оос ББСБ-уудад өгдөггүй. СЗХ-оос ББСБ-ын хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулдаг ба холбоо энэхүү үйл ажиллагаанд оролцдоггүй.

(2) Банк санхүүгийн байгууллага ба зээлийн тогтолцоо

1) Холбогдох байгууллага

Монгол улсын зээлийн тогтолцоо болон зээл олгох үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага гэвэл арилжааны банк, банк бус, санхүүгийн байгууллага, лизингийн компаниуд, төрөл бүрийн санг дурдаж болно. Арилжааны банкны хувьд Монголбанкнаас үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрөл авах шаардлагатай байдаг ба 2018 оны 6-р сарын байдлаар 11 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байна. Харин ББСБ-ын хувьд СЗХ-оос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай байдаг бөгөөд 2018 оны 6 сарын байдлаар 537 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосноос 480 байгууллага нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Лизингийн компанийн хувьд СЗХ-ны хяналтын доор байдаг ч үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шаардлагагүй бөгөөд аж ахуй нэгжийн тоо тодорхойгүй байна.

Санхүүгийн салбарыг бүхэлд нь авч үзэхэд дээр дурдсан байгууллагаас гадна үнэт цаасны компани, даатгалын компани, хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ) зэрэг байгууллагууд хамрагдана.

2) Зээлийн ангилал

Арилжааны банк болон ББСБ-ын хувьд зээлийг байгууллагын зээл, иргэний зээл гэж ерөнхийд нь хоёр хувааж, зээлийн бүтээгдэхүүний хөгжил, зээл шийдвэрлэх эрх, зээлийн удирдлагаар ханган ажилладаг. Энэ ангилал нь банкны бүтээгдэхүүн хөгжүүлэх, санхүүгийн тайланг авах хэрэгцээ шаардлага болон Монголбанкны статистик мэдээнд ч нийтлэг ашиглагддаг. Энэхүү судалгаагаар зээлийн мэдээллийн хяналт, тэр дундаа ЖДҮ, аж ахуй нэгж байгууллагын зээлийг голчлон анхаарч судалсан хэдий ч Монголд ЖДҮ-д олгох зээлийг тухайн байгууллагын захирал болон үүсгэн байгуулагч нь хувь хүний буюу иргэний зээлээр шийдвэрлэх тохиолдлууд их байдаг тул ялгаж ангилахад хүндрэлтэй юм. Ийм учраас зээл тус бүрийн агуулгыг нэгтгэн дүгнэхийн тулд ерөнхий ангиллаар хуваан дараах байдлаар харуулав.

• Байгууллагын зээл

Байгууллагын зээл (Corporate loan) -ийн хувьд банк болгон тус бүрийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан байдаг. Арилжааны банкууд зээлийн бүтээгдэхүүнийг гаргахдаа банк тус бүрийн харилцагчийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэхээс гадна олон улсын байгууллагуудын төслийн зээлийн санхүүжилт байх тохиолдолд тэдгээрийг хослуулан санал болгодог. Монголын дөрвөн том арилжааны банкны жишээнээс харахад шугамын зээл, тоног төхөөрөмжийн зээл, Оюу Толгойн ханган нийлүүлэгчдэд зориулсан зээл, бичил бизнесийн зээл, бизнесийн дэмжлэгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, ажил эрхлэлтийг дэмжих сангийн төслийн зээл, АХБ-ны хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн зээл, KfW банкны ажил эрхлэлтийг дэмжих төслийн зээл, ЖАЙКА-ийн хоёр үе шаттай зээлээс гадна, арьс ширний үйлдвэрлэгчдэд зориулсан зээл, овердрафт зээл

зэрэг зээлийн бүтээгдэхүүнүүд байдаг.

Байгууллагын зээлийн зээлийн үнэлгээ нь аж ахуй нэгжийн нэр дээр зээлийн хүсэлт гаргасан тохиолдолд хийгдэнэ. Энэ тохиолдолд ямар ч санхүүгийн байгууллагад сүүлийн хэдэн жилийн¹⁸ санхүүгийн тайланг баталгаажуулах шаардлагатай байдаг.

Монголбанкнаас гаргасан статистикийн үзүүлэлтээс харахад “ байгууллагын зээл” нь арилжааны банкууд аж ахуй нэгжийн нэр дээр олгосон зээлийн дүн, тоо хэмжээг нэгтгэн гаргасан байдаг.

- Иргэний зээл

Хувь хүнд зориулсан (иргэний) зээлийн бүтээгдэхүүнийг ангилахдаа банкууд 10 гаруй төрлийн бүтээгдэхүүн болгон хуваадаг. Үүнд, картын зээл, цалингийн зээл, малчны зээл, автомашины зээл, сургалтын төлбөрийн зээл зэрэг, хэрэглээний зээлүүд, ЖДҮ, бичил бизнесийн зээл, эргэлтийн хөрөнгийн зээл гэх мэт бизнесийн холбоотой зээлийн бүтээгдэхүүн олон байдаг.

Иргэний зээлийн зээлийн судалгаанд зээл хүсэгч хувийн хүний нэр дээр хүсэлт гаргасан байх ёстой ба анхнаасаа бизнес эрхлэгчдэд чиглэсэн зээл биш учраас зээлийн судалгааны явцад заавал санхүүгийн тайланг авна гэсэн үг биш юм. Гэсэн хэдий ч хувь хүний нэрээр иргэний зээл авсан этгээд нь бизнес эрхэлдэг тухайн зээлийн хэрэглээнээс хамааран зээл хариуцсан эдийн засагчийн шийдвэрээс шалтгаалан тухайн зээлдэгчийн эрхэлж буй аж ахуй нэгжийн санхүүгийн тайланг авах хүсэлт¹⁹ тавьж болно.

- Байгууллагын болон иргэний зээлийн ялгаа

Иргэний зээл олгосон ч цаанаа бизнес, байгууллагатай холбоотой байх тохиолдлууд их байдаг тул байгууллагын болон иргэний зээлийг тодорхой ангилан ялгахад хүндрэлтэй байдаг талаар судалгааны явцад уулзалт хийсэн байгууллагууд онцолж байсан. Энэ нь бизнесийн зээлээр хязгаарлагдахгүй бөгөөд жишээлбэл, тэтгэврийн зээл авч байсан ч тухайн харилцагч өөрийн бизнест зориулан ашиглах тохиолдол ч байдаг. Тиймээс бодит байдлыг ялгахад маш хэцүү байдаг байна.

Арилжааны банкуудын үүсгэн байгуулагдсан түүх, бодлого өөр өөр байдаг тул байгууллагын

¹⁸ Банкны бодлогоос хамааран өөр өөр байдаг.

¹⁹ Энэ судалгаанд иргэний зээлийн дунд санхүүгийн тайлан шаарддаг харьцааг тодруулах зорилгоор судалж үзсэн боловч арилжааны банкууд эдгээрийг тодорхой болгоогүйг ба зээл хариуцсан эдийн засагчийн үзэл бодол ихээхэн нөлөөлдөг нь харагдсан.

болон иргэний зээлийн зээлийн харьцаа харилцан адилгүй байдаг. Монголбанкны статистик тоо баримтаас зээлийн үзүүлэлтийг харахад “байгууллага”, “иргэн”, “иргэн/ ЖДҮ” гэж хуваан ангилсан байна. “Иргэний/ ЖДҮ” ангилалд орсон зээл нь банкуудын зээл олгох шийдвэрт ихээхэн нөлөөлдөг бөгөөд банк иргэнд олгосон зээлийн дотор бодит байдал дээр ЖДҮ-ийн санхүүжилт болсон гэж үзэх зээлийн эцсийн үлдэгдэл, зээл тоог тайлагнаж нэгтгэн гаргадаг байна. Иргэний зээлийг ЖДҮ-ийн зээл гэж үзэх шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас гаргасан удирдамж байдаггүй тул банкууд дотоод журмаар шийдвэр гаргадаг.

Бизнес эрхлэгч хувийн нэр дээр зээл авахыг илүүд үздэг шалтгаан

Монголын ЖДҮ-үүд байгууллагын зээлээс илүүтэйгээр захирлын нэр дээр иргэний зээл авах тохиолдол их байдаг. Байгууллагын зээл авахын тулд компанийн эзнийг хязгаарлагдмал хариуцлагаас чөлөөлөхөөс гадна, татварын давуу талтай байдаг. Гэсэн хэдий ч хувь хүний нэр дээр зээл авахыг илүүд үздэг шалтгааны талаар арилжааны банкуудтай хийсэн ярилцлагаас үзэхэд 1) байгууллагын зээл авахад сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан болон бүрдүүлэх бичиг баримт их байдаг ба иргэний зээл²⁰ авах хүсэлт гаргахаас илүү хүндрэлтэй байдаг тул зээлдэгч, банкны ажилчид ч аль аль нь зайлсхийдэг, 2) Татвараас зайлсхийх зорилгоор²¹ хувь хүний нэр дээр зээл авах шалтгаан болдог гэж хэд хэдэн банк онцолж байсан.

(3) Зээлийн гүйцэтгэл

Банкны салбарын зээлийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг Монголбанк арилжааны банкуудын тайланг авч нэгтгэн олон нийтэд хүргэдэг. Статистик нэгтгэлд банк санхүүгийн салбар нийтэд нь байгууллагын зээл, иргэн/ ЖДҮ-ийн зээл²² гэсэн ангилалтай байна. Энэ мэдээлэлд Монголбанк, СЗХ, Үндэсний статистикийн газраас гаргасан статистик тоо мэдээг ашиглан зээлийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.

1) Ерөнхий нэгтгэл

Банк санхүүгийн салбарын зээлийн гүйцэтгэлийг хүснэгт 3.1.1-д үзүүлсэнчлэн 2014-2016 онд

²⁰ Бүрдүүлэх бичиг баримтын тухайд иргэний зээл олгох тохиолдолд бүтээгдэхүүн тус бүр ялгаатай, зээлийн карт авахад иргэний үнэмлэх, орлогын тодорхойлолт, өргөдөл гм хялбар байхаас гадна, бизнесийн хувийн зээл авахад ААН бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад зүйлс шаардагдах хэдий ч ерөнхийдөө баримт бичиг бага байна.

²¹ Тухайлбал, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй жижиглэн худалдааны А компани, хувиараа бизнес эрхлэгч Б г харьцуулж үзье. А компанийн хувьд эзэмшиж буй дэлгүүр дээр Б хувийн нэрээр авсан зээлээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, А компанийн зөвшөөрлөөр худалдаа эрхэлнэ. Уг нь Б нь зээлээ арилжаанд ашиглаж байгаа тул тайланд тусган, татвар төлөх ёстой. Гэтэл А компанийн бүртгэлд орохгүй тул татвар төлдөггүй байна.

²² Монголбанкны статистик мэдээлэлд “Иргэний/ЖДҮ” ангилалд ЖДҮ ихэнхийг эзэлж байгаа хэдий ч ЖДҮ гэж үзэж байгаа хувь хүнийг ч оруулан тооцож байгаа.

зээлийн эцсийн үлдэгдэл бага зэргийн бууралттай ч тогтмол хэмжээнд байна. Гэсэн хэдий ч 2013 оны гүйцэтгэлийг 2017 онтой харьцуулахад 1.4 дахин өссөн байгаа нь зээлийн хэмжээ нэмэгдэж байна гэж үзэж байна. Ялангуяа, ББСБ-аас олгосон зээлийн хэмжээ нь 5 жилийн хугацаанд бараг 3 дахин өсөж цар хүрээгээ тэлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. Зээлдэгчийн тооноос харахад 2016-2017 оны хооронд банкнаас зээл авсан зээлдэгчийн тоо өссөн байсан байна.

Хүснэгт 3.1 Санхүүгийн байгууллагуудын зээлийн эцсийн үлдэгдэл болон зээлдэгч

Нэгж: (сая төгрөгөөр), зээлдэгчийн тоо (бодит тоо)

		2013	2014	2015	2016	2017
Банк	Зээлийн үлдэгдэл	10,715,63 2	12,440,92 1	11,633,57 1	12,337,50 9	13,506,46 3
	Зээлдэгчийн тоо	N/A	N/A	893,030	888,298	1,014,910
Банк бус санхүүгийн байгууллага	Зээлийн үлдэгдэл	223,700	303,100	391,369	478,200	638,000
	Зээлдэгчийн тоо	533,016	663,098	636,341	592,461	1,471,099
Бусад санхүүгийн байгууллагууд ²³	Зээлийн үлдэгдэл	49,300	61,500	75,300	84,400	102,100
Нийт зээлийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдэл	10,988,63 3	12,805,52 6	12,100,24 3	12,900,10 9	14,246,56 3

Эх сурвалж: МБ, СЗХ, УСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ чанаргүй зээлийн хэмжээ мөн адил нэмэгдсэн байна. Энэ нь 5 жилийн хугацаанд чанаргүй зээлийн хэмжээ 2.3 дахин нэмэгдэж зээлийн эцсийн үлдэгдэл 1.4 дахин өссөн байгаатай харьцуулахад ихээхэн өссөн үзүүлэлт юм. Ялангуяа банк бус санхүүгийн байгууллага 5 жилийн хугацаанд арав дахин өссөн байгаа бөгөөд зээлийн эрсдэл өндөртэй харилцагчид ч зээл олгож байна гэж таамаглаж байна.

Хүснэгт 3.2 Банк санхүүгийн байгууллагын чанаргүй зээлийн дүн зээлдэгчийн тоо

Нэгж: (сая төгрөгөөр), зээлдэгчийн тоо (бодит тоо)

	2013	2014	2015	2016	2017
Банкны чанаргүй зээлийн дүн	565,956	625,699	869,840	1,051,680	1,152,951
Банкны чанаргүй зээлдэгчийн тоо	N/A	N/A	N/A	30,388	34,245
ББСБ-ийн чанаргүй зээлийн дүн	8,014	17,825	38,325	59,455	84,712
Бусад санхүүгийн байгууллагууд	1,545	1,563	3,467	4,621	4,475

Эх сурвалж: МБ, СЗХ, УСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

2) Байгууллагын зээл

2013 оноос 2017 он хүртэл таван жилийн хугацаанд арилжааны банкнаас олгосон байгууллагын зээлийн эцсийн үлдэгдэл 10% -р өссөн байна. Харин зөвхөн ЖДҮ-д олгосон зээлийн эцсийн

²³ Лизингийн компани, хадгаламж зээлийн хоршоо гэх мэт.

үлдэгдэл 60%-р өссөн байна. Байгууллагын тооны хувьд банкуудын нийт зээлдэгчийн тоо 2013-2015 оны статистик тоо баримт байхгүй боловч 2013- 2017 оны хооронд ЖДҮ-ийн зээлдэгчийн тоо бараг 1.5 дахин өссөн байна.

Хүснэгт 3.3-ийн ББСБ-ын статистик мэдээ нь Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн бүртгэлийн тоо болно. Банк бус санхүүгийн байгууллагаас авсан байгууллагын зээл 70 орчим хувиар хурдацтай өссөн байна. Гэсэн хэдий ч банк бус байгууллагын зээлийн хэмжээ нь банкуудын зээлийн хэмжээтэй харьцуулахад 0.5% орчим бөгөөд байгууллагын зээлийн хувьд үндсэндээ банк голлох үүргийг гүйцэтгэж байна.

Хүснэгт 3.3 Байгууллагын зээлийн зээлийн эцсийн үлдэгдэл, зээлдэгчийн тоо

Нэгж: (сая төгрөгөөр), зээлдэгчийн тоо (бодит тоо)

		2013	2014	2015	2016	2017
Банк	Байгууллагын зээлийн эцсийн үлдэгдэл	5,968,121	6,618,774	6,408,347	6,637,774	6,806,104
	Байгууллагын зээлийн зээлдэгчийн тоо	N/A	N/A	N/A	6426	6688
	Үүнээс ЖДҮ-ийн олгосон зээлийн дүн	939,258	1,132,789	679,526	791,834	1,249,299
	Үүнээс ЖДҮ-ийн олгосон зээлийн эцсийн үлдэгдэл ²⁴	971,079	1,270,619	1,270,097	1,282,229	1,661,516
	Үүнээс ЖДҮ-ийн зээлдэгчийн тоо	3,660	4,618	5,232	4,840	5,477
ББСБ	Олгосон зээлийн дүн	20,656	39,619	38,194	29,243	33,765
	Зээлийн эцсийн үлдэгдэл	641	3,028	5,099	7,948	11,782
	Зээлдэгчийн тоо	196	284	292	226	240

Эх сурвалж: МБ, СЗХ, ҮСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Арилжааны банкны байгууллагын чанаргүй зээлийн бодит үзүүлэлтийг Монголбанк нэгтгэн олон нийтэд мэдээлдэг. 2016 он хүртэлх байгууллагын зээлийн зээлдэгчийн мэдээлэл байхгүй боловч, байгууллагын зээлийн зээлдэгчийн тоог чанаргүй байгууллагын зээлийн зээлдэгчийн тоотой харьцуулан үзэхэд 2016 онд 11.7%, 2017 онд 13.8% байгаа нь чанаргүй зээлийн түвшин маш өндөр байна. Санхүүгийн салбарын чанаргүй зээлийн талаар энэ бүлгийн 2-р хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

²⁴ Зээлийн эцсийн үлдэгдэл нь өмнөх улирлын зээлийн эцсийн үлдэгдэл дээр тухайн жилд шинээр олгосон зээлийн дүнг нэмж эргэн төлөгдсөн дүнг хассан улирлын эцсийн зээлийн үлдэгдлийг хэлнэ. Дараах хүснэгтэд мөн адил хамаарна.

Хүснэгт 3.4 Байгууллагын чанаргүй зээлийн зээлдэгчийн тоо

Нэгж: (сая төгрөгөөр), зээлдэгчийн тоо (бодит тоо)

		2013	2014	2015	2016	2017
Банк	Зээлийн эцсийн үлдэгдэл	507,074.5	554,278.9	737,395	854,557.6	929,876.6
	Зээлдэгчийн тоо	N/A	N/A	N/A	754	921
ББСБ		N/A	N/A	N/A	N/A	N/A

Эх сурвалж: МБ, СЗХ, ҮСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

3) Иргэн/ ЖДҮ-ийн зээл

Банкнаас иргэн/ЖДҮ-д олгодог зээлийн тухайд ЖДҮ эрхлэгч аж ахуй нэгж иргэний зээл авдаг бизнес эрхлэгчдийг энэхүү судалгаанд чухалчлан авч үзэх шаардлагатай ба ийм зээлдэгчийн тоо 2013 оноос хойш жил тутам буурч байна. Нөгөө талаас зээлийн дүнгийн хувьд бага зэргийн өсөлт бууралт ажиглагдах хэдий ч 2013-аас 2017 оны хоорондох хугацааны туршид бараг өөрчлөгдөөгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчийн авч буй иргэний зээлийн нэг зээлдэгчийн зээлийн дүн нэмэгдсэн байгааг ойлгож болно.

Хүснэгт 3.5 Иргэн/ ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдэл, зээлдэгчийн тоо

Нэгж: (сая төгрөгөөр), зээлдэгчийн тоо (бодит тоо)

		2013	2014	2015	2016	2017
Банк	Иргэний зээлийн эцсийн үлдэгдэл	4,640,385	5,648,914	4,963,948	5,605,062	6,608,506
	Иргэний зээлийн зээлдэгчийн тоо	730,753	847,583	893,030	881,668	1,007,997
	Үүнээс ЖДҮ-ийн олгосон зээлийн дүн	1,052,127	826,718	580,238	532,113	1,101,562
	Үүнээс ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдэл	833,435	905,542	778,684	697,782	808,542
	Үүнээс ЖДҮ-ийн зээлдэгчийн тоо	52,947	57,220	49,945	40,465	40,532

Эх сурвалж: МБ, СЗХ, ҮСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Иргэнээр зээл авч буй ЖДҮ-ийн чанаргүй зээлийн дүн жилээс жилд нэмэгдэж 2013-2017 оны хооронд бараг дөрөв дахин нэмэгдсэн байна. Зээлийн эцсийн үлдэгдэл нэгэн хэвийн хэмжээнд байгаа боловч чанаргүй зээлийн эрсдэл жилээс жилд нэмэгдэж байна.

Хүснэгт 3.6 Иргэн/ ЖДҮ-ийн чанаргүй зээлийн дүн


Нэгж: (сая төгрөгөөр)

	2013	2014	2015	2016	2017
Иргэн/ЖДҮ-ийн чанаргүй зээлийн дүн	57,776.1	70,883.3	132,248	196,696.5	213,846.4

Эх сурвалж: МБ, СЗХ, ҮСГ-ийн статистикийн мэдээнд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

4) ЗБДС-ын батлан даалтын эцсийн үлдэгдлийн өөрчлөлт

Зээлийн батлан даалтын сангийн сүүлийн 4 жилийн зээлийн эцсийн үлдэгдлийг зураг 3.1.4-с харахад 2013-2014 оны хооронд 4 дахин өссөн боловч 2014 оноос хойш тал хувь нь буурсан байна. 2013 оноос 2016 оны хоорондох 4 жилийн хугацааны өөрчлөлтийг дараах графикаар харуулав.



Эх сурвалж: “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох төсөл”, ЗБДС

Зураг 3.4 ЗБДС-ийн зээлийн эцсийн үлдэгдэл өөрчлөлт

(4) Зээлийн мэдээлэлтэй холбоотой олон улсын байгууллагын дэмжлэг, хамтын ажиллагаа

1) Олон улсын валютын сан

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл 2017 оны 5 сарын 24-ний өдөр Монгол улсад өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 314.55 сая ЗТЭ буюу (434 сая ам доллар, монгол улсын квотын 435% тай тэнцэх хэмжээ) санхүүжилтийг олгохоор баталсан. Энэхүү өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр нь эдийн засгийг тогтворжуулж, эдийн засгийг сэргээх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн. Хөтөлбөрийн гол тулгуур нь төсвийн сахилга бат, улс орны санхүүгийн зах зээлийн дарамтыг бууруулж, гадаад секторыг тогтворжуулах өрийн тогтвортой

байдлыг сэргээх явдал юм.

Түүнчлэн ирээдүйн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгохын тулд өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр нь 1) төсвийн бодлогыг сахилга баттай болгох 2) төв банкны хараат бус бие даасан байдал, засаглалыг бэхжүүлж үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт төвлөрүүлэх 3) санхүүгийн салбарыг бэхжүүлэх 4) эдийн засгийг төрөлжүүлэх 5) нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах гэсэн арга хэмжээг авна. Мөнгөний бодлого нь инфляцийн хүлээлтийг тогтворжуулахад чиглэсэн, саяхан батлагдсан Монголын Хөгжлийн Банкны тухай хууль, Монголын банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга нь цаашид төсвийн болон мөнгөний хяналтыг сайжруулахад хувь нэмэр оруулна. Монголбанк нь банкны системийг сайжруулах, хяналт шалгалт, зохицуулалтын чадавхыг бэхжүүлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг зогсооход чиглэсэн цогц стратегитай байх юм²⁵.

Мөнгөний болон ханшийн бодлого: Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг шинэчлэн баталж, Монголбанкны эрх үүргийг тодотгон, засаглал, бие даасан байдлыг бэхжүүлэх болно. Мөнгөний бодлого ойрын үед хатуу хэвээр хадгалагдаж, ханш уян хатан байх шаардлагатай.

Санхүүгийн салбарын шинэчлэл: Эрх баригчид эхний ээлжинд банкны системийн иж бүрэн үнэлгээ хийж, банкуудын санхүүгийн байдал, эрсдэл даах чадварын түвшинг тогтооно. Дараагийн алхамд шаардлагатай бол дахин хөрөнгөжүүлэлт, бүтцийн өөрчлөлт хийгдэнэ. Зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлнэ. 2018 оноос зээлийн мэдээллийн бүртгэл, барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх зэрэг санхүүгийн хяналт шалгалтын чадахийг бэхжүүлэхэд чиглэсэн “Монгол улсад санхүүгийн хяналт шалгалтыг бэхжүүлэх төсөл” техникийн хамтын ажиллагааны дэмжлэгийг үзүүлж байгаа.

2) Дэлхийн банк

Дэлхийн банкнаас Монголбанкт хамтран олон талт техникийн хамтын ажиллагааны хүрээнд 2010 оноос Мөнгө угаахтай тэмцэх (AML Anti-money Laundering)-тэй холбоотой хууль эрх зүйн орчныг бий болгох техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байгаагаас гадна ЖДҮ, хувийн хэвшлийг хөгжүүлэх зорилгоор “хувийн хэвшлийн хөгжлийн зээл” (Private Sector Development Credit PSDC) төслийг 2000 оноос хэрэгжүүлсэн зэрэг санхүүгийн салбарт голлон дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байгаа. PSDC төслийн эхний шат 2000-2004 он, дараагийн шат нь

²⁵ ОУВС хэвлэлийн мэдээлэл No.17/193 <https://www.imf.org/ja/News/Articles/2017/05/24/17193-imf-executive-board-approves-financial-arrangement-for-mongolia>

2006- 2011 оны хооронд хэрэгжсэн. гурав дахь шатыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэж байгаа боловч Монгол улсын засгийн газрын санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан эцсийн шийдвэр гарах төлөвтэй байна.

3) Олон улсын санхүүгийн корпораци

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) нь Монгол улсын хувийн хэвшилтэй түлхүү хамтран ажилладаг ба 1) ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах, 2) Хөдөө аж ахуйн салбар болон үйлдвэрлэлийн төрөлжүүлэн хөгжүүлэх, 3) дэд бүтцийг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа. 2015 оноос эхлэн Хаан банк, Хас банкаар дамжуулан хамтарсан зээл олгохоос гадна, шинэ зочид буудлын (Ibis) хөрөнгө оруулалт, худалдааны төвийн бүтээн байгуулалтын (Shangri-La) хөрөнгө оруулалт, усны нөөцийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг 10 жилийн өмнөөс арилжааны банканд хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хийж эхэлсэн. Монголын банкны холбоотой хамтран хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн байгууллага байгуулах, хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хууль боловсруулахад санал солилцох зэрэг санхүүгийн салбарыг сайжруулах чиглэлээр дэмжлэг үргэлжлүүлэн ажиллаж байгаа.

(i) Санхүүгийн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр

ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр 2013-2018 оны хооронд үл хөдлөх хөрөнгө барьцаалахтай харьцуулахад хоцрогдож байсан хөдлөх эд хөрөнгийг барьцаалах мэдүүлэхтэй холбоотой судалгаа, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх судалгаанд дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд 2015 онд хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдаж 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж дагаж мөрдсөн.

(ii) Дампуурал (Bankruptcy)

Хууль зүйн яам, Монголбанк, Монголын банкны холбоотой хамтарч хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар сургалт зохион байгуулахаас гадна АХБ, ЕСБХБ-тай хамтран Cost Debt Reconstructing Committee үүсгэн байгуулж өр дампуурлын талаар зөвлөгөө өгч байгаа.

(iii) Зээлийн мэдээллийн төв ХХК

Зээлийн мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааг 2006 оноос эхлүүлж, зээлийн мэдээллийн тухай хуулийг боловсруулахад хамтран ажилласан. Монголбанкны олон нийтийн зээлийн мэдээллийн санаас тусдаа МБХ Зээлийн мэдээллийн төв ХХК-г байгуулахад дэмжлэг өгч, хамтран ажилласан. Одоогоор ОУСК нь зээлийн мэдээллийн төв ХХК-д холбоотой тусгайлсан дэмжлэг

хамтын ажиллагааг явуулаагүй байгаа. Нөгөөтэйгөөр ОУВС-аас гаргасан эдийн засгийн хямралын талаарх зөвлөмжийг үндэслэн 2017 оны сүүлээр зээлийн мэдээллийн санг сайжруулах тухай хүсэлтийг Монголбанкнаас гаргасны дагуу ОУСК-аас Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн талаар дараах зөвлөмжийг өгсөн байна.

a) Зээлийн мэдээллийн сангийн бүртгэлийн системийн программ хангамжийг өөрчлөх (10 жилийн өмнө Монголын компанийн боловсруулсан хуучирсан систем)

b) Зээлийн бүртгэл хийдэг ажилтны чадавхийг сайжруулах, Монголбанкны хяналт шалгалтын газрын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, ажилтаны тоог нэмэгдүүлэх. (Одоогоор зөвхөн 3 хүн байгаа боловч дор хаяж 10 хүн байх шаардлагатай)

c) Data submission (How to collect and deliver)

2018 оны 6-р сараас Зээлийн мэдээллийн санг сайжруулах төслийг эхлүүлэхээр төлөвлөж байгаа.

4) Азийн хөгжлийн банк

Олон улсын байгууллага, хувийн хэвшлийн дэмжлэг, хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхайн салбарт төвлөрч, Монгол улс хэт уул уурхайгаасхараат үйлдвэрлэлийн бүтэцтэй болохоос сэргийлж Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь хөдөө аж ахуйн салбараас гадна бусад салбарын бичил аж ахуй нэгж, ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж ирсэн. Тэр дундаа ХАА, хөдөөгийн хөгжлийн төсөл (ARDP)-өөр дамжуулан хөдөө аж ахуйн бизнест зээл олгох, батлан даалтын үйл ажиллагаа явуулахаас гадна үнэ цэнийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх, холбогдох боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх ажлуудыг хийж байгаа. АХБ-аас Монгол улсад олон тооны төсөл хэрэгжүүлж байгаагаас дээр дурдсан зээлийн батлан даалтын санг бэхжүүлэх замаар Монголын санхүүгийн зах зээлийг сайжруулах зорилготой Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох төсөл (Supporting the Credit Guarantee System for Economic Diversification and Employment Project) төслийн ач холбогдол их юм. Доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

5) Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)

Монголын хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэхэд Бичил, жижиг, дунд үйлдвэр (БЖДҮ)-т дэмжлэг үзүүлэх нь маш чухал асуудлын нэг бөгөөд ЕСБХБ-ны хамтын ажиллагааны голлох салбар юм. БЖДҮ-д шууд туслалцаа үзүүлээд зогсохгүй ихэнх дэмжлэг нь арилжааны банкинд

хөрөнгө оруулалт хийх, төрөл бүрийн зээл олгох зэрэг болно. БЖДҮийг хариуцдаг ХХААХҮЯ ны ЖДҮ, хоршооны бодлогын хэрэгжилтийн газартай нягт хамтын ажиллагаатай, ХХААХҮЯтай хамтран 1500 ААН хамарсан судалгаа явуулсан (2014 оноос 2017 он), судалгааны мэдээллийн хувьд бизнес үйл ажиллагааны чиглэлд суурилсан тул санхүүгийн мэдээлэл ороогүй байна. ЖДҮ хөгжүүлэх сантай хамтран ажилладаггүй (ЭСБХБ нь Sovereign Loan Засгийн газарт олгодог) .

ЖДҮ чиглэсэн бизнесийн зөвлөх үйлчилгээ ASB (Advice for Small Business) Европын холбооны дэмжлэг дээр тулгуурлах бөгөөд илүү үр дүнтэй менежмент явуулахын тулд хэрэгцээтэй хөрөнгийн эх үүсвэрийн 50-60% олгодог. Өмнө хэрэгжиж байсан ТАМ (Turn Around Management), BAS (Business Advisory Service) нэршлийг одоо ашиглахгүй байгаа хэдий ч үйл ажиллагааны хувьд ижил.

ЖДҮ-ийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн Хаан банкны БЖДҮ-ийн зээлийг өргөжүүлэх, хүний нөөцийг мэргэшүүлэх “Internal Capacity Building for MSME Lending”²⁶ төслөөр БЖДҮ-ийн зээлийг өргөжүүлэх зорилгоор эрсдлийн менежментийн зөвлөх (Risk Management Expert) зээлжих зэрэглэл тогтоох зөвлөх (Credit Scoring Expert) авчирч ажиллуулсан нь цаашид зээлийн мэдээллийн хяналтын салбарт хамран ажиллах, мэдээлэл солилцох өндөр ач холбогдолтой гэж үзэж байна²⁷.

²⁶ <https://www.ebrd.com/work-with-us/procurement/p-pn70817.html>

²⁷ 2018 оны 5 сарын 3ны өдрийн уулзалтаар ЕСБХБ нь арилжааны банк санхүүгийн байгууллагын зээлийн функцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, ЗЭМСтай ижил мэдээллийн сан бүрдүүлэхээр хэлэлцэж буй нь тодорхой болсон. Арменийн ЕСБХБ нь БЖДҮийн зээлийн скоринг систем бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа.

3.2 Банкны зээлийн мэдээллийн хяналт өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

(1) Зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал (Эрсдэлийн удирдлага, зээлжих зэрэглэлийн тухай ойлголт)

1) Зээлийн ангилал, зээлийн хүү, зээлжих зэрэглэл

Арилжааны банкнуудын зээл нь байгууллагын зээл, иргэдийн зээл гэсэн ерөнхий хоёр ангилан хуваагддаг. Байгууллагын зээл хувьд нэг банкнаас бусад банк зээлийн үнэлгээнд суурилсан хүүтэй зээл олгодоггүй байна²⁸. Сүүлийн жилүүдэд арилжааны банкуудын жилийн дундаж хүү 18-20% орчим байгаа боловч, ЖДҮ-тэй хийсэн ярилцлага судалгаанаас үзэхэд сарын 2-2.5% (жилийн 24-26% гэх мэт)-ийн хүүтэй зээл давамгайлдаг тухай дурдсан.

Зээл олгох шийдвэрийг зээлийн зэрэглэлээс гадна үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгийн барьцаанд суурилан гаргадаг хэдий ч барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад цаг хугацаа, зардал шаардлагатай тул чирэгдэл ихтэй байдаг. Барьцаа хөрөнгөтэй л бол зээл олгох шийдвэрийг гаргадаггүй. Зээлийн батлан даалтын сангаас зээлийн дүнгийн 60% хүртэлх батлан даалтыг гаргах боломжтой боловч, зээлийн нийт дүнгийн 40%-ийг зээлдэгч тал барьцаа хөрөнгө гаргах шаардлагатай .

Барьцаанд суурилсан зээлээс гадна онцгой тохиолдлуудаас дурдвал ихэнх арилжааны банк Оюу толгой зэрэг том аж ахуй нэгжтэй ханган нийлүүлэх гэрээ хэлэлцээр хийсэн компанийн мөнгөн гүйлгээнд (CF) суурилан барьцаа хөрөнгөгүй зээл олгодог арилжааны банк цөөнгүй байна .

2) Зээлийн хүүгийн бүрэлдэхүүн хэсэг, зээлийн хүүг бууруулах арга

Монгол улс дахь зээлийн орчин буюу тогтолцоонд хэд хэдэн асуудал байгаа хэдий ч санхүүгийн салбар бүхэлдээ зээлийн хүүгийн түвшин өндөр байгаа нь хамгийн том асуудал болоод байна. Зээлийн хүүгийн түвшний тухай энэхүү тайлангийн “Үнэлгээ ба хүү”-ийн хэсэгт дэлгэрэнгүй дурдах болно. Энгийн зээлийн хүү жилд дунджаар 24% ба түүнээс дээш байна. Зээлийн хүү өндөр байгаатай холбоотой хэд хэдэн хүчин зүйлсийг²⁹


харгалзан үзвэл зээлийн хүүгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бууруулах аргачлал дараах байдалтай байна.

²⁸ Зөвхөн 1 банкны хувьд байгууллагын зээл олгоход зээлжих зэрэглэлд (эрсдэл) тулгуурласан зээлийн хүү ногдуулдаг нь тодорхой болсон.

²⁹ Япон Эрсдэлийн Мэдээллийн банк ХХК, 2010 оны “ Банкны санхүүжилтийн зээлийн эрсдэлийн үнэлгээ” (http://www.jsda.or.jp/katsudou/kaigi/chousa/shasai_kon/shasaikon_wg/files/100201s.pdf)

Зээлийн хүүгийн түвшин нь банкны зардал, ашгийн хувиас хамаардаг. Эх үүсвэрийн зардал (банкны зээлийн эх үүсвэрт шаардагдах хүүгийн түвшин), зардлын харьцаа (зээлийн үйл ажиллагаатай холбоотой боловсон хүчний зардал хөрөнгийн зардал гэх мэт), зээлийн зардал (зээлдэгчид зээлийн эргэн төлөлтийн чадваргүй болох үед учирч болзошгүй алдагдлын нөөц)-өөс бүрдэнэ. Ашгийн хувь нь банк бүрийн эрсдэлийн давуу эрхээр (Хүлээгдэж буй ашиг) тодорхойлогддог боловч, тооцоолох боломжтой тохиолдолд зээлдэгчийн зээлийн эрсдэлийн урамшууллыг оруулж тооцдог.

Дээрх хүүгийн бүрэлдэхүүн хэсэг дотор эх үүсвэрийн хүүгийн түвшинд инфляцийн түвшин, бодлогын хүүгийн түвшин зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлдөг хэдий ч ОУВС аль альд нь байнгын хяналт мониторинг, зөвлөвж өгч байна. 2018 оны 7 дугаар сард өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн (EFF) хүрээнд хийгдсэн дөрөв дэх удаагийн дүгнэлтийн үр дүнг³⁰ олон нийтэд танилцуулсан ба сүүлийн 3 жилийн инфляцийн түвшин, бодлогын хүүгийн харьцааг доорх графикаар харуулав.



Эх сурвалж: Haver Analytics, IMF Country Report No. 18/204, P.6

Зураг 3.5 Инфляцийн түвшин, бодлогын хүүгийн өөрчлөлт

Энэхүү өөрчлөлтөөс харахад арилжааны банк санхүүгийн байгууллагын хүүгийн түвшний³¹

³⁰ ОУВС 2018 он “Country Report No. 18/204” (<https://www.imf.org/external/pubs/ft/wp/2012/wp12192.pdf>)

³¹ Монголбанкинд буцаан худалдан авах гүйлгээ (Борлуулах буюу эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй бондыг тодорхой үнээр худалдан борлуулах)-ны чиглэлийг баримтлан ажиллаж байгаа

гол үзүүлэлт болох Монголбанкнаас гаргадаг бодлогын хүү сүүлийн жилүүдэд буурсан хандлагатай байгаа ба 11%-13%-ийн хооронд хэлбэлзэж байгааг харж болно. Гэсэн хэдий ч, энэхүү эх үүсвэрийн хүүгийн түвшин бууруулахад дан ганц арилжааны банкны хүчин чармайлт хангалтгүй юм.

Банкууд зардлын харьцааг бууруулж, зээлийн зардлыг зохистой тооцоолох, хүлээгдэж буй ашгийн тооцооллыг сайжруулах зэрэг асуудлуудыг анхаарч арга хэмжээг авбал зээлийн хүүг багасгах боломжтой юм. Банк бүрийн удирдлагын үр ашигтай ажиллагааг дээшлүүлснээр зардлын харьцааг бууруулах боломжтой. Зээлийн зардлыг зохистой тооцоолохын тулд зээлдэгчийн дампуурах эрсдэлийг мэдээллийн сангаас авч статистикийн тооцооллын аргыг ашиглан бууруулах боломжтой юм. Мөн хүлээгдэж буй ашгийн харьцааг сайжруулахын тулд, одоогийн өртөгт жигд хуваарилах арга ашиглаж байгаа боловч эрсдэлийн урамшууллын дагуу хүүгийн түвшнийг тогтоох замаар хүүг бууруулах арга байж болно.

3) Эдийн засгийн үүднээс зээлийн хүүг бууруулах арга

Эрсдэлд тохируулан хүүгийн түвшин тогтоох, хүүг бууруулах үр дүнгийн талаар Азийн Хөгжлийн банкны институтын захирал Ёшино Наоюки эдийн засгийн үүднээс судалсан байна³². Тэр дундаа эрсдэл тооцоогүй тогтмол хүүтэй зээл нь, банк, харилцагчдын хоорондох мэдээллийн тэгш бус байдал үүсэж сөрөг сонголт болох магадлалтай тул эрсдэлд тохирсон хүүгийн түвшинг тогтоох шаардлагын тухай тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, эрсдэл багатай харилцагчийн зээл тогтмол хүүтэй байвал тэдний нөхцөл байдлаас шалтгаалан хүүгийн түвшин өндөр байна гэсэн шалтгаанаар зээл авахаас татгалзана. Нөгөөтэйгөөр, өндөр эрсдэлтэй харилцагч өөрийн эрсдэлтэй харьцуулахад хямд зээл авах сонирхолтой байдаг. Хамгийн муу үр дүн нь эрсдэл багатай харилцагчид зээл авахгүй бөгөөд зөвхөн өндөр эрсдэлтэй харилцагчид үлдэхэд банкны дундаж хүүг өсгөхөөс өөр аргагүй болох юм. Үүний үр дүнд сайн харилцагч, банкууд зээлийн эрсдэлийн мэдээллийн санг ашиглан харилцагчийн эрсдэлийн талаар урьдчилан таамаглаж чадвал мэдээллийн тэгш бус байдлыг сулруулж, эрсдэлд тохирсон хүүгийн түвшин тогтоох боломжтой болно. Үүний үр дүнд сайн хэрэглэгчид банкнаас бага хүүтэй зээлийг авах боломжтой бөгөөд өндөр эрсдэлтэй хэрэглэгчид эрсдэлдээ тохирсон зээлийн хүүг төлж, сайн харилцагчийг нэмэгдүүлснээр хүүгийн түвшнийг бүхэлд нь

(<https://www.mongolbank.mn/eng/dblistmongolbankrate.aspx>)

³² Ёшино Наоюки (2015 он) “ЖДҮ- д чиглэсэн зээлийн батлан даалтын систем, бодлогын хүү болон ЖДҮ-ийн мэдээллийн сан” <https://www.rieti.go.jp/jp/publications/pdp/15p003.pdf>

бууруулах боломжтой юм.

4) Эрсдлийг нөхөх аргачлал болон тулгарах асуудал

Монгол улсад зээлийн хүү өндөр байгаагаас гадна зээлийн барьцааны хөрөнгийн тогтолцоо, зээлийн батлан даалтын тогтолцооны үр ашиггүй байдал нь тулгамдаж буй асуудлууд юм .

Барьцаа хөрөнгийн тогтолцооны хувьд барьцаа хөрөнгийн эрхийг шилжүүлэн гүйцэтгэхтэй (үл хөдлөх барьцаа хөрөнгийг захиран зарцуулах холбоотой асуудлууд) холбоотой зардал өндөр байдаг талаар банкнууд онцолж байсан. Барьцаа хөрөнгөнд суурилан зээл олгодог Монгол улсын хувьд арилжааны банк барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахын тулд шүүхэд нэхэмжлэх гаргах ба шүүхийн эцсийн шийдвэр гаргал дунджаар 2 жил орчим шаардагддаг. Хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд банкнууд барьцаа хөрөнгийн эрхийг мөнгө болгох боломжгүй байдаг тул зээлийн эргэн төлөлт хийгдэхгүйгээс гадна зээлийн хүүгийн эргэн төлөлт ч хийгдэхгүй. Үүнээс гадна шүүхэд нэхэмжлэх гаргах үйл ажиллагаа нь өөрөө төвөгтэй байдгаас гадна нэмэлт зардал гардаг. Тиймээс банкууд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хийлгэх замаар хөрөнгөө буцаан татах арга хэрэглэхээс аль болох зайлсхийдэг бөгөөд хамгийн эцсийн авах арга хэмжээтэй ойрхон гэж онцолж байсан. Барьцаа хөрөнгийн хэт хамаарлыг арилгаж, зээлийн мэдээлэл, статистик тооцоололд үндэслэн зээлийн эрсдэлийг харгалзан харьцуулж зээл олгох шийдвэрийг гаргах боломжтой болбол банкны зээлийн шийдвэр гаргалтын шалгуур үзүүлэлтийн цар хүрээ нэмэгдэх болно.

Зээлийн батлан даалтын тогтолцоо нь одоогоор ЗБДС-ийн зээлийн баталгаанд төвлөрөн явагдаж байгаа ба тогтсон батлан даалтын шимтгэлийг тогтоосон ЗБДС-ын хувьд дээр дурдсаны эсрэг сонголтын хийх боломжтой юм. ЗБДС-ын зорилго болох эрсдэл багтай боловч барьцаа хөрөнгөгүй зээлдэгчийг өргөжүүлэхийн тулд санхүүгийн эрсдэлд уялдуулж батлан даалтын шимтгэлийг тогтоосноор ЗБДС нь тогтвортой болохоос гадна батлан даалгуулсан байгууллага нь ч өргөжин тэлэх гарц болно Банкны хувьд найдвартай компанид бага хүүтэйгээс гадна баталгааны шимтэлтэй багатайгаар санал болгох боломжтой юм.

(2) Зээл судалгааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал (зээлийн мэдээлэл, барьцаа хөрөнгийн үнэлгээ, банкны дотоод зээлийн үнэлгээ)

1) Банкны зээлийн судалгаа хийх үйл явц

(i) Бүрдүүлэх бичиг баримт

Харилцагчид зээл авахдаа олон төрлийн бичиг баримт бүрдүүлэн, банканд тушаах шаардлагатай болдог. Монголбанкнаас шаардлагатай баримт бичгийн талаар тодорхой заавар, удирдамж байдаггүй.

- Арилжааны банкууд зээл авахад шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтыг өөрсдийн цахим хуудсанд нийтэлсэн байдаг.

Арилжааны банкуудын зээлийн хүсэлт гаргахад шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтууд бага зэрэг ялгаатай байдаг боловч байгууллагын зээл нь үндсэндээ арав гаран төрлийн баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай байдаг ба цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй байна. Томоохон дөрвөн банкны нэгийг жишээ болгон дурдвал зээл авах өргөдөл, аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээ (хуулбар бол нотариатаар баталгаажуулсан байх)³³ компанийн дүрэм, танилцуулга, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол, эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхийн эх хувь, эх хувиар авчрах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, сүүлийн 6 сарын дотор авхуулсан цээж зураг (хагас жилийн дотор), барьцаанд тавих хөрөнгийн холбогдох баримт бичгүүд, аудит, татварын албаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон бусад орлого, зарлагыг нотлох баримтууд, зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл, сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд, зээлийн гэрээ болон бусад баримт бичгийг шаарддаг байна.

- Банкны цахим хуудсанд тусгагдаагүй бүрдүүлэх бичиг баримтууд

Банкууд цахим хуудсандаа нийтэлдэггүй боловч зээлийн судалгаа хийх явцад “хар данс, хар дэвтэр” гэж нэрлэгддэг бизнес эрхлэгчид хөтөлдөг бодит орлого зарлагын гүйлгээг он сар өдрөөр нь тэмдэглэсэн дэвтэр, бодит санхүүгийн тайлан, өнгөрсөн хугацаан дахь борлуулалтыг нотлох гэрээ (мэдээ мэдээлэл) шаардлагатай байдаг. Эдгээр бичиг баримтуудыг ил тод

³³ ААН гэрчилгээний хуулбарын нотариатаар батлуулсан хувийг өгнө. Бусад холбогдох бичиг баримтыг мөн нотариатаар батлуулсан байх шаардлагатай.

шаарддаггүй хэдий ч банкны зээлийн судалгаа хийх явцад боловсруулдаг санхүүгийн тайлан (ирүүлсэн санхүүгийн тайланг баталгаажуулан шалгасан) болон ирээдүйн мөнгөн гүйлгээний урсгалыг таамаглал тооцооллыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Дээр дурдсан бичиг баримтаас гадна зээлийн агуулга болон зээл авах хүсэлт гаргасан аж ахуй нэгжийн нөхцөл байдлаас шалтгаалан бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, төслийн агуулга зэрэг нэмэлт баримт бичиг шаардах тохиолдлууд байдаг.

(ii) Банкны зээлийн судалгаа

• Зээлийн бичиг баримт

Банк тус бүр зээлдэгчийн зээл хүссэн өргөдлийн дагуу зээлийн судалгааг хийдэг тул зээлийн хүсэлт гаргасан бичиг баримтад тулгуулан хариуцсан эдийн засагч зээлийн судалгааны маягтын дагуу судалгааны баримт бичгийг боловсруулдаг. Зээлийн судалгааны баримт бичиг банк бүр харилцан адилгүй боловч судалгаанд хамрагдсан банкууд зээлийн эргэн төлөлтийн чадавхийг тодорхойлох зорилгоор зээл хүсэгчийн ирээдүйн боломжит үр дүнд тулгуурлан (ирээдүйн мөнгөн урсгалын таамаглал) боловсруулдаг. Мөнгөн урсгалын таамаглалыг бэлтгэхдээ зээл хүсэгчийн ирээдүйд хийх гэрээ хэлэлцээр, хар данс, өнгөрсөн хугацаан дахь санхүүгийн тайлан зэргийг ашигладаг. Цаашилбал банкууд зээлийн судалгааны баримт бичгийн нэг болгон Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашиглан аж ахуй нэгжийн болон бизнес эрхлэгчийн зээлийн мэдээллийн лавлагааг³⁴ ашигладаг.

Цуглуулж боловсруулсан төрөл бүрийн баримт бичгийн мэдээллийг харилцагчийн мэдээллийн, зэрэглэлийн, эсвэл зээлийн судалгааны зэрэг олон төрлийн системд оруулж харилцагчийн бүрдүүлж өгсөн олон төрлийн бичиг баримтыг зээлийн судалгааны бичиг баримт болгон нэгтгэдэг.

• Зээл шийдвэрлэх эрх

Харилцагчийн гаргасан зээлийн өргөдөл бичиг баримт болон зээлийн эдийн засагчийн боловсруулсан зээлийн судалгааны бичиг баримтад үндэслэн зээл олгох боломжтой эсэхийг

³⁴ Монголбанкны ЗМС-ийн тухай “ 3.4 Монголбанкны ЗМС-ийн хөгжлийн түүх, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал”-2. Монголбанкны ЗМС-ийн систем-дэлгэрэнгүй тусгасан. ЗМС-д байгууллага, иргэний зээлийн үнэлгээг хэвийнээс муу хүртэл 5 ангилалд хуваан зээлийн нөхцөл байдлыг үнэлэн гаргадаг ба банк санхүүгийн байгууллагууд энэхүү зээлийн түүхийн мэдээллийг авч ашигладаг.

тодорхойлохын тулд хянан шалгадаг. Зээлийн шийдвэрийг салбар банкны зээл хариуцсан менежер, салбарын захирал, салбарын зээлийн хороо эсвэл төв оффисын зээлийн хороогоор батлуулдаг. Зээлийн шийдвэрийг салбар эсвэл төв оффис дээр гаргах уу гэдгийг зээлийн мөнгөн дүнгийн хэмжээнээс шалтгаалдаг ч мөнгөн дүнгийн хэмжээг банкны бодлогоор зохицуулагддаг.

- Барьцаа хөрөнгийн нөхцөл ба үнэлгээ

Барьцаа хөрөнгийн нөхцөл, үнэлгээний талаар Монголбанкнаас гаргасан тодорхой удирдамж байдаггүй ба ихэвчлэн банкууд зээлийн дүнг 100% нөхөх боломжтой барьцаа хөрөнгийг барьцаалахыг харилцагчдаас шаарддаг байна. Үл хөдлөх хөрөнгө (газар гэх мэт) хангалтгүй байх тохиолдолд дутагдалтай хөрөнгийг бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж зэргийг барьцаа болгон барагдуулдаг. Арилжааны банк тус бүр дотоод журамд заасан арга аргачлалаар барьцаа хөрөнгийн үнэлгээг хийдэг. Орон сууцны үнэлгээг хийхдээ байршил, давхрын тоо, зам, үйлчилгээ зэргийг харгалзан үзэхээс гадна тухайн үл хөдлөх хөрөнгийн байршиж буй нутаг дэвсгэрээс ихээхэн хамаарч үнэлгээг хийдэг. Япон улсад байдаг үл хөдлөх хөрөнгийн мэргэжсэн үнэлээчийн зэрэг Монголд байдаггүй тул банк тус бүр бие даан үнэлгээ хийдэг хэдий ч санхүүжүүлэх зээлийн дүнгээс хамааран банкны төв эсвэл салбар дээр үнэлгээг хийх эсэхийг шийдвэрлэдэг. Ихэнх банкны төв дээр үнэлгээний газар, хэлтэс, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй байдаг.

Зээлийн үнэ цэнийг (LTV) үнэлж барьцаалсан арилжааны банк барьцаа хөрөнгийн үнэлгээг 70% гэж тооцдог боловч зээлийн санхүүжилтийн бүтээгдэхүүнээс хамаарч өөр байж болно. Жишээлбэл үл хөдлөх хөрөнгийн хувьд ч гэсэн, бизнесийн зээлийн 70%, хөрөнгө оруулалтын 60% -аар (хөрөнгө оруулагчид эрсдлийг үүрэх) тооцдог.

Монгол улсад үл хөдлөх хөрөнгийн тухай хуулийн 33-р зүйл, “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 13-р зүйлд заасны дагуу барьцааны зүйлийг бусад этгээдэд давхар барьцаалах эрхтэй, барьцааг тохируулах боломжтой байдаг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр нэг барьцаатайгаар хоёр банкнаас зээл олгодоггүй³⁵ бөгөөд зөвхөн анх барьцаанд тавьсан банкнаасаа нэмэлт зээл авах боломжтой. Үүнээс гадна анх барьцаанд тавьсан банкны зээлийг өөр банкны зээл болгон шилжүүлэх боломжтой байдаг. Энэ тохиолдолд барьцаалсан барьцаа хөрөнгө болон зээлийн гэрээ зэргийг бүхэлд нь шилжүүлдэг байна.

³⁵ Тухайлбал барьцаанд тавьсан байрны үнэлгээний мөнгөн дүнг 100, зээлийн хэмжээг 70 хувь гэж тооцох тохиолдолд зөрүү 30 хувьд өөр банкнаас зээл авах боломжгүй.

Барьцаа хөрөнгө шаардлагагүй зээлийн тухайд найдвартай томоохон аж ахуй нэгжид зээл олгохдоо ажил гүйцэтгэх гэрээнд суурилан барьцаа хөрөнгө шаарддаггүй зээлийн бүтээгдэхүүнтэй хэд хэдэн арилжааны банк байсан. Харин иргэн хувь хүн зээлийн бүтээгдэхүүнд барьцаа хөрөнгө шаардлагагүй цалингийн зээл, тэтгэврийн зээл зэрэг багтана.

(iii) Зээлийн шийдвэр гаргалт ба ашиглаж буй систем

Зээл олгохдоо арилжааны банк тус бүр санхүүгийн тайланг багтаасан харилцагчийн мэдээллийг оруулсан мэдээллийн сангийн системийг³⁶ ашиглан бүртгэл, хяналтыг явуулдаг. Санхүүгийн тайланг бүртгэхдээ E-Balance-тай адилхан санхүүгийн үзүүлэлтүүдийг оруулдаг ба эсвэл PDF файл болгон хадгалдаг. Мөн зээлийн шийдвэр гаргалтад зориулсан харилцагчийн үнэлгээ, зээлийн агуулгын үнэлгээний тухай ихэнх банкнуудад зээлийн тоон үнэлгээний систем (1-100 оноо хүртэл оноогоор үнэлнэ) эсвэл зээлийн зэрэглэлийн систем (А-Е хүртэл зэргэлдэг)-ийг боловсруулан үйл ажиллагаандаа ашигладаг. Томоохон гэгдэх дөрвөн арилжааны банкны нэг нь Монголын ИТ компанийн боловсруулсан өөрийн байгууллагын үнэлгээний системийг ашигладаг бол 2 арилжааны банк нь Oracle компанийн үнэлгээний системийг ашигладаг байна.

Зээлийн үнэлгээ болон зэрэглэлийн системийн тухай 4 том арилжааны банкны бодит үйл ажиллагаанаас жишээ болгон доорх байдлаар харуулав.

- Томоохон харилцагч нарт зориулсан тоон үнэлгээ, жижиг харилцагч нарт зориулсан зээлийн зэрэглэлийг хийдэг. Тоон үнэлгээг хийхдээ харилцагчийн үнэлгээ, зээлийн нөхцөлийн үнэлгээг тус тусад хийдэг.
- Харилцагчийн үнэлгээг хийх үзүүлэлтүүд
 - a) Бизнесийн орчин (салбар, салбарын эдийн засгийн нөхцөл байдал, өрсөлдөх чадвар, хууль эрх зүйн орчин, бизнесийн эрсдэл, (худалдан авалтын тогтвортой байдал) , үйлдвэрлэлийн эрсдэл, борлуулалтын эрсдэл (хэрэглэгчийн зан төлөв), гадаад валютын эрсдэл)
 - b) Боловсон хүчин (захирал, удирдах албан тушаалтны эрсдэл, ёс суртахуун, хандлага, мэргэжлийн ур чадвар, туршлага)

³⁶ Ихэнх арилжаанд банк Loan origination system ашигладаг.

с) Санхүүгийн эрсдэл (санхүүгийн индекс (1-5) (санхүүгийн тайланд үндэслэн 5 үзүүлэлтээр) санхүүгийн тайлангийн найдвартай үнэн зөв байдал)

Эдгээрийг үнэлгээний үр дүнг нэгтгэн 1 (сайн) - 10 (муу) гэж тооцдог.

- Зээлийн нөхцөл байдлын үнэлгээний хувьд зээлийн хэмжээ / хугацаа / эргэн төлөх нөхцөл / барьцаа зэрэг зээл гэсэн үзүүлэлтэд мэдээллийг оруулж, эцсийн байдлаар А (сайн) хүртэл Е (муу) үнэлгээг өгнө.
- Харилцагчийн зэрэглэл, зээлийн зэрэглэлийн аль аль нь оруулсан агуулган дээр үндэслэн ямар зэрэглэлийн үр дүнг гаргадаг алгоритмын тухайд банк тус бүр дээр байгаа мэдээлэлд үндэслэн банк дотроо боловсруулж, санхүүгийн тайланг багтаасан төрөл бүрийн мэдээллийг бүхэлд нь нэгтгэн харж зээлийн шийдвэрийг гаргадаг ч энэ нь олон нийтэд дэлгэдэггүй.

Дээрх үнэлгээний системүүдээс гадна банкны барьцааны бүртгэлийн систем байдаг ба барьцаа хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг хавсарган барьцаа хөрөнгийн түүхийн тухай мэдээллийг оруулдаг байна. Энэ барьцаа хөрөнгийн мэдээллийг зээлийн тоон үнэлгээ болон зээлийн зэрэглэлийн системд ч мөн адил оруулдаг.

Дээр дурдсан системүүдэд мэдээллүүдийг оруулсны үр дүнд нэгдсэн байдлаар зээлийн шийдвэр гаргалтын үнэлгээ гардаг. Гэсэн хэдий ч ихэнх арилжааны банкнууд зөвхөн системээс гарсан зээлийн үнэлгээгээр зээлийн шийдвэр гаргалтыг хийдэггүй ба зээлийн эдийн засагч харилцагчийн талаар нарийвчилсан судалгаа явуулж системээс гарсан үнэлгээтэй нэгтгэн эцсийн шийдвэрийг гаргадаг.

(iv) Зээлийн зэрэглэл ба хүүгийн түвшин

Монголын бараг бүх арилжааны банкнууд тогтсон зээлийн хүүтэй байдаг ба банк, зээлийн бүтээгдэхүүн, зээлийн хугацаа зэргээс шалтгаалан жилийн 16.8% буюу сарын 1.4%-аас жилийн 36% буюу сарын 3% хүртэл өөр байдаг. Жилийн 16.8% хүүтэй зээлийн бүтээгдэхүүн нь төрөл бүрийн сан зэрэг байгууллагын санхүүжилтээр олгодог зээлийн хүүгийн түвшин юм. Арилжааны банкнууд дээр очин уулзалт, судалгаа хийж байхад ихэнх бизнесийн зээлийн хүү дунджаар жилийн 24%-тай байсан.

Энэхүү судалгааны явцад зээлийн зэрэглэл болон тоон үнэлгээнээс хамаарч байгууллагын зээлийг банкны дотоод зэрэглэлийн дагуу зээлийн хүүгийн түвшнийг тодорхойлдог тогтолцоог

ашигладаг ганцхан банк байсан юм. Тус банк нь эхний зээлийг тогтсон зээлийн хүүгээр олгодог бол 2 дахь ба дараагийн зээлийг эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан дундаж хүүг банкны дотоод мэдээллийн сангийн мэдээлэлд суурилан тооцон гаргаж үүнээс хэр зэрэг бууруулах боломжтой эсэхийг хэлэлцдэг. Эрсдэлийн үнэлгээг 1-9 хүртэл оноогоор гарган санал болгох боломжтой хүүгийн түвшнийг гаргадаг. Бууруулах түвшнийг шийдвэрлэх эрх мэдлийн тухайд зээлийн эдийн засагч санал тавьж зээлийн хороо эцсийн байдлаар шийднэ.

Бусад арилжааны банкнуудад зээлийн зэрэглэл хийдэг ч үр дүнг нь зөвхөн зээл олгох шийдвэр гаргалтад ашиглаж зээлийн хүүгийн түвшинд тусгагддаггүй. Гэсэн хэдий ч ихэнх банкнуудад зээлийн хөнгөлөлтийн тогтолцоотой байдаг. Өөрөөр хэлбэл, эхний зээлийн хувьд хүүгийн түвшин бууруулахгүй ч 2 түүнээс хойших зээлийг зээлийн түүх, бизнесийн туршлага зэрэг дээр тулгуурлан зээлдэгчтэй хэлэлцээр хийж бууруулах тохиолдол их байдаг. Хүүгийн түвшнийг бууруулахдаа (давуу эрхтэй хувь хэмжээ) жилийн хүүгийн түвшнийг ойролцоогоор 1% буюу түүнээс бага байна.

(v) Зээлийн шийдвэр гаргахад тэргүүлэх үзүүлэлт

Арилжааны банкнууд зээлийн шийдвэрийг гаргахдаа ашигилдаг зээлийн судалгааны шалгуур үзүүлэлтүүдийн тэргүүлэх үзүүлэлтүүд өөр өөр байсан ч ерөнхийдөө эргэн төлөх чадвар (ирээдүйн мөнгөн гүйлгээ: CF), зээлийн зорилго, эргэн төлөлтийн аргыг тэргүүлэх ач холбогдолтой гэж үзэн, барьцаа хөрөнгийг гуравдугаарт тавьдаг. Барьцаа хөрөнгөөр гэрээний үүргийг гүйцэтгүүлэхэд шүүхийн шийдвэр гаргуулах шаардлагатай тохиолдол гардаг ба энэ нь цаг хугацаа, зардал ихтэй байдаг тул барьцаа хөрөнгө нь гэрээний үүргийг гүйцэтгүүлэх эцсийн арга байдаг. Харин зээлийн судалгааны хувьд эргэн төлөх чадвар нь тэргүүлэх үзүүлэлт болдог.

(vi) ЖДҮ-ээс ирүүлсэн санхүүгийн тайлангийн бүртгэл, загвар болон чанар

Ихэнх арилжааны банкнууд ЖДҮ-ээс санхүүгийн тайлангаа Сангийн яамнаас гаргасан санхүүгийн тайлангийн маягттай (E-Balance)³⁷ адилхан гаргахыг шаарддаг. Банк тайлангийн мэдээлэлд тулгуулан системд данс, мөнгөн дүнг бүртгэн балансын тэнцлийг шалгадаг. Өмнө нь тайлан, бүрдүүлэх баримт бичгийг цаасан хэлбэрээр хадгалдаг байсан бол сүүлийн жилүүдэд PDF файл болгон хадгалах зэрэг цахим хэрэгслүүд их болж байгаа талаар хэлж байсан.

³⁷ Энэ системийн талаар тус тайлангийн 3.5 ЗМС-аас бусад зээлийн мэдээллийн датабааз (ii) Сангийн яамны мэдээллийн бааз (E-Balance) хэсэгт дурдсан болно.

2) Зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Дээр зээлийн судалгааны өнөөгийн байдлын талаар дурдсан бол тулгамдаж буй асуудлын талаар доорх зүйлүүдээс харж болно.

- Үл хөдлөх хөрөнгийн барьцаа байхгүй бол зээл авахад бараг боломжгүй гэж хэлж болох ба үйл ажиллагаагаа эхлүүлэх үед (үйл ажиллагааны эхлэлийн үе) үндсэн хөрөнгө багатай ч маш сайн бизнесийн санаатай компанид санхүүжилт хийх боломжгүй байдаг.
- Аж ахуй нэгжүүд Сангийн яам болон Татварын ерөнхий газрт тушаадаг санхүүгийн тайлан, дотооддоо зориулсан бодит санхүүгийн тайлан гэж ялган давхар данс хөтөлдөг гэсэн үндсэн дээр санхүүжилтийг олгодог.
- Банкны хувьд аж ахуй нэгжүүдийн татварын албанд зориулсан санхүүгийн тайлан, дотооддоо зориулсан бодит санхүүгийн тайлан, хар дэвтэр (хар данс) болон төрөл бүрийн гэрээ хэлцэлд үндэслэн ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолон гаргадаг. Хэрэв аж ахуй нэгжүүд санхүүгийн тайлангаа бодитоор тушаадаг байсан бол гарах шаардлагагүй зардлыг төлөх шаардлагагүй болох юм³⁸.
- Зээлийн судалгааны үйл ажиллагааны явц хүндрэлтэй байдаг тул зээлийн хүсэлт гаргаснаас зээл олгох хүртэл хугацаа цахим хуудас дээр заагдсан өдрөөс хоёр дахин их байдаг.
- Улсын бүртгэлийн систем нь бүртгэл хийхэд хугацаа их зарцуулагддаг тул нэг барьцаа хөрөнгөөр хэд хэдэн зээл авах эрсдэлтэй байдаг.
- Арилжааны банкны төв зээлийн үйл ажиллагаанаас ашиг олохын тулд аль болох эрсдэлээс зайлсхийж шаардлагагүй эрсдэлийг гаргуулахгүйн тулд зээл олгохдоо маш болгоомжтой ханддаг. Нөгөөтэйгүүр салбар дээр ажиллаж буй зээлийн эдийн засагч харилцагч нартаа аль болох таатай хурдан шуурхай үйлчилгээг үзүүлэхийг эрэлхийлдэг ба зээлийн бүрдүүлэх баримт бичиг хэтэрхий их зэрэг асуудалд өөр өөр саналтай байдаг.

³⁸ ЖДҮ-д нь ААНОАТ-ыг бага дүнгээр тайлагнахын тулд бодит орлого зарлагаа тайлагнахгүй байх хандлагатай байдаг. Хөндлөнгийн аудитаар санхүүгийн тайлангаа шалгуулах үүрэг хүлээгээгүй байдаг ба шаардлагатай бол хийлгэдэг. (Аудитын тухай хууль 8-10 зүйл) ЖДҮ -ийн үнэн зөв санхүүгийн тайлан гарган улсад тайлагнах арга хэмжээний талаар 4-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

(3) Зээлийн мэдээллийн агуулга болон хяналтын аргын өнөөгийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал (чанаргүй зээлийн хяналт, тайлагнах үүрэг, агуулга зэрэг)

1) **Зээлийн мэдээллийн хяналтын арга**

(i) **Зээлдэгчийн хяналт**

Зээлдэгчийн хяналтын тухайд арилжааны банкууд зээл олгосны дараа тухайн байгууллагын санхүүгийн тайланг авах, тухайн байгууллага дээр очин нөхцөл байдалтай нь танилцах зэрэг уулзалтуудыг зохион байгуулдаг. Зээл олгосны дараа санхүүгийн тайланг авахдаа ихэнх арилжааны банкууд 300 сая төгрөгөөс дээш зээл авсан бол жилдээ 1 удаа буюу жилийн эцсийн тайлан, 300 саяас 2 тэрбум төгрөгийн зээл авсан бол хагас жилийн тайлан, жилийн эцсийн тайлан түүнээс дээш зээлийн дүнтэй бол улирлын тайланг өгөхийг шаарддаг ба санхүүгийн болон татварын тайлагналтай уялдуулан авдаг.

(ii) **Чанаргүй зээлийн тодорхойлолт**

Чанаргүй зээлийг тодорхойлохдоо Монголбанкнаас гаргасан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу зээл, хувьсах нөхцөлтэй актив, үнэт цаас зэргийн төрлөөр нь ялган хугацаа хэтэрсэн хоногоор нь дараах байдлаар ангилдаг³⁹.

Хүснэгт 3.7 МБ-ны Активын хугацааны үзүүлэлтээр дүгнэж ангилах

АКТИВЫН ХУГАЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР ДҮГНЭЖ АНГИЛАХ ХҮСНЭГТ

Ангилал	ӨР ТӨЛБӨР ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ХОНОГООР				
	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл*	≤ 15	≤ 90	91-180	181-360	≥ 361
Хувьсах нөхцөлтэй актив**	≤ 15	15-90	91-180	181-270	≥ 271
Үнэт цаас***	-	≤ 30	31-60	61-90	≥ 91
Авлага болон бусад актив	≤ 30	31-60	61-90	91-120	≥ 121

*Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөр

**Хувьсах нөхцөлтэй актив, хүүгийн эргэн төлөлтөөр

***Үнэт цаас, хүүгийн эргэн төлөлтөөр

Эх сурвалж: “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, МБ

Дээрх ангиллаас харахад 91 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлдэгчийн зээлийн тухай “Зээлийн мэдээллийн сангийн тухай журам”-д заасанчлан Монголбанкинд тайлагнах үүрэгтэй байдаг ба арилжааны банкнуудын хувьд энэхүү нөхцөл байдлыг чанаргүй зээл гэж үздэг. Үүнээс гадна Монголбанкнаас гаргадаг чанаргүй зээлийн харьцааг тооцоолохдоо дээрх журмын тодорхойлолтыг баримталдаг.

³⁹ Хавсралт материалын хавсралт 2-с бүрэн эхээр нь харна уу.

(iii) Чанаргүй зээлийн хяналтын арга ба тайлагнал

Чанаргүй зээлийн хяналтын аргын тухайд 90 хоногоос доош хугацаа хэтэрсэн зээлийг салбар банк хариуцдаг бол 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийг арилжааны банкны төв дээр хяналтыг шилжүүлж авдаг байна.

Түүнчлэн чанаргүй зээлийн мэдээллийг Монголбанкинд тайлагнахдаа “Зээлийн мэдээллийн сангийн тухай журмын 2.1-т сар бүрийн 10-ны дотор тайлагнах гэж заасан байдаг ч Монголбанкинд арилжааны банкуудын чанаргүй зээлийн мэдээллийг тайлагнах (сар бүр) өдөр өөр өөр байсан. Тиймээс санхүүгийн байгууллагуудад нэг сарын хугацаанд үүргээ биелүүлээгүй байсан ч бусад санхүүгийн байгууллагуудаас нэмэлт зээл авах боломж гарч ирдэг тухай зарим нэг санхүүгийн байгууллага онцолж байсан. Нөгөөтэйгөөр нэг өдөр хугацаа хэтэрсэн зээлийн мэдээлэл байсан ч системээс автоматаар Монголбанкинд тайлагнадаг банк ч бий.

(4) Холбогдох үйл ажиллагаа (Харилцагч нарт зориулсан үйлчилгээ)

Арилжааны банкуудтай хийсэн уулзалт судалгааны үр дүнд 4 арилжааны банк зээлийн хяналтын үйл ажиллагааны нэг болгон санхүүгийн тайланг бэлтгэх, санхүүгийн мэдлэг олгох семинар зохион байгуулах, байгууллагуудад тусгайлан зөвлөгөө өгөх, ЖДҮ-ийн менежер, удирдлагуудад зориулсан арга хэмжээг зохион байгуулдаг талаар тодорхой мэдээлэлтэй болсон. Нөгөөтэйгөөр иймэрхүү үйл ажиллагааг огт хийгээгүй банкууд нийт арилжааны дийлэнх хувийг эзэлж байсан. Харилцагч нарт зориулсан үйлчилгээ, хүчин чармайлтын талаарх жишээг доор дурдав.

1) Зөвлөгөө

• Санхүүгийн тайлангийн зөвлөгөөг өгөхдөө банкны цахим хуудсан дахь (Гүйцэтгэх захирлуудын сүлжээ, санхүүгийн зөвлөгөө) гэсэн дэд цонхоор дамжуулан санхүүгийн болон боловсон хүчний харилцааны тухай нийтлэн бизнесийн дэмжлэг үзүүлдэг.

• Жишээ нь харилцагч бетон зуурмагийн үйлдвэр шинээр замын бизнес эхлүүлэхээр боллоо гэхэд санхүүгийн тал дээр анхаарвал зохих зүйл болон бусад зөвлөмж зөвлөгөөг өгдөг байна. Ийм үйлчилгээ үзүүлэхдээ Customer Care Advisor гэдэг албан тушаалтай хүнийг томилон ажиллуулдаг.

2) Семинар

• Одоогийн болон ирээдүйн харилцагч нарт зориулсан нягтлан бодох бүртгэлийн сургалт семинарыг зохион байгуулдаг. Жишээ нь 15 цагийн сургалтыг 2 ангид (анхан шат, ахисан шат) хуваан зохион байгуулдаг ба сургалтад хамрагдахад ямар нэгэн нөхцөл шалгуур тавьдаггүй байна.

• Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд AFA академитай хамтран сургалт зохион байгуулсан арилжааны банк байсан. Тус сургалт нь ямар ч хүн хамрагдах боломжтой ба нэг удаад 40-50 хүнтэйгээр санхүүгийн болон бусад олон төрлийн сэдвийг хамруулан зохион байгуулдаг.

3) Арга хэмжээ

• ЖДҮ болон бизнес эрхлэгч харилцагчдынхаа бизнесийн амжилтад бодитой хувь нэмэр оруулахаар “Next Champion 2018” форумыг амжилттай зохион байгуулсан. Одоогоор Монголд томоохон гэгдэх 250 компанийн дараагаар орох 600 орчим аж ахуй нэгжийг хамарсан тус арга хэмжээнд MCS групп, Монос групп, Таван богд зэрэг Монголын топ аж ахуй нэгжүүдийн захирлууд илтгэгчээр оролцож өөрсдийн туршлагаас хуваалцан ЖДҮ-дэд тулгамддаг асуудал, арилжааны банктай хэлэлцээр хийхэд шийдвэрлэх арга замын талаар санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ арга хэмжээг зохион байгуулсан банк нь 2016 оноос эхлэн ЖДҮ-д зөвхөн зээл олгох бус зөвлөгөө өгч хамтран ажиллахыг гол чиглэлийн нэг болгон ажиллаж, цаашид төрөл бүрийн зөвлөгөө өгч ажиллах байдалтай ажиглагдсан.

(5) Зээлийн хүсэлт гаргах, зээлийн мэдээллийн хяналт, үйлчилгээг харьцуулсан жагсаалт

Өмнөх хэсгүүдэд Монгол улсын зээлийн орчны тухай зээлийн хүсэлт гаргах болон зээлийн мэдээллийн хяналт, үйлчилгээ зэрэг асуудлыг дэлгэрэнгүй тайлбарласан. Банк тус бүрийн үйл ажиллагаа ерөнхийдөө олон талаараа нийтлэг байдаг ч банк тус бүр өөрийн гэсэн өнгө аястай байдаг. Тодорхой жишээ болгох зорилгоор 4 арилжааны банкиг харьцуулан дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3.8 Арилжааны банкны зээлийн хүсэлт гаргах, зээлийн мэдээллийн хяналтын талаарах харицуулалт

	Банк 1	Банк 2
Зээлийн төрөл / ангилал	<p>Хөрөнгө оруулалтын зээл Эргэлтийн хөрөнгийн зээл Хөдөө аж ахуйн зээл Оюу толгойн ханган нийлүүлэгчдэд зориулсан зээл Шугамын зээл Шуурхай бичил зээл Барилгын зээл Санхүүгийн түрээс Худалдааны зээлийн эрх Гэрээ барьцаалсан бизнесийн зээл Төслийн зээл Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн төслийн зээл Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн зээл ЖАЙКА-ийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл Зээлийн баглан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төслийн зээл</p>	<p>Шугамын зээл Тоног төхөөрөмжийн зээл Оюу толгойн бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан бизнесийн зээл Бичил бизнесийн зээл Бизнес дэмжих зээл Хөрөнгө оруулалтын зээл Эргэлтийн хөрөнгийн зээл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төслийн зээл АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн зээл АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл KFW ЖАЙКА-ийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл Арьс шир үйлдвэрлэгчдийг дэмжих төслийн зээл Овердрафт зээл</p>
Зээлийн үйл ажиллагаа (Байгууллагын зээл)	<ul style="list-style-type: none"> • Зээлийн эдийн засагч шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтаас гадна ЗМС-ийн мэдээлэл, нэмэлт бичиг баримт (хар данс, шинэ гэрээ гэх мэт) -ыг харилцагчаас авдаг. • Цуглуулсан мэдээллийг банкны дотоод хэрэглэгчийн болон үнэлгээний системд оруулдаг. • Системийн боловсруулсан баримт бичиг, харилцагчаас авсан баримт бичгийг зээлийн судалгааны баримт бичиг болгон нэгтгэдэг. • Зээлийн шийдвэр гаргалтын тухайд банкны бодлогын дагуу зээлийн хэмжээ / бүтээгдэхүүнээс хамааран салбар эсвэл төв дээр эцсийн шийдвэрийг гаргадаг. 	<ul style="list-style-type: none"> • Зээлийн эдийн засагч шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтаас гадна ЗМС-ийн мэдээлэл, нэмэлт бичиг баримт (хар данс, шинэ гэрээ гэх мэт) -ыг харилцагчаас авдаг. • Цуглуулсан мэдээллийг банкны дотоод хэрэглэгчийн болон үнэлгээний системд оруулдаг. • Системийн боловсруулсан баримт бичиг, харилцагчаас авсан баримт бичгийг зээлийн судалгааны баримт бичиг болгон нэгтгэдэг. • Зээлийн шийдвэр гаргалтын тухайд банкны бодлогын дагуу зээлийн хэмжээ / бүтээгдэхүүнээс хамааран салбар эсвэл төв дээр эцсийн шийдвэрийг гаргадаг.
Зээлийн хүсэлт гаргах, бүрдүүлэх бичиг баримт (Байгууллагын зээл)	<p>Зээлийн маягт ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ Байгууллагын дүрэм Байгууллагын танилцуулга Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл Зээл авах тухай ТУЗ-ийн зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхийн эх хувь, эх хувиар авчрах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар сүүлийн 6 сарын хугацааны цээж зураг Барьцаанд тавих хөрөнгийн баримт бичгүүд Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан орлого, зарлагыг нотлох баримтууд</p>	<p>ААН, байгууллагын зээл хүссэн өргөдөл ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан/ Байгууллагын дүрэм / нотариатаар баталгаажуулсан/ Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан Төслийн бизнес төлөвлөгөө Холбогдох гэрээ, хэлцлүүд / нотариатаар баталгаажуулсан/ Харилцагч банк, татварын албаны тодорхойлолт Байгууллагын товч танилцуулга Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх зөвшөөрөл Зээлийн барьцаа баталгаа Барьцаанд тавих хөрөнгийн ҮХЭХБГ-аас авсан лавлагаа, ҮХЭХБГ гэрчилгээний хуулбар</p>

	Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл Сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд Бусад	Удирдах ажилтнуудын иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар, анкет Бусад банкнаас зээл авч хугацаандаа төлж байснаа нотлох Зээлийн болон Барьцааны гэрээ, төлбөр хийсэн баримтууд Холбогдох бусад баримт бичгүүд
Зээлийн шийдвэр гаргалтад	1) Эргэн төлөх чадавх (ААН-ийн ирээдүйн мөнгөн гүйлгээ), 2) үйл ажиллагааны агуулга, 3) Барьцаа	(ЖДҮ-ийн зээл) 1) Санхүүгийн тайлан, 2) бизнесийн талаарх мэдээлэл, 3)орлогын хэмжээ, 4) барьцаа хөрөнгө
Барьцаа хөрөнгийн тогтолцоо	<ul style="list-style-type: none"> • Банкны дотоод журмын дагуу барьцаа хөрөнгийг авдаг. • ЗБДС-аас батлан даалт гаргуулах тохиолдол байдаг. • Бүх харилцагч нар барьцаа хөрөнгө бэлтгэдэг • Ихэвчлэн газар, байшин, барилгыг барьцаалдаг ч бизнесийн зээлийн төрлөөс хамааран бараа, бүтээгдэхүүнийг барьцаалж болно. • Барьцааны 70-ийг үл хөдлөх хөрөнгө, үлдсэн 30%-ийг бараа бүтээгдэхүүн барьцаалах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Барьцаа хөрөнгийн хувьд бизнесийн гэрээ хэлэлцээр, харилцагчаас шалтгаалах • Үл хөдлөх хөрөнгийн барьцаа барьцаалаагүй тохиолдолд авлагын дансыг барьцаалж, борлуулалтын орлогын шилжүүлэн авдаг. • Барьцаа шаарддаггүй онцгой тохиолдлууд байдаг Оюу толгойтой бэлтгэн нийлүүлэгчийн гэрээтэй байгууллага болон зээлийн картын зээл авах тохиолдлууд юм. • ЗБДС-ийн батлан даалтыг ашгилдаг ба тодорхой газар хариуцдаг.
Банкны дотоод зээлийн зэрэглэл	Харилцагчийн зэрэглэл, зээлийн зэрэглэл үнэлгээг хийдэг боловч хүүгийн түвшинд нөлөөлдөггүй.	Харилцагчийн зэрэглэл, зээлийн зэрэглэл хийдэг ч хүүгийн түвшинд өөрчлөлт ордоггүй. Зээлийн зэрэглэлийн үнэлгээг зээл олгох шийдвэр гаргалтад ашгилдаг ба 1-9 хүртэл үнэлгээний оноог өгч үр дүн өндөр (1 хамгийн өндөр оноо) бол зээлийг олгох шийдвэрийг гаргадаг. Харин үнэлгээний оноо бага байвал нэмэлт мэдээллийг нэмэн авч ахин хэлэлцсэний эцсийн шийдвэр гаргадаг.
Хүү	Сарын хүү дунджаар 2-2.1% байдаг. Хоёр болон түүнээс олон удаа зээл авч байгаа харилцагчийн хүүг 0,2% хүртэл бууруулах тохиолдол байдаг.	Зээлийн бүтээгдэхүүнээс шалтгаалан сарын 1.4-2%, 2,5-3% -ийн хүүтэй 6-60 сарын хугацаатай байдаг. Зээлийн бүтээгдэхүүн, барьцаа, зээлийн судалгааны үнэлгээ зэргээс шалтгаалан зээлийн хүү өөр байдаг.
Зээл олгох үйлчилгээний шимтгэл	Олгосон зээлийн дүнгийн 1%	Олгосон зээлийн дүнгийн 1%
Зээлдэгчийн хяналт/ Дефолт	<ul style="list-style-type: none"> • Эргэг төлөлт хийгдээгүй зээлийн мэдээлэл сарын эцэст автоматаар ЗМС-руу илгээгддэг. Нэг өдөр хоцорсон ч илгээгддэг. Эргэн төлөлт хийгдээгүй 91 хоног хүртэл банкны төв дээр хариуцан гэрээний үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээг авдаг. 	<ul style="list-style-type: none"> • Эргэг төлөлт хийгдээгүй зээлийн мэдээлэл сарын эцэст автоматаар ЗМС-руу илгээгддэг. Нэг өдөр хоцорсон ч илгээгддэг. Эргэн төлөлт хийгдээгүй 91 хоног хүртэл банкны төв дээр хариуцан гэрээний үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээг авдаг. • Харилцагчийн зээлийн дүнгээс хамааран сарын улирлын, хагас жилийн санхүүгийн тайланг авдаг.
Харилцагч нарт зориулсан үйлчилгээ	Зээл олгогдсон компани, зээлдэгч нарын менежмент, эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай хэлтсийг бий болгон гүйцэтгэх захирлуудад зориулсан семинар, сургалтыг зохион байгуулдаг.	<ul style="list-style-type: none"> • Нягтлан бодох бүртгэлийн сургалт • ЖДҮ-ийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт арга хэмжээ • Цахим хуудсаараа дамжуулан төрөл бүрийн мэдээллээр хангадаг
Одоогийн тулгамдаж буй гол асуудлууд	<ul style="list-style-type: none"> • 2018 онд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан томоохон аж ахуйн нэгжүүдийн эрсдэл өндөр байх магадлалтай гэж үзсэн учраас ЖДҮ-ийн зээлийг нэмэгдүүлэх төлөвлөсөн. • Хүүгийн түвшнийг бууруулахаар өнгөрсөн жил шинэ газар бий болгож, харилцагчдыг сегментээр нт хувааж сегментүүдэд тохирсон зээл,зээлийн шинэ бүтээгдэхүүн бий болгохоор ажиллаж байгаа. 	N/A

	Банк 3	Банк 4
Зээлийн төрөл / ангилал	Эргэлтийн хөрөнгийн зээл Хөрөнгө оруулалтын зээл Импортыг дэмжих зээл Тоног төхөөрөмжийн зээл Биет болон биет бус алт барьцаалсан зээл Овердрафт зээл Төслийн зээл АХБ-ны эх үүсвэр, зээлийн батлан даалтын сангийн батлан даалттай зээл ЯОХАБ-ын хоёр үе шаттай төслийн зээл АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн зээл Германы KFW банкны төслийн зээл ХХААХҮЯ-ны ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн төслийн зээл Зээл батлан даалтын сангийн зээл Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	Эргэлтийн хөрөнгийн зээл Үндсэн хөрөнгийн зээл Зээлийн шугам Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор олгогдох бизнесийн зээл АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төслийн зээл ЖАЙКА-ын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төслийн зээл Монголын бизнес инкубаторуудын үндэсний нэгдсэн холбооны төслийн зээл "Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил" /IFAD/ төслийн зээл Органик монгол хөтөлбөр: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН болон иргэдэд зориулсан зээл. EBRD санхүүжилт: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН болон иргэдэд зориулсан зээл Барилгын зээл
Зээлийн үйл ажиллагаа (Байгууллагын зээл)	<ul style="list-style-type: none"> • Зээлийн эдийн засагч шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтаас гадна ЗМС-ийн мэдээлэл, нэмэлт бичиг баримт (хар данс, шинэ гэрээ гэх мэт) -ыг харилцагчаас авдаг. • Цуглуулсан мэдээллийг банкны дотоод хэрэглэгчийн болон үнэлгээний системд оруулдаг. • Зээлийн эдийн засагч газар дээрх үзлэгийг хийж харилцагчийн нөхцөл байдлыг тодорхойлно. • Системийн боловсруулсан баримт бичиг, харилцагчаас авсан баримт бичгийг зээлийн судалгааны баримт бичиг болгон нэгтгэдэг. • Зээлийн шийдвэр гаргалтын тухайд банкны бодлогын дагуу зээлийн хэмжээ / бүтээгдэхүүнээс хамааран салбар эсвэл төв дээр эцсийн шийдвэрийг гаргадаг. 	<ul style="list-style-type: none"> • Зээлийн эдийн засагч шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтаас гадна ЗМС-ийн мэдээлэл, нэмэлт бичиг баримт (хар данс, шинэ гэрээ гэх мэт) -ыг харилцагчаас авдаг. • Цуглуулсан мэдээллийг банкны дотоод хэрэглэгчийн болон үнэлгээний системд оруулдаг. • Системийн боловсруулсан баримт бичиг, харилцагчаас авсан баримт бичгийг зээлийн судалгааны баримт бичиг болгон нэгтгэдэг. • Зээлийн шийдвэр гаргалтын тухайд банкны бодлогын дагуу зээлийн хэмжээ / бүтээгдэхүүнээс хамааран салбар эсвэл төв дээр эцсийн шийдвэрийг гаргадаг.
Зээлийн хүсэлт гаргах, бүрдүүлэх бичиг баримт (Байгууллагын зээл)	N/A	Хас Банкны маягтын дагуу анкет Бизнесийн танилцуулга Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, үүсгэн байгуулсан гэрээ Санхүүгийн тайлан /1-3 жил/ Бизнесийн үйл ажиллагааны зөвшөөрөл, лиценз, патент Бусад банк санхүүгийн байгууллагаас авч байсан сүүлийн зээлийн түүх Зээлээр санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд Бизнесийн онцлогоос шалтгаалан шаардагдах бусад бичиг баримтууд. Харилцагч банк болон татварын албаны тодорхойлолт авах тохиолдол байна.
Зээлийн шийдвэр гаргалтад	1) Бизнесийн үйл ажиллагааны ашиг, 2) хөрөнгө оруулалтыг зориулалт, 3) харилцагчийн борлуулалтын орлого, 4) барьцаа	Мөнгөн гүйлгээний тайлан, ААН болон захирлын зээлжих чадавх, Санхүүгийн тайлан, Барьцаа хөрөнгийн үнэлгээ зэрэг бүгдийг нь чухалчлан харгалзан үздэг.

Барьцаа хөрөнгийн тогтолцоо	• Банкны дотоод журмаар баглагдсан байдаг ба бүх байгууллагын зээлийн бүтээгдэхүүнд барьцаа шаардлагатай байдаг.	Банкны дотоод бодлогын дагуу бүх байгууллагын зээлийн бүтээгдэхүүнд барьцаа шаардлагатай байдаг бол Факторингийн үйлчилгээнд шаардахгүй. Газар барьцаалах тохиолдолд зээлийн бүтээгдэхүүнээс шалтгаалаад үнэлгээний 45-75% хүртэл дүнгээр зээл олгох боломжтой.
Банкны дотоод зээлийн зэрэглэл	Харилцагчийн зэрэглэл, зээлийн зэрэглэл үнэлгээг хийдэг боловч хоёр дахь удаагийн зээл авах тохиолдолд хүүгийн түвшинг харгалзан үздэг.	Харилцагчийн зэрэглэл, зээлийн зэрэглэл үнэлгээг хийдэг боловч хүүгийн түвшинд нөлөөлдөггүй.
Хүү	Зээлийн бүтээгдэхүүнээс шалтгаалан сарын хүү дунджаар 1.6-1.9% байдаг.	Зээлийн бүтээгдэхүүнээс шалтгаалан сарын хүү дунджаар 1.5-1.7% байдаг.
Зээл олгох үйлчилгээний шимтгэл	Олгосон зээлийн дүнгийн 0.5%	Олгосон зээлийн дүнгийн 1%
Зээлдэгчийн хяналт/ дефолт	<ul style="list-style-type: none"> • Эргэн төлөлт хийгдээгүй зээлийн мэдээлэл сарын эцэст автоматаар ЗМС-руу илгээгддэг. Нэг өдөр хоцорсон ч илгээгддэг. Эргэн төлөлт хийгдээгүй 91 хоног хүртэл банкны төв дээр хариуцан гэрээний үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээг авдаг. • Харилцагчийн зээлийн дүнгээс хамааран сарын улирлын, хагас жилийн санхүүгийн тайланг авдаг. 	<ul style="list-style-type: none"> • Эргэг төлөлт хийгдээгүй зээлийн мэдээлэл автоматаар ЗМС-руу илгээгддэг. • Харилцагчийн зээлийн дүнгээс хамааран сарын улирлын, хагас жилийн санхүүгийн тайланг авдаг. • Хоцорсон байгууллагад төлбөрийн мэдэгдэл хүргүүлж уулзалт хийхийг шаарддаг • 270 өдөр хэтэрсэн харилцагчийг тусгай төлбөр барагдуулах хэлтэс хариуцан арга хэмжээ авдаг.
Харилцагч нарт зориулсан үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Харилцагч нартаа зориулан удирдлага, санхүүгийн чиглэлээр болон өргөн агуулгын хүрээнд сургалт семинар зохион байгуулдаг. • Харилцагч нартайгаа тогтмол уулзалт зохион байгуулахаас гадна зээлийн эдийн засагч нар тогтмол зөвлөгөө өгч ажилдаг. 	• Улаанбаатар хотын харилцагч нарт зориулан нягтлан бодох бүртгэлийн сургалт семинарыг зохион байгуулдаг.
Одоогийн тулгамдаж буй гол асуудлууд	<ul style="list-style-type: none"> • ЖДҮ бизнес эрхлэгч харилцагч нарын хамгийн том асуудал нь ЖДҮ-ийн захирлуудын санхүүгийн (санхүүгийн тайлан) мэдлэг муутай байдаг. Захирлууд татварын тайлан болон санхүүгийн тайлан гаргахдаа л нягтлан бодогчид хөлслөн тайлан хийлгэдэг, төлбөр тооцооны агуулгаа ойлгодоггүй захирлууд их байдаг. • Улсын сангаар дамжуулан олгодог зээлийн асуудал нь сангийн яам, ХХААХҮЯ зэрэг хөрөнгө оруулалт зээлийн мэдлэг багатай төрийн байгууллагууд хариуцдаг. • МБ-ны асуудлын хувьд ЖДҮ тэр дундаа дунд хэмжээний аж ахуй нэгжүүдийн дарамт их байдаг ба улсаас үзүүлэх дэмжлэг бага байдаг. • Жижиг аж ахуй нэгжийн хувьд жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум байх гэсэн заалт нь хэтэрхий бага юм. • Хоёр үе шаттай зээлийн хувьд бүрдүүлэх бичиг баримт их, зээл олгох үйл явц удаашралтай байдаг. Монголын зах зээлийн орчинд тохируулан хялбар болгох хэрэгтэй. Зээлийн дээд хэмжээ нь хэтэрхий бага. 	N/A

3.3 Банк бус санхүүгийн байгууллага дахь зээлийн мэдээллийн хяналтын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал

(1) Зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал (эрсдэлийн урамшууллын тухай ойлголт)

Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо (ББСБХ) -той хийсэн уулзалтын үеэр банк бус санхүүгийн байгууллагын салбарын хэмжээнд одоогоор 17.000 орчим харилцагч байгаагаас 3.000 орчим нь аж ахуй нэгж байгууллага байгаа гэж тооцоолж байгаагаа дурдсан⁴⁰. Томоохон банк бус санхүүгийн байгууллага болох Транс Капитал, Бид, Газар капитал партнерс, Визион Фанд гэх мэт компаниуд нэрлэж болох бол эхний 30-д багтах компаниудыг томоохон ББСБ гэж үздэг байна. Нийт зээлийн хэмжээ 5 тэрбумаас дээш байна. Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн салбарт хэт их ББСБ үүсгэн байгуулагдсан асуудал болон өрсөлдөөнийг бууруулах зорилгоор СЗХ-с өмнө нь дүрмийн сангийн доод хэмжээ 400 сая төгрөг байсныг 2020 гэхэд 1 тэрбум, цаашилбал 2.5 тэрбум болгон нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан. СЗХ-с шинээр банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум төгрөг болгох шийдвэр гаргасан.

Зээлийн төрлийн талаар томоохон гэгдэх 2 ББСБ-тай уулзалт хийхэд хуулийн итгээд буюу аж ахуй нэгжээр олгосон зээл 10 хүрэхгүй ба ихэвчлэн хувь хүн иргэдэд зээл олгодог байна. Гэсэн хэдий ч хувь хүний нэр дээр олгосон зээлийн 50% орчим нь бизнесийн зорилготой байдаг талаар хэд хэдэн ББСБ-ууд хэлж байсан. Дунд зэргийн ББСБ-тай хийсэн уулзалтын үеэр ч мөн адил зээлийн төрлийн талаар тодруулахад хэрэглээний зээл 60% орчим, 40% нь бизнесийн зориулалтаар авч байгаа боловч тухайн байгууллагын захирал нь байнга хувь хүний нэр дээр бизнесийн зээл авах тохиолдлууд байдаг талаар дурдсан юм.

ББСБ-аар үйлчлүүлэх олон төрлийн шалтгаан харилцагч нарт байдаг ч хурдан хугацаанд зээл олгодог нь хамгийн чухал шалтгаан юм. Өөрөөр хэлбэл, арилжааны банкнаас зээл авахад ихээхэн цаг хугацаа шаардлагатай байдаг тул богино хугацаанд эргэлтийн хөрөнгөтэй болохын тулд ББСБ-аар үйлчлүүлэх шаардлагатай болж харилцагч ББСБ-ын өндөр хүүг төлөхийг хүлээн зөвшөөрдөг байна.

⁴⁰ МБ-ны ЗМС-ийн бүртгэл (2017 оны жилийн эцсийн байдлаар 240 ААН)-тэй харьцуулахад маш их ялгаатай байсан. 1. Бүх ББСБ нь ЗМС-д зээлийн мэдээгээ өгдөггүй. 2. ББСБХ-ноос гаргасан тооцоолол нь ЖДҮ-ийн зээл ч хувь хүн иргэний нэр дээр олгосон зээлийг зориулалтаар нь байгууллагын гэж бүртгэсэнтэй холбоотой гэж үзэж байна.

(2) ББСБ-ын зээлийн судалгааны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал

1) ББСБ-ын зээл олгох үйл явц

(i) Бүрдүүлэх баримт бичиг

- Зайлшгүй шаардлагатай баримт бичиг

Зээл авахад зайлшгүй шаардлагатай бичиг баримт ББСБ бүр дээр ихээхэн өөр байдаг ч томоохон ББСБ-ууд нь арилжааны банкны иргэний зээл авахтай адилхан баримт бичгийг бүрдүүлэн өгөхийг шаарддаг. Нөгөөтэйгүүр жижиг ББСБ дунд барьцаа л байвал зээл олгодог ББСБ-ууд байдаг ба тухайн тохиолдолд бүрдүүлэх баримт бичиг ч хялбар байдаг. Томоохон ББСБ-ын хувьд бизнесийн зээл авах бүх харилцагчдаас дараах баримт бичгийг бүрдүүлэн өгөхийг шаарддаг. Үүнд: орлогыг нотлох баримт бичиг (зээлийн төрлөөс шалтгаалан өөр өөр байдаг) оршин суугаа хорооны тодорхойлолт, барьцаа хөрөнгийн холбогдох баримт бичиг гэсэн 3 төрлийн бичиг баримт байна.

Нэмэлт бүрдүүлэх баримт бичиг

Нэмэлт бүрдүүлэх баримт бичгийн тухайд иргэний зээлийг байгууллагын зориулалтын зээлээр авч байна гэж үзсэн тохиолдолд тухайн байгууллагын санхүүгийн тайланг авдаг.

(ii) Зээлийн судалгаа

- Зээлийн судалгааны баримт бичиг

Байгууллагын дотоод зээлийн судалгаа учир харилцагчийн төлөв байдлын мэдээллийг оруулсан материал, зээлийн шийдвэр гаргалтын шалгуур болох үнэлгээ, цаашилбал барьцааны хөрөнгийн нэмэлт мэдээлэл болон бусад мэдээллийг өгдөг.

- Зээл шийдвэрлэх эрх

ББСБ-ын салбар нь ерөнхийдөө жижиг хэмжээний үйл ажиллагаа явуулдаг бөгөөд салбарын түвшинд салбарын захирал, зээлийн эдийн засагч, теллер гэсэн 3 хүнээс бүрдэнэ. Ихэнх ББСБ нь адилхан бүтэцтэй байх ба хамгийн ихдээ 5 хүний бүтэцтэй байдаг.

Уулзалт хийсэн ББСБ-ууд нь хэд хэдэн салбартай байсан ч зээлийн судалгаа хийх арга аргачлал нь зээлийн мөнгөн дүнгээс шалтгаалан өөр өөр байсан. Салбар дээр 20 сая төгрөгөөс доош зээлийг батлах эрх байдаг бол мөнгөн гүйлгээний тооцоолол хийдэг ба тооцоолол хийх арга нь

байгууллагаас хамаарч бага зэрэг өөр байдаг.

- Барьцаа хөрөнгийн нөхцөл ба үнэлгээ

Томоохон ББСБ-ууд үл хөдлөх хөрөнгийн барьцааны үнэ цэнийг тооцоолохдоо үл хөдлөх хөрөнгийн цаг хугацааны үнэлгээний харьцаа, барьцааны төрөл, зээлийн төрлийг харгалзан үзэж 50%-70%-ийн хооронд тооцдог. Мөн зээлийн дээд хэмжээг орлогын 1/3-ээс дээшгүй байвал санхүүжүүлэх боломжтой гэсэн шалгуур байдаг. Сүүлийн жилүүдэд хамтран зээлдэгчтэй байхыг шаардах болсон. Өндөр настай харилцагч нарыг үр хүүхэд, гэр бүлийн хүн, хамтран амьдрагчийг хамтран зээлдэгч болохыг шаарддаг байна.

ЗМС-г ашигладаггүй зарим ББСБ-ууд бага хэмжээний 500 мянгаас 7 сая төгрөгийн зээлийг зөвхөн үнэт эдлэл, гар утасны дугаар зэргийг барьцаалан олгодог байгууллагууд байдаг. Түүнчлэн харилцагчийн сүүлийн 6 сарын банкны дансны хуулгыг хараад зээл олгох шийдвэрийг гаргадаг ББСБ-ууд ч байдаг ба тухайн ББСБ-д барьцаа хөрөнгө шаардлагагүй юм.

- (iii) Ашиглаж буй систем

ББСБ-ууд харилцагчийн талаарх мэдээллийн сан үүсгэсэн байдаг ч зээлийн судалгаа шинжилгээ хийдэг нэгдсэн систем байдаггүй. Томоохон ББСБ-ууд нэг нь ЕСБХБ-ны санхүүжилтаар Германы их сургуультай хамтран Excel-д суурилсан үнэлгээний (Scoring system) системийг дотооддоо боловсруулан хөгжүүлсэн байсан нь хамгийн дэвшилтэт хүчин чармайлт байсан. Энэхүү системд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг шивж оруулдаг ч зээлийн дүнгээс шалтгаалан өөр өөр байдаг ба санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л мэдээллүүд багтдаг. Гадаадын хөрөнгө оруулалт авч байсан эсэх, дэлгэрэнгүй мэдээллийг оруулан хэвлэхэд А4-ийн цаасан дээр 2 хуудас орчим болдог байна.

- (iv) Зээлжих зэрэглэл, зээлийн хүү

Банк бус санхүүгийн байгууллагуудтай тус бүр биечлэн уулзалт хийхэд ББСБ-ууд харилцагчдын зээлжих зэрэглэлийг хийдэг байгууллага байдаг ч зээлжих зэрэглэлийн үр дүнд уялдуулан зээлийн хүүг тогтоодог байгууллага байгаагүй. ББСБХ-ны хэлснээр зээлийн хүүг ББСБ тус бүрдээ тодорхойлдог. Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан зээлийн хүүгийн түвшнийг тогтоодог. Жишээлбэл Засгийн газраас хэрэгжүүлж буй ЖДҮ-ийн зээлээр дамжуулан сарын 0.6% -ийн хүүтэй санхүүжилт авсан тохиолдолд ББСБ нь ЖДҮ-д сарын 2% орчим хүүтэй зээл олгодог. Одоогийн зээлийн хүүгийн түвшин нь ББСБ, зээлийн бүтээгдэхүүнээс

хамааран бизнесийн зээлийн хүү сарын 2.6%-4.4% хооронд хэлбэлзэж байна. Зээлийн эрсдэлийн үнэлгээний системээр үнэлгээ хийдэггүй ч, ихэнх арилжааны банктай адил эхний зээлийг тогтсон зээлийн хүүгээр олгон 2 дахь удаагийн зээлээс эхлэн өнгөрсөн хугацаан дахь үр дүнд үндэслэн хүүгийн хэмжээг 0.5% хүртэл бууруулан хөнгөлөлт үзүүлэх тохиолдол байдаг.

(v) **Зээлийн шийдвэр гаргалтын тэргүүлэх үзүүлэлт**

Томоохон ББСБ-ууд нь арилжааны банктай адил зээлийн төслийн эргэн төлөх чадавхи гэх мэт тэргүүлэх үзүүлэлтүүдтэй бөгөөд, барьцаа хөрөнгийн хувьд гуравдугаарт ордог. Ялангуяа барьцаа хөрөнгөгүй зээл олгодог ББСБ-ууд нь эргэн төлөх чадавхыг чухалчлан авч үздэг. Нөгөөтэйгөөр жижиг ББСБ-ууд зөвхөн барьцаа хөрөнгийг барьцаалан зээл олгодог тохиолдол их байдаг. Энэ тохиолдолд зээл нь тэргүүлэх ач холбогдолтой гэж үзнэ.

(3) Зээлийн мэдээллийн агуулга, хяналтын арга өнөөгийн байдал, асуудал (чанаргүй зээлдэгчийн хяналт, тайлагнах үүрэг, агуулга)

1) Зээл олгосон байгууллагад тавих хяналт

Аж ахуй нэгж байгууллагын зээл авсан зээлдэгчид хяналт тавихдаа арилжааны банзтай адилхан зээл олгосны дараа санхүүгийн тайланг авдаг. Гэсэн ч ББСБ-ын зээл нь ихэвчлэн хувь хүн иргэнд чиглэсэн байдаг тул тогтмол зээлдэгчтэй уулзах зэргээр хяналтыг явуулдаг. ББСБХ-ны ярилцлага судалгаагаар салбарын хэмжээнд чанаргүй зээлийн харьцаа дунжаар 9.4%-тай байдаг байна.

2) Чанаргүй зээлийн тодорхойлолт

ББСБ-уудад хамааралтай бөгөөд 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийг чанаргүй зээл гэж тодорхойлдог. Бодит байдал дээр томоохон ББСБ-ууд нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийг чанаргүй зээл гэж тодорхойлон үздэг байгууллагууд байдаг бол 30 хоног хэтэрсэн зээлийг чанаргүй зээл гэж үзэх байгууллагууд ч байдаг.

3) Чанаргүй зээлийн нөхцөл байдлын хяналтын арга

Банк бус санхүүгийн байгууллагууд дотоод эрсдэлийн журмын дагуу чанаргүй зээлийг шийдвэрлэдэг. Томоохон ББСБ-ын нэгээс жишээ дурдахад эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн тохиолдолд ямар арга хэмжээ авдаг талаар тодруулахад хэтэрсэн нэг өдөр бүрийн авах арга хэмжээний агуулга нь тогтсон байдаг байна. 1-90 хүртэл өдрийн эргэн төлөлтийн арга хэмжээг салбар дээр, түүнээс дээш болбол төв шилжиж хяналт арга хэмжээг авдаг. Чанаргүй зээл гарсан

тохиолдолд хөдлөх хөрөнгийн барьцаа байвал гэрээнд заасны дагуу ББСБ хөдлөх хөрөнгийг хураан авч борлуулан зарснаар хөрөнгө буцаан олдог бол үл хөдлөх хөрөнгө барьцаанд байх тохиолдолд шүүхээр маргааныг таслан шийдвэрлүүлэх шаардлагатай болдог.

(4) Холбогдох үйл ажиллагаа (харилцагч нарт зориулсан үйлчилгээ)

1) Зөвлөгөө

Сүүлийн жилүүдэд, ББСБ-уудын дунд хүчтэй өрсөлдөөн бий болсны улмаас ББСБ-ууд зээл авсан харилцагч нартаа төрөл бүрийн зөвлөгөө өгөх ажлыг хэрэгжүүлж байгаа хэд хэдэн компаниуд байна.

2) Семинар

Харилцагч нарт зориулан зохион байгуулдаг сургалт семинарын жишээ. Тодорхой агуулгын хувьд гурван үе шаттай сургалтыг зохион байгуулж хувь хүмүүст 2-3 цагийн орлогын зарлага, ашиг, хадгаламжийн талаар холбогдох сургалт семинарыг зохион байгуулдаг. Үүнээс гадна, ЕСБХБ зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах тохиолдлууд байдаг ба бизнес төлөвлөгөөг хэрхэн бэлтгэх аргыг зааж сургасан ололт амжилт байна.

Мөн ББСБ-ын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулдаг. Жишээ нь, 2018 оны 6-р сарын 5-ноос 7-ны хооронд СЗХ, ББСБХ хамтран ББСБ-ын зээлийн эдийн засагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан байна. Тус сургалт нь Монгол улсын банкны салбар дахь шилдэг туршлагаууд, бодит жишээ, зээлийн холбогдох ёс суртахуун, хэрэглээний арга барил зэрэг чадварлаг зээлийн мэргэжилтнийг бэлтгэх зорилготой байсан.

3.4 Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хөгжлийн түүх, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

(1) Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хөгжлийн түүх

1) Зээлийн мэдээллийн сангийн хэрэгцээ шаардлага, бэлтгэл ажил

Монгол улс хоёр үе шаттай банкны тогтолцоог нэвтрүүлснээр зээлийн эрсдэлийг бууруулах хэрэгцээ шаардлага нэмэгдсэн байна. Тиймээс 1995 онд арилжааны банкуудын болзошгүй зээлийн эрсдэлийг багасгаж бууруулахаар Монголбанкны ерөнхийлөгчийн 11-р тушаал “Зээлийн мэдээллийн системийг бий болгох, зээлийг тайлагнах журам” -ыг баталсан. Түүнчлэн төрийн зээлийн бүртгэлийн тогтолцооны эхлэлийн үе шат болох “улсын зээлийн бүртгэлийн систем” -ыг боловсруулах тухай Монголынбанкны ерөнхийлөгчийн 384 тоот тушаал 1996 онд батлагдсан. Үүнээс гадна “Зээлийн мэдээллийн тухай журам” (1999 оны 1-р сарын 1-ны өдөр) батлагдсаны дараа Монгол улсад төрийн зээлийн бүртгэлийг албан ёсоор эхлүүлсэн.

2) Төрийн зээлийн бүртгэлийг сайжруулах

Монголын зээлийн мэдээллийн систем үүсгэн байгуулагдсанаас хойш хэд хэдэн удаа шинэчлэл хийгдсэн байна. 1997 оны 159 дүгээр тушаалаар төрийн зээлийн бүртгэлийн байгууллага, банк санхүүгийн байгууллагууд дахь зээлийн мэдээллийн талаарх мэдээллийг дамжуулах (солилцох) ажлын нэг хэсэг болгон шаардлагатай бүх мэдээллийг, нягтлан бодох бүртгэлийн програмд суурилан бий болгож сүлжээгээр дамжуулан автоматаар илгээх боломжтой болгон шинэчлэн сайжруулсан. 1999 онд шүүхийн байгууллага, хууль сахиулах байгууллагуудын зээлийн мэдээллийг ашиглах боломжтой болгох зохицуулалт (№ 467 тоот тушаал)-ыг батлагдсан. 2001 оны 565 дугаар тушаалын дагуу арилжааны банкнаас гадна бусад санхүүгийн байгууллагууд зээлийн мэдээллийг ашиглан мэдээлэл зээлэн мэдээллийг солилцож эхэлсэн. Үүнээс гадна, 2005 онд баталсан 131-р тушаалаар программ хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг хангах шалгуурыг стандартыг баталсан. Мөн 2011 онд томоохон шинэчлэл хийгдэж зээлийн мэдээлэл, санхүүгийн сахилга батыг сайжруулахын тулд Монголбанк зээлийн мэдээллийн тухай хуулийг боловсруулж УИХ-аар батлуулсан байна.

Бүтэц зохион байгуулалтын сайжруулалтаас гадна программ хангамжийг шинэчлэн сайжруулах арга хэмжээ авч байсан. Тухайлбал, 1997 оны 159 тоот тушаалын дагуу Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран төрийн зээлийн бүртгэлийн программ хангамжийг боловсруулсан бөгөөд 2009 оны 6-р сарын 1-ээс 2017 он

хүртэл тухайн программыг ашигласан байна. Монголбанкны мэдээллийн технологийн газар нь улсын зээлийн бүртгэлийн шинэ программ хангамжийг боловсруулж, 2017 оны 6-р сарын 24-нд ашиглалтад оруулсан байна.

(2) Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн систем

1) Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн системийн хэрэглээний төлөв

Энэхүү судалгааны үеэр Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн системтэй 14 арилжааны банк, 1 хөгжлийн банк, 407 ББСБ, 94 хадгаламж зээлийн хоршоо, засгийн газрын ипотекийн компани Монголын ипотекийн зээлийн компани, зээлийн батлан даалтын сан, лизингийн компаниуд тусгай зориулалтын яам, агентлаг гар утасны оператор компани зэрэг 650 орчим байгууллага холбогдож хандах эрхтэй байсан. Мөн зээлийн мэдээллийн санд ойролцоогоор 1,722 зээлдүүлэгчийн (хувь хүн: 1,7 сая, аж ахуй нэгж байгууллага: 22,000) 9,753,387 тооны зээлийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Зээлийн мэдээллийн санд хандах эрхтэй байгууллага сард дунджаар 575,000 удаа хандалт хийж ойролцоогоор 1,675,000 зээлийн мэдээллийг хүлээн авдаг байна.

2) Банк санхүүгийн байгууллагаас ЗМС-д мэдээлэл оруулах

Монгол Улсын өнөөгийн банкны тогтолцоо нь арилжааны банк, ББСБ-ууд зээлийн мэдээлэл, эргэн төлөх хугацаа хэтэрсэн тухай дараах мэдээллийг Монголбанкны хяналт шалгалтын газарт тайлагнах үүрэгтэй байдаг⁴¹.

- 1) Зээлдэгч, батлан даагч, зээлийн хүсэлт гаргасан этгээдийн мэдээлэл (овог нэр, хаяг, регистрийн дугаар, бизнесийн төрөл гэх мэт)
- 2) Зээл, баталгаа, зээлийн холбогдох мэдээлэл (зээл олгосон хугацаа, эргэн төлөх өдөр, зориулалт, мөнгөн дүн, эцсийн төлөлт хийх хугацаа гэх мэт)
- 3) Хугацаа хэтэрснээс үүдэн шүүхэд гомдол гаргуулсан зээлдэгчийн мэдээлэл
- 4) 3 сар ба түүнээс дээш хугацаа хэтэрсэн зээлийн карт эзэмшигч, зээлдэгчийн мэдээлэл (овог нэр, зээлийн эцсийн үлдэгдэл гэх мэт)
- 5) Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл (барьцаа хөрөнгийн төрөл, зээлийн дүнд эзлэх хувь, барьцаа хөрөнгийн үнэлгээ гэх мэт)

⁴¹ Зээлийн мэдээллийн сангийн тухай журам (Монголбанкны ерөнхийлөгчийн 2005 оны 131 тушаал) Хавсралт 1

6) Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, нэгийн үйлчилгээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хөрөнгийн бирж зэрэг төрийн байгууллагаас авсан лавлагаа.

7) Бусад мэдээлэл

Монголбанкны хяналт шалгалтын газар нь эдгээр цуглуулсан мэдээллийг зээлийн мэдээллийн санд боловсруулан хадгалж, мэдээллийн нууцлалыг хангах талаар зохистой удирдан зохицуулах үүрэгтэй юм. Монголбанкны орон нутгийн салбарууд нь салбар газарт харьяалагдах компаниудын зээлийн мэдээллийн цуглуулах үүрэгтэй ба зээлийн мэдээллийн санг хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлж байна.

Арилжааны банк, ББСБ нь ЗМС-д өгсөн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцахаас гадна ЗМС-аас хуурамч буюу буруу мэдээлэл авах, эсвэл мэдээллийг өөр зорилгоор ашигласан тохиолдолд торгууль ногдуулна зорилготой юм⁴².

3) ЗМС-ын банк санхүүгийн байгууллагуудын хэрэглээ

Бүх санхүүгийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк ЗМС-д зээлдэгчийн нэрийг тодорхойлон өгөгдлийг хадгалах үүрэгтэй. Энэхүү мэдээллийн сан нь банк, ББСБ, тооцооны төв, Төлбөр тооцооны үндэсний зөвлөл⁴³, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөрөнгийн бирж зэрэг газрууд нь ЗМС-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан хэрэглэгчид үүрэгт ажлын шаардлага зорилгоор ашиглах боломжтой. Харилцагч зээл авах хүсэлт гаргасан тохиолдолд банк бүр тухайн байгууллагын талаарх лавлагааг авах ба дараах загвараар гарна.

⁴² Цалингийн доод хэмжээний 40 дахинтай тэнцэх торгууль ноогдуулах, сангаас мэдээлэл авах эрхийг 6 сараас 1 жил хураана.

⁴³ Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар 2008 онд байгуулагдсан. Төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд системийн оролцогчдын хамтын ажиллагааг бий болгох зорилготой. (<https://www.mongolbank.mn/eng/listpaymentsystem.aspx?id=2>)

Л/О	Registration number	The total amount of loans	Date of loan	The loan maturity Date	Currency name	Loan outstanding	Loan classification					Types of collateral		Number of Collateral	State registration number of collateral certificate	Name of Bank	Explanation	
							Pass	Overd	Substandard	Doubtful	Loss	Group	Subgroup					
1			2017-07-26	2018-12-10	MNT	0.00	+						Receivable, future income	Receivables from local organizations			Khas Bank (32)	
													Receivable, future income	Dividend income				
													Land	Right of ownership of land				
													Buildings	Apartment				
													Buildings	Apartment				
													Buildings	Apartment				
													Buildings	Apartment				
													Buildings	Industrial buildings and facilities				
													Machinery, transport and other equipment	Other vehicles				
2			2017-05-10	2017-12-18	MNT	0.00	+						Receivable, future income	Other fixed income			XAC (32)	

Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.6 Зээлийн мэдээллийн сангийн загвар (аж ахуй нэгж)

(3) Одоогийн Монголбанкны ЗМС-ийн системийн тулгамдаж буй асуудал

Өнөөгийн Монголбанкны ЗМС-ийн системд тулгамдаж буй асуудал олон байна. Тухайлбал, ОУСК 2018 оны 3-р сард ЗМС-ийн өнөөгийн байдлыг судалж, дараах асуудлуудыг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзсэн ба шинэчлэн сайжруулах саналыг гаргасан байна.

- Зээлийн мэдээллийн лавлагаа нь зээлдэгчийн зээлийн үйл ажиллагаанд шаардлагатай бүх мэдээллийг агуулдаггүй
- ЗМС нь хангалттай мэдээллийн сан, мэдээллийг боловруулдаггүй
- ЗМС-ийн ашиглаж буй программ хангамж нь олон улсын стандартад нийцэхгүй

Дээр дурдсан асуудлуудыг ОУСК-аас Монголбанканд санал болгосон тайланд тусгаагүй бөгөөд тус бүрийн дэлгэрэнгүй агуулга нь олон нийтэд ил тод болоогүй байна. Одоогоор Монголбанк ОУСК-тай ЗМС-ийн мэдээллийн санг шинэчлэн сайжруулах ажлыг 2018 оны 6-аас эхлүүлэхээр бэлтгэж байна.

Түүнчлэн ОУСК-с гаргасан саналаас гадна хөдөө орон нутагт цуглуулсан зээлийн мэдээллийг санхүүгийн тайлангнгалын улирал бүр Монголбанкинд тайлагнаж үйл ажиллагааны тайланг хавсарган илгээх зээлийн мэдээллийн өгөгдлийг мэдээлэл технологийн газарт тайлагнахаар заасан байдаг боловч бодит байдал дээр ЗМС-ийн мэдээллийг шуурхай шинэчлэх, чанартай мэдээллийг хадгалахад хүндрэлтэй байдаг. Энэ нь арилжааны банк болон бусад байгууллагууд өөрсдийн гэсэн мэдээллийн санг бий болгох чиг хандлагатай байгаа ч банк санхүүгийн салбар ЗМС нь илүү өргөн хүрээний цогц мэдээллийг цуглуулан санхүүгийн байгууллага, холбогдох яам, агентлагуудтай мэдээлэл солилцох маш их сонирхолтой байгаа.

Үүнээс гадна, ЗМС-д хамрагдах шаардлагатай байгууллагууд бүгд хамрагдаагүй байгаа нь асуудал болоод байна. ББСБ-ууд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авснаас хойш 3 сарын дотор Монголбанктай гэрээ байгуулж ЗМС-аас зээлийн мэдээлэл авах тухай 2015 оны журамд үүрэг болгосон байдаг ба Монголбанкны ЗМС-тай гэрээ байгуулахад үнэ төлбөргүй байхад ЗМС-г бүх ББСБ-ууд ашиглахгүй байна.

3.5 ЗМС-аас бусад зээлийн мэдээлэл агуулсан мэдээллийн сан

Зээлийн мэдээлэлд хамаарах өгөгдлийн санг ерөнхийд нь 1) нэртэй мэдээлэл, 2) нэрийг хууцалсан мэдээлэл гэж хоёр ангилан хуваадаг. Мэдээллийн сан бүрийн хувьд Монголбанкны ЗМС-аас өөр өгөгдлийн санг боловсруулах, хадгалах нөхцөлийн талаар доор дурдав.

(1) Нэр нь тодорхой мэдээлэл

Нэр нь тодорхой мэдээллийн тухай дээр дурдсанчлан Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн одоогийн явуулж буй зээлийн мэдээллийн хяналтад суурилсан мэдээллийн сан бөгөөд бусад хувийн компаниудын ЗСМ-ийн үүсгэх, мөн компанийн санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулсан мэдээллийн хувьд Сангийн яамны санхүүгийн тайлангийн мэдээллийн сан, ХХААХҮЯ-ны ЖДҮ-ийн газрын ЖДҮ-ийн мэдээллийн сан болон ҮХГ-ын аж үйлдвэрийн мэдээллийн сан байна.

1) Хувийн хэвшлийн ЗМС

1990 оны сүүлээс эхлэн Монголбанкинд зээлийн мэдээллийн төв байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байсан боловч дээр дурдсанчлан хувийн арилжааны банкуудад хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн сангийн хэрэгцээ шаардлага байсан бөгөөд 2005 оноос хойш МБХ-ны гишүүн банкууд Зээлийн мэдээллийн төв ХХК-г үүсгэн байгуулах талаар хэлэлцэж ирсэн. 2009 онд МБХ-нь Зээлийн мэдээллийн төв ХХК нь АНУ-ын ОУХА болон ОУСК-ын дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан. 2010 онд АНУ-ын Dun & Bradstreet ХК болон Зээлийн мэдээллийн төв ХХК хамтран хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэх төвийг байгуулахаар тохиролцож 2014 онд Монголын Интерактив ХХК-д зээлийн мэдээллийн системийг боловсруулах захиалгыг өгч үнэлгээний системийг (Scoring system) нэвтрүүлэхээр зорьж байгаа. Гэсэн хэдий ч хувийн хэвшлийн Зээлийн мэдээллийн төв ХХК нь Монголбанкинд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай ба Зээлийн мэдээллийн төв ХХК нь ажилтны томилгоог хүртэл хийсэн байгаа хэдий ч үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөлд хэвээр байна. Энэхүү Зээлийн мэдээллийн төв ХХК-аас гадна хоёр компани шинээр зээлийн мэдээллийн үйлчилгээний зөвшөөрлийг авахаар оролдлого хийсэн ч (компанийн нэрийн нууцалсан), энэхүү судалгааны явцад аль ч компани систем нь зээлийн мэдээллийн тухай хуулийн 23-р зүйлд заасны дагуу шаардлагатай систем үйл ажиллагааг явуулах байгууллагын зөвшөөрлийн нөхцөлийг хангаж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа эрхлэх

тусгай зөвшөөрлийг аваагүй байдалтай байна⁴⁴.

2) Сангийн яамны мэдээллийн сан (E-Balance)

< Сангийн яамны мэдээллийн сангийн тойм >

Сангийн яамны мэдээллийн сан нь сангийн сайдын тушаалд үндэслэн аж ахуйн нэгж байгууллагын тушаасан санхүүгийн тайланг харьяа аймаг, дүүрэг тус бүрийн санхүүгийн газраас Сангийн яамны нягтлан бүртгэлийн бодлогын газарт илгээдэг байна. ҮСХ-ны статистик мэдээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар ойролцоогоор 120,000 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байгаагийн 78% нь санхүүгийн тайлангаа илгээсэн байна. Санхүүгийн тайлангийн тухайд бараг бүх компани, тэр дундаа ЖДҮ-үүд жил бүр шинэчилдэг ба одоо санхүүгийн тайланг цахим байдлаар (E-Balance) системийг ашиглан илгээдэг. Санхүүгийн тайлан нь дөрвөн төрлийн тайлангаас (санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан) бүрдэх ба санхүүгийн бус мэдээлэл 25 үзүүлэлтийг бөглөн тушаадаг болно. Санхүүгийн тайлангийн агуулгыг аймаг, дүүргүүдийн санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн шалган хүлээн авдаг байна. Цахимаар санхүүгийн тайланг тушаасны дараа Сангийн яаманд журмын дагуу тушаасан эсэхийг шалгах боломжтой боловч тайлангийн агуулгыг засаж өөрчлөх боломжгүй юм. Орлогын агентлагийн татвар төлөх мэдүүлгийн хэмжээ, тууштай байдлыг баталгаажуулсан болно. Татварын ерөнхий газар тушаах татварын тайлантай мөнгөн дүнг тэнцүүлэн гаргадаг боловч дефолтын талаар холбогдох мэдээлэл огт оруулдаггүй байна.

< Төрийн байгууллагууд дахь мэдээллийн санг ашиглах >

Сангийн яамны мэдээллийн санг Засгийн газрын холбогдох бүх байгууллагууд ашиглаж болох ба их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд ч ашиглаж болдог. Төрийн байгууллагууд санхүүгийн тайлангийн аль үзүүлэлтийн мэдээллийг ашиглаж болох талаар байгууллага бүрийн хүсэлтэд үндэслэн өөр байж болно. Тухайлбал, ХХААХҮЯ нь Сангийн яаманд санхүүгийн тайлангийн борлуулалт орлогын талаарх мэдээллийг авах хүсэлт гарган байдаг тул зөвхөн борлуулалтын орлогыг харах боломжтой. Гэсэн хэдий ч бүх төрийн байгууллагууд Сангийн яамны мэдээллийн санд нэвтрэх эрхтэй гэсэн үг биш юм. Татварын ерөнхий газрын E-

⁴⁴ 2018 оны 5-р сарын 24-ны өдөр Монголбанктай хамтарсан ажлын хэсгийн 3 дахь удаагийн уулзалтаар Монголбанкнаас “ОУСК-аас Монголбанкны ЗМС-ийн системийг судалгааг хийж байгаа ба эхний ээлжинд хуучин олон улсын стандартад нийцээгүй ЗМС-г шинэчлэх саналыг тавьсан. Энэ оны 6 -р сараас системийг шинэчлэх төслийг эхлүүлэхээр төлөвлөсөн байсан ч өндөр зардлын зохицуулалт хийхэд хугацаа их орж байгаа. Тиймээс ЗМТ ХХК-ийн тусгай зөвшөөрлийг 2020 он хүртэл олгох боломжгүй” гэсэн тайлбарыг өгсөн.

Тах орлогын тайланг E-Balance-ийн тайлантай харьцуулан үздэг.

3) ХХААХҮЯ-ны мэдээллийн сан

ХХААХҮЯ-ны ЖДҮ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын үндсэн чиг үүргийн нэг болох ЖДҮ-ийн хүсэлтийн дагуу ЖДҮ-ийг баталгаажуулан гэрчилгээ олгох үйл ажиллагаа юм. Энэхүү баталгаажуулалт нь ЖДҮ-үүд ЖДҮ хөгжүүлэх сан болон ЗБДС-аас зээл авахын тулд тухайн компани нь ЖДҮ эрхлэгч (200 хүртэл ажилтантай, жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөр) мөн гэдгийг баталгаажуулсан гэрчилгээг шаарддаг тул дээрх газар нь чиг үүргийн дагуу олгодог байна. Энэхүү үйл ажиллагааны явцад ЖДҮ-эрхлэгчд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн тайлан, үйл ажиллагааны чиглэл зэрэг холбогдох материалуудыг өгөхөөс гадна нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгал төлж буй ажилчдын тоог баталгаажуулсан тодорхойлолт, татварын ерөнхий газрын татварын тодорхойлолтыг бүрдүүлэн өгдөг. Эдгээр мэдээлэл материалыг ХХААХҮЯ-д хуримтлуулан хадгалдаг. Мэдээллийн сангийн хувьд нэг жилийн хугацаанд 2000 компани хүсэлт гаргадаг ба одоогоор 10,000 орчим компанийн мэдээлэл цугларсан байдаг байна.

4) ХХААХҮЯ-ны шинэ мэдээллийн сан

ХХААХҮЯ нь одоогийн байгаа мэдээллийн сангаас өөр шинэ мэдээллийн санг бий болгохоор судлан үзэж байна. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний зорилгуудын нэг мэдээллийн санг бий болгох арга хэмжээ орсон байна.

Мэдээллийн сангийн мэдээллийн агуулгын хувьд өнгөрсөн хугацаанд ЖДҮХ сангаар дамжуулан зээл авсан компаниудын мэдээллээс бүрдэнэ гэж таамаглаж байна. Тодруулбал мэдээллийн санд борлуулалтын орлого, ажиллагсдын тоо зэрэгт тулгуурлан үнэлгээ хийх аргаар төлөвлөж байгаа. Одоогоор ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан байгаа ба тус хуулийн төсөл батлагдвал мэдээллийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой болно гэж үзэж байна.

Монголбанкны ЗМС байгаа нөхцөл байдалд ХХААХҮК нь шинээр мэдээллийн сан үүсгэж байгаа нь 1) Энэхүү мэдээллийн сан нь ЖДҮ-ийн зээлийн эрсдлийн мэдээллийг цуглуулах гол зорилготой биш ч, төрөл бүрийн сангаар дамжуулан зээл авсан ЖДҮ-ийн зээлийн түүхийг нэгтгэх зорилготой юм. 2) ЗМС нь арилжааны банк болон ББСБ-уудын зээлийн мэдээнээс бүрддэг бөгөөд бусад сангуудаар дамжуулан олгосон зээл болон бусад санхүүжилтийн

мэдээллийг оруулаагүй талаар онцолж байсан.

Гэсэн хэдий ч энэхүү мэдээллийн сангийн талаарх хэлэлцүүлэг эхний үе шатанд явж байгаа ба МБХ-оос хэрэгцээ шаардлага, хамтран ажиллах саналыг хүлээн авсан ч мэдээллийн сангийн үйл ажиллагааг явуулах байгууллага, сангийн мэдээллийг цуглуулах аргын тухайд тодорхой шийдвэрт хүрээгүй байгаа ба ЖДҮ-ийн агентлаг үүсгэн байгуулах хэрэгцээ шаардлагын талаар судлан үзэх юм байна.

5) Үндэсний хөгжлийн газрын аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сан

Үндэсний хөгжлийн газар бүс нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлдвэрлэгч бүрд хүрсэн бодлогыг хэрэгжүүлэх, дэмжлэгийг оновчтой зохион байгуулах зорилгоор улсын хэмжээнд аж үйлдвэрлэлийн цахим мэдээллийн санг бий болгоод байна. Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын 25% буюу 1,800 орчим аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл орсон байна. Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны цар хүрээ, зарим нэгийнх нь зээлийн мэдээлэл, бизнесийн төлөвлөгөө зэрэг мэдээллийг шинэчлэн хянах боломжтой. Одоогоор Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр системийг шинэчлэх, мэдээлэл оруулах ажлыг зохион байгуулж байна.

(2) Нэр нь тодорхойгүй мэдээлэл

Энэхүү судалгааны үеэр Монгол улсад нэр нь тодорхойгүй санхүүгийн тайлангаас бүрдэх зээлийн мэдээллийн хяналтын хүрээнд ерөнхийдөө ашиглах боломжтой мэдээллийн сан байгаагүй ба бий болгох төлөвлөгөө байгаагүй.

3.6 ЗЭМС нэвтрүүлэх боломж

(1) Монголын санхүүгийн салбарт нэвтрүүлэх боломжийн талаар танилцуулж, хэлэлцэх

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монгол улсын эдийн засгийн чиг хандлагын тухайд 2006-2013 оны хооронд уул уурхайн нөөцийн хөгжилд тулгуурлан өсөлттэй байсан хэдий ч 2013 оноос хойш ашигт малтмалын түүхий эдийн үнийн уналт, улс төрийн тогтворгүй байдал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг нөлөөллийн улмаас эдийн засаг, санхүүгийн хямралд орж цаашилбал ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор олон улсаас эдийн засгийн дэмжлэгийг авснаар эдийн засгийн сэргээх үе шатанд байгаа. Санхүүгийн салбарын хувьд төсвийн хэмнэлт явуулж санхүүгийн хүртээмжийг өргөтгөх үе юм.

Хувийн хэвшлийн санхүүгийн чадавхи, хөрөнгийн эх үүсвэрийн хүртээмжийн чадавхи нь санхүүгийн зах зээл, механизм зарим талаараа дутагдалтай байсан бөгөөд урт хугацааны харьцааны хувьд салбар бүр харилцан адилгүй байдаг боловч 5 жилээс дээш хугацаатай зээл нь нийт зээлийн 13%-тай тэнцүү байна. Үүнээс гадна ЖДҮ-ийн санхүүжилтийн хувьд иргэний зээл нь ЖДҮ-ийн зээлээс их ялангуяа санхүүгийн хэрэглээний өсөлт өндөр (Хүснэгт 3.10) байгаа тул цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна. Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр ЖДҮ-ийн санхүүжилтийн нийт дүн, багцын харьцаа урт хугацааны зээлийн харьцаа зэрэг бүхэлдээ хэдийгээр бага боловч сайжирч байгаа ба 2017 онд ЖДҮ / иргэний зээл ойролцоогоор 808 тэрбум төгрөг, ЖДҮ /хувийн хэвшлийн зээл 1,661 тэрбум төгрөг нийт 2,500 тэрбум төгрөгийн зээл байна (Хүснэгт 3.10). Иргэний зээлийн эцсийн үлдэгдэл 6,608 тэрбум (2017 он хүснэгт 3.10) төгрөг, үүний тал нь бизнесийн зориулалттай санхүүжилт 3,000 тэрбум төгрөг, ЖДҮ-ийн санхүүжилтийн суурь 2017 онд 5,500 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 3.9 Хувийн хэвшилд олгосон зээлийн эцсийн үлдэгдэл

Нэгж: тэрбум төгрөг

Салбар	Он	Эцсийн үлдэгдэл	1 жилээс бага		1-5 жил		5-аас дээш жил	
			Төлөв	Хувиар	Төлөв	Хувиар	Төлөв	Хувиар
Нийт	2008	1,336	583	44%	704	53%	48	3%
	2012	3,495	956	27%	2,260	65%	269	8%
	2017	5,179	1,004	19%	3,488	68%	686	13%
Уул уурхай	2008	113	63	56%	47	42%	3	2%
	2012	673	251	37%	422	63%	0	0
	2017	574	129	22%	442	77%	2	1%
Үйлдвэрлэлийн салбар	2008	312	85	27%	205	66%	22	7%
	2012	677	170	25%	415	61%	92	14%
	2017	975	182	19%	656	67%	137	14%
Барилга	2008	294	133	45%	158	54%	3	1%
	2012	1,118	241	22%	762	68%	52	5%
	2017	823	81	10%	668	81%	74	9%
Үйлчилгээний салбар	2008	617	304	49%	294	48%	20	3%
	2012	1,027	303	30%	661	64%	125	11%
	2017	1,321	432	33%	748	57%	140	10%

Эх сурвалж: BOM HP Statistics, Banks Outstanding Loan

Хүснэгт 3.10 Иргэн / ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдэл

Нэгж: тэрбум төгрөг

Year	Individual loan	Mortgage loan	SME loan /individual	Consumer loan	Salary loan	Pension loan	Other	SME loan /private/
2008	1,030,054	237,491	291,659	104,153	104,096	47,438	245,216	212,927
2009	919,949	244,003	255,637	58,816	120,356	55,331	185,806	227,431
2010	1,334,140	362,856	347,544	114,586	234,000	71,280	203,874	277,618
2011	2,439,603	710,583	568,859	159,554	559,104	116,979	324,525	473,698
2012	3,074,548	915,281	598,997	167,322	762,490	200,895	429,562	590,174
2013	4,640,385	1,620,345	833,435	223,984	1,220,096	260,756	481,769	971,079
2014	5,648,914	2,024,458	905,542	330,395	1,435,070	354,800	598,650	1,270,619
2015	4,963,948	1,425,420	778,684	303,101	1,393,206	433,918	629,620	1,270,097
2016	5,605,062	1,855,208	697,782	298,103	1,528,428	547,404	678,137	1,282,229
2017	6,608,506	1,699,186	808,542	679,760	2,131,634	695,163	594,102	1,661,516

Эх сурвалж: BOM HP Statistics, Banks Outstanding Loan

Энэ судалгааны ажлын хүрээнд судалгаа эхэлсний дараа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ЗЭМС-ийн семинарыг зохион байгуулж Монгол Улсад ЗЭМС-ийн тухай мэдээлэл өгч ойлголтыг бий болгохын зэрэгцээ холбогдох банк санхүүгийн байгууллага, ЖДҮ-эрхлэгч, ААН-тэй уулзалт ярилцлагыг хийх замаар ЖДҮ-ийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар ойлголттой болсон. Семинарт оролцсон оролцогч нарын холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулсан. Ажил ихтэй хэдий ч олон байгууллагууд идэвхитэйгээр уулзалтын цаг зав гарган ЗЭМС-ийн талаарх сонирхол ихэссэн гэж үзэж байна.

Банк санхүүгийн салбартай хийсэн уулзалтын үеэр зээлийн судалгааны үйл ажиллагаа их, барьцаа хөрөнгө, батлан даалтаас гадна зээлийн судалгаанд ашиглах арга хэрэгсэл хомс байдаг нөхцөлд ЗЭМС гэдэг шинэ хэрэглүүрийг Монголд нэвтрүүлэх нь ач холбогдолтой, хүлээлттэй байгааг мэдсэн. Үүний зэрэгцээ санхүүгийн холбогдох хүмүүсийн хувьд ч ЗЭМС болон үнэлгээний загварчлалын тухай ойлголт дутмаг, ялангуяа нэр нь тодорхойгүй санхүүгийн тайланг авах тал дээр ойлголтгүй байснаас харилцагчийн мэдээллийг авах гэсэн нэг төрлийн буруу ойлголтыг өгсөн тохиолдол байсан тул ЗЭМС-ийн холбооны мэргэжилтнийг ахин урьж хоёр дахь удаагийн ЗЭМС-ийн семинарыг зохион байгуулан Монгол улсад ЗЭМС-г нэвтрүүлэхэд сайн болон сул тал үнэлгээний загварыг боловсруулах, ЗЭМС-г бий болгохын учир, ач холбогдлыг холбогдох хүмүүст сайтар ойлгуулахаар ажилласан.

(2) Бусад зээлийн судалгааны хэрэгсэлтэй харьцуулсан судалга

Энэхүү судалгаанд банк санхүүгийн байгууллага, ЖДҮ-үүд хийсэн уулзалт ярилцлагаас үзэхэд ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг хязгаарлаж буй 1. Өндөр хүүтэй богино хугацаатай зээл, 2. Барьцаа хөрөнгийн асуудал, 3. ЖДҮ санхүүгийн бүтэц эмзэг, 4. ЖДҮ-ийн бизнесийн төлөвлөгөө болон санхүүгийн тайлан боловсруулах чадавхи сул зэрэг асуудлуудыг тавьж байсан. “Монгол улсын санхүүгийн дэд бүтцийн суурь судалгаа”-ны (2014 оны 3 сар) тайланд дурдсан асуудлуудтай нэг их зөрөөгүй байсан. Тэр дундаа батлан даалтын асуудал ЗБДС-ийн батлан даалтын асуудал (өмнө хэсгийн (4) зээлийн мэдээллийн салбарын холбогдох олон улсын байгууллагын дэмжлэг хамтын ажиллагааны АХБ-ны техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлсний дараа гарсан асуудал хэсэгт дурдсан) үргэлжилж байгаа тул барьцаагүй, батлан даалтгүй санхүүжилт нь банк санхүүгийн байгууллагуудын хувьд маш их бэрхшээл болоод байгаа ба эрсдэлийн урамшууллыг бууруулах болон зээлийн судалгааны зардлыг багасгахад хүргэх ЗЭМС нэвтрүүлэх тал дээр ихээхэн сонирхож байгаа нь тодорхой харагдсан билээ.

Монголын ЖДҮ-ийн санхүүгийн тайлан хэд хэдэн төрөл байгаа нь ойлгомжтой юм. Банкны зээлийн судалгаанд санхүүгийн тайлангаас гадна бизнесийн түншүүдтэй хийсэн гэрээг өгөхийг шаарддаг ба банк бодит санхүүгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлаг боловсруулж санхүүгийн шинжилгээг хийдэг. Банкны зээлийн судалгаа хийхэд цаг хугацаа их зарцуулж судалгааны зардал ихсэхэд нөлөөлдөг. Судалгааны хүрээнд Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газраас энэхүү нөхцөл байдлыг сайжруулах саналтай байгаа талаар сонссон юм. ЗЭМС -г бий болгоход үнэн бодитой санхүүгийн тайланг цуглуулах нь хамгийн чухал нөхцөл ба ЗЭМС-г нэвтрүүлэх, санхүүгийн тайланг сайжруулах асуудлыг зэрэг явуулснаар гарах үр дүн нь өндөр байна гэж үзэж байна.

Монголд ЖДҮ-д зориулсан урт хугацааны бага хүүтэй зээлийг Хоёр үе шаттай зээл болон АХБ-ны техникийн хамтын ажиллагааны хүрээнд ЗБДС-аар дамжуулан олгодог зээл зэргээр хязгаарлагдаж байна. Барьцаа, батлан даалт, харилцах хадгаламжийн зээлээс бусад зээлийн эрсдэлийг бууруулах хангалттай арга хэрэгсэл байхгүй, зээлийн шийдвэр гаргалтад зарцуулдаг судалгааны зардал, цаг хугацааг багасгах арга хэрэгслийн тухайд бодит байдал дээр ЗЭМС-аас өөр сайн арга байхгүй. Нөгөөтэйгөөр ЗЭМС-г нэвтрүүлэхтэй холбоотойгоор дефолт мэдээлэлтэй хамт үнэн зөв санхүүгийн тайлан зэрэг холбогдох мэдээлэлд регрессийн шинжилгээ хийх учир тохирох хэмжээний мэдээллийг цуглуулах шаардлагатай юм. Иймээс Монголын эдийн засаг, аж ахуй нэгж байгууллагын тоо, банк тус бүрийн олгосон зээлийн тоог харгалзан үзэж сул талгүй ЗЭМС-ийн системийг үр дүнтэй ажиллах эсэх дээр маш болгоомжтой анхаарч үзэх хэрэгтэй гэсэн санал байсан ч⁴⁵ үүний хажуугаар одоогоор ОУВС-аас хийхээр төлөвлөж буй ЗМС-ийн мэдээллийн өгөгдлийг шинэчлэх ажилтай зэрэгцүүлэн ЗЭМС-г нэвтрүүлэхтэй холбогдуулан хэлэлцүүлэх ажлыг үргэлжлүүлэх зааварчилгааг Монголбанкнаас авсан.

Одоогийн байдлаар банкны зээлийн судалгаанд ашигладаг үнэлгээний загварчлалыг арилжааны банкнууд тус бүр дотооддоо боловсруулж, ажиллуулж байгаа ч гэсэн үнэлгээний загвар дээр ч гэсэн чухал байр суурьтай ЗМС-г Монголбанк ОУВС-тай хамтран шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байгаа. Зээлийн түүхийн лавлагаа бол чухал асуудал боловч зээлийн шийдвэр гаргалтад чухал үзүүлэлт болох бизнесийн үнэлгээнд үзүүлэх найдвартай мэдээлэл (үзүүлэлт) шаардлагатай. Энэ утгаараа ЗЭМС-г нэвтрүүлэх нь үр дүнтэй байх магадлал маш өндөр байдаг. Энэ нь арилжааны банкуудын сонирхлыг ихээхэн татсан нь ЗЭМС-ийн

⁴⁵ 2018 оны 5-р сарын 25 Монголбанкны Дэд ерөнхийлөгч О. Эрдэнэбилэгтэй хийсэн уулзалтаас.

семинарын үеэр ажиглагдсан. Хүн ам болон аж ахуйн нэгж байгууллага цөөтэй Монгол улсад арилжааны банк тус бүрдээ ЗЭМС-ийн системийг бий болгохоос илүү Монголбанканд төвлөрүүлэн Японтой адил нийтийн ЗЭМС-ийн бүтцийг бий болгох арга нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Үүний тулд одоо арилжааны банканд байгаа буюу зээлийн судалгаанд зардал гарган баталгаажуулан ашигласан санхүүгийн тайланг авах зайлшгүй шаардлагатай. ЗЭМС-ийн тухай зөв мэдлэгийг олж авсан банкны мэргэжилтнүүдтэй уулзахад энэхүү механизмын аюулгүй байдал, эрсдэлд суурилсан хүүгийн түвшнийг тогтоох (хүүг бууруулах⁴⁶), ирүүлэх мэдээллийн ач холбогдлын маш сайн ойлгож арилжааны банк зайлшгүй авч хэрэгжүүлэхийг хэрэгтэй гэсэн саналаа илэрхийлж байсан. Үүний зэрэгцээ банкны удирдлагын түвшинд зөв нэгдсэн ойлголттой болгохын тулд үргэлжлүүлэн хамтран ажиллах шаардлагатай гэсэн саналаа илэрхийлсэн. Цаашид Монголбанкны санаачилгаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх болон ЗЭМС-г нэвтрүүлэх боломжийг хэлэлцэн авч үзэх шаардлагатай.

(3) Одоогийн зээлийн судалгаанд үзүүлэх нөлөөлөл

Банк санхүүгийн байгууллагуудтай хийсэн уулзалт ярилцлагаас үзэхэд зарим томоохон арилжааны банкууд дунд өөрийн үнэлгээний загварыг боловсруулж, тэдгээрийг зээлийн судалгаанд ашиглаж байгаа нь тодорхой болсон боловч үнэлгээний загварын нарийвчилсан алгоритм болон дэлгэрэнгүй мэдээлэлтэй жишээ маягыг олж авч чадаагүй юм. Дээр дурдсан нөхцөл байдалд ЗМС-ийн систем, үнэлгээний загварын тухай зөв ойлголт цөөн тооны банкны ажилтнуудаар хязгаарлагдаж байгаа. Хариуцсан ажилтантай уулзан ярилцахад ЗЭМС-ын механизмын талаарх оновчтой зөв ойлголтыг удирдлагын түвшинд өгснөөр санхүүгийн мэдээлэл, үнэлгээний загварын маягт, мэдээллийг авах боломжтой болно гэж үзсэн (Энэ асуудал дээр Монголбанкны зүгээс хариуцан ажиллах талаар Монголбанк, судалгааны багийн хамтарсан ажлын хэсгийн түвшинд санал нэгдсэн).

Оюутолгой зэрэг томоохон аж ахуйн нэгжтэй холбоотой барьцаагүй, батлан даалтгүй олгодог зээл байдаг талаар тодорхой болгосон ч энэ нь итгэлцэлд суурилсан зээл гэхээс илүүтэйгээр шилжүүлэг нь тодорхой болсон зэрэг ямар нэгэн байдлаар эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байсан. Иймэрхүү итгэлцлийн буюу харилцааны банкны (Relation banking, орон нутагт тулгуурласан санхүүгийн байгууллага) талаар судалгаагаар тодорхой үр дүн илрээгүй. Тус судалгаа нь ЖДҮ-ийн санхүүжилтийн талаар илүү анхаарал хандуулан төслийн

⁴⁶ ЗЭМС-г нэвтрүүлснээр хүүгийн түвшнийг бууруулж гарах үр дүнгийн талаар “3.2 -ийн Банкны зээлийн мэдээллийн хяналт өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал (1) Зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал (Эрсдэлийн удирдлага, зээлжих зэрэглэлийн тухай ойлголт)” -г дэлгэрэнгүй тайлбарласан.

санхүүжилтийн төслийн бэлэн мөнгөний гүйлгээний шинжилгээ гэх мэт аргуудын талаар судлаагүй ба хэрэглээний санхүүжилтийн барьцаанд суурилсан зээлээс бусад санхүүгийн хэрэгсэл арга хэрэгслийн талаар тодорхой болгож чадаагүй .

Арилжааны банкны одоогийн нөхцөл байдлын хүрээнд УИХ-аас зээлийн хүүг бууруулах шаардлага тавьж байгаа ба арилжааны банкны зүгээс зээлийн судалгааны зардалд тохирсон зээлийн хүүг тогтоосон гэж үзэж байгаа ч зээлийн судалгаанд хэрэглэх шинэ шийдвэр гаргалтын хэрэгслийг хайж байгаа. ЗЭМС-ыг нэвтрүүлснээр дефолтын магадлалыг гаргахаас гадна зээлийн судалгаа хийж байхад чухал үзүүлэлт болох салбарын нөхцөл байдлыг үнэлэх үзүүлэлтийг гаргах боломжтой юм Үүнээс гадна, Япон маягийн нэгдсэн дундын мэдээллийн ЗЭМС-ыг нэвтрүүлсэн тохиолдолд нэг банкин дээр шалгах боломжгүй янз бүрийн салбарын онцлог болон бусад мэдээллийг бусад банкуудтай мэдээлэл солилцох замаар статистикт суурилсан давуу байдлын дүн шинжилгээнд үндэслэн үзүүлэлтүүдийг гарган авах сайн талтай юм. Эдгээр нь шинэ харилцагчийн зээлийн судалгааны шийдвэр гаргалтын үзүүлэлт болохоос гадна одоогийн барьцаатай, батлан даалттай багтаасан хязгаарлагдмал шийдвэр гаргалтын материалд суурилсан зээлийн судалгааг боловсронгуй болгох боломжийг олгохоос гадна зээлийн судалгааны цаг, зардлыг бууруулж хүүгийн дундаж түвшнийг оновчтой бодит болгоход ихээхэн нөлөөлнө гэж үзэж байна.

(4) ЗЭМС-ын семинарын хэрэгжилт, санал хүсэлт

Энэхүү судалгааны хүрээнд ЗЭМС-ыг танилцуулах семинарыг 3- сарын 6-ны өдрийн үдээс өмнө төрийн байгууллагуудад (МБ, ХХААХҮЯ, ҮХГ зэрэг байгууллагуудаас 27 хүн оролцсон), 3- сарын 7-ны өдрийн үдээс өмнө банк санхүүгийн байгууллагуудад зориулан (МБХ, Японы болон Монголын арилжааны банкнаас нийт 24 хүн оролцсон) зохион байгуулсан. Тус семинарын гол илтгэл агуулга нь адилхан байсан ч хэлэлцүүлгийн үеийн санал солилцох агуулга нь өөр өөр байсан. Семинарын үндсэн илтгэгчээр Японы ЗЭМС-ын холбооноос 2 мэргэжилтэн урьж, ЗЭМС-ыг нэвтрүүлснээр гарах ач холбогдол, давуу талын тухай танилцуулах илтгэлийг тавьсан. Тодруулбал эхний илтгэгч “Япон дахь ЖДҮ-ийг дэмжихэд ЗЭМС-ийн үүрэг роль - Азийн орнуудад хөгжүүлэх” гэсэн сэдвээр, дараагийн илтгэгч “ЗЭМС-ийн загварын хэрэглээ - Азийн орнуудад түгээх” гэсэн сэдвийн доор илтгэл тавьсан.

“Япон дахь ЖДҮ-ийг дэмжихэд ЗЭМС-ийн үүрэг роль - Азийн орнуудад хөгжүүлэх” сэдэвт илтгэлээр мэдээллийн тэгш бус байдал, эрсдэлийн хуваарилалтын таамаглал, эрсдэлд суурилсан үнэлгээ, буруу сонголт, ЗЭМС-ийн системийн тойм, зээлийн мэдээллийн төв,

үнэлгээний загварчлалын бүтцийн төрөл, АНУ, Европын туршлага, ЗЭМС-ийн холбооны үйл ажиллагааны тойм болон баталгаажуулалт хийх ач холбогдлын талаар тайлбарлан танилцуулсан.

“ЗЭМС-ийн загварын хэрэглээ-Азийн орнуудад түгээх” сэдвээр Зээлийн сайжруулалтын системийг ашиглах, санхүүгийн байгууллагуудын зээлийн эрсдэлийн менежментийг ашиглах, ЖДҮ-ийн дэмжихэд ашиглах, төрийн байгууллагуудад ашиглах, CLO (хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны) схемийг ашиглан, Азийн орнуудад түгээх талаар танилцуулсан.

Хэлэлцүүлгийн тухайд аль аль семинар дээр ЗЭМС-ийн тухай ойлголтыг баталгаажуулахаас гадна Монголбанк санаачлагыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн саналууд их байсан. Нөгөөтэйгөөр, хувийн хэвшлийн зүгээс ерөнхийдөө санал нэгтгэйгээр дэмжиж байсан хэдий ч үнэхээр мэдээлэл цугларах эсэх дээр их санаа зовж байсан. Үүнээс гадна бүтэц зохион байгуулалтын хувьд Япон шиг хувийн хэвшил үйл ажиллагааг явуулах боломжтой эсэх, хууль эрхзүйн асуудал дээр анхаарах, цаашид хэлэлцэн шийдвэрлэх ёстой асуудлуудын талаар саналаа дэвшүүлж байсан.

Анкет асуулгын үр дүнгээс харахад бараг бүх оролцогчид агуулгыг ойлгосон байсан ба ЗЭМС-г ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаар өөрсдийн санал сэтгэгдлийг бичсэн байсан.

(5) Хамтарсан ажлын хэсэг дээр хэлэлцсэн асуудлууд

Энэхүү судалгааны хүрээнд зээлийн мэдээллийн хяналтын тухай мэдээлэл солилцон хэлэлцэх, Монголд тохиромжтой зээлийн хяналтын системийн талаар санал солилцон тодорхойлох зорилготой Монголбанкны холбогдох газрын мэргэжилтнүүд болон ЖАЙКА-ийн судалгааны багын зөвлөлдөх хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Тодруулбал Монголбанкнаас Хяналт шалгалтын газар, Мониторинг санхүүгийн үйлчилгээний хэлтэс, Судалгаа статистикийн газрын судалгааны хэлтсээс оролцсон бол хоёр дахь удаагийн уулзалтаас Мэдээллийн технологийн газраас нэмэгдэн оролцсон. Мөн гурав дахь удаагийн уулзалтаар Японы ЗЭМС-ийн холбоог урьж оролцуулсан. Хамтарсан ажлын хэсэг нь энэ судалгааны хэрэгжилтийн хугацаанд 6-р сарын дуустал 4 удаагийн уулзалтыг зохион байгуулсан ба уулзалт тус бүрийн тоймыг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3.11 Хамтарсан ажлын хэсгийн уулзалтын тойм

	Оролцогчид	Хэлэлцсэн асуудал
Эхний уулзалт 2018 оны 3 сарын 19-ны өдөр	Судалгаа статистикийн газраас 2 хүн, Хяналт шалгалтын газраас 3 хүн, ЖАЙКА Монгол дахь төлөөлөгчийн газраас 2 хүн (Ажиглагч), ЖАЙКА-ийн судалгааны багын зөвлөх 2 хүн	1. ЖДҮ-ийн санхүүгийн тайлан 2.ЗЭМС болон ЗМС-ийн ялгаа
Хоёр дахь удаагийн уулзалт 2018 оны 4 сарын 26-ны өдөр	Судалгаа статистикийн газраас 1 хүн, Хяналт шалгалтын газраас 3 хүн, Мэдээллийн технологийн газраас 2 хүн, ЖАЙКА Монгол дахь төлөөлөгчийн газар 2 хүн (Ажиглагч), ЖАЙКА-ийн судалгааны багын зөвлөх 3 хүн	1.ЗЭМС-ийн тухай хэлэлцүүлэг, түүний ач холбогдол 2. ЗЭМС-ийн ашиглах арга 3. ЗЭМС-ийн нэвтрүүлэх тохиолд шаардлагатай зураглал (Road map)
Гурав дахь удаагийн уулзалт 2018 оны 5 сарын 24-ны өдөр	Судалгаа статистикийн газраас 1 хүн, Хяналт шалгалтын газраас 3 хүн, Мэдээллийн технологийн газраас 2 хүн, ЖАЙКА Монгол дахь төлөөлөгчийн газар 2 хүн (Ажиглагч), ЖАЙКА-ийн судалгааны багын зөвлөх 3 хүн, Багш: (ЗЭМС Холбооноос 2 хүн)	ЗЭМС-ийн эхний баталгаажуулалтын аргачлалын тухай дэлгэрэнгүй тайлбар
Дөрөв дахь удаагийн уулзалт 2018 оны 6 сарын 22-ны өдөр	Судалгаа статистикийн газраас 1 хүн, Хяналт шалгалтын газраас 3 хүн, Мэдээллийн технологийн газраас 2 хүн, ЖАЙКА-ийн судалгааны багын зөвлөх 3 хүн	1. ЗМС-ийн системийг хөгжүүлэх ажлын явц, цаашдын сайжруулах төлөвлөгөө 2.ЗЭМС-ийн эхний баталгаажуулалтын аргачлалын алхам 3. Монголын компанийн санхүү болон компанийн засаглалын талаарх асуулга судалгааны тойм болон цаашид авах арга хэмжээ

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

4 удаагийн ажлын хэсгийн уулзалтаар хэлэлцсэн гол асуудлуудыг (гишүүдийн бодол, ойлголт, мэдээлэл солилцох гол чиглэл гэх мэт) дараах байдлаар нэгтгэн харууллаа.

<ЗЭМС-ийн байр суурь ба ойлголт>

Монголбанкны зүгээс хамтарсан ажлын хэсгийн эхний уулзалтаас бараг сүүлийн уулзалт хүртэл ЗЭМС-ийн ач холбогдол, онцлог, ЗМС-аас ялгаатай байдлыг маш их сонирхож байсан. Хамтарсан ажлын хэсгийн уулзалтаас өмнө ЗЭМС-ийн семинарын үеэр дээрх асуудлуудын талаар тайлбарласан байсан хэдий ч семинарт оролцоогүй гишүүд байсан тул эхний болон хоёр дахь удаагийн уулзалтаар шууд үзүүлэх ач холбогдол, салбар тус бүрийн дүн шинжилгээ хийх боломж, бусад хөгжиж буй орнууд дахь хэрэглээ, ЗМС-тай харьцуулах зэрэг асуудлуудын талаар санал солилцсоны үр дүнд ЗЭМС-ийн онцлог болон ач холбогдлын талаарх ойлголтын зузаатгаж чадсан. Хоёр дахь удаагийн уулзалт болохоос өмнө УИХ-ын байнгын хорооны хурал

дээр ЗЭМС-ийн талаар бүрэн ойлголтгүй хүн ташаа тайлбар өгснөөс үзэхэд Монголбанкнаас гадна холбогдох хүмүүст үргэлжлүүлэн ЗЭМС-ийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар талууд санал нэгдсэн. Гурав дахь удаагийн уулзалтын үеэр Монголбанкны зүгээс “ЗМС-ийн хувь хүний талаарх мэдээлэл хангалттай байгаа боловч байгууллагын талаарх мэдээлэл хангалтгүй тэр дундаа ЖДҮ-ийн тухайд зээлийн судалгаа, шийдвэр гаргалтад ашиглах материал хомс байдаг тул ЗЭМС нь их тохиромжтой юм. ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлснээр санхүүгийн салбарыг өргөжүүлэх, зээлийн хүүг бууруулах бололцоотойгоос гадна барьцаанаас хэт хараат зээлийн системийг боловсронгуй болгон зээлийн шалгуурын ач холбогдлыг дахин авч хэлэлцэх чухал ач холбогдолтой гэж найдаж байна” гэсэн санал гарсан.

2 сангийн ялгаатай тухайд ЗЭМС нь нэрийг нууцалсан мэдээллийн сангаас статистик шинжилгээний аргачлалд тулгуурлан дефолтийн магадлал (probability) нэмж тооцдог, ЗМС нь тодорхой нэр бүхий зээлийн түүхийн мэдээлэл гэсэн тодорхой ялгаатай гэдгийг эхэндээ сайтар ойлгохгүй байсан. 3 дахь хамтарсан ажлын хэсгийн уулзалтаар Японы ЗЭМС Холбооны мэргэжилтэний тайлбараас ЗЭМС ын талаар нэгдсэн ойлголттой болохоос гадна, техникийн тал (нэр нууцалсан мэдээлэл бол арилжааны банктай хамтран ажиллахад саад бага, банк зөвшөөрвөл хууль эрхзүйн зохицуулалт шаардлагагүй, зээлийн шалгуурт зээлийн түүхээс гадна тухайн аж үйлдвэрийн салбарын (эсвэл санхүүгийн тайлангаас харагдах тодорхой үйл ажиллагааны хэвшил) дефолтын хувь, тус тусын онцлог гэх мэт) дээр олон дахин тодруулгачийн сайтар авч хэлэлцсэн.

<ЗЭМС-тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн хууль эрхзүйн зохицуулалт>

ЗЭМС нэвтрүүлэхэд шаардлагатай хууль эрхзүйн орчны тухайд мэдээллийг цуглуулах тал дээр 1, 2 дахь хамтарсан ажлын хэсгийн уулзалт дээр Монголбанкны зүгээс Зээлийн мэдээллийн тухай хуульд (6.1.13) заагдсанаар Монголбанк арилжааны банкнаас мэдээлэл авах боломжтой гэж үзсэн. Нөгөө талаас бодитоор нэвтрүүлэхийн тулд Монгол улсын нөхцөл байдлын хувьд 1) Тодорхой хууль батлагдахгүй бол Засгийн газар болон хувийн хэвшил хөдлөхгүй, 2) ЗМС, ЗЭМС өөр чиг үүрэгтэй тул Зээлийн мэдээллийн тухай хуулиар ЗЭМС зохицуулах нь зохимжгүй тул ЗЭМС талаар ямар нэгэн эрхзүйн актаар зохицуулах хэрэгтэй (ЗЭМС тухай хууль гм) болов уу гэсэн асуудал олон тавигдсан.

Түүнчлэн одоо мөрдөгдөж буй хуулийн хүрээнд ЗЭМС нэвтрүүлэх хувилбарын тухайд

Монголбанкны хамтарсан ажлын хэсгийн гишүүнээс “ЗЭМС-ын нөхцөл байдлаас шалтгаалан одоогийн холбогдох хуулиудаар (Компанийн тухай, Хувийн мэдээллийн нууцыг хадгалах тухай, Банкны тухай гэх мэт) зохицуулах бололцоо байж болох ч үүний зэрэгцээ хуулийн шинэчлэл, шинэ хууль боловсруулах тал дээр ч эхнээс өргөн хүрээнд харж авч хэлэлцэх шаардлагатай” гэсэн.

<ЗЭМС-тогтолцоог нэвтрүүлэхэд анхан шатны (мэдээллийн) чанарын шинжилгээ>

ЗЭМС нэвтрүүлэх тухай нухацтай авч хэлэлцэхийн тулд бодитоор байдал дээр ЗЭМС-ийг үйл ажиллагааг явуулахад чанарын шаардлага хангасан хангалттай хэмжээний мэдээллийг одоо Монголд байгаа мэдээлэл хангах боломжтой эсэхийг баталгаажуулж үзэх нь маш чухал гэдэг дээр санал нэгдсэн. Монголбанкны хамтарсан ажлын хэсгийн хүлээлт их, 2 дахь уулзалт дээр Японы ЗЭМС Холбооны мэдээллийн орцны талаар ихээхэн сонирхож 3 дахь уулзалт дээр ЗЭМС Холбоо оролцон мэдээллийг цуглуулах үйл явцаас эхлээд ЗЭМС-ийн бэлтгэл ажлын үе шат хүртэлх тайлбарыг хийсэн. Үүний дүнд тодорхой хэмжээний мэдээллийг цуглуулан Монголд нэвтрүүлэх бололцоотой эсэхийг турших хэрэгтэй, тодорхой хэмжээний загвар мэдээлэл цуглуулан анхан шатны дүн шинжилгээ хүртэл хийн баталгаажуулах тал дээр санал нэгдсэн (Анхан шатны чанарын шинжилгээ хүртэлх үе шат).

Анхан шатны шинжилгээ хийхэд шаардагдах санхүүгийн тайланг цуглуулах аргачлалын тухайд 1 дэхь уулзалт дээр Монголбанкны ажлын хэсгийн зүгээс арилжаанд банкнаас мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй гэж үзэж байсан. Иймд хэлэлцүүлгийн явцад харьцангуй мэдээлэл хүсэх боломжтой ЖДҮХС, ЗБДС, Сангийн Яам зэргээс санхүүгийн тайлан авах боломжтой эсэх тал дээр Монголбанкнаас санал гарсан хэдий ч арилжааны банкны зээлийн дефолтын мэдээлэл цуг орсон байх чухал шаардлагатай, санхүүгийн тайлан үнэн зөв байх, өөрөөр хэлбэл (хөнгөлөлттэй зээлийн онцлог гм) шинжилгээний үр дүнг ерөнхийлж болох эсэх нь тодорхойгүй зэргийг авч хэлэлцсэн бөгөөд 4 дэхь уулзалтаар арилжааны банкнаас санхүүгийн тайлан авах чиглэлээр цаашид ажиллахаар санал нэгдсэн.

Чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор регрессийн шинжилгээ хүртэлх хүрээг хамарсан анхан шатны ажил хэрэгжүүлэх тохиолдолд, мэдээллийг CSV форматаар бэлтгэх, мэдээллийн нууцлалыг хадгалах гэрээ зайлшгүй шаардлагатай талаар судалгааны багийн зүгээс тайлбарлаж, мэдээлэл солилцсон. Практик үйл ажиллагааны тухайд ч тодорхой хэмжээний ойлголт хүргэсэн болно.

< ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэх тухай бусад хэлэлцүүлэг >

ЗЭМС нэвтрүүлэх тухай хэлэлцүүлэгт дээрх хууль эрх зүйг арга хэмжээнээс гадна, үйл ажиллагаа эрхлэн явуулах гол байгууллага, төсөв, санхүүгийн тайланг оновчтой болгох, ажлын зургийн тухай ч хэлэлцсэн болно. Үйл ажиллагаа хариуцах гол байгууллагын тухайд, Монголбанкны зүгээс шинээр үүсгэн байгуулах Зээлийн мэдээллийн төв ХХК нь Зээлийн мэдээллийн сангийн зээлийн мэдээллийн хамтаар ЗЭМС-ийн мэдээллийг давхар хүргэдэг байх санал дэвшүүлсэн. Гэвч 3 дахь удаагийн хэлэлцүүлгийн үеэр ЗЭМС-ийн холбооноос онолын хувьд нэг байгууллага хариуцаж боломжтой ч тусад нь бие даасан байгууллага байгуулах нь илүү оновчтой гэсэн санал дэвшүүлж дэмжигдсэн. Энэ тухай цаашид хууль эрх зүйн тухай үргэлжлүүлэн хэлэлцэх, анхан шатны судалгаа шинжилгээ явагдах явцад илүү тодорхой болно гэж үзэж байна.

Нэвтрүүлэх, үйл ажиллагаа эрхлэн явуулах зардлын тухайд, ЗМС-ийн сайжруулалтад зарцуулах төсөв өндөр байгаатай холбогдуулан Монголбанкны гишүүдийн зүгээс анхан шатны зардлын талаар эхний хэлэлцүүлгийн үеэр асуусан ба 3 дахь удаагийн уулзалт дээр Японы системийг бий болгоход зарцуулагдсан зардлыг ЗЭМС-ийн Холбооноос танилцуулсан.

Санхүүгийн тайланг оновчтой болгох тухай асуудал нь Монголбанканд өнөөг хүртэл төдийлөн хөндөгдөөгүй сэдэв байв. Гэвч 2 санхүүгийн тайлан гаргасан байгаа нь ЗЭМС-тай хамаарах асуудал гэдэг дээр санал нэгтэй байв. Тиймээс энэхүү асуудлыг шийдэх арга замын талаар 4 дахь хэлэлцүүлгийн үеэр уг судалгаанд тусгагдсан компанийн засаглалыг сайжруулах, ЖДҮ санхүүгийн тайлан сайжруулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулсан.

Ерөнхий зураглалын (Roadmap) тухайд 2 дахь уулзалтын үеэр авч хэлэлцсэн ба мэргэжилтнүүдийн зүгээс ерөнхий ажлын зураглалын жишээ ашиглаж түүний ач холбогдлын талаар танилцуулсан. Монголбанкны зүгээс ЗЭМС-г бүрдүүлэх бүхий л дэмжлэгийг хүсэх бус, тус тусын үүрэг хариуцлагыг тодорхойлон хамтран ажиллах саналтай ба цаашид идэвхтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн.

<Бусад хандивлагчдын чиг хандлага >

Судалгааны хэрэгжилтийн явцад ОУВС-аас Монголбанкны ЗМС-г шинэчлэн сайжруулах тухай зөвлөмжид үндэслэн ЗМС-г сайжруулахад чиглэсэн хандивлагчдын дэмжлэг (төслийн санал) төдийгүй ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэх талаар хэлэлцэхийн хамт мэдээлэл авч санал

солилцсон. Монголбанкны ажлын хэсэгт эхэндээ ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг ЗМС-ийн шинэчлэн сайжруулахтай холбогдоно гэсэн бодолтой хүн байсан ч эцсийн байдлаар хамтарсан ажлын хэсгийн бүх гишүүд дээрх сангийн ялгаа, гүйцэтгэх үүрэг, хэрэгцээ шаардлагын талаар нэгдсэн ойлголттой болсон.

(6) ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэх орчин (Эрх зүйн орчин, холбогдох байгууллага, хэрэгцээ ба хязгаарлалт)

1) Эрх зүйн орчин,

ЗЭМС-ийг нэвтрүүлэхэд, байгууллага тус бүрийн (a) санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэлт шийдвэрлэхэд ашигласан нэр нууцалсан санхүүгийн тайлан, (b) тухайн нэр нууцалсан тайлан өгсөн байгууллагын бусад хамаарал бүхий мэдээлэл, (c) тухайн нэр нууцалсан санхүүгийн тайлан өгсөн байгууллагын Default data хэрэгтэй болдог. Энэ үйл ажиллагааг тодорхой байгууллага хариуцаж, хяналт тавих бөгөөд мэдээлэлтэй холбоотой төрөл бүрийн хууль тогтоомжийн хүрээнд, нийцүүлж ажиллах шаардлагатай. Монгол улсын хувьд одоо хэрэгжиж буй 1.Банкны тухай хууль 2.Байгууллагын нууцын тухай хууль 3.Хувь хүний нууцын тухай хууль 4.Төв банк “Монголбанк”-ны тухай хууль 5.Зээлийн мэдээллийн тухай хууль 6.Зээлийн мэдээллийн сангийн журам, зэрэг хууль тогтоомжууд хамааралтай ба Ялангуяа нэр нууцалсан санхүүгийн тайлан, зээлийн мэдээлэл түүний хяналт болон эрхлэн явуулах арга хэлбэрийг хэрхэн авч үзэх тухай хэлэлцэх шаардлагатай болно. 1-3 нь мэдээллийн хамгаалалтай холбоотой хууль, 4-6 нь зээлийн мэдээллийн сантай холбоотой хууль тогтоомж гэж ерөнхийд нь хувааж, ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэхэд тус бүр анхаарал хандуулах нь агуулга нь ялгаатай байна. ЗЭМС-тай хамаарал бүхий хууль тогтоомж, журам дахь жишээг доор оруулав.

① Банкны тухай хууль

7 дугаар зүйл. Банкинд хориглох үйл ажиллагаа
7.2. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд⁴⁷ бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно:

⁴⁷ Нууц задруулах үндэслэл 5 тохиолдол байна. 1. Тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн 2.Монголбанк, түүний хянан шалгагч, Монголбанкны улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан 3.Шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын шаардлагаар 4. Монгол Улсын хуулийг зөрчсөн нь нотлогдсон бол олон улсын хуулийн байгууллага, Засгийн газар хүсэлт гаргасан 5. СЗХ-ны олон улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрт үндэслэсэн үүргийн дагуу хүсэлт гаргасан г.м

Банкны тухай хуульд, үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой мэдээллийг задруулахтай холбоотой нөхцөлийг заасан 5 тохиолдолд багтаагүй учир, “нууц гэж үзсэн аливаа мэдээлэл” (Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээлэл)-д нэр нууцалсан санхүүгийн тайлангийн мэдээлэл багтах үгүйд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

② Байгууллагын нууцын тухай хууль

Хоёр дугаар бүлэг: Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах
5 дугаар зүйл. Байгууллагын нууцыг хамгаалах
2. Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй.
3. Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална.
7 дугаар зүйл. Байгууллагын нууцтай танилцах
2. Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

Байгууллагын тухай хуульд ч банкны тухай хуулийн адилаар, Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн нууцыг бусад этгээдэд задруулах нь хориотой гэж заасан ба мөн л “нууц” гэх ойлголтод нэр нууцалсан санхүүгийн тайлан багтах эсэх.

③ Хувь хүний нууцын тухай хууль

4 дүгээр зүйл. Хувь хүний нууцын төрөл
1. Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:
1/ захидал харилцааны нууц;
2/ эрүүл мэндийн нууц;
3/ хөрөнгийн нууц;
4/ гэр бүлийн нууц;
5/ хуулиар тогтоосон бусад нууц.
2. Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:
1) захидал харилцааны нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;
2) эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;
3) хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг;
4) гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг.
3. Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.
5 дугаар зүйл. Хувь хүний нууцыг хамгаалах

1. Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.
2. Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.
3. Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.
4. Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

Хувь хүний нууцын тухай хуульд хувь хүний нууцын мэдээллийг хамгаалах талаар нарийн тогтоосон байгаа ба тухайн мэдээллийг олж авсан этгээд цааш бусад этгээдэд задруулахыг хориглосон байна. Гэвч энэхүү хуулиар хамгаалагдах мэдээллийн хувьд ч, мэдээлэл олж авсан этгээд нь нэр нууцалсан мэдээллийг бусдад задруулах талаар тусгаагүй байна.

Дээрх 3 хууль нь банк олж авсан мэдээллээ бусдад задруулах нь бусад хуулиудтайгаа зөрчилдөх эрсдэлтэй боловч, нэр нууцалсан мэдээлэл ч адил ойлголтоор үйлчлэх эсэх талаар тусгаагаагүй байна. Тиймээс эдгээр хуулиудыг боловсруулах явцад нэр нууцалсан мэдээллийг задруулах эсэх хүртэл багтааж боловсруулсан эсэх нь асуудал юм. Хуулийн заалтууд дахь үгээр нь авч үзвэл эзэн холбогдогчыг нь тогтоох боломжгүй нэр нууцалсан мэдээлэл нь мэдээлэл бус дата гэж ойлгогдохоор байна. Аль нь ч байсан хэрхэн ойлгох аргаар шийдэх эсвэл тусад нь шинээр заалт оруулах тухайд цаашид хэлэлцэх шаардлагатай.

④ Төв банк Монголбанкны тухай хууль

- 19¹ дүгээр зүйл. Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих
1. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

Төв банкны тухай хуулийн тухайд, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрхийг төв банк эзэмшдэг тул ЗЭМС-г хариуцаж ажиллах байгууллагыг шинээр байгуулах тохиолдолд ч гэсэн энэхүү хуулийн заалт хэрэгжих ба Монголбанк зөвшөөрөл олгож болох эсэх нь гол асуудал болно.

⑤ Зээлийн мэдээллийн тухай хууль ⑥ Зээлийн мэдээллийн сангийн тухай журам

- Энэхүү судалгаанд дээрх хууль эрх зүйн актны хамаарал ихтэй учир, хавсралт материалын 2 болон 3-г бүх хуулийг бүрэн эхээр нь оруулав.

Зээлийн мэдээллийн тухай хууль болон зээлийн мэдээллийн сангийн тухай журам нь Зээлийн мэдээллийн сан (ЗМС) болон тухайн системийн үйл ажиллагааг хариуцаж ажилладаг байгууллагат тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой журам учир, одоогийн агуулгаараа нэр

нууцалсан мэдээллийн талаар тусгагдаагүй байна. Иймд ЗЭСМ-ийн тухайд өгөгдөл/мэдээлэл цуглуулах, шинжлэх, системийн зохион байгуулалт болон эрхлэн явуулах, ашиглах тухайд шууд холбоотой бус ч ЗЭСМ-ийн талаар цаашид нэмэлт өөрчлөлт оруулах эсэх нь анхаарал хандуулах асуудал юм.

Иймээс аль ч хууль журам, эрх зүйн орчны хувьд ЗЭСМ-ийн тогтолцоог нэвтрүүлэхэд хангалттай эсэх аль эсвэл шинэ хуулийн зохицуулалт хэрэгтэй болох талаар одоогийн байдлаар дүгнэхэд хүндрэлтэй байна. Цаашид ЗЭСМ-г жинхэнэ утгаар нь нэвтрүүлэхдээ хэрхэн нэвтрүүлэх арга хэлбэр, бүтэц зохион байгуулалтын талаар, хуулийн ойлголт, хуулийн хэрэгжилт хооронд зөрүү үүсэхгүй байх хэмжээнд сайтар судалж, хууль эрх зүйн дэмжлэг, үйл ажиллагаа эрхлэх дүрмийг боловсруулан батлах шаардлагатай. Илүү нарийн ойлголтын тухайд Монгол Улсын хууль, эрх зүйн мэргэжилтэн, Хууль зүйн яамны судалгаа шинжилгээ шаардлагатай гэж үзэж байна.

Гэхдээ ЗЭСМ-ийн семинар, хамтарсан ажлын хэсэг болон банк тус бүртэй хийсэн ярилцлагаас харахад аливаа шинэ бодлогыг хэрэгжүүлэхэд, түүний үндсэн эрх зүйн орчин бүрдүүлэх хууль тогтоомжгүйгээр оролцогч талууд үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй гэсэн санал олон байсан. Монголбанктай хамтарсан ажлын хэсгийн тухайд одоогийн Зээлийн мэдээллийн сангийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар, арилжааны банкуудаас санхүүгийн тайланг шаардаж мэдээлэл цуглуулах боломжтой гэсэн санал гарсан хэдий ч, ЗЭСМ-ийн хууль журамд үндэслэн ЗЭСМ-ийн мэдээллийг цуглуулах нь зохимжгүй талаар хэлэлцсэн. Үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг шинээр байгуулах эсэх, тухайн байгууллагын хууль эрх зүйн байдал, бүтэц зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч хууль эрх зүйн заалтууд ялгаатай болно. Япон маягийн ЗЭСМ-ийн хэлбэрийг тэр чигээр нь нэвтрүүлэх бус, Монголд тохирсон ЗЭСМ-ийг бий болгохын тулд, шинээр хууль тогтоомж боловсруулахыг анхнаасаа алгасах бус илүү өргөн хүрээтэйгээр судалж үзэх нь чухал.

2) Үйл ажиллагааг эрхлэх боломжит байгууллага

Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг нэвтрүүлэхэд өнөөгийн байдлаар Монголбанк санаачлагыг аван, Засгийн газрын зүгээс холбогдох гол байгууллага болно гэж үзэх боломжтой. Гэхдээ Японы “Зээлийн эрсдэлийн мэдээллийн сангийн холбооны” өнөөгийн үйл ажиллагааны арга замын давуу талыг бодож үзвэл, эхэн үедээ Монголбанк систем нэвтрүүлэх гол субъект болон Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг боловсруулах, эрхлэх үйл ажиллагаа явуулж, системийг

удирдан хэрэгжүүлэх бүтцийг (мэргэжлийн хүний нөөц, мэдээлэл цуглуулах арга зам/ICTсистем бий болгох, бие даан ашигтай ажиллаж чадахуйц санхүүгийн хэгийн төлөв зэргийг хамруулсан) бий болгосны дараа бие даасан байгууллагад шилжүүлэх гэсэн хувилбар ч байж болох юм. Мөн Монголбанкнаас гадна Сангийн яам хариуцах ёстой гэсэн санал ЗЭМС-ийн семинар зэрэг дээр гарч байсан ба төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагын хуваарилалт, тус хоёр байгууллагатай хийсэн ярилцлагаас үзвэл Монголбанкинд хариуцуулах нь зүйтэй гэсэн санал нийтлэг байв.

СЗХ-ны гүйцэтгэх үүрэг хариуцлагын тухайд ч бодож үзэх шаардлагатай. ББСБ, ХЗХ, лизингийн компани гэх мэт банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд СЗХ үйл ажиллагааны зөвшөөрөл олгох зэрэг хяналтыг хэрэгжүүлдэг ба ялангуяа Монгол улсын нийт ААН-ийн тоо цөөн тул ББСБ зэргийг хамруулан ЗЭМС-ийн хамрах хүрээг өргөжүүлэх талаар ч авч үзэж болно. СЗХ-ны хувьд ч уулзалт ярилцлагын үед хамтарсан ажлын хэсэгт оролцох хүсэлтээ гаргасны адилаар ЗЭМС-г нэвтрүүлэхэд их сонирхолтой байгаагаа илэрхийлсэн болно.

Дээр дурдсан байгууллагууд дээр нэмэгдэх бас нэгэн чухал байгууллага бол Зээлийн батлан даалтын сан гэж үзэж байна. Энэ нь Японы ЗЭМС-ийн системд Батлан даалтын холбооны баталгаажуулалтын түвшингийн тооцооллыг ч хэрэглэдэг гэдэг үүднээс Монгол улсад ч гэсэн ирээдүйд адилхан тогтолцоог хэрэгжүүлнэ гэж үзвэл Зээлийн батлан даалтын сан нь ихээхэн холбоотой болно. Үүнээс гадна ХХААХҮЯ, Сангийн яам, Монголын банкны холбоо, Үндэсний хөгжлийн газар, Хөгжлийн банк зэрэг мөн адил санхүүгийн тогтолцоонд оролцогчид тул тэдэнтэй хамтран ажиллах, мэдээлэл түгээлгэхийн тулд ЗЭМС-ийн талаар сайн ойлголт өгөх шаардлагатай гэж үзэж байна.

Хувийн хэвшлийн тухайд ЗЭМС-ийн голлох хэрэглэгч болох арилжааны банкууд, ББСБ-ууд нь чухал харилцагчид юм. Түүгээр зогсохгүй ХЗХ болон бусад санхүүгийн байгууллагуудын хувьд ч ирээдүйд хэрэглэгч болох боломжтой. Цаашилбал ЗМТ ХХК байгуулсан Монголын банкны холбоо болон МҮХАҮТ гэсэн бүлгийнхний хувьд ч банкны хэрэглэгчдийн сургалт таниулга зэргийн үед чухал харилцагч болж ирэх болов уу.

Хүснэгт 3.12 ЗЭМС-ийн системийг нэвтрүүлэхтэй холбоотой голлох харилцагчид

Төрийн байгууллага	МБ, СЗХ, СЯ, MOFALI, ҮХГ, DBM, ЗБДС
Хувийн хэвшил	Арилжааны банк, ББСБ, MNCCI, МБХ, ХХЗ болон бусад санхүүгийн байгууллага
ОУБ	Жайка, АХБ, ОУСК, ЕСБХБ

3) Хэрэгцээ

ЗЭМС нь төрийн байгууллага, хувийн хэвшлийн хувьд аль алиных нь зүгээс хэрэгцээ шаардлага их байна. Тухайлбал, ЗЭМС-ийн системээр хийгдэх санхүүгийн тайлангийн үнэлгээний мэдээллийн дагуу эрсдэлийг харгалзсан хүүгийн түвшин тогтоох болон зээлийн хүүг ерөнхийд нь буулгах боломжтой гэдгээр Монголбанк бусад санхүүгийн байгууллагаас хүлээлт өндөр байна. Энэ нь 1) ЗЭМС-ийн семинарт оролцогсдын анкет судалгааны дүн, 2) Байгууллага бүртэй хийсэн ярилцлагын дүн, 3) Монголбанкны хамтарсан ажлын хэсгийн уулзалт болон анхан шатны чанарын шинжилгээ явуулах сонирхол зэргээс ч харагдаж байна.

Ялангуяа санхүүгийн байгууллагын бодит хэрэгцээний хувьд Монголд банк тус бүрийн зээлийн харилцагч ААН-ийн тоо цөөн, нэг банкинд ногдох харилцагч ААН-ийн тоо хамгийн олондоо 2,000-аас доош байна. Иймд харилцагч ААН цөөнтэй жижиг банк, ББСБ-ууд иймэрхүү өөрсдийн мэдээллийн санд суурилсан эрсдэлийн үнэлгээ хийж чадахгүй байх магадлалтай. Нийт улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн сантай болох нь санхүүгийн байгууллага тус бүр зээлийн дүгнэлт гаргахад нь туслах үүргийг гүйцэтгэх болно.

4) Саад ба тулгамдсан асуудлууд

ЗЭМС-г нэвтрүүлэхтэй холбогдон 1) цуглуулах боломжтой санхүүгийн тайлан цөөхөн 2) өнөөг хүртэлх банк хоорондын хамтын ажиллагаа сул гэсэн 2 зүйл саад тогтор болж, 3) банк тус бүрийн мэдээллийн хяналтын ялгаатай байдал асуудал тулгарах болов уу гэж үзэж байна. Саад болох зүйлийн талаар дэлгэрэнгүйг дор дурдъя.

1) Цуглуулах боломжтой санхүүгийн тайлан цөөхөн

Монгол улсын хүн ам цөөн тул ААН-ийн тоо ч олон биш. Өмнө дурьдсанчлан Үндэсний статистикийн хороо, Сангийн яамны мэдээллээр үйл ажиллагаа явуулж буй нийт ААН-ийн тоо 70,000 орчим. Мөн энэ бүлгийн 8 дугаар хэсэгт дурьдсан банкнаас байгууллагын нэр дээр зээл авсан ААН-ийн тоо банк болон ББСБ-ыг оролцуулаад 6,928 (2017 он) байсан ба үүн дээр хувь хүний нэрээр ЖДҮ-д зориулан авсан зээл гэж үзэх тохиолдлыг оруулаад ч 40,000 орчим байх юм. ЗЭМС-г бүрдүүлэхэд цугларсан жилийн тоогоор үржүүлж зээлийн тоог тооцдог тул ААН-д зориулсан зээлд шаардагдах өнгөрсөн жилүүдийн санхүүгийн тайлан болон зээл авсны дараа дор хаяж жил бүр 1 санхүүгийн тайланг авч хэрэглэх боломжтой. Гэтэл үүнийг харгалзаж үзсэн ч санхүүгийн тайлангийн нийт тоо ба үндсэн өгөгдөл хангалтгүй бол тохиромжтой загвар

бүтээхэд шаардлагатай өгөгдөл хуримтлагдахгүй гэдгийг анхаарах нь чухал юм.

2) Өнөөг хүртэлх банк хоорондын хамтын ажиллагааны сул байдал

Уулзалт ярилцлагаас үзэхэд Монгол улсын хувьд нэг байгууллага нөгөө байгууллагатай хамтарсан платформ хийх явдал маш ховор гэдгийг анхааруулж байв. Ялангуяа банкуудын хооронд өрсөлдөөн ихтэй тул бусад банктай хамтран ажиллахаас татгалзах явдал ч байж болзошгүй бөгөөд энэ нь загвар бий болгох боломжийг хязгаарлаж болзошгүй юм.

Гэхдээ дээр дурдсан саад бэрхшээлийн тухайд нийт улсын хэмжээнд мэдээллийн сан бүрдүүлэхэд өгөдлийн тоо хангалтгүй байхад эсрэгээрээ нэг банк дангаар мэдээллийн сан бүрдүүлнэ гэвэл бүр хэцүү байх болно гэдгийг харуулж байна. Тийм учраас Моэнгол банк зэрэг төрийн байгууллага удирдан, мэдээллийн санг бүрдүүлэх үедээ санхүүгийн байгууллагуудад энэ талаар тайлбарлан таниулж, аль болох олон санхүүгийн байгууллагын идэвхитэй оролцоог дэмжиж, оролцуулах боломжтой гэж үзэж байна.

Мөн энэхүү санхүүгийн тайлангийн тооны хязгаарлагдмал байдлын тухайд гаргуулж авах санхүүгийн тайлангийн жилийн тоог нэмэгдүүлэх болон ААН-ийн зээл (ЖДҮ) боловч хувь хүний нэр дээр авч буй зээлдэгчийн санхүүгийн тайланг гаргуулж авах нь үүнийг шийдвэрлэхэд чухал гэж үзэж байна.

Тулгарах асуудлын талаарх дэлгэрэнгүйг дор дурдъя.

3) Банк тус бүрийн мэдээллийн хяналтын ялгаатай байдал

ЗЭМС-г нэвтрүүлэхийн тулд банк бүрээс эцсийн байдлаар нэг тогтсон форматаар мэдээллийг авах шаардлагатай. Энэ тухайд банк харилцагчаас санхүүгийн тайлан авахдаа E-Balance-ийн маягтаар авдаг болохыг олон банкнаас лавлан баталгаажуулсан ба банкны дотоод мэдээллийн хяналтын тухайд E-Balance дахь санхүүгийн үзүүлэлтэд нийцэх эсэх, мөн банк хоорондын ялгаа хэр зэрэг байгаа нь тодорхойгүй. Банк тус бүр өөрсдийн аргаар санхүүгийн мэдээлэл (Үндэсний татварын газарт тушааж буй санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад бодитой тусгасан санхүүгийн мэдээлэл)-ийг харилцагчаас цуглуулан авдаг. Банк тус бүрийн мэдээллийн хяналтын системд ямар хэлбэрээр хадгалан хяналт хийгдэж байгаа (эксел гэх мэт хүснэгтэн програм, эсвэл PDF-ээр хадгалах) талаар тодорхой болгож чадаагүй Өгөгдлийн форматыг стандартчилах шаардлагатай гэж систем нэвтрүүлэхтэй холбоотойгоор тулгарах асуудал болно гэж үзэж байна.

(7) ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэх орчны талаарх дүгнэлт

1) ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлснээр гарах ач холбогдол

- Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн мэдээлэл хомсдолтой байдгаас шалтгаалан үүсдэг зээлийн судалгааны цаг хугацаа, зардлыг хэмнэх.
- Эрсдэлд суурилсан хүүгийн түвшнийг тогтоох (Хүүгийн өндөр өсөлтийг тогтоох боломж)
- ЗБДС-ийн батлан даалтын хураамжийг үе шаттай болгох
- ЖДҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэх
- Санхүүгийн тайланг боловсронгуй болгох/ нэгтгэх
- Зээлийн хугацааг уртсах
- Барьцаагүй зээлийн боломж бүрдүүлэх
- Монголд компаниудын нэгдсэн платформ бий болгох жишиг бүрдүүлэх

2) ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлэхэд үүсч болох сөрөг тал

- Хүн ам, аж ахуй нэгж цөөтэй гэдэг нь Монгол улсын сул тал биш, өвөрмөц онцлог боловч ийм нөхцөлд ЗЭМС-г нэвтрүүлсэн ч санхүүгийн тайлангийн нийт тоо, дефолт мэдээллийн тоо хангалтгүй тохиолдолд ЗЭМС-ийн дүн шинжилгээгээр тохирох загварыг бий болгож чадахгүй байх магадлалтай.
- Дээр дурдсан давуу талыг эсрэг талаас нь авч үзвэл бусад компаниудтай хамтран ажиллах туршлага багатай тохиолдолд мэдээллийн хяналт, мэдээлэл хуваалцах механизмыг хэрэгжүүлэх боломжтой эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

3.7 ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлснээр гарах үр нөлөө

(1) Үр нөлөө

Японы ЗЭМС-ийн тогтолцоог Монголд улсад зүй зохистойгоор нэвтрүүлснээр санхүүгийн бүх төрлийн байгууллагууд зөвхөн барьцааны үнэ цэнэд тулгуурлахгүй, эрсдэлийг харгалзсан зээлийн хүүг тогтооход илүү хялбар болно. Мөн эрсдэлийг харгалзсан зээлийн баталгааны төлбөрийг үр ашигтайгаар тогтоох болон шатлал бий болгох зэргээр төлбөрийн хувь хэмжээг бууруулах ч боломжтой. Ингэснээр хангалттай барьцаа хөрөнгөгүй аж ахуйн нэгж, тэр дундаа ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмж сайжирна гэж үзэж байна. ЖДҮ-ийн хувьд зээлийн хүү буурах, барьцаа хөрөнгийн хэмжээ буурах зэрэг бодит эерэг нөлөөлөл гарах болно. ЗЭМС-ийн тогтолцоог нэвтрүүлснээр гарах эдийн засгийн үр нөлөөний мөнгөн тоон хэмжигдэхүүнийг гаргах нь түүнийг нэвтрүүлэхэд гарах зардалтай харьцуулахад чухал шаардлагатай боловч өнөөгийн байдлаар нэвтрүүлэх хэлбэр ч тодорхойгүй байгаа тул тоон үзүүлэлт бүхий тооцоо хийхэд бэрхшээлтэй байна.

Энэхүү судалгааны үр нөлөөг үнэлэх материал болгож ЗЭМС-аас нөлөө үзүүлэх ЖДҮ-ийн өнөөгийн болон ирээдүйн тоог авч үзнэ. Мөн ирээдүйд зээл аван, ЗЭМС-ийн харилцагч болох боломжтой ЖДҮ-ийн тоог тооцоолохдоо одоогийн байдлаар иргэний нэрээр авч байгаа боловч үнэн хэрэгтээ хувийн компанидаа (ЖДҮ) санхүүжилт хийж байгаа тохиолдлыг ч аж ахуйн нэгжийн тоонд оруулан тооцож үзнэ. Түүнчлэн одоогийн байдлаар зээл аваагүй байгаа ЖДҮ-ийн тоог ч (ирээдүйд зээл авах магадлалтай компаниудын тоо) тооцож үзнэ.

(2) Өнөөгийн байдлаар зээл авсан байгаа ААН-ийн (ЖДҮ хамарсан) тоо

Монгол улсын хэмжээнд өнөөгийн байдлаар зээл авсан байгаа ЖДҮ, иргэдийн тооны тухайд хэд хэдэн төрлийн мэдээллийн эх сурвалжаас тооцоолж гаргах боломжтой гэж үзэж байна. Тухайлбал: 1) Монголбанкнаас гаргадаг банкны статистик, 2) Монголбанкны Зээлийн мэдээллийн албан дахь бүртгэлийн тоо, 3) Статистик мэдээнээс тооцоолох ЖДҮ-ийн тоо болон 4) Сангийн яамны мэдээллийн сангаас тооцоолох зэрэг болно. Эдгээр мэдээллийг нэгтгэн дүгнэвэл дараах байдалтай болно.

1) Монголбанк, СЗХ-ны статистик мэдээлэл

Энэ бүлгийн 1 дэх хэсэгт тэмдэглэснээр Монголбанкнаас гаргадаг банкны статистик мэдээллээр бол 2017 оны эцсийн байдлаар банкнаас зээл авсан нийт ААН-ийн тоо 6,688 бөгөөд

үүнээс 5,477 нь ЖДҮ байна.

Гэвч Монголбанкны статистик нь зөвхөн банкуудын талаарх мэдээлэл бөгөөд ББСБ болон бусад санхүүгийн байгууллагын санхүүжилтийн талаарх мэдээлэл байхгүй ба СЗХ дээр нэгтгэдэг мэдээллээр бол ААН-д зориулсан санхүүжилт 2017 оны эцсийн байдлаар 240 гэсэн байна.

2) Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн тоо

Монголбанкны мэдээлснээр Монголбанкны Зээлийн мэдээллийн санд 1,722,000 хүн (1,700,000 иргэн, 22,000 ААН) гэж тооцоолсон төрөл бүрийн зээлийн хэрэглэгчдийн дотроос 9,753,387 хүний зээлийн мэдээллийг ББСБ зэрэг санхүүгийн байгууллагаас ирүүлж, бүртгэгдсэн байна. Гэхдээ энэ ААН-ийн мэдээлэл нь 2009 оноос (мэдээллийн сан бий болсноос хойш) хойшхи нийт бүртгэлийн тоо юм.

Харин 2009 оноос хойш зээл авсан ААН-ийн тоо 22,000 гэдгээс харвал одоо зээлийн үлдэгдэлтэй ААН-ийн тооны хувьд энэ тооноос хэтрэхгүй гэж ойлгож болно.

3) Арилжааны банкуудтай хийсэн ярилцлагад үндэслэсэн тооцоолол

Банк бүр зээлийн үлдэгдлийн талаар “Үйл ажиллагааны жилийн тайлан” зэрэгтээ тусган олон нийтэд мэдээлдэг боловч зээлийн тооны талаар мэдээлдэггүй. Мөн ярилцлагын үеэр ч бодит зээлийн тооны тухайд олон нийтэд нээлттэй бус мэдээлэл гэсэн болно. Гэвч том 4 банкны 3 банкны хувьд ААН-ийн зээлийн тоог ойролцоогоор 1,500-2,000 (багцаалсан тоо), 1,100 гаруй (бодит тоо) болон 1,000 орчим (бараг бодит тоо) гэсэн тоонуудыг танилцуулсан.

4) Сангийн яамны мэдээллийн сангаас гаргасан тооцоолол

Сангийн яамны мэдээллийн сангийн тухайд ЖДҮ-ийг хамрах хувь өндөр тул одоо байгаа санхүүгийн тайлангийн мэдээллийн сангийн хувьд хамгийн том нь болж байна. Мөн 2 төрөл байдаг гэж яригддаг санхүүгийн тайлангаас (Засгийн газар, Улсын орлогын газарт зориулсан санхүүгийн тайлан болон жинхэнэ тайлан) Засгийн газарт зориулсан нь бүртгэгдсэн гэж үзэж болно. Гэвч ААН 2 төрлийн санхүүгийн тайлан бэлдэх хөшүүрэг болж байгаа зүйл нь орлогын тайланг өөрчилснөөр төлөх татварын дүнг бууруулах гэж тооцож үзвэл өр төлбөрийн дүнг өөрчлөх хөшүүрэг бол бага юм. Тийм учраас Сангийн яамны санхүүгийн тайлангийн тухайд ч өр төлбөрийн дүн нь бодит дүнгээ мэдүүлсэн хэмээн үзэж, энэхүү мэдээллийн сан дахь банкны зээлтэй гэж бүртгэгдсэн ААН-ийн тоог тооцож үзвэл байгууллагын зээл авсан ААН-ийн тоог

мэдэх боломжтой. Энэ зүйлийн тухайд Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар нь Жайка болон Монголбанк зэрэг байгууллагын албан бичгээр хүсэлт тавьбал мэдээллийг нэгтгэж өгөх боломжтой гэсэн боловч энэ удаагийн судалгааны хугацаанд хэрэгжүүлж амжаагүй болно.

(3) Ирээдүйд байгууллагын зээл авах боломжтой ЖДҮ-ийн тоо

1) Монголбанкны статистик мэдээнд үндэслэсэн тооцоолол

Монголбанкны статистик мэдээгээр хувь хүний бизнесийн зээлийн зээлдэгч, өөрөөр хэлбэл үнэн хэрэгтээ ЖДҮ-ийн зориулалттай гэж үзэж болохоор зээлдэгчийн талаарх статистик мэдээ ч мэдээлсэн байна. Ярилцлагаас үзвэл, энэ төрлийн зээлд ЖДҮ гэж үзэн, санхүүгийн тайланг шаардах тохиолдол ч олон аж. Статистикт энэ тоо нь 2017 оны эцсийн байдлаар 40,467 байв. Энэ нь ААН-ийн зээлээс ойролцоогоор 6.6 дахин их байна. Гэвч Монголбанк болон бусад арилжааны банктай хийсэн ярилцлагаас үзвэл, энэхүү тооны тухайд санхүүгийн байгууллага бүрийн ЖДҮ-ийн тодорхойлолт ялгаатай учир эцсийн бүлэгт зах зээлийн мэдрэмжийн тоон үзүүлэлт гэж авч үзнэ гэсэн саналыг олон байгууллага өгсөн. Энэ тухайд том 4 банкны 1 банк нь дээрх бодит ЖДҮ-ийн зээлийн (хувь хүний бизнесийн зээл) тоог танилцуулсан ба тэрхүү тоо нь нэрийг тодруулахаас өмнө ойролцоогоор 5,000 бөгөөд ААН-ийн зээлээс ойролцоогоор 5 дахин их байсан.

2) Арилжааны банктай хийсэн ярилцлагад үндэслэсэн тооцоолол

Хувь хүн иргэний зээл авсан харилцагчдаас хэд орчим хувь нь ААН (ЖДҮ) гэж санхүүгийн тайлангаа өгч байгаа вэ гэдгийн тухайд бүх банкнаас тодорхой хариу авч чадаагүй болно. Энэ нь хувь зээлдэгчээс санхүүгийн тайлан шаарддаг эсэх тухайд зээлийн төрөл, зээлдэгчийн байдал, банкны хариуцсан ажилтан зэргээс шалтгаалан шийдэгдэж, тэрхүү тоог тоолох нь банкны хувьд ач холбогдолгүй тул тооцож нэгтгэдэггүй ба мэдээлэл байхгүй байгаатай холбоотой

(4) Төрөл бүрийн тооцооллын нэгтгэл ба хэрэгжих боломжит байдал

Дээрх (2)-т тэмдэглэгдсэн одоогийн байдлаар зээл авсан байгаа ААН-ийн (ЖДҮ хамарна) тооноос үзвэл ААН гэж ААН-ийн зээл авсан тооны хувьд Монголбанкны статистик мэдээллийг үндэслэлтэй гэж үзэж болно. Түүнчлэн бүх банк санхүүгийн байгууллагын зээлийн тухайд өнгөрсөн хэдэн жилийнх нь санхүүгийн тайланг авдгаас үзвэл Зээлийн эрсдэлийн мэдээллийн сан бүх банкинд нэвтэрч, үнэлгээ нь хүүгийн түвшинд нөлөөлвөл дор хаяж 5,000 орчим

компани хамрагдана гэж тооцоолж байна.

Мөн (3)-т тэмдэглэсэн ирээдүйд ААН-ийн зээл авах магадлалтай ЖДҮ-ийн тооноос үзвэл Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг нэвтрүүлснээр Монгол улс дахь үйл ажиллагаа явуулж буй 75,000 ААН-ийн дотроос багадаа 40,000 орчим ЖДҮ-д нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн дээр дурьдсан одоо зээлтэй байгаа болон ирээдүйд зээл авах боломжтой ААН-д хамрах зээлийн нийт үлдэгдэл 2017 оны эцсийн байдлаар 3,000 сая ам.доллар (7,614,646 сая төгрөг⁴⁸) байгаа ба 2017 онд Монгол улсын нэрлэсэн ДНБ ойролцоогоор 11,135 сая ам.доллар (Монгол улсын Үндэсний статистикийн хорооны мэдээлэл) байгааг авч үзвэл Зээлийн эрсдэлийн сангийн нөлөө үзүүлэх боломжтой зээлийн хэмжээ их байгаа нь харагдана.

⁴⁸ Энэ бүлгийн 1-р хэсгийн (3) Зээлтэй холбоотой бүртгэл-д 2017 оны байгууллагын зээлийн эцсийн үлдэгдэл болон иргэн/ЖДҮ-ийн зээлийн эцсийн үлдэгдлийн нийлбэр

3.8 ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал, чиглэл

Энэ хүртэл Монгол улсын санхүүгийн тогтолцоо, түүн дотроо зээлийн үнэлгээний системийн өнөөгийн байдал ба асуудал, зээлийн мэдээллийн агуулга, хянаж үнэлэх аргын байдал, асуудлын талаарх судалгаа, дүгнэлтдээ үндэслэн Монгол улсын хувьд Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг нэвтрүүлэхийн давуу болон сул талын тухай одоогийн хэрэгжиж буй зээлийн үнэлгээний системд үзүүлэх үр нөлөөнд дүн шинжилгээ хийж ирсэн болно.

Ялангуяа өнөөгийн ЖДҮ-ийн санхүүжилт дэхь 1) хүү өндөр, хугацаа богино зээл 2) барьцаа хөрөнгийн асуудал 3) ЖДҮ-ийн санхүүгийн сул байдал 4) ЖДҮ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн тайлан боловсруулах чадавхын дутмаг байдал гэсэн зээлийн хүртээмж, зээлийн нөхцөлийг (хүү болон бусад) сайжруулахад тулгарч буй асуудлын талаар төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, бага зэрэг эерэг нөлөө байгаа боловч нөхцөл байдлыг сайжруулах хэмжээнд хүрээгүй байна. Мөн хувилбарт зээлийн үнэлгээний системийн тухайд банк тус бүртгээ хөгжүүлэхээр ажиллаж байгаа ч санхүүгийн салбарын хэмжээнд эрс шийдэмгийгээр систем нэвтрүүлэх явдал судалгаа, шинжилгээний шатанд байна гэж хэлж болно. Ийм нөхцөл байдалд Монгол улсын УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо зэрэг газрын зүгээс ЖДҮ-ийг дэмжих, түүнд зориулсан санхүүгийн тогтолцоо, ялангуяа зээлийн хүүг бууруулах талаар Монголбанкинд анхааруулсан байна. Иймд Монголбанк, Сангийн яамны зүгээс ЗМС-г болон ААН-ийн санхүүгийн тайлангийн стандартыг сайжруулахаар авч үзэж буй бөгөөд Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг нэвтрүүлэх орчин бүрдэж эхэлж буй гэж үзэж болно. Тус төслийн судалгааны хүрээнд Монголбанкт хамтран зохион байгуулсан Зээлийн эрсдэлийн мэдээллийн сан нэвтрүүлэх талаар хамтарсан ажлын хэсэг ч Монголбанк Зээлийн эрсдэлийн мэдээллийн санг нэвтрүүлэх сонирхол их байгаа ба цаашид судлах шаардлагатай байгааг гэдгээ илэрхийлсэн. Хүснэгт 3.13-т хамтарсан ажлын хэсэг дээр хэлэлцэгдсэн ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал ба авах арга хэмжээнүүд байгаа бөгөөд Зээлийн эрсдэлийн мэдээллийн сан нь аль ч арга хэмжээнд хувь нэмрээ оруулах болно гэж үзсэн.

Хүснэгт 3.13 ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал ба авах арга хэмжээний чиглэл

	ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал	Арга хэмжээний чиглэл
1) Хүү өндөр, хугацаа богино зээл	урт хугацаат зээл, ЖДҮ-ийг дэмжих бага хүүтэй зээл	2) 3) 4)-г дурдсан асуудалд байгаагаар ЖДҮ-ийн зээлийн үнэлгээний зардлыг бууруулах арга хэмжээ урт хугацаанд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар урт хугацааны үзүүлэлтийг тодорхой болгох
2) Барьцаа, баталгааны асуудал	Өнөөгийн хуулийн тогтолцоогоор бол барьцаа хөрөнгө бүртгүүлсэн байсан ч давж заалдаснаар 2 жилээр түдгэлзүүлэх зэрэг эрсдэл ч их. Зээлийн батлан даалтын сангийн баталгааны систем ч өмнө дурдсаны дагуу АХБ-ны Техникийн туслалцаа нь барьцааг голчилсон, барьцаа хөрөнгийн хүрэн дэхь зээлийг чухалчлан үздэг	барьцаа, баталгааны системийг сайжруулах барьцаа, баталгаанаас гадна эрсдэлийг бууруулах тогтолцоог нэвтрүүлэх
3) ЖДҮ-ийн санхүүгийн сул байдал	санхүүгийн байдал сул ЖДҮ олон тул үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгал дээр суурилсан үнэлгээ хийхэд хүндрэлтэй ба барьцаа, баталгаанд суурилахаас өөр аргагүй болдог.	Үүсгэн байгуулагчид зээл олгох тогтолцоо зэрэг аж ахуй эрхлэгчийг дэмжих тогтолцоо (ЖДҮ-ийг дэмжих сан зэргийн үнэлгээний стандартыг тодорхойлох)
4) ЖДҮ-ийн ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн боловсруулах чадавхийн байдал	үйл тайлан дутмаг санхүүгийн тайлан дугмаг санхүүгийн тайлан боловсруулах чадавхаас гадна өнөөгийн олон янзын тайлан гаргадаг системийн (өөрөөр хэлбэл хуурамч санхүүгийн тайлан гаргаж өгдөг) үед харилцагчийн жинхэнэ санхүүгийн байдлыг мэдэхийн тулд гэрээ, журнал, баримт гэх мэт нэмэлт материал цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг ажил хийж, цаг зардал их зарцуулдаг.	Үнэн зөв санхүүгийн тайлан гаргахад зориулсан ойлгоход хялбар үзүүлэлт, шалгах жагсаалт ыг бий болгох Найдвартай санхүүгийн тайланг нэгтгэхийн төлөөх улсын хүчин чармайлт

3.9 Зээлийн эрсдлийн мэдээллийн санг нэвтрүүлэхэд чиглэсэн ерөнхий зураглал

Монгол улсын шийдвэрлэх зохих асуудлын нэг нь санхүүгийн эрүүл тогтолцоот байдлыг хадгалсан эдийн засгийн тогтвортой суурийг дахин бий болгох явдал бөгөөд, ААН-ийн 97 гаруй хувийг хамарсан ЖДҮ-ийг дэмжих нь зайлшгүй шаардлагатайн дээр хөрөнгө санхүүгийн хүртээмжийг сайжруулах асуудлыг орхигдуулж болохгүй. Дээр дурдсанчлан, банк санхүүгийн байгууллагууд ч энэ өнцгөөс бодолцож зээлийн шийдвэр гаргалтын зохистой байдал, түүний үр дүн, цаашилбал зээлийн торхиромжтой байдал, зээлийн хүүг оновчтой тогтоох зэрэг асуудлуудлыг шийдвэрлэх нь чухал болоос байна.

Зээлийн шийдвэр нь журмын дагуу тодорхой хэмжээнд тухайн санхүүгийн байгууллагуудын шийдвэрт тулгуурлах нь тодорхой боловч, ЖДҮ-ийн хувьд санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах үүднээс санхүүгийн салбар нэгдсэн цогц байдлаар оновчтой үр дүнтэй болгох орчинг бүрдүүлэх нь нэн чухал юм. Энэ утгаараа ЗЭМС-ийг нэвтрүүлснээр арилжааны банкууд тус бүрийн Scoring Model буюу онооны загварыг бий болгож, ашиглаж буй өнөө үед санхүүгийн салбарын үйл ажиллагаанд шинэлэг хөндлөнгийн үнэлгээний стандарт бий болох чухал ач холбогдолтой.

Өнөөдрийг хүртэл ашиглагдаж ирсэн ЗМС-аар үзүүлж буй зээлдэгчдийн зээлийн түүх нь холбогдох санхүүгийн байгууллагын зээлийн шалгуур стандарт болсоор ирсэн. Түүнчлэн Монголбанкны үйл ажиллагааны нэг хэсэг болон жигдэрч, банк санхүүгийн байгууллагуудын зээлийн шийдвэрийн шалгуур бичиг баримт болсон⁴⁹. Зээл олгох шийдвэрт өмнөх зээлийн түүх хамгийн чухал үзүүлэлт болох нь тодорхой хэдий ч зээл авч буй ААН-ийн хүчин чадал, бизнесийн төлөв, ирээдүйтэй байдал зэрэг зээлийн эрсдэлийг тодорхойлох тал дээр хангалттай биш байна. Үүнээс гадна, ЖДҮ компаниудын зээлийн барьцаа хөрөнгө болон зээлийн түүх төдийгүй бизнесийн төлөв байдал зэрэг ЖДҮ-ийн үйл ажиллагаа нь зээлийн шийдвэрийн үзүүлэлт болдог байх хэрэгцээ бий бөгөөд ААН-ийн бүхий л санхүүгийн мэдээллийг тусгасан санхүүгийн тайланг бэлтгэх зэрэг ЗЭМС үйл ажиллагааны орчинг бэлдэх явдал нь чухал болов уу. (Мөн ЖДҮ, аж үйлдвэрийн хөгжлийн хувьд ч компаниудын зээлийн мэдээллийн талаарх ойлголт нэмэгдэж, компанийн засаглалыг сайжруулахад хувь нэмэр болох ба хөрөнгө оруулагчид таатай орчин бүрдэнэ).

Гэхдээ регрессийн систем дээр тулгуурласан ЗЭМС нь статистикийн бодит баталгаа бий

⁴⁹ Удаан хугацаанд томоохон шинэчлэл хийгээгүй системийг илүү боловсронгуй болгохоор ОУСК-тай энэ жилээс эхлэн хамтын ажиллаж байгаа.

болгохын тулд тодорхой хэмжээний мэдээлэл шаардагддаг. Хөгжингүй орнуудад ажиглагддаг нэг зүйл нь нэг банк хэдэн зуун мянган ААН зээлдэгчтэй байхад банкны дотооддоо биеэ даасан систем болон хөгжүүлэлт хийх боломжтой байдаг хэдий ч бодит байдал дээр эрсдэлд тулгуурласан зээлийн хүүг тооцоолдог систем ашигладаг банк ганцхан л байна. Монголбанкнаас энэ талаар ямар нэгэн заавар зааварчилгаа байдаггүй. Цаашилбал, Монголд хамгийн том дөрвөн тэргүүлэх банк нь тус бүрдээ 1,000-аас 1,500 гаруй зээлдэгч компанитай байгаа бөгөөд банк тус бүрт системийн нэвтрүүлэлт хийхэд статистик тооцоолол хийхэд хэцүү байх магадлалтай юм. Тийм учраас арилжааны банкуудтай хамтран, нэгдсэн мэдээлэл авах боломжтой Япон маягийн ЗЭМС загварыг нэвтрүүлснээр статистик нарийвчлал нэмэгдэх магадлалтай бөгөөд Монголын нөхцөлд энэхүү Япон загвар илүү ач холбогдолтойг ойлгоно. Монгол улсын банк санхүүгийн салбарт өнөөдрийг хүртэл нэгдсэн мэдээллийн сан бий болоогүй байсан ба мэдээллийг цуглуулах, боловсруулах, хянах аргачлал, банк бүрийн мэдээлэл боловсруулалт, хяналтын систем зэрэг технологийн үйл ажиллагаанаас гадна холбогдох хууль журам боловсруулан гаргах зэрэг тогтолцоо бий болгох асуудлыг авч хэлэлцэх шаардлагатай байна.

Нөгөө талаас, санхүүгийн салбарын нэгдсэн системийг авч хэлэлцэхэд өнөөгийн бодит зээлийн харилцагч аж ахуйн нэгж тоо 7000 орчим байгаа нь зээлдэгчийн хүрээ маш бага байгааг харуулж байна⁵⁰. Энэхүү судалгааны үе шатанд бүхий л талын зээлийн мэдээллийн бодит нөхцөл байдал, хууль эрх зүйн орчинг тодорхой болгохыг зорьсон, системийн гол цөм нь болсон бодит өгөгдөл (загвар) болон бодит үйл ажиллагаанд тулгарах асуудал хүртэл гүнзгий ороогүй болно. Цаашдаа уг асуудлыг нэн тэргүүнд авч хэлэлцэх нь чухал бөгөөд энэ утгаараа бодитоор туршилт, баталгаажуулалт хийх нь зүйтэй болов уу.⁵¹

(1) Санхүүгийн салбар дахь хүчин чармайлтууд

1) ЗЭМС (ЗМС)-ын байр суурийг тодорхойлох нь

Одоогийн байдлаар Монголбанк, Сангийн Яам, арилжааны банк болон холбогдох байгууллагуудын ихэнхи нь “Нэг хэсэгтээ ЗЭМС нэвтрүүлэх болон эхэн үеийн үйл ажиллагааг Монголбанк удирдан, дараагийн шатанд ямар тогтолцоотой байхыг авч хэлэлцэх нь

⁵⁰ Одоо Япон улсын ЗЭМС-ийн холбоонд бүртгэлтэй ойролцоогоор 2,4 сая аж ахуй нэгж байгууллагын 19 сая санхүүгийн тайлангийн мэдээлэл бүртгэлтэй байдаг.

⁵¹ Монголбанк талаас ч өгөгдлийн цар хүрээг харгалзан үзэж бодит регрессийн системийг нэвтрүүлэх нь чухал гэж онцолж байгаа.

зүйтэй ”гэсэн саналтай байна⁵². Энэхүү нөхцөл байдлаас авч үзэхэд Монголбанкны удирдлага доор арилжааны банкууд, МБХ, ЗБДС, ЖДҮС зэрэг Монголбанктai нягт харилцаа хамаарал бүхий байгууллагуудаас бүрдсэн Удирдах Зөвлөл, мөн түүний дор асуудал тус бүрийг хариуцсан ажлын хэсгийг байгуулахаас эхлэх нь зүйтэй болов уу.

ЗЭМС-ийг нэвтрүүлэх талаар авч хэлэлцэхэд, тухайн ситемийн байр суурийг шийдэх явцтайгаа зэрэгцүүлэн технологийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх нь чухал. Эдгээрийг Удирдах Зөвлөл буюу Хороо асуудлыг нарийвчлан цэгцлээд ажлын хэсэг хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй. Юуны түрүүнд Монголбанкны санаачилгаар арилжааны банкууд дундын мэдээллийн нэгдсэн сан байгуулахыг зорьлоо гэхэд хамгийн наад зах нь дараах асуудлыг банк тус бүрээр зохион байгуулах шаардлагатай .

- i) Өгөгдлийн стандартчилал (мэдээллийг цэгцлэх арга, мэдээллийн төрөл зүйл, мэдээллийн илэрхийлэмж, мэдээллийн хэлбэр гэх мэт)
- ii) Өгөгдөл дамжуулах стандартчиллын аргачлал (ЗМС-с салгах эсвэл хамааруулах)
- iii) Мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх үүрэг (хариуцлага, мэдээллийн хадгалалт гэх мэт) –ийг тодорхой болгох
- iv) Систем болон системийн удирдлагын эрх, үүргийг тодорхойлох

Үүнээс гадна Сангийн Яам нь ирээдүйд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн тайлан бэлтгэх удирдамжийг боловсруулж, банкууд дахь мэдээллийн системт үе шат тус бүрт "стандарт" –ыг хэрхэн бий болгож, хэрхэн ашиглах талаар шийдвэрлэх шаардлагатай байна.

ЗЭМС–г нэвтрүүлэх тохиолдолд Монголбанк дотроо эрхлэн явуулахад хариуцах салбар хэсэг болон ЗМС-ы системээс тусад салгалаа гэхэд, зээлийн мэдээллийг нийлүүлэх салбар нэгж нь нэг байна ярилцаж байна. Одоогийн байдлаар ЗМС-ын системийн шинэчлэл ба сайжруулалтыг мөн оны 6 дугаар сараас хэрэгжүүлж байна. Банк тус бүрээс санал авах цуврал уулзалтуудыг зохион байгуулж, ОУВС–ын тусламжтайгаар бодит системийн шинэчлэл ба сайжруулалт зэргийг ажлыг хэсэг байгуулан ажиллаж байна. Дээр санал болгож буй Удирдах зөвлөлийг байгуулж эхлэх хүртэл судалгааны багтай хамтарсан ажлын хэсэг нь ЗМС шинэчлэлийн ажлыг

⁵² Энэ удаагийн судалгаагаар семинар болон төрөл бүрийн уулзалтуудаас үзэхэд Монголбанк нь албан ёсоор мэдэгдээгүй боловч системийг хөгжүүлэх, үйл ажиллагааг явуулах ажлыг Монголбанк дээр төвлөрүүлэн эхлүүлж тогтвортой үйл ажиллагааг тодорхой хугацаанд явуулсны дараа тохиромжтой үед нь хувийн хэвшил болон Монголбанкнаас өөр байгууллагад шилжүүлэх байр суур ажиглагдсан.

хэсэгт орж мэдээлэл солилцон ЗЭМС-тай хэрхэн уялдуулах талаар авч хэлэлцэх шаардлагатай⁵³.

2) Зээлийн судалгааны үр ашгийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг оновчтой болгохын тулд санхүүгийн байгууллагын дотоод бүтэц зохион байгуулалтыг бий болгох

ЗЭМС-г нэвтрүүлэх нь зээлийн судалгааны үр ашгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэг нь өнөөг хүртэлх Япон дахь үйл ажиллагаа болон Европ, Америк дахь ЗЭМС-ийн дотоод сүлжээний загвар (in-house CRD model) дахь үзүүлэлтийн үнэлгээний загварын хэрэглээний байдал зэргээр батлагдаж байна. (Монголын нэг томоохон банк ижил төрлийн үзүүлэлтийг (систем) дотоод сүлжээний хэлбэрээр нэвтрүүлж байгаа нь тодорхой болсон⁵⁴.

Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэвэл 2018 оны 6 сарын 12-ны өдөр “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023 он”-ийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн баталгааны корпораци (DICOM) гэсэн 4 тал оролцон баталсан байна. Үүнд зээлийн хүүг бууруулах чиглэл болгож макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарыг бэхжүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэргийг дурьдсан ба томоохон зорилгын нэг болгож банкны эрсдэлийн удирдлагын чадавхийг сайжруулах ба үр ашгийг нэмэгдүүлэх гэж тодорхойлсон байна.

Зээлийн хүүг бууруулахын тулд хадгаламжийн хүүгийн өсөлтийн талаарх арга хэмжээг дэмжих, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээс гадна банк хоорондын зах зээлийг бий болгох болон худалдан авалтын зах зээлийг төрөлжүүлэх, мөн арилжааны банкуудын илүү хүчин чармайлттай үйл ажиллагаа зэрэг олон тэргүүлэх хүчин зүйлүүд байгаа ч эрсдэлийн удирдлагын үр ашигтай байдал ч зээлийн хүүг бууруулахад багагүй хувь нэмэр оруулах юм.

ЗЭМС нь хөндлөнгийн статистик үзүүлэлтийг нэвтрүүлснээр онолын хувьд эрсдэлийг харгалзсан зээлийн хүүг тогтооход туслах бөгөөд эрсдэлийн удирдлагын үр ашгийн дагуу зээлийн хүүг бууруулах хүрээнд хүүгийн хэмжээг оновчтой болгоход хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

ЗЭМС-ийн мэдээллийг зөвхөн банкууд үнэлгээний загвартаа хэрэглэх бус санхүүгийн

⁵³ Монголбанкнаас мэдээллийн цар хүрээг харгалзан үзэж бодитой регрессийн системийг нэвтрүүлэх чухал ач холбогдолтой болохыг онцолсон.

⁵⁴ Энэхүү дотоод сүлжээний загварын талаар энэ удаагийн судалгааны ярилцлагын үед хариулсан зүйл бөгөөд ямархуу түвшний загвар болохыг тодруулаагүй болно. Ярилцсан хүний зүгээс илүү олон тооны өгөгдөлд суурилсан ЗЭМС-ийн талаар их хүлээлттэй байгаа бөгөөд дотоод сүлжээний загварынхаа үзүүлэлтүүдтэй харьцуулахад ч хэрэгтэй юм гэсэн санал хэлж байв.

байгууллагуудын эрсдэлийн үнэлгээ хийх зэрэгтэй холбох боломжийн талаар судалж үзэх нь чухал байна. Дээр дурьдсан “Хороо” мөн систем нэвтрүүлэх техникийн талын “Ажлын хэсэг”-ээс гадна иймэрхүү асуудлыг хариуцах ББСБ-ыг ч оролцуулсан, илүү өргөн хүрээний бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг” байгуулах талаар ч авч үзэх нь зүйтэй болов уу.

3) Баталгаа, барьцаа

Дээр дурьдсанаар ЗЭМС-ийн байр сууринаас хамаарах боловч ЗБДС-ийн баталгааны шимтгэлийн хувь болон зээлийн үед шаардагдах баталгаа хөрөнгийн тухайд ч ЗЭМС-аар үр ашгийг нэмэгдүүлэх, оновчтой болгох талаар судалж үзэх нь зүйтэй болов уу. Японы туршлагаас үзвэл Зээлийн баталгааны холбооны баталгааны хувь нь ЗЭМС-ийн боловсруулж гаргасан, тооцоологдсон үндсэн дефолт магадлалыг харгалзан тогтоогдгийн адилаар Монголд ч ЗБДС-ийн баталгааны хувийг тогтоох шалгууруудын нэг болгох найдвартай үзүүлэлт болж болох юм.

Одоогоор баталгааны шимтгэлийн хувь нь банкны зээлийн үнэлгээний үр дүнг ЗБДС-ийн зүгээс үнэлж үзсэний дагуу банкны зээлийн хэлбэрт тааруулсан тогтмол хувь юм. Баталгааны дээд хэмжээг өөрчлөх (зээлийн дүнгийн 60 хувиас 80 хувь болгох) тухай хэлэлцүүлэг өрнөж буй энэ үед цаашид ЗЭМС-г нэвтрүүлснээр илүү үр ашигтай бөгөөд оновчтой баталгааны үнэлгээ, баталгааны шимтгэлийн хувийг тооцоолох боломжийн талаар судалж үзсэнээр, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдох болно гэж үзэх нь чухал болов уу. Үүний тулд ЗЭМС-ийн мэдээллийг нэмсэн техникийн үнэлгээний аргыг судалж үзэх, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн (“Law on the Credit Guarantee Fund of Mongolia of 2012”) нэмэлт өөрчлөлт зэрэг тогтолцооны талын оновчтой байдлын талаар хэлэлцэх нь бас чухал юм.

Хэлэлцэх зохион байгуулалтын хувьд тусдаа “Ажлын хэсэг” байгуулж болох ч энэ асуудлын тухайд юуны өмнө дээр дурьдсан үнэлгээний үр ашигтай байдал, хүүгийн оновчтой байдлын талаар байгуулагдах “Ажлын хэсэг”-ийн хэлэлцэх асуудлын нэг болгон шийдвэрлэх боломжтой.

(2) Хууль эрх зүй болон зохион байгуулалтын талаар авч үзэх

Судлах аргачлалын тухайд одоогийн байдлаар хууль эрх зүйн тогтолцооны талаарх ажлын хэсгийг байгуулах, эсвэл хууль эрх зүйн тогтолцооны асуудлыг ч дээр дурьдсан ажлын хэсгийн авч судлах асуудал болгох. Аль нь ч байсан цаашид судлах зүйл болж үлдэх ба доорх зүйлүүдийн талаар авч үзэх хэрэгтэй болно.

1) ЗЭМС-г нэвтрүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдүүлэх

○Мэдээллийн хяналт

ЗЭМС-г нэвтрүүлэхэд анхны өгөгдөл болох арилжааны банкны зээлдэгчдийн зээлийн мэдээлэл, ААН-ийн мэдээлэл, зээлийн эргэн төлөлтийн хоцорсон болон төлөгдөөгүй байдал зэрэг мэдээлэлтэй хэрхэн харьцахыг тодорхой болгох шаардлагатай. Монгол улсын хувьд өмнө дурьдснаар “Компанийн нууцын тухай хууль”, “Хувь хүний нууцыг хамгаалах хууль”, “Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн хэрэглэгдэх байдлыг тодорхой болгох шаардлагатай. Мөн ийм мэдээллийг “Төрийн нууцын тухай хууль”-иар зохицуулагдах мэдээллээс ялгаж, салгах хууль зүйн үүднээс тодруулах шаардлагатай.

Тухайлбал, “Хувь хүний нууцыг хамгаалах тухай хууль”-ийн 4.1.3-т зааснаар хамгаалагдах “хувийн мэдээлэл”-д “тооцоолсон мэдээлэл” гэсэн байгаа нь ЗЭМС-нд хэрэглэгдэх анхны өгөгдөл болох мэдээлэл нь үүнд хамрагдах үгүй юу, угаас банкны цуглуулсан зээлдэгчийн байгууллагын мэдээлэл нь хувийн мэдээллийн “хувь хүн” гэдэгт хамрах уу үгүй юу, нэргүй мэдээлэл нь ямар хуулиар хамгаалагдах, зохицуулагдах вэ зэрэг асуудал юм. Одоогийн байдлаар “тийм”, “үгүй” гэж хэлж чадахааргүй зүйлүүдийг нэг бүрчлэн тодорхой болгох шаардлагатай.

○Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль зэрэг зохион байгуулалт, үйл ажиллагаа эрхлэх талын асуудал

“Зээлийн мэдээллийн төв” ХХК-ийг байгуулахад Зээлийн мэдээллийн албаны тухай хууль батлагдаж, арилжааны банк зэрэг санхүүгийн байгууллагаас мэдээлэл ирүүлэх хэлбэр болон байгуулах стандарт, Төв банкны үүрэг, Банкны хуультай зохицуулах зэрэг Монголбанкнаас гаргасан олон шийдвэр зэрэг зүйлүүдийн тайлбарыг баталгаажуулсан байна. ЗЭМС нь нэг хэсэгтээ Монголбанкинд харьяалагдан үйл ажиллагаа явуулна гэж үзвэл Зээлийн мэдээллийн албаны адилаар, эсвэл түүнд тохирсон эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай болов уу.

○Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль зэрэг холбогдох байгууллагуудтай харилцах харилцааны асуудал

ЗЭМС-ийн үйл ажиллагаа эрхлэх арга, зохион байгуулалтаас шалтгаалах ч дээр дурьдсаны дагуу, тухайлбал ЗБДС-ийн баталгааны шимтгэлийн хувийг тогтооход ЗЭМС-ийн үзүүлэлтийг ашиглах зэрэг үйл ажиллагааны хүрээнд харилцаа үүссэн тохиолдолд зайлшгүй ЗБДС-ийн

тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэх зэргийг тодруулах шаардлагатай. Барьцааны тогтолцоо, ЖДҮ-ийн сан зэрэг институцийн санхүүжилтэд хэрэглэгдэх тохиолдлын эрх зүйн зохицуулалтын талаар ч авч үзэх нь чухал юм.

2) Үйл ажиллагаа эрхлэх байгууллага, тогтолцоо

Үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг төрийн байгууллага болгож шинээр байгуулах эсвэл төрийн байгууллагад хавсруулах тохиолдолд хувийн хэвшил, хөндлөнгийн салбар зэрэг үйл ажиллагааг эрхлэх шинэ субъектыг авч үзэхдээ аль ч тохиолдолд ямархуу эрх зүйн зохицуулалт шаардлагатай болохыг авч үзэх хэрэгтэй болно. Одоогийн байдлаар нэг хэсэгтээ Монголбанкны харьяанд байна гэж үзвэл түр хугацаанд ч гэсэн Монголбанкны тэрхүү эрхийг Төв банкны тухай хуулиар зохицуулж өгөх шаардлагатай. Зээлийн мэдээллийн албаны адилаар Төв банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4-т “банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих” гэсэн заалтыг хэрэглэх үү, шинээр заалт оруулах уу зэрэг харилцааны талаарх ч эрх зүйн зохицуулалтыг авч үзэх хэрэгтэй.

3) Бусад олон улсын байгууллага, бусад системтэй харьцах

Одоогийн байдлаар Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн системийн шинэчлэлийн талаар Санхүүгийн зохицуулах хороо голлох үүрэгтэйгээр ажиллаж байна. Мөн ЗБДС-ийн тухайд Азийн хөгжлийн банкны 60 сая ам.долларын санхүүжилтээс гадна үйл ажиллагаа эрхлэх тал дээр техникийн тусламжийн хөтөлбөр хэрэгжиж байна. Одоогоор бодитоор үйл ажиллагаа явуулаагүй байгаа ч Зээлийн мэдээллийн төв ХХК байгуулагдахтай холбогдуулан ОУСК нь Зээлийн мэдээллийн алба ХХК-ийн үүсгэн байгуулагч, Монголын банкны холбоо зэрэгт туслалцаа үзүүлэн, систем нэвтрүүлэх тал дээр ч тусламж үзүүлэх санал тавьж байсан байна. ЗЭМС-ийн хувьд манай улсаас өөр аль нэг улсын байгууллага тусламж үзүүлэх асуудал байхгүй ч нийт санхүүгийн байгууллага дахь эрсдэлийн удирдлага болон эрх бүхий байгууллагын хяналт, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх тухайд ЗЭМС болон Зээлийн мэдээллийн алба гэсэн 2 баганатай тогтолцоог бий болгох, ЗБДС, ЖДҮДС-тай харьцах харилцаа нь чухал бөгөөд үр ашигтай бөгөөд оновчтой тогтолцоог бий болгохын төлөө холбогдох олон улсын байгууллагуудтай давхардаагүй, харилцан нөхсөн үр дүнг гаргахын тулд мэдээлэл хуваалцах, хамтрах, шаардлагатай бол хамтарсан үйл ажиллагаа явуулахыг ч авч үзэх хэрэгтэй.

(3) ЗЭМС үүсгэх анхны өгөгдлийг цуглуулах, хянах (санхүүгийн тайлан, ААН-ийн мэдээллийн ашиглалт)

Санхүүгийн тайлан, ААН-ийн мэдээллийн ашиглалттай холбоотой анхаарах зүйл гэвэл ЗЭМС нэвтрүүлэхэд банкинд буй зээлдэгчийн санхүүгийн тайлан (мэдээлэл), ААН-ийн мэдээлэл, зээлийн мэдээлэл (эргэн төлөлтийн хоцролт ба төлөөгүй талаарх мэдээлэл орно) хэрэгтэй болно. Систем нэвтрүүлэх эхэн үед эдгээр мэдээллүүдийг цуглуулах арга зам нь маш чухал болно. Энэ удаагийн судалгаагаар эдгээр мэдээлэл нь банк тус бүрийн өөрийн аргаар боловсруулагдан, хянагддаг болох нь тодорхой болсон. Мөн аль ч банкны хувьд ямар нэг мэдээллийн сан үүсгэх, системчлэх ажил хийгдэж байгаа нь ч тодорхой болсон. Гэвч эдгээр нь банкны тус бүрийн “хувийн мэдээллийг хамгаалахад” хамрах зүйл ба бодит хяналтын арга, мэдээллийн сан, болон системийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон байдлыг тодруулах хэмжээнд хүрээгүй болно. Өөрөөр хэлбэл багц тус бүрийн мэдээлэл боловсруулалт, хяналтын арга зам, мэдээллийн сан болон систем нь ямар хэмжээний агуулгатай болох, процедур, маягт зэргийг оруулаад аль хэр стандартчилагдсан болохыг цаашид тодруулах шаардлагатай.

Санхүүгийн тайлан гэхэд л ихэнх банк E-Balance-ийн маягтийг хэрэглэдэг гэсэн ба тэр дансны зүйлийг хэр хэмжээгээр хамарч байгаа, хамгийн багаар хамруулах зүйлийг банк дотооддоо журамласан эсэх, хяналтын хугацаа нь хэдэн сар тутам байдаг, доод тал нь хэдэн жилийн мэдээллийг авахаар заасан байдаг, “хар тэмдэглэлээс” мэдээлэл цуглуулах стандарт шалгуур болон процедурыг боловсруулсан эсэх, ямар давтамжтайгаар шинэчилдэг (шинэчлэх стандарт байгаа эсэх) зэрэг бодит мэдээлэл болон банкны дотоод журам, процедурыг тодруулахгүйгээр байгаа байдалд дүгнэлт хийх боломжгүй байна. Мөн “мэдээлэл хадгалах аргын” талаар ч нарийвчлан тодруулах шаардлагатай ба салбар дээр хадгалах, төв дээр хадгалах мэдээлэл гэж байдаг эсэх, салбар тус бүрийн хяналтын тогтолцооны нийтлэг журам байдаг эсэх, мэдээллийн формат нь тоон уу, аналог уу, нэгдсэн нэг формат нэвтрүүлсэн эсэх зэргийг нэг бүрчлэн тодруулах шаардлагатай.

3.10 ЗЭМС нэвтрүүлэх боломжийн талаарх судалгаа

Өмнөх зүйлд ЗЭМС нэвтрүүлэхтэй холбоотойгоор “ерөнхий зураглалыг” судалж үзсэн ба энэ удаагийн судалгаагаар тодорхой хүрээнд сонголт, чиглэл, анхаарах зүйлсийг авч үзсэн. Мөн тэдгээрийн тэргүүлэх байр суурийн талаар агуулгын харьцангуй мэдрэмжээр илэрхийлсэн ба тодорхой цаг хугацааны мөчлөгийг гаргах хэмжээнд хүрээгүй болно. Энэ нь ЗЭМС-г бүрдүүлэхэд гол орох хаалга болох анхны өгөгдлийн (Арилжааны банкин дахь санхүүгийн мэдээлэл, ААН-ийн мэдээлэл, зээлийн мэдээлэл) хадгалах хэлбэр, удирдлагын бодит байдал, жинхэнэ анхны өгөгдөл болон удирдлага, хяналтын систем (процедур) хүртэл нь тодруулж чадаагүй ба байгууллага тус бүрийн тайлбараас гарсан тоймыг дүгнэхээс өөр сонголтгүй байсантай холбоотой. Арилжааны банкны хувьд эдгээр мэдээлэл нь байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалахад холбогдох хэсэг байгаагаас гадна Монголын компаниудын хаалттай байдал ч бас нэг нөлөөлөх хүчин зүйл болсон гэж үзэж байна. (Ялангуяа хөндлөнгийн этгээд болох судалгааны багийн мэдээлэлд хүрэх хүрээ нь хязгаарлагдмал байсан гэж хэлж болно.)


Ийм учраас банкуудын удирдлага хяналтыг хэрэгжүүлэгч болох Монголбанкны удирдлага дор тодорхой тооны мэдээллийг цуглуулж, загвар бий болгох боломжийн талаар судалгаа хийх шаардлагатай.

4 Компанийн засаглалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

4.1 Монгол улсын компанийн засаглал

Монгол улсын компанийн засаглалын хууль эрх зүйн орчин Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдана. Тус тайлангийн 2 дугаар бүлэгт дурдсанчлан зах зээлийн системд шилжсэний дараа буюу 1999 онд анхны Компанийн тухай хууль батлагдан, компанийн эрх зүйн нийтлэг зарчим, компанийн засаглалын зарчмуудыг ч тусгасан. 2007 онд Компанийн засаглалын кодекс, 2011 онд Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд 2014 онд Компанийн засаглалын кодекс шинээр батлагдсан.

2017 оны 12 сард ЕСБХБ томоохон 10 хувьцаат компани, Хөрөнгийн бирж, хуулийн компаниудыг оролцуулан судалгаа явуулсан бөгөөд “Corporate Governance in Transition Economies Mongolia-Country Report” судалгааны тайланд өнөөгийн Монгол улсын компанийн засаглалын нөхцөл байдлыг дараах байдлаар үнэлсэн байна (зураг 4.1). ТУЗ-ын бүтэц, мэдээллийн ил тод байдал болон тайлагнал, дотоод хяналт, хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцогч талууд болон тогтолцоо гэсэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээс 3 үзүүлэлт нь дундаас доогуур үнэлгээ авсан бөгөөд дундаас дээш үнэлгээтэй 2 үзүүлэлт дундаж хэмжээнд байна. Хувьцаат компаниудад ч компанийн засаглалын кодексд заагдсан компанийн мэдээллийн ил тод байдал болон хууль дүрмийг чандлан мөрдөх асуудал хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа нь харагдаж байна.



Үзүүлэлт: 1 маш муу / 2 муу / 3 энгийн / 4 харьцангуй сайн / 5 маш сайн Эх сурвалж: EBRD, Corporate Governance Assessment 2016

Зураг 4.1 Монголын компанийн засаглалын үнэлгээ

4.2 Компанийн засаглалын өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудал

(1) Засгийн газрын бодлого, хэрэгжүүлэгч байгууллага

1) Компанийн засаглалын хөгжил

Өмнө дурдсанчлан 1999 онд Компанийн тухай хууль батлагдсанаар Компанийн засаглалын зарчим хуульчлагдан, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Компанийн засаглалын ажлын хэсэг байгуулагдсан. Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн чиглэл удирдамжийн дагуу Үнэт цаасны хороо 2000 оны 10 сараас нийт бүртгэлтэй хувьцаат компаниудад үзлэг шалгалт хийх удирдамж баталж, 2002 оныг дуустал үзлэг хийсэн. Үзлэгт хамрагдсан 353 компаниас үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 203 компани, хангалтгүй үнэлгээтэй 124 компани, үйл ажиллагаа нь бүрэн зогссон 59 компани байна.

2007 онд ЭЗХАХБ-ын компанийн засаглалын зарчимд суурилсан Монгол улсын Компанийн Засаглалын кодексийг батлан гаргасан. Үүний дараа 2014 онд компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан байна. Компанийн засаглалын кодексыг хүснэгт 2.4-д үзүүлсэнчлэн Компанийн засаглалын үндсэн зарчим, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх, хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ын эрх үүрэг, санхүүгийн тайлан, мэдээллийн ил тод байдал, дотоод хяналтын тогтолцоо, эрсдлийн менежмент, оролцогч талуудын эрхийн талаар тодорхой заасан.

2) Компанийн засаглалын Үндэсний хөтөлбөр

2 дугаар бүлэгт дурдсанчлан 2011 онд Засгийн газраас батлагдсан Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Компанийн засаглалын кодекс, бизнесийн зарчим, ёс зүйд суурилсан үндэсний компани, бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор дараах 7 бүлгээс бүрдэнэ.

Хүснэгт 4.1 Компанийн засаглалын агуулга

Но.	Бүлэг	Дэд бүлэг
1	Нийтлэг зарчим	-
2	Хөтөлбөрийн зорилт	1
3	Хөтөлбөрийн зорилго болон хамрах хүрээ	1
4	Хөтөлбөрийн хэрэгжилт, хэрэгжүүлэх байгууллага	6
5	Хөтөлбөрийн хэрэгжих үе шат, төсөв	3
6	Хөтөлбөрийн гарах үр дүн, шалгуур үзүүлэлт	2
7	Хөтөлбөрийн мониторинг үнэлгээ	2

Эх сурвалж: 2011 оны Засгийн газрын 69 тоот тушаал

Энэхүү хөтөлбөрийн 3 дугаар бүлэгт 1) Компанийн засаглалын кодекс болон бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, 2) Компанийн засаглалын кодексг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын манлайлах, 3) Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх компани, аж ахуйн нэгжийн удирдлага менежментийг сайжруулах, 4) Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх гэсэн 4 тодорхой зорилт дэвшүүлсэн. Түүнчлэн 3 дахь зорилтод Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат компанийн засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах механизмыг бий болгох, 4 дүгээр зорилтод компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох тухайд авах арга хэмжээнүүд орсон бөгөөд компанийн засаглалыг хөгжүүлэх хүрээнд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэхээр тусгагдсан байна.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллага нь хувьцаат компаний хувьд СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж, төрийн өмчит компаний хувьд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хороо, бусад аж ахуйн нэгж нь Ажил олгогч эздийн холбоо, МҮХАҮТ, КЗХТ байна. Түүнчлэн Сангийн яам, Монголбанк, хуучин Аж үйлдвэрийн яам хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Энэхүү хөтөлбөр нь СЗХ-ны төсвөөр 3 үндсэн үе шатаар хэрэгжсэн. 1 дүгээр шатыг 2011-2012 онд хууль, дүрэм журмаар засаглалыг хэрэгжүүлэх шаардлагыг бий болгох, 2 дугаар шат буюу 2013-2014 онд компаниуд өөрсдөө ойлгож сайн дураар авч хэрэгжүүлэх, 3 дугаар шат буюу 2015-2016 онд засаглалын үнэлгээ хийх, ил тод мэдээлж бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх зорилт тавьж хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд Компанийн засаглалын Үндэсний Зөвлөлтэй хийсэн ярилцлагаар хөтөлбөрийн зорилт 80 хувьтай хэрэгжсэн байна. 2013 онд ТОП 20 хувьцаат компанийн засаглалын үнэлгээг хийсэн бөгөөд сайн засаглалтай компани 27.5% байсан бол 2016 онд хийсэн үнэлгээгээр сайн засаглалтай үнэлгээ авсан компани 54% байна. Судалгаанд хамрагдсан компаниудын 51% нь ТУЗ-тэй байсан бөгөөд үүний 34% нь төрийн өмчит компани байсан байна.

Хүснэгт 4.2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат

Үе шат	Зорилт	Гарсан үр дүн
1-р шат (2011-2012)	Хууль, дүрэм журмаар хэрэгжүүлэх шаардлагыг бий болгох	Компанийн тухай хууль шинэчлэгдэн батлагдан, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн орчин бүрдсэн.
2-р шат (2013-2014)	Компаниуд өөрсдөө ойлгож сайн дураар авч хэрэгжүүлэх	Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталж, компанийн засаглалын сургалт явуулдаг 11 байгууллагатай болж, сургалтад хамрагдагсад 3100 хүрч, цаашид өсөх хандлагатай байна.
3-р шат (2015-2016)	Засаглалын үнэлгээ хийх, ил тод мэдээлж бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх	Компанийн засаглалын үнэлгээ хийх журам батлагдан, үнэлгээний тайланг гаргадаг болсон. (2 жилд 1 удаа)

Эх сурвалж: Ярилцлагын дүнгээс ЖАЙКА судалгааны баг

Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийн 1, 2 дугаар шатанд холбогдох хууль эрх зүйг бэхжүүлж хувьцаат компани, төрийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-тай байх, компанийн удирдлагаас засаглалын сургалтад хамрагдах зэрэг үндсэн асуудал бүрэн нэвтэрч чадсан гэж хэлж болно. Компанийн тухай хуулийн шинэчлэл, компанийн засаглалын кодекс батлуулах зэргээр хууль эрх зүйн тогтолцоо бүрэлдсэнээр компанийн засаглалын талаар ойлголт өндөржиж улмаар засаглалын сургалт, семинарт идэвхитэй оролцох болсон.

- Холбогдох журмууд
- Компанийн засаглалын сургалт
- Аудит, цалин, урамшууллын зөвлөл байгуулах
- Хувьцаат компанийн дүрмийн загвар
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар түгээх журам
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны загвар
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны загвар
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын загвар журам

Хөтөлбөрийн 3 дахь шатанд компанийн засаглалын үнэлгээ хийх журам батлагдан, үнэлгээнд хамрагдах компанийн төрөл, үнэлгээний хугацаа зэргийг тодорхойлсон. Хөрөнгийн биржийн 1, 2 ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд холбогдох хууль, журмын хүрээнд 2 жил тутам үнэлгээ хийлгэн, түвшинг тогтоолгон, хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ. Олон нийтээс хөрөнгө

татан төвлөрүүлсэн (төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, арилжааны банк, даатгалын компани, хадгаламж, зээлийн хоршоо, аудитын компани, итгэлцлийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага) нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг компаниуд удирдлага болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр хийж гүйцэтгэж болно. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2016 он хүртэл байсан хэдий ч 2015 оны 12 сарын 17-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 444 тоот тогтоолоор үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тогтсон.

3) Үндэсний хөгжлийн газрын Аж үйлдвэрийн мэдээллийн сан

Тус тайлангийн 3 дугаар бүлэгт дурдсанчлан Үндэсний хөгжлийн газар нь Аж үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, нийт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэж байна. Энэхүү мэдээллийн санд 1) Түүхэн замнал, 2) Эрхэм зорилго, 3) Үйл ажиллагааны чиглэл, бизнесийн салбарууд 4) Дотоод бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт, 5) Компанийн свот шинжилгээ, 6) Байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй эсэх, 7) Бүтээн байгуулалт, дэд бүтэц, 8) Компанийн нийгмийн хариуцлага, 9) Ирээдүйн зорилт зэрэг мэдээлэл хамрагдана.

Энэ жилийн 4 сард Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлтэй хамтран ажиллах болсон бөгөөд дээрх мэдээллийн санд компанийн засаглалын талаарх мэдээллийг оруулах болсон. Дээрх мэдээллийн санд бүртгэгдсэнээр төрийн худалдан авалтад давуу эрхтэй оролцох төдийгүй ҮХГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан Оюу Толгой ХК зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай болон томоохон компаниудтай хамтран ажиллах боломж нэмэгдэнэ. Энэ жилийн 4 сард Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлтэй хамтран ажиллах болсон бөгөөд дээрх мэдээллийн санд компанийн засаглалын талаарх мэдээллийг оруулах болсон. Дээрх мэдээллийн санд бүртгэгдсэнээр төрийн худалдан авалтад давуу эрхтэй оролцох төдийгүй ҮХГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан Оюу Толгой ХК зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай болон томоохон компаниудтай хамтран ажиллах боломж нэмэгдэнэ.

Цаашид мэдээллийн ил тод байдал болон илүү үр дүнтэй ашиглах тал дээр анхааран мэдээллийн санг бэхжүүлэх шаардлагатай байна.

4) Холбогдох байгууллага: Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл

Компанийн засаглалын хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллага болох

Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл нь Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэд байгуулагдсан.

Санхүү, үнэт цаасны зах зээлийн тогтвортой хөгжил, компанийн засаглалын үнэлгээ, холбогдох мэдээллийн ил тод байдал, компанийн тайлагнал зэргийг сайжруулах замаар эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилготой, гишүүнчлэлтэй, мэргэжлийн институт юм. 2016 оны 4 сарын 25-нд Засгийн газрын 24-р тэмдэглэлээр хөтөлбөрийг үргэлжлүүлэн бүрэн хангуулах төр, хувийн хэвшлийн хамтарсан түншлэлд тулгуурлан мэргэжлийн институтын түвшинд өөрсдийн үйл ажиллагаагаар санхүүжүүлж ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөлийн гишүүдэд МҮХАҮТ-ын ерөнхийлөгч, СЗХны гишүүн, Монголбанкны дэд ерөнхийлөгч, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын хэлтсийн дарга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга, Монголын Хөрөнгийн биржийн хянан шалгах албаны дарга, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын захирал, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал нар сонгогдон ажиллаж байна. Одоогоор компанийн засаглалын сургалт явуулдаг 10 байгууллага, сургагч 65 багш, судлаач 15 хүн байна. КЗҮЗ нь жилд нэг удаа хуралдан жилийн төлөвлөгөөгөө баталдаг. Голлох үйл ажиллагааг доор дурдав.

Компанийн засаглалын кодекс, хуулийн хэрэгжилтийг хангуулах, бизнесийн таатай орчин бүрдүүлэх

Компанийн засаглалын кодексын хэрэгжилтэд төрийн манлайлалыг бэхжүүлэх (төрийн өмчит компанийн засаглалыг бэхжүүлэх)

Компанийн засаглалын кодекс буюу бизнес ёс зүйгээр компанийн менежментийг сайжруулах (Хувьцаа эзэмшигч, ТУЗ, удирдлагатай холбоотой маргаан, асуудлыг хөндлөнгийн байр сууринаас туслалцаа үзүүлэх, компанийн засаглалын үнэлгээ хийх)

Оролцогч талууд болон байгууллагын төлөөллийн чадавхийг дээшлүүлэх (сургалт, семинар, хэлэлцүүлэг, зөвлөмж)

Компанийн засаглалын нарийвчилсан, ахисан түвшний сургалт зохион байгуулах

Түүнчлэн Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу КЗҮЗ нь компанийн засаглалын үнэлгээ хийн, үнэлгээний түвшинг дараах байдлаар тогтоодог.

Хүснэгт 4.3 Засаглалын үнэлгээний түвшин

оноо	Үнэлгээ
75 оноогоос дээш	Сайн засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн.
50-74 оноо	Дунд засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй.
25-49 оноо	Хангалтгүй засаглалтай буюу компанид хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн.
24 оноогоос доош	Муу засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай.

Эх сурвалж Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл

Түүнчлэн Компанийн засаглалын сургалт явуулах зөвшөөрөл бүхий байгууллагуудтай хамтран (сургалт, семинар гэх мэт) үйл ажиллагаа явуулдаг. Аж үйлдвэрийн салбарын төлөөлөл болох МҮХАЖТ тэй хамтран төрөл бүрийн сургалт зохион явуулдаг.

2013 оноос компанийн нийгмийн хариуцлагыг дэмжих үүднээс уул уурхайн болон гадны компаниудыг хамруулан Statutory Report гаргаж байгаа хэдий ч энэ нь албан шахалт бус сайн дурын үндсэн дээр явагддаг, мөн зардал шаардагдах тул цөөн хэдэн аж ахуйн нэгж хамрагдсан. Түүнчлэн төрийн өмчит компаниудын хувьд засаглалын талаар ойлголт, хэрэгжилтийн талаар нэлээдгүй зөвлөн, туслалцаа үзүүлж ирсэн хэдий ч Засгийн газар солигдох тоолонд захирал болон удирдах ажилтан солигдох тул байгууллагад тогтсон систем болж нэвтэрч чаддаггүй байна.

Засаглалыг хөгжүүлэхтэй холбогдсон мэдээлэл түгээх, сурталчлах үйл ажиллагааны хувьд 2 жилд 1 удаа компанийн засаглалын нэгдсэн тайлан болох “Good Governance” сэтгүүлийг хэвлэн гаргадаг. Мөн өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэл цацахаас гадна бусад хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан сурталчилгаа байна хийдэг.

(2) Хувийн хэвшлийн үйл ажиллагаа, холбогдох байгууллага

Монгол улсад компанийн засаглалыг хөгжүүлэх, дэлгэрүүлэх үйл ажиллагаа, сургалт, семинар зохион байгуулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нийт 11 байна. Тухайлбал, 1) МУИС, Бизнесийн сургууль, Бизнес консалтинг төв, 2) Банк санхүүгийн академи, 3) Де Юре Партнерс, 4) Компанийн засаглалын хөгжлийн төв, 5) Монголын ажил олгогч эздийн холбоо, 6) Монголын дотоод аудиторуудын институт, 7) Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, 8) Компанийн засаглалын институт, 9) Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, 10) Монголын үнэт цаас эрхлэгчдийн холбоо, 11) Удирдлагын академийн дэргэдэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн холбоо болно.

Дээрх байгууллагуудын үйл ажиллагааны талаар товч дурдъя.

Хүснэгт 4.4 Компанийн засаглалын сургалтын байгууллагууд

Сургалтын байгууллага	Үйл ажиллагаа
КЗҮЗ	4.2 (1) 4) дэлгэрэнгүй дурдсан
МУИС, Бизнесийн сургууль	МУИС, Бизнесийн сургуулийн Бизнес консалтинг төв дээр компанийн засаглалын сургалтыг явуулдаг. Тус сургуулийн бизнес удирдлага, санхүү бүртгэл, хуулийн салбарын мэргэжлийн багш, профессоруудын нэгдсэн сургалтын хөтөлбөртэй.
Банк санхүүгийн академи	2011 онд Монголбанкны дэргэдэх сургалтын төв болон Санхүүгийн академи (ХК) нэгдэн байгуулсан. Санхүүгийн салбарын хүний нөөц бэлдэх, мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд Монголын Банкны Холбоотой хамтран үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны 10 сараас ТББ болсон.
Де Юре Партнерс	Хуулийн зөвлөгөө, хууль эрх зүйн чиглэлийн сургалт явуулдаг ХХК. 2012 оны 9 сард байгуулагдсан.
Компанийн засаглалын хөгжлийн төв	2009 оны 4 сард Санхүүгийн Зохицуулах Хороо болон Санхүү Эдийн Засгийн Сургуулийн санаачлагаар байгуулагдсан. Компанийн засаглалын анхдагч байгууллага.
Монголын ажил олгогч эздийн холбоо	1990 онд байгуулагдсан. Ажил олгогчдыг хамгаалах, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих зорилготой ТББ. 21 аймагт салбар, 61 суманд төлөөлөлтэй. 41 мэргэжлийн холбоо зэрэг 8100 гишүүнтэй.
Монголын дотоод аудиторуудын институт	2002 онд байгуулагдсан. СРВ, мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн ажилтан (САТ), мэргэшсэн дотоод аудитор (СИА), мэргэшсэн дотоод хяналтын аудитор (СІСА), мэргэшсэн удирдлагын нягтлан бодогч (СМА), СGA, ССFO, ССЕО эрх олгох сургалт явуулдаг. Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгал, Сангийн яам, Мэргэжлийн холбоотой хамтарсан сургалт зохион явуулдаг.
Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн 4,000 мэргэшсэн нягтлан бодогч (СРА), 130 аудитын компани гишүүнтэй. Нийт 25 салбартай.
Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	1960 онд байгуулагдсан. Нийт 3226 гишүүд компанитай, үүний 70% нь ЖДҮ. Гишүүдийн 3-ны 1 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг. 31 бизнесийн зөвлөл, 21 салбар, гадаадад 60 гаруй төлөөлөгч, өргөмжит төлөөлөгчидтэй.
Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо	1995 онд анх байгуулагдсан. 47 гишүүн байгууллагаатай. Үнэт цаасны зах зээл дээрх мэргэжлийн оролцогчдын байр суурийг бататгах, шийдвэр гаргалтад мэргэжлийн оролцоог хангах тал дээр анхааран ажилладаг.
Удирдлагын академын дэргэдэх ТУЗ-ийн хараат бус гишүүдийн холбоо	1924 онд байгуулагдсан МАХНын хүний нөөц бэлдэх Намын төв сургууль 1994 онд Удирдлагын академи болсон. 1994 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, 1999 онд Удирдлагын академи болсон. Төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийтийн албан хаагчдыг сургах, давтан сургах, судалгаа шинжилгээ хийх үүрэг бүхий байгууллага. Удирдлагын академын дэргэдэх ТУЗ-ийн хараат бус гишүүдийн холбоо нь компанийн засаглалын сургалтыг зохион явуулдаг.

Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг

1) Компанийн засаглалын хөгжлийн төв

Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ нь 2009 оны 4 сард Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Санхүү эдийн засгийн дээд сургуулийн санаачлагаар байгуулагдсан. Монголын компанийн засаглалын хөгжлийн манлайлагчдын нэг болохын хувьд мэргэжлийн сургалт, судалгаа, үнэлгээ, бодлогын зөвлөмж өгөх зэрэг үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг бөгөөд компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын нэг билээ.

Компанийн засаглалын хөгжлийн төвийн гишүүдэд Монголын хөрөнгийн биржээс гадна арилжааны томоохон банк, даатгалын компани, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байдаг. Компанийн засаглалын хөгжлийн төв нь аж ахуйн нэгжид зориулсан төрөл бүрийн сургалт, судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээ явуулахаас гадна жил бүр Компанийн засаглалын форум зохион явуулдаг.

- 2011 оноос жил бүр дараах сэдвүүдээр зохион явуулсан байна.
- 2011 он- Компанийн засаглал, хөрөнгийн зах зээл
- 2012 он - Хувийн компанийн засаглал
- 2013 он- Санхүүгийн байгууллагын засаглал
- 2014 он- Зохицуулалттай байгууллагын засаглал
- 2015 он- Тайлагнал ба ил тод байдал
- 2016 он- Компанийн засаглалын үр нөлөө Төр, иргэний нийгмийн байгууллагууд, компаниудын үүрэг
- 2018 он-Тогтвортой компаниудыг бий болгоход хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагуудад тулгарч буй сорилт

2013 онд Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), СЗХ-той хамтран хөрөнгийн биржид бүртгэлтэй Топ 10 компанийн засаглалын үнэлгээг хийсэн. ОУСК-ы гарын авлагад тулгуурлан Монголын компанийн засаглалын үнэлгээг анх удаа явуулсан. Түүнчлэн дараагийн хэсэгт (4.4(1) 3) дурдсанчлан ОУСК-ийн гэр бүлийн компанийн засаглалын гарын авлагыг Монгол хэл дээр орчуулан гаргасан.

ОУСК-тай 2015 оноос компанийн засаглалын ойлголтыг нэмэгдүүлж, компанийн засаглалын

холбогдох тогтолцоог сайжруулж компаниудад тусгайлан зөвлөгөө өгөх зэрэг дээр хамтран ажиллаж, 2017 оны 4 сард компанийн засаглалыг хөгжүүлэх зорилгоор компанийн нарийн бичгийн дарга нарын клуб байгуулсан.

Компанийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд ОУСК, СЗХтай хамтран шинэчилэгдсэн Компанийн тухай хуулийг сурталчлах сургалт, семинар, хэлэлцүүлэг, форумыг зохион байгуулж ирсэн.

2) Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 1995 онд байгуулагдсан. Нийт 47 гишүүн байгууллагатай. Үнэт цаасны зах зээл дэхь мэргэжлийн оролцогчдын байр суурийг бататгах, нөлөөллийг өсгөх, үнэт цаасны зах зээлтэй холбоотой аливаа шийдвэр гаргалтад мэргэжлийн оролцоог хангах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн олон нийтэд хандан үнэт цаас эрхлэгчдийн дуу хоолойг хүргэсээр ирсэн. Гишүүдийн чадавхийг дээшлүүлэх, холбогдох хууль эрх зүйн бичиг баримтад санал, дүгнэлтээ хүргүүлэн, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахаар тал дээр ажилладаг.

Үнэт цаасны арилжааны мэргэшлийн эрх олгох, хөрөнгийн зах зээлийн боловсрол олгох сургалт зохион байгуулахаас гадна компанийн засаглалын сургалтыг зохион байгуулдаг. 2015 онд компанийн засаглалын сургалтыг 1 удаа зохион байгуулж, 15 хүн хамрагдсан, 2016 онд 1 удаа, 18 хүн, 2017 онд 5 удаа зохион байгуулж, нийт 75 хүн хамрагдсан байна.

3) Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн 4,000 мэргэшсэн нягтлан бодогч (CPA), 130 аудитын компани гишүүнтэй, нийт 25 салбартай. Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, аудитын байгууллагын бүртгэл хөтөлж, бүртгэгдсэн тухай үнэмлэх буюу гэрчилгээ олгох, шинээр аудитын тусгай зөвшөөрөл хүсэгчдэд үнэлгээ гаргах, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулдаг. ЖДҮ-ийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн шинэчлэлээр олон улсын санхүүгийн бүртгэлийн стандарт (IFRS for SMEs) нэвтрүүлэхтэй холбогдон Монгол хэл рүү хөрвүүлэхээс гадна Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газартай хамтран ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн сургалтын хөтөлбөрт компанийн засаглал, эрсдэл, бизнесийн ёс зүйн асуудал орсон байдаг. Мэргэшсэн нягтлан бодогчдоор дамжуулан тэдний харилцагч нарт компанийн засаглалын

талаар таниулах зорилготой.

(3) Олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа

1) Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)

ОУВС нь 2009 оноос эхлэн Монгол улсад компанийн засаглал хөгжүүлэх асуудал дээр идэвхитэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж ирсэн. Өнөөг хүртэл Хаан банк, Хас банк, Голомт банк, Капитал банк, Макс группээс гадна Эрдэнэс Монгол төрийн өмчит компанид засаглалын зөвлөгөө өгөх төсөл хэрэгжүүлсэн. 2014 онд СЗХ компанийн засаглалын кодекс боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн 2013 онд КЗХТ-тэй хамтран Топ 20 хувьцаат компанийн засаглалын үнэлгээ (хүснэгт 4.5) хийсэн.

Хүснэгт 4.5 Компанийн засаглалын үнэлгээ

№	Үзүүлэлт	тоо
A	Хувьцаа эзэмшигчдийн эрх	22
B	Хувьцаа эзэмшигчдийн эрх тэгш байдал	19
C	Оролцогчдын үүрэг хариуцлага	14
D	Мэдээллийн ил тод байдал, тайлагнал	32
E	ТУЗ-ын хариуцлага	36

Эх сурвалж : Компанийн Засаглалын Хөгжлийн Төв

Түүнчлэн ОУСК-ийн дэмжлэгтэй байгуулагдсан КЗХТ 2009 оноос зохион байгуулж ирсэн Компанийн Засаглалын Форумг дэмжин ажиллахаас гадна, шилдэг жилийн тайлан шалгаруулах үндэсний уралдаан (ARAM) зохион байгуулж, компаний тайлагналыг сайжруулах асуудлыг дэмждэг. Мөн компанийн засаглалтай холбоотой хэд хэдэн судалгааны тайлан, гарын авлагыг Монгол хэл дээр хэвлэн гаргасан байна.

2) Америкийн олон улсын хөгжлийн агентлаг

Америкийн олон улсын хөгжлийн агентлагаас эдийн засгийн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд Сангийн яам болон тухайн үеийн Төрийн өмчийн хороотой (одоогийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар) хамтран 2011 онд төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах зорилгоор төрийн өмчит компаниудын ТУЗ хандсан засаглалын сургалт явуулсан. Мөн 2013 онд Бизнесийг дэмжих санаачлага төслөөр засаглалын өөрийн үнэлгээний хуудсыг боловсруулсан. Энэ нь компанийн засаглалын холбогдох хууль, журмын хэрэгжилт, олон улсын шилдэг туршлагаас нэвтрүүлэх гарын авлага болон ашиглагдаж ирсэн.

3) Азийн Хөгжлийн Банк (АХБ)

Азийн Хөгжлийн Банк нь КЗХТ тэй хамтран 2013 онд банк, санхүүгийн салбарын засаглалыг сайжруулах, оролцогч талуудын оролцоог хангах зорилгоор Монголбанк болон арилжааны банкуудыг хамруулсан засаглалын сургалтыг зохион байгуулсан. Нийт Монголбанкнаас 52, арилжааны банкуудаас 20 ажилтан уг сургалтад хамрагдсан байна.

4) Европын сэргэн босголтын хөгжлийн банк

Азийн Хөгжлийн Банк нь КЗХТ-тэй хамтран 2013 онд банк, санхүүгийн салбарын засаглалыг сайжруулах, оролцогч талуудын оролцоог хангах зорилгоор Монголбанк болон арилжааны банкуудыг хамруулсан засаглалын сургалтыг зохион байгуулсан. Нийт Монголбанкнаас 52, арилжааны банкуудаас 20 ажилтан уг сургалтад хамрагдсан байна.

ЕСБХБ-ны Монгол улсад үзүүлэх дэмжлэгт компанийн засаглалыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, ЖДҮ-ийг дэмжих асуудал орсон байна. ЖДҮ-ийн дэмжлэг нь бизнесийн орчинг сайжруулах, ЖДҮ-ийг дэмжих байгууллагуудыг хөгжүүлэх, бизнес шинээр эхлэгчдэд зөвлөмж өгөх гэсэн 3 үндсэн тулгууртай. ЖДҮ-ийг дэмжих байгууллагад Монголын менежментийн зөвлөхийн нийгэмлэг, Банк санхүүгийн академи, Монголын уул уурхайн холбоо, МҮХАҮТ, Санхүү эдийн засгийн дээд сургууль зэрэг орно.

Өнөөг хүртэлх ЖДҮ-ийг дэмжих төсөл нь 600-аад ЖДҮ хандан компанийн засаглал болон менежментийн зөвлөх үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулсан.

(4) Компанийн засаглалын тулгамдаж буй асуудал

Монгол улсад Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр, Компанийн засаглалын кодекс зэрэг голчлон хувьцаат компани, төрийн өмчит компанид хандсан засаглалын холбогдох хууль эрх зүйн орчин хангалттай бүрдсэн гэж хэлж болно. Мөн Компанийн засаглалын Үндэсний Зөвлөл, Компанийн засаглалын хөгжлийн төв зэрэг ТББ, ОУСК болон ЕСБХБ зэрэг олон улсын байгууллагууд компанийн засаглалыг нэвтрүүлэх тал дээр идэвхтэй ажиллаж байна.

Гэхдээ ЕСБХБ-ны судалгаагаар тодорхой болсончлон хувьцаат компаниуд тэр дундаа топ 10 компанийн түвшинд засаглалын түвшин хангалтгүй байгаа нь харэгдсан. Үнэт цаасны зах зээлийн холбогдох хүмүүсээс авсан ярилцлагаас хувьцаат компаниуд дотор компанийн засаглалтай холбогдох хууль журмыг мөрдсөнөөс ХХК болсон нь дээр гэж үздэг захирлууд

байдаг нь компанийн засаглал жинхэнэ утгаараа нэвтрэхэд цаг хугацаа шаардлагатай байж магад.

Компанийн засаглал нь хууль журам гэдэг талаас нь хүчээр дагаж мөрдөх гэхээс илүү компани талаас ашиг хэрэгцээ, шаардлагыг нь сайтар ойлгож өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь илүү үр дүнтэй. Үнэлгээний хувьд сайн дурын үндсэн дээр хэрэгждэг, ямар нэгэн зөрчил маргаан үүссэн тохиолдолд компани хүсэлт гаргадаг төдийхөн байна. Компанийн засаглал сайжирснаар менежмент тогтвортой болох зэрэг компанийн дотор гарах эерэг нөлөөнөөс гадна компанийн үнэ цэнэ өссөнөөр бусад компаниудтай хамтран ажиллах, шинэлэх технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, шинэ борлуулалтын суваг нэмэгдэх зэрэг бизнесийн боломж өргөжих зэрэгт үр дүнтэй гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй.

Төрийн өмчит компаниудын тухайд төлөөлөн удирдах зөвлөлийг Засгийн газраас томилох тохиолдол их байдаг, энэ утгаараа бусад компаниас илүү компанийн засаглалыг идэвхи зүтгэлтэй нэвтрүүлэх шаардлагатай. Ашиг сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн ТУЗ-аар сонгогдох механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Гэхдээ компанийн тухай хуулиар төрийн өмчит компанийн удирдлага засаглалын сургалтад заавал хамрагдах хэрэгтэй байдаг ч халаа, сэлгээ ихтэй тул үй ажиллагаа нь тогтворжиж чаддаггүй нөхцөлтэй байна.

Нөгөөтэйгүүр ЖДҮ-ийн хувьд бусад улсын адил, хувьцаат компани болон төрийн өмчийн компани шиг хууль эрх зүйн хариуцлага хүлээдэггүй. Мөн засаглалын үнэлгээ хийлгэх үүрэг хүлээдэггүй, сайн дурын үндсэн дээр үнэлгээ хийлгэж болно гэж заагдсан байгаа тул үнэлгээ хийлгэх компани бараг байдаггүй. 4.3 хэсэгт дурдсанчлан компанийн засаглалын хэрэгцээ, шаардлагын талаар ойлголт дэлгэрсэн хэдий ч хэрэгжүүлэхэд хөрөнгө хүч шаардагдах хирнээ давуу тал багатай, бизнесийн хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад бүхий л хүчээ дайчлан ажилладаг ЖДҮ-ийн хувьд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тооцогддоггүй. Иймд төрөөс ЖДҮ-т чиглэсэн дэмжлэг, бодлого, хөтөлбөрт компанийн засаглалыг дэмжих тодорхой дэмжлэгийг оруулах шаардлагатай. Тухайлбал, арилжааны банк болон санхүүгийн байгууллагуудын зээлийн хүүг бууруулах, татварын хөнгөлөлт тогтоох зэргийг компанийн засаглалын үнэлгээтэй уялдуулах зэрэг байж болно. Мөн хөрөнгийн үүсвэрээс гадна экспортын болон хөрөнгө оруулах, хамтран ажиллах, харилцагч болох магадлалтай томоохон компани, гадаадын компаниудтай харилцахад ЖДҮ-ийн хувьд тодорхой урамшууллыг авч хэлэлцэх нь компанийн засаглалыг дэлгэрүүлэхэд үр дүнтэй гэж хэлж болно.

4.3 ЖДҮ, бичил бизнесийн компанийн засаглалын бодит байдал, асуудал (асуулга судалгаа)

(1) Судалгааны товч

Энэхүү судалгаа нь компанийн засаглалын бодит байдал, тулгамдаж буй асуудлыг тодруулахын тулд мэргэжлийн байгууллагаар захиалгат судалгаа хийлгэсэн. Судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, аж үйлдвэрийн төрөлжилтөд хувь нэмэр оруулах магадлал өндөртэй аж үйлдвэрийн салбарыг (уул уурхай, үл хөдлөх хөрөнгө, банк, санхүүгийн байгууллагыг оруулаагүй) хамруулсан. Судалгааг асуулга судалгааны аргаар үйл ажиллагааны салбар, аж ахуйн нэгжийн хэмжээ, хэлбэр, үйл ажиллагааны онцлог, бүтэц зэргийг харгалзан цахимаар авсан.

Судалгааг МҮХАҮТ-ийн гишүүн 3400 аж ахуйн нэгжээс (үүнээс Улаанбаатар хотын 1100) “Компанийн засаглалыг нэвтрүүлэх “, “ЖАЙКА зэрэг олон улсын байгууллагын ЖДҮ-ийн хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг авсан аж ахуйн нэгж “ гэсэн 2 талаас дараах аж ахуйн нэгжүүдийг оролцуулахаар төлөвлөж байсан.

Монголын хөрөнгийн биржийн 1, 2 ангиллын хувьцаат компани (ойр. 300 компани)

Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнес курс төгсөгч (ойр. 550 компани)

ЖАЙКА-ийн ЖДҮ-ийн хөгжил, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан компани (ойр. 700 компани)

МҮХАҮТ-ын гишүүн ЖДҮ гэх мэт (хувиараа бизнес эрхлэгч)

Гэхдээ судалгааны хугацаа богино, байгууллагын нууцын мэдээллийн асуудал зэргээс дээрх компаниудыг оролцуулах хүндрэлтэй байсан тул Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн сургалтад хамрагдсан аж ахуйн нэгжийг голчлон хамруулсан. Бизнесийн сургалт төгсөгчидийн ихэнх нь ЖДҮ байгаагаас гадна аж ахуйн нэгжийн удирдлагууд нь тогтвортой бизнесээ өргөтгөх хүсэл эрмэлзлэл дүүрэн байдаг нь судалгаанд хамруулахад зохистой хэмээн үзсэн.

Судалгааг 2018 оны 4 сарын 17-ноос 5 сарын 25-ны хооронд явуулан, нийт 554 аж ахуйн нэгжээс асуулгын хариултыг авсан. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдээс харахад хувьцаат компани 12, Япон Монголын хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн сургалт төгсөгч 180 компани, ЖАЙКА-ийн 2 шатлалтай хөнгөлөлттэй зээлд хамрагдсан компани 16 тус

тус байна.

(2) Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн товч

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны салбар тус бүрээр авч үзэхэд нийт аж үйлдвэрийн салбарын бүтэцтэй харьцуулахад зөрүү багатай байгаа нь харагдана. Тухайлбал, Монгол улсын ДНБ эзлэх аж үйлдвэрийн салбар тус бүрийн харьцаатай харьцуулахад үйлдвэрлэлийн салбар, барилгын салбар их хэмжээг эзэлж байгаа бөгөөд голлох салбар болох ХАА салбараас бага зэрэг цөөн тоотой байгаа нь Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд түлхүү хамрагдсантай холбоотой.

Аж ахуйн нэгжүүдийг ажиллагсадын тоогоор нь харьцуулж үзэхэд 20 оос доош хүнтэй жижиг компани 70 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 30 хувь нь ЖДҮ голдуу байна. ЖДҮ-ийн тухай хуулиар 19-ээс доош ажиллагсадтай аж ахуйн нэгжийг бичил, 20-оос дээш 49 доош ажиллагсадтайг жижиг, 50-аас дээш 1499-аас доош ажиллагсадтай дунд хэмжээний аж ахуйн нэгж гэж үзнэ. Монгол улсын хувьд 20-оос доош ажиллагсадтай бичил буюу жижиг аж ахуйн нэгж нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 90 хувийг эзэлдэг тул энэхүү бүтцээс харахад энэ удаагийн судалгаанд ЖДҮ-ийн эзлэх хувь өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь судалгаанд Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн сургалт төгсөгчид түлхүү хамрагдсантай холбоотой. Тиймээс судалгааны үр дүнг харсан ч компанийн засаглалыг нэвтрүүлэх нөөц бололцоотой хэсэг томоохон аж ахуйн нэгж, мөн бизнесээ өргөжүүлэх зорилготой ЖДҮ байгаагаас судалгааны зорилго болох компанийн засаглалыг хэрэгжүүлэх ирээдүйтэй аж ахуйн нэгжүүдийг хамруулж чадсан гэж хэлж болно.


Орон нутаг тус бүрээр нь харахад Улаанбаатар хотод бүртгэлтэй аж ахуйн нэгж 483 (87%), бусад аймаг орон нутагт бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж 70 (13%) байсан. Аж ахуйн нэгжүүдийн байгуулагдсан оноос харахад дунджаар 10-аас дээш жил бизнес эрхэлж буй аж ахуйн нэгж дийлэнх хувь нь байна.

(3) Компанийн засаглалын талаарх асуулгын дүнгээс

Тус судалгаагаар компанийн засаглалын бодит байдлыг тодруулахын тулд ЖДҮт компанийн засаглалтай холбогдох дотоод журам, ТУЗ, хувьцаа эзэмшигчид байгаа эсэх, гаднаас удирдах ажилтан томилдог эсэх, мэдээллийн ил тод байдал болон тайлагнал, шийдвэр гаргалтын процесс зэргийн талаар асууж тодруулсан.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс компанийн засаглалтай холбогдох дотоод журам,

дүрэм байдаг талаар асуултад нийт аж ахуйн нэгжийн 43% нь Тийм гэж хариулсан байна. Агуулгыг нь харахад хамгийн их байгаагаас 1) Компанийн засаглалын үндсэн зарчим боловсруулсан, 2) компанийн засаглалын бүтэц боловсруулсан, 3) үйл ажиллагааны чиг хандлага, бизнесийн ёс зүйн дүрэмтэй, 4) дотоод болон хөндлөнгийн аудит хийгддэг, 5) ТУЗ тай гэж хариулсан байна (Зураг 4.3.1)



Эх сурвалж Асуулга судалгааны дүнгээс судалгааны баг

Зураг 4.2 Компанийн засаглалын холбогдох дүрэм, журамтай аж ахуйн нэгж

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 25% нь ТУЗ тай бөгөөд ажиллагсадын тоо 50аас дээш аж ахуйн нэгжийн хувьд 51% нь байна. Эдгээрээс ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийг харахад гэр бүлийн бус гишүүн ТУЗ-д орсон байгаа нь 58%, гэр бүлийн бус гишүүн хувьцаа эзэмшдэг 60% байгаа нь харагдсан. Түүнчлэн шийдвэр гаргах болон хэрэгжүүлэгч функц тусдаа байдаг аж ахуйн нэгж нийт аж ахуйн нэгжүүдийн 6% байна.

Аж ахуйн нэгжийн мэдээллийн ил тод байдал дээр цахим хуудас болон цахим сүлжээгээр мэдээллээ цацдаг аж ахуйн нэгж 3ны 1 төдий байсан бөгөөд мэдээллээ ил болгох тал дээр идэвхигүй байдаг нь харагдсан. Ил тод болгосон мэдээллийн агуулгыг авч үзэхэд хөрөнгө


оруулалттай холбогдох мэдээлэл тавьсан аж ахуйн нэгж 47 буюу 10%-д хүрэхгүй хэмжээнд байна. Мөн компанийн засаглалын үнэлгээний тайлангаа цахим хуудсандаа тавьсан нь 1 хувьцаат компани, гадаадын компанитай худалдаа хийдэг 2 аж ахуйн нэгж байсан. Түүнчлэн ерөнхийдөө нь олон нийтэд ил тод дэлгэгдсэн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд итгэх үү гэсэн асуултад нийт судалгаанд хамрагсдын 3 ны 1 (62%) нь Үгүй гэж хариулсан байна. Давхар тайлан гаргадаг аж ахуйн нэгж их байдагтай холбоотойгоос гадна мэдээллээ ил тод болгосны давуу тал төдийлөн харагдахгүй байгаагаас мэдээллийн ил тод байдалд хандах хандлага сул байна гэж үзэж байна.

(4) Аж ахуйн нэгжийн санхүүтэй холбогдох асуудал

Аж ахуйн нэгжийн санхүүтэй холбогдох асуудлыг засаглал талаас нь тайлагнал буюу санхүүгийн тайлан бүртгэл, холбогдох яам тамгын газарт цаг тухайд нь мэдүүлдэг эсэх, хөрөнгийн эх үүсвэр, зээлийн процесс, зээлийн мэдээлэлтэй холбогдох асуултаар тодруулсан. Хөрөнгийн эх үүсвэр хязгаарлагдмал үед арилжааны банк болон санхүүгийн байгууллагаас авах зээлийн нөхцөл, зээлийн шалгуурт аж ахуйн нэгжид дарамт болдог асуудлын талаар асууж тодруулсан.

Санхүүгийн тайлангийн хувьд жилийн эцсийн тайланг холбогдох яам, тамгын газарт (Татварын ерөнхий газар, Сангийн яам аль алинд нь өгдөг 58%, Татварын ерөнхий газарт өгдөг 41%) өгдөг нь тодорхой болсон. Зээлийн тухайд хамгийн хүндрэлтэй гэсэн асуудлуудаас 40%аас дээш хариулт авсан нь зээлийн хүү өндөр 445 компани (80%), барьцаа хөрөнгөний үнэлгээ доогуур 367 (66%), бүрдүүлэх материал олон 294 компани (53%), эргэн төлөх хугацаа богино 238 компани (43%) зэрэг байна (Зураг 4.3.2). Зээл авсан байгууллага нь арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага 60-аас дээш хувийг эзэлж байгаа бөгөөд хувь хүнээс зээл авсан нь 10%, зээл авч үзээгүй нь 30% байна.

Аж ахуйн нэгжийн хэмжээгээр авч үзэхэд 50аас дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн 57% нь, ажиллагсадын тоо нь 20 49 бүхий жижиг аж ахуйн нэгжийн 36%, ажиллагсадын тоо 1 19 бүхий аж ахуйн нэгжийн 20% нь арилжааны банкнаас зээл авсан байна. Эдгээрээс гадна зээл авч үзээгүй гэж хариулт өгсөн аж ахуйн нэгжийн талаас илүү хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь банкны зээлийн хүү өндөр, эргэн төлөх хугацаа богино, зээлийн шалгуурт тэнцдэггүй зэрэг шалтгаан байна.



Эх сурвалж Асуулга судалгааны дүнгээс судалгааны баг

Зураг 4.3 Банкнаас зээл авахад тулгарсан дарамт


(5) Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн засаглалын үнэлгээ

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн дийлэнхи нь ЖДҮ байсан тул ОУСК-аас боловсруулсан ЖДҮ-ийн компанийн засаглалын үе шатны матрицыг ашиглан дараах байдлаар анализ хийв.

1) Сайн засаглалын үүрэг хариуцлага

Компанийн үндсэн хэсэг болох санхүү, удирдлага, хуулийн хэлтэс байгаа эсэх, түүнчлэн бизнес төлөвлөгөө, компанийн стратеги төлөвлөлт, үндсэн чиг хандлага хир хэмжээнд байгааг тооцоно. Мөн компанийн үүсгэн байгуулагчийн засаглалын талаарх ойлголт, ажиллагсад болон оролцогч талуудад энэ тухай хуваалцсан эсэх хамаарна.

Судалгаанд хамрагдсан компанийн 43% нь компанийн засаглалтай холбогдох дүрэм, журамтай байгаа бөгөөд компанийн хэмжээ тус бүрээр харахад 1 19 ажиллагсадтай компанийн 33%, 20 49 ажиллагсадтай компанийн 60%, 50 дээш ажиллагсадтай компанийн 69% нь байна.



Эх сурвалж: Асуулга судалгааны дүнгээс

Зураг 4.4 Компанийн засаглалын журам, дүрэмтэй компаниуд (хэмжээ тус бүрээр)

Судалгаанд нийт 12 хувьцаат компани хамрагдсаны 10 компани нь засаглалын холбогдох дүрэм, журам боловсруулсан байна. Мөн ЖДҮ-ийн хувьд ямар нэгэн байдлаар засаглалын арга хэмжээ авч байгаа нь тодорхой болсон. Ярилцлага судалгааны үед ч 19-оос доош ажиллагсадтай жижиг аж ахуйн нэгж Enterprise Resource Planning (ERP) систем нэвтрүүлэн хэрэглэгчдээс захиалга авах шатнаас эхлээд үйлдвэрлэлийн нийт шат дамжлага, бараа бүтээгдэхүүний үлдэгдэл, санхүүгийн хяналтыг нэг дор хянаж байна. Түүнчлэн ажилтны гарын авлага, хэрэглэгчтэй харьцах удирдамж зэргийг боловсруулан, хэрэглэгчдээс ирсэн санал гомдлыг ажилчдын хурал дээр хэлэлцдэг аж ахуйн нэгж байсан. Мөн ажилчдаа дотоод болон гадаад руу мэргэжлийн сургалтад хамруулах зэргээр оролцогч талуудын идэвхийг дээшлүүлэн хариуцлагатай ажилладаг аж ахуйн нэгж цөөнгүй байна.

Эдгээрээс харахад аж ахуйн нэгжийн удирдлагын хүсэл эрмэлзлэл, ойлголт ухамсраас шалтгаалах зүйл их байгаа тул ЖДҮ-ийн засаглалын талаарх ойлголт хангалтгүй гэж хэлж болохгүй. Иймд компанийн засаглалын талаарх ойлголт, ухамсрыг дээшлүүлэх, сурталчилгаанд үйл ажиллагааг ЖДҮ-дэд чиглүүлэх шаардлагатай байна.

2) Шийдвэр гаргалт, стратеги төлөвлөлт боловсруулах

Компанийн стратеги төлөвлөлт боловсруулах, санхүү, хүний нөөцийн холбогдох шийдвэр гаргалт үүсгэн байгуулагчийн шийдвэрээр явдаг уу, албан бус гадны зөвлөхийн саналыг тусгаж байна уу, эсвэл удирдах ажилтны хурал, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэгддэг үү, гаднаас ТУЗ хөлсөлдөг эсэхийг авч үзнэ.

ТУЗ-тай компаний нийт судалгаанд хамрагсадын 24%, ТУЗ ийн сонгон шалгаруулалт, цалин урамшууллын дотоод журам боловсруулсан нь 17%, мөн гаднаас авч ажиллуулдаг компани 10% байна. Компанийн засаглалын хэрэгжилтийн үйл ажиллагааны чиг хандлага, ёс зүйн журам боловсруулсан компани 42% , хувьцаа эзэмшигч дотор гэр бүлийн гишүүд байдаг компани 40% зэргээр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 86% нь гэр бүлийн компани байсан. Иймд шийдвэрийг үүсгэн байгуулагч юмуу ерөнхий захирал гаргадаг нь нийтлэг байсан. Гэр бүлийн компани дийлэнхийг эзэлж тул залгамж халааны талаарх асуудал хөндөгдөх ёстой хэдий ч залгамж халааны талаар арга хэмжээ авсан аж ахуйн нэгж ердөө 17% байна. Ярилцлага судалгаанд явцад ч гадны хөрөнгө оруулалт, харилцагч сонгох асуудал дээр хэлэлцэгдсэн зүйлүүд шийдвэр гаргагчийн нэг үгээр өөрчлөгддөг гэх асуудал олонтаа байсан нь тодорхой болсон.

3) Дотоод хяналт

Дотоод хяналтын хувьд санхүү, нягтлан бодогч тусад нь хөлсөлсөн эсэх, аудит хийдэг эсэх, төсвийн хяналт, санхүүгийн тайлан, татвар төлөлтийн байдал, хүний нөөц, мэдээлэл технологи зэрэг хэлтэс байгаа эсэх, тайлагнах систем, холбогдох гарын авлага, эрсдлийн үнэлгээний менежмент хир зэрэг байгаа талаар авч үзнэ.

Санхүүгийн тайлан, татвар төлөлтийн хувьд Татварын Ерөнхий газар болон Сангийн яам аль алинд нь цаг тухайд нь тайлангаа өгдөг нь 58% , зөвхөн Татварын Ерөнхий газарт тайлангаа өгдөг нь 37%, захиргааны байгууллагаас шаардлага ирсэн тохиолдолд өгдөг нь 4%, цагтаа амждаггүй, тайлан өгдөггүй гэж хариулсан нь 1% байна. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан хөлсөлдөг нь 65%, гэрээгээр хөлсөлдөг нь 30%, мэргэжлийн компани хөлсөлдөг 5% байсан.

ЖДҮ-ийн тухайд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар олон улсын стандарт IFRS for SMEs нэвтрүүлэх ажил хуульчлагдсан хэдий ч холбогдох гарын авлага, удирдамж байхгүй, мөн

нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн софт программ байхгүй зэргээс шалтгаалан санхүүгийн тайлан боловсруулах ажил хүндрэлтэй байдаг. Үүнээс гадна давхар тайлан гаргадаг аж ахуйн нэгж олон, олон нийтэд ил болгосон санхүүгийн тайлангийн итгэл үнэмшил муу байдаг зэрэг асуудал тодорхой болсон.

Хүснэгт 4.6 Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хяналт

	2-8) Does your company have full time accountant?	2-9) If answered "No", Does your company have a Contract Accountant?	2-18) Do you think that Mongolian companies report their financial statements in a different ways?	2-20) Can you trust publicly available financial statements of Mongolian companies?				
Total	Yes	374 68%	Contract Accountant	152 27%	Yes	254 46%	Yes	213 39%
	No	179 32%	Full time Accountant	9 2%	299 54%	No	340 61%	
			Other (Exe. director etc.)	18 3%				
1 - 19	Yes	211 55%	Contract Accountant	146 38%	Yes	173 45%	Yes	141 37%
			Full time Accountant	8 2%				
			Other (Exe. director etc.)	18 5%				
2 - 49	Yes	64 91%	Contract Accountant	5 7%	Yes	33 47%	Yes	25 36%
			Full time Accountant	1 1%				
			Other (Exe. director etc.)	18 5%				
More than 50	Yes	99 99%	Contract Accountant	1 1%	Yes	48 48%	Yes	47 47%
			Full time Accountant	0 0%				
			Other (Exe. director etc.)	18 5%				

Эх сурвалж Асуулга судалгааны дүнгээс

4) Мэдээллийн ил тод байдал, тайлагнал

Давхар тайлан гаргадаг эсэх, ТУЗ-д тайлагнадаг эсэх, гадны аудит, олон улсын санхүүгийн стандарт IFRS нэвтрүүлсэн эсэх, компанийн танилцуулга байгаа эсэх, цахим хуудсаар мэдээлэл түгээдэг байдал зэргээр тодорхойлно.

Цахим хуудастай эсэх тал дээр мэдээллээ ил тод болгодог аж ахуйн нэгж 33% (180 аж ахуйн нэгж), үүн дотроо хөрөнгө оруулагч нарт зориулсан мэдээлэл гаргадаг 47 аж ахуйн нэгж, хувьцаа эзэмшигчдэд зориулсан мэдээлэл гаргадаг 20 аж ахуйн нэгж, компанийн засаглалын чиг хандлагаа ил тод болгосон 10 аж ахуйн нэгж, засаглалын тайлангаа ил тод болгосон 6 аж ахуйн нэгж байсан байна. Хөрөнгө оруулалт татах зорилгоор үйл ажиллагааны танилцуулга, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулагч нарт зориулсан арга хэмжээ зэрэг мэдээлэл гаргасан аж ахуйн нэгж 27 байна.

Санхүүгийн тайлагналын хувьд Татвар болон Сангийн яам аль алинд нь цаг тухайд нь тайлангаа хүргүүлдэг, эсвэл Татварт тайлангаа өгдөг хэдий ч тайлангаа цахим хуудсандаа ил тод мэдээлдэг аж ахуйн нэгж 20, өөрийн гаргасан болон гадны нягтлан бодох бүртгэлийн компаниар гаргуулсан санхүүгийн тайлангаа ил тод болгосон аж ахуйн нэгж 9 байна.

Хүснэгт 4.7 Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийн ил тод байдал

2-12) If answered "Yes" for the question No 11, what kind of information is provided? (Multiple answers possible)	Financial statement		Financial statement reports done by the company's internal or professional accounting firms		Current activity reports for investors and shareholders		Company introduction and business plan for investors who are planning to invest		Action plan for investors (company and introduction meeting, investment meeting, etc.)		Dividends and compensations paid to investors and shareholders		Directions of corporate governance		Corporate governance reports		Information to other investors	
	Count	%	Count	%	Count	%	Count	%	Count	%	Count	%	Count	%	Count	%	Count	%
Total	20	4%	9	2%	20	4%	16	3%	11	2%	12	2%	10	2%	6	1%	11	2%
1-19	3	1%	0	0%	3	1%	1	0%	0	0%	2	1%	2	1%	1	0%	6	2%
2-49	5	7%	3	4%	4	6%	2	3%	1	1%	2	3%	2	3%	0	0%	2	3%
More than 50	12	12%	6	6%	13	13%	13	13%	10	10%	8	8%	6	6%	5	5%	3	3%

Эх сурвалж Асуулга судалгааны дүнгээс

Үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналын тухайд судалгааны дүнгээс харагдаж байгаачлан хангалттай бус байна. Хөгжиж буй аль ч улсад ижил асуудал байгаа гэж хэлж болох ч өөрийн технологи, худалдааны ноу хау зэрэг мэдээллээ алдахгүйн үүднээс үйл ажиллагааныхаа талаар нарийн мэдээллээ гадагш гаргадаггүй аж ахуйн нэгж олон байгаа нь Монголын аж ахуйн нэгжүүдийн онцлог гэж хэлж болно. Ярилцлага хийсэн аж ахуйн нэгжүүд ч мөн адил мэдээллээ ил тод болгох тал дээр эрсдэлтэй гэж үздэг гэх санал олон байсан.

Нөгөөтэйгүүр бусад аж ахуйн нэгжийн ил тод болгосон санхүүгийн тайлангийн үнэн зөвд итгэдэггүй байдал нь мэдээллээ ил тод болгохоос дургүйцдэг хүчин зүйлийн нэг байж болно. Мэдээллээ ил тод болгон, үнэн зөв тайлагнаснаар гадны харилцагчтай болох хөрөнгө оруулалт татах зэрэг эерэг талыг нэмэгдүүлнэ гэдгийг ухамсарлах хэрэгтэй болов уу.

5) Үүсгэн байгуулагч/ гэр бүл

Үүсгэн байгуулагч болон бусад гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлага тодорхой байгаа эсэх, гэр бүлийн бус гишүүдтэй ажил үүргийн хуваарилалт тодорхой байгаа эсэх, хувьцаа эзэмшигчдийн хурал зэрэг асуудлыг тодруулсан.

Энэхүү судалгаанд хувьцаа эзэмшигч, ТУЗ-д үүсгэн байгуулагчийн гэр бүлийн гишүүн байдаг аж ахуйн нэгж 72%, ТУЗ-ийг дотроосоо сонгон шалгаруулдаг 15%, гаднаас сонгон шалгаруулдаг компани 7.8% байсан. Шийдвэр гаргах процесс дээр мөн адил үүрэг хариуцлагын хуваарилалт тодорхой бус эсвэл гэрээний заалт дээр тодорхой тусгагдаагүй зэргээс үүдэн гэр бүлийн бус гишүүдтэй зөрчил үүссэн тохиолдол олон байдаг байна.

б) Судалгааны дүгнэлт

Асуулга судалгааны хариулт болон ярилцлага судалгааны агуулгаас компанийн засаглалыг нэвтрүүлэхэд компани доторх систем хараахан бүрэлдэж чадаагүй байгаа нь харагдсан. Үүний учир шалтгаан нь засаглалын хэрэгцээ шаардлагын талаарх ойлголт, мэдээлэл, хүний нөөц дутагдал гэж үзэж байна. Компанийн үйл ажиллагаа явуулсан жил, хэмжээнээс үл хамааран удирдлагын ойлголт, хүсэл эрмэлзлэлээр засаглал хэрэгжүүлж байгаа ахуйн нэгж цөөнгүй байна. Гэхдээ олон жил үйл ажиллагаа явуулсан, ажиллагсадын тоо ихтэй аж ахуйн нэгжүүд ч үйл ажиллагааны тайлагнал, ил тод байдал хангалтгүй, давхар тайлан гаргадаг, гэр бүлийн бус гишүүд шийдвэр гаргалтад оролцож чаддаггүй байх зэрэг олон асуудал байна.

Нөгөөтэйгүүр харьцангуй шинэ аж ахуйн нэгж болон хүсэл эрмэлзлэл дүүрэн залуу бизнес эрхлэгчид хүч түрэн орж ирж буй Монголын бизнесийн орчинд зохих арга хэмжээ авч чадвал компанийн засаглал хөгжих боломжтой. Өөрөөр хэлбэл, компанийн засаглалын ойлголт хангалтгүй байгаа хэдий ч холбогдох сургалтын тогтолцоо сайн хөгжсөн тул ЖДҮ-дэд чиглэсэн мэдээлэл, оролцоог хангах ажлыг нэмэгдүүлснээр үр дүн гарах болно

Монголын бизнес эрхлэгч, компанийн захирал, удирдах ажилтнууд засаглалын хэрэгцээ, шаардлагыг талаар ойлгож байсан ч хэрэгжүүлэх тал дээр арга хэмжээ авч чадахгүй байгаа нь тодорхой харагдсан.

Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр хөрөнгө татах, гадны компанитай хамтын ажиллагаа тогтоох зэрэг үйл ажиллагаагаа өргөжүүлэх бодит боломж бий болох бол компанийн засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах хүсэл эрмэлзлэл байсан ч бодит байдал дээр тодорхой давуу талаас илүү өөрийн компанийн мэдээллийг ил тод болгосноор өрсөлдөх чадвараа алдах зэрэг сөрөг талтай, түүнчлэн бусдын ил тод мэдээллийн үнэн зөв байдалд итгэдэггүй тул хэрэгцээтэй гэж төдийлөн боддоггүй гэж хэлж болно.

Иймд компанийн засаглалын хэрэгцээ, шаардлагын талаар мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлж, бизнесийг дэмжих бодлого, хөтөлбөрт давуу талыг илүү тусгах шаардлагатай.

Компанийн засаглал хэрэгжүүлснээр менежмент сайжирч, зөв гольдролд орох асуудал тод харагддаг хэдий ч компанийн үнэ цэнэ өссөнөөр бусад арилжаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, шинэ бизнес болон бизнесээ өргөжүүлэх зэрэг эерэг нөлөө үзүүлж болохыг аж ахуйн нэгжүүдэд сайтар сурталчлах хэрэгтэй.

4.4 Компанийн засаглалын өөрийн үнэлгээ

Өөрийн үнэлгээний хэрэгсэл нь ААН-ийн удирдлагын зүгээс өөрийн компанийн засаглалын бодит байдлыг тодорхойлон давуу талаа улам бэхжүүлэн, сул талаа сайжруулан засаж заларуулснаар тухайн ААН-ийн суурь чадавхийг дээшлүүлэхэд шаардлагатай хэрэгсэл юм. Гэхдээ ЖДҮ-ийн хувьд өөрийн ААН-ийн үнэ цэнийг дээшлүүлэх зардлыг давуу тал гэж ойлгож хандах ойлголт сул, компанийн засаглалыг нэвтрүүлэх хөшүүрэг, сэдэл байдаггүй нь түгээмэл байдаг нь хувьцаат компаниас ялгаатай юм. Иймэрхүү тал дээр анхааран санхүүгийн байгууллага зэрэг гаднаас хөрөнгө оруулалт авах, түүнчлэн арилжааны боломжит түнш болж мэдэх томоохон ААН, гадаадын компанитай худалдаа хийх, үйл ажиллагаагаа хоршин явуулах, хамтарсан компани байгуулахдаа итгэл олох үүднээс өөрийн үнэлгээний хэрэгслийг компанийн засаглалыг нэвтрүүлэх эхний шат болгон ашиглан, үр дүнг нь банк санхүүгийн байгууллага болон боломжит түншүүдэд танилцуулах замаар байгууллагын итгэл хүлээх чадварыг дээшлүүлэх боломжтой.

Юуны өмнө (1)-д Монголоос бусад гадны орон, олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд ашиглагддаг компанийн засаглалын талаарх материалыг (гарын авлага, зааварчилгаа), (2)-т Гадны орнуудад ашиглагдаж буй өөрийн үнэлгээний хэрэгслийг авч үзэн, (3)-т Монгол дахь жишээ болгон томоохон компаниудад зориулагдсан боловч аль хэдийн нэвтрээд байгаа “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулгатай ” тоймлон танилцаж, дээр нь (4) асуулга судалгааны үр дүн, (5) Японы компаниудын судалгаанаас гаргаж ирсэн асуудлыг оруулан боловсруулсан (6) өөрийн үнэлгээний хэрэгслийн товч агуулга, энэхүү хэрэгслийг ашиглан явуулсан (7) семинар ба санал сэтгэгдлийн талаар танилцуулна.

(1) Компанийн засаглалын талаарх материал (Гадаадын болон ОУБ-ын жишээ

Компанийн засаглалын тухай гарын авлага, зааварчлагыг ОУБ, Засгийн газрын байгууллага,ТББ аас эрхлэн гаргадаг. Ер нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгодог, өмчлөл ба менежментийн үйл ажиллагаа нь хоорондоо заагтай, гадны хувьцаа эзэмшигч олонтой ААН-д зориулсан, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурал зэрэг шийдвэр гаргадаг байгууллагын үр нөлөөтэй үйл ажиллагаа, цөөн тооны хувьцаа эзэмшигчид зэрэг ашиг сонирхолын бүлгийн эрхийг хамгаалсан агуулгатай баримт бичиг түгээмэл байдаг хэдий ч хувиараа бизнес эрхлэгч болон ЖДҮ-т зориулсан компанийн засаглалын тухай материал ч цөөнгүй байдаг.

Энэ хэсэгт хувьцаат компаниудад зориулсан засаглалын жишээ болгон G20 ба ЭЗХАХБ (OECD)-ын компанийн засаглалын зарчим, Японы компанийн засаглалын кодексийг

танилцуулсны дараа гэр бүлийн компанид зориулсан ОУСК-ын (IFC) гэр бүлийн корпорацийн зааварчлага, түүнчлэн Хонконгийн захирлуудын холбооноос ЖДҮ-т зориулан гаргасан компаний засаглалын зааварчлагыг танилцуулна

1) G20/ ба ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчим

G 20 ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчим нь “ Улс орны онцлогоос шалтгаалан нэгдсэн нэг загвар байхгүй хэдий ч хэд хэдэн нийтлэг элемент байх бөгөөд тэдгээрийг цэгцлэх нь тухайн орны хууль эрх зүйн тогтолцоо болон компаниудын арга хэмжээг сайжруулахад тус нэмэр болно.”⁵⁵ гэж тэмдэглэснийг үндэслэн 1999 онд батлагдсан бөгөөд 2004 ба 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш өнөө хүртэл баримталж ирсэн юм. “Эдийн засгийн үр ашиг, тогтвортой өсөлт,санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих үүднээс бодлого боловсруулагчид компаний засаглалын талаарх хууль, журам болон тогтолцооны бүтцийг үнэлэн сайжруулахад нэмэр болох зорилго тавьж байгааг” онцлон дурдсан бөгөөд өмнөх үгэнд “дэлхийн нийтийн бодлого боловсруулагч, хөрөнгө оруулагч, ААН, бусад холбогдох талуудын хувьд баримтлах олон улсын стандарт юм” хэмээн дурьдсан байдаг.

Тэрчлэн энэхүү үндсэн зарчим нь “Банк санхүүгийн байгууллага ба санхүүгийн бус байгууллагыг багтаасан нээлттэй компанид гол анхаарлаа хандуулсан байна. Мөн нэвтрүүлэх боломжтой хүрээнд нээлттэй бус компаниудын засаглалыг сайжруулахад ч үр нөлөөтэй ашиглагдах магадлалтай. Үндсэн зарчимд жижиг компани гэхээсээ томоохон компаниудад илүү тохирох асуудал байгаа ч бодлого боловсруулагчид жижиг ААН ба хөрөнгийн биржид бүртгэлгүй ААН-ийн тухайд ч компаний засаглалын тухай ойлголтыг сайжруулахыг хүсэж байна.” гэсэн байна. Иймд аливаа улсын төрийн байгууллага болон зах зээлд оролцогчид энэхүү зарчимд үндэслэн тухайн улс орны эдийн засаг, хууль эрхзүй, соёлыг харгалзан өөрийн орны компаний засаглалын тогтолцоог хөгжүүлэхийг зорилт болгосон нь харагдаж байна. 2015 онд батлагдсан компаний засаглалын үндсэн зарчмын агуулгыг Хүснэгт 4.8-д харуулав.

⁵⁵ Япон улсын ГХЯ “Компаний засаглалын удирдах бүлэг” https://www.mofa.go.jp/mofaj/gaiko/occd/data_cg.html

Хүснэгт 4.8 G20/ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчимын агуулга.

№	Зарчим	Зарчмын тойм	Агуулга
1	Үр нөлөөтэй компаний засаглалыг тогтолцооны суурийг бий болгох.	Компаний засаглалын тогтолцооны ач холбогдол, ил тод шудрага зах зээл, нөөцийн үр ашигтай хувиарлалтыг дэмжих, хуулийг дээдлэх зарчим ба үр нөлөөтэй хяналт, хэрэгжилтийг дэмжих.	А) Компаний засаглалын тогтолцоог бий болгох В) Компаний засаглалын практикт нөлөө үзүүлэх хууль журамын талаарх хүсэлт. С) Байгууллага хоорондын хариуцлагын хувиарлалт D) Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт E) Хянан шалгах, зохицуулах, хэрэгжүүлэх байгууллагынажил үүрэг, бие даасан байдал, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг хангах, мөн тухайн байгууллагуудын хэрэгжүүлэлтийн чанар ба ил тод байдлыг хангах. F) Хил дамнасан арилжаан дахь тухайн байгууллагууд хоорондын гадаад хамтын ажиллагаа.
2	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчидтэй эрх тэгш харилцах, хувьцааг хөрөнгөний үндсэн үүрэг.	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бүх хувьцаа эзэмшигчидтэй эрх тэгшээ харилцах, эрх нь зөрчигдсөн үед арга хэмжээ авах боломж.	А) Хувьцаа эзэмшигчийн үндсэн эрх. В) Хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, гаргасан шийдвэрийг батлах эсвэл шийдвэр гаргахад оролцох эрх С) Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр шийдвэр гаргах эрхээ хэрэгжүүлэх боломж ба хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын талаар мэдээлэл олгох. D) Хувьцаа эзэмшигчийн үндсэн эрхийн талаар хувь нийлүүлэгчдийн зөвшөлцөөн E) Адил төрлийн хувьцааг эзэмшигчид нь адил тэгш эрхээр хангагдах F) Холбогдох талуудын хоорондын арилжааг батлах, хэрэгжүүлэх. G) Цөөн хувьцаа эзэмшигчдийг эрхийг хамгаалах, хариу авах арга хэмжээ H) ААН худалдах авах зэрэг арилжааг зохицуулах журам, процедурын ил тод байдал, худалдан авахаас сэргийлэх арга хэмжээний зохистой хэрэгжүүлэлт.
3	Институцийн хөрөнгө оруулагч (institutional investor), хөрөнгийн зах зээл болон бусад зуучлагчид	Хөрөнгө оруулалтын гинжин хэлхээ компаний засаглалын хөшүүрэгт үзүүлэх нөлөө.	А) Институцийн хөрөнгө оруулагчийн (institutional investor) зүгээс нээлттэй болгох ёстой компаний засаглалын чиглэл ба саналын эрхээ хэрэгжүүлэх чиглэл. B) Хувьцаа эзэмшигчдийн зааврын дагуу саналын эрхийг хэрэгжүүлэх C) Институцийн хөрөнгө оруулагч (institutional investor) итгэмжит төлөөлөгчийн хувьд нээлттэй болгох ёстой ашиг сонирхолын зөрчлийн хяналт D) Зуучлагч өмчлөгч ид зөвлөгөө өгөх ба үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа сайтай компаний засаглалын практикийг бий болгохын тулд гүйцэтгэх үүрэг ба тэдгээрийн ашиг сонирхолын зөрчлийг ил тод болгож, багасгах.

			<p>Е) Хаалттай мэдээлэл ашиглан үнэт цаасны арилжаа хийж, ашиг олохыг хориглох.</p> <p>Ү) Байгуулагдсанаас өөр газар хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, давхар бүртгүүлэх тохиолдолд компаний засаглалын журамыг нь мөрдөх улс, бүс нутаг, тэдгээрийн ялгааг ил болгох.</p> <p>Г) Хөрөнгийн зах зээл бий болгох ёстой шударга, үр өгөөжтэй үний бүтэц</p>
4	Компанийн засаглал дахь оролцогч талуудын үүрэг	Оролцогч талуудын эрхийн талаарх ойлголт, компаниба оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих	<p>А) Оролцогч талуудын эрхийг хүндэтгэх</p> <p>В) Оролцогч талуудын эрх зөрчигдөхөд авах арга хэмжээ.</p> <p>С) Компаний ажилтнуудын оролцоотой механизмыг бий болгох.</p> <p>Д) Оролцогч талууд компаний засаглалд оролцох тохиолдолд мэдээлэл авах боломжоор хангах.</p> <p>Е) Оролцогч талууд аас бүрдсэн ТУЗ болон байгууллагад мэдээлэл өгөх.</p> <p>Ү) Үр нөлөөтэй, үр ашигтай дампуурлын тогтолцоо болон зээлдүүлэгчийн эрхийг зохистой хэрэгжүүлэх.</p>
5	Нээлттэй, л тод байдал	Компанитай холбоотой аливаа чухал асуудлыг цаг тухайд нь үнэн зөвөөр мэдээлэх.	<p>А) Нээлттэй болгох ёстой чухал мэдээллийн төрөл</p> <p>В) Санхүүгийн тайлагналын стандарт зэрэг нээлттэй болгох мэдээллийн чанарыг тодорхойлох шалгуур.</p> <p>С) Нээлттэй болгож буй мэдээлэлд хөндлөнгийн обьектив баталгаа өгөх аудит хийх.</p> <p>Д) Хөндлөнгийн аудитын үүрэг хариуцлага.</p> <p>Е) Мэдээлэл дамжуулах суваг ба мэдээлэл нээлттэй болгох журам</p>
6	ТУЗ-ийн үүрэг хариуцлага	ТУЗ-ийн зүгээс компани ба хувьцаа эзэмшигчдэд тайлбар хийх, тайлагнах хариуцлагыг баталгаажуулах.	<p>А) Гүйцэтгэх удирдлагын анхаарал хандуулах үүрэг ба үнэнч байх үүрэг.</p> <p>В) ТУЗ-ийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах.</p> <p>С) ТУЗ-ийн ёс зүйн шалгуур, оролцогч талуудын ашиг сонирхолыг харгалзах.</p> <p>Д) ТУЗ-ийн зүгээс хэрэгжүүлэх чухал чиг үүрэг.</p> <p>Е) ТУЗ-ийн бодит, бие даасан байдлыг хангах</p> <p>Ү) Гүйцэтгэх удирдлагын зүгээс компаний дотоод мэдээлэлд нэвтрэх нөхцлийг хангах.</p> <p>Г) Ажилтнуудын төлөөлөл болсон гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага, үйл ажиллагаа, дотоод мэдээлэл авах, бие даасан байдлыг хангах.</p>

Эх сурвалж: G20/ ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчим

2) Япон улсын компанийн засаглалын кодекс

Япон улсад 2015 оны 3 сард “Компаний засаглалын кодекс боловсруулах” эрдэмтэн, судлаачдын зөвлөлөөс нэгтгэсэн “Компанийн засаглалын кодексийн төслийг үндэслэн Токиогийн хөрөнгийн биржийн Үнэт цаас гаргах компанийн бүртгэлийн журмын хавсралт болгон батлахын хамт бүртгэлийн тогтолцоог бий болгосон. Үүнээс өмнө 2013 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Японы дахин сэргэлтийн стратегийн” хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг үндэслэн “Хариуцлагатай институцийн хөрөнгө оруулагчийн” үйл ажиллагааны зарчим болох Стюардшипийн кодексийн боловсруулан баталсан тул ААН-ийн үйл ажиллагааны зарчим болох 2014 онд ЗГ-ийн тогтоолоор батлагдсан “Японы дахин сэргэлтийн стратегийн нэмэлт өөрчлөлт 2014-ийн” хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг үндэслэн компанийн тогтвортой өсөлтийг хангах, урт хугацаанд компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх үүднээс компанийн засаглалын кодексийг боловсруулан баталсан билээ. Тэрчлэн түүний дараахан Стюардшипийн кодекс болон компанийн засаглалын кодексийн Follow Up хурлыг дээрт авигдсан нэмэлт өөрчлөлт оруулах саналыг үндэслэн уг саналын дагуу 2018 оны 6 сард нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

Ийнхүү Японы компанийн засаглалын кодекс нь хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудад зориулагдсан бөгөөд доор дурьдсан 2 онцлогтой юм. Юуны өмнө компаниуд өөр өөрийн байгаа нөхцөл байдлаас хамааран компанийн засаглалыг бодитоор хэрэгжүүлж чадахуйц зарчимч хандлагыг чухалчлан үздэг. Дараа нь хууль тогтоомжийн заавал дагаж мөрдөх хүрээнд биш тэдгээрийг хэрэгжүүлэх явцад “ мөрдөх үгүй бол тайлбарлах” гэсэн аргыг авч хэрэглэдэг.

Компанийн засаглалын кодекс нь хүснэгт 4.9-д харуулсанчлан ①хувьцаа эзэмшигчдийн эрх, эрх тэгш байдлыг хангах, ②хувьцаа эзэмшигчдээс бусад оролцогчидтой зохистой хамтран ажиллах, ③мэдээллийг зохих ёсоор нээлттэй болгох, ил тод байдлыг хангах, ④ ТУЗ-ийн үүрэг, ⑤ хувьцаа эзэмшигчидтэй явуулах яриа хэлцэл гэсэн 5 үндсэн зарчмыг үндэслэсэн 31 зарчим, 42 дэд зарчмаас бүрдэж байна. 2018 оны 6 сарын нэмэлт өөрчлөлтөөр ①-д бодлогын хувьцааны талаар дэлгэрүүлэн бичиж, ② -т компанийн тэтгэврийн хуримтлалын хөрөнгөний ашиглалтын талаар нэмэлт оруулж, ③-т мэдээллийг нээлттэй болгох асуудлын хүрээнд санхүүгийн бус мэдээлэл болох ESG-ийн элементүүдийг нээлттэй болгох талаар нэмэлт оруулж, эцэст нь ④-т ТУЗ-ийн үүрэг, хариуцлага, сайн дурын зөвлөх хороо, ТУЗ-ийн гишүүдийн бие даасан байдал, олон талт байдлыг хангах, аудитор тавигдах шаардлага, менежментийн стратеги ба менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлахтай холбоотой

нэмэлт оруулсан болно.

Компанийн засаглалын кодексийн дотор ① ба ④-д олон зүйл заалт агуулагдсан байгаагаас өмчлөл ба менежментийн үйл ажиллагаа нь хил заагтай, олон хувьцаа эзэмшигчтэй ААН-д зориулагдсан болохыг ойлгож болно.

Хүснэгт 4.9 Компанийн засаглалын кодексийн агуулга

№	Үндсэн зарчим	Зарчмийн тоо	Дэд зарчмийн тоо
1	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба эр тэгш байдлыг хангах	7	11
2	Хувьцаа эзэмшигчдээс бусад оролцогчидтой зохистой хамтран ажиллах	6	3
3	Мэдээллийн зохих ёсоор нээлттэй болгох, ил тод байдлыг хангах	2	4
4	ТУЗ-ийн үүрэг	14	21
5	Хувьцаа эзэмшигчидтэй явуулах яриа хэлцэл	2	3

Эх сурвалж: Япон улсын Компанийн засаглалын кодекс

2017 оны 7 сарын байдлаар компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн байдлыг Токиогийн хөрөнгийн биржийн нэгтгэн гаргасан статистикээр аваад үзэхэд тус хөрөнгийн биржийн 1 ба 2-р ангилалд бүртгэлтэй 2540 ААН-ийн 25.9% нь нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнөх 73 зүйл заалтыг бүгдийг нь, 63.0% нь тэдгээрийн 90-эс дээш хувийг биелүүлсэн⁵⁶ байна.

3) ОУСК-ийн Гэр бүлийн бизнесийн засаглалын гарын авлага

ОУСК-ийг зүгээс хөрөнгө оруулалт хийж, зөвлөлгөө өгөхдөө ОУСК-ийн ажилтнууд тухайн ААН-ийн компанийн засаглалд тулгарч буй асуудлын талаар сайтар ойлголттой болохуйцаар хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, гэр бүлийн эсвэл үүсгэн байгуулагчийн эзэмшлийн компани, санхүүгийн байгуулга, шилжилтийн эдийн засагтай орны хувьчлагдсан компани, төрийн өмчийн компани, хөрөнгийн сан, ЖДҮ зэрэг 7 төрлийн ААН-ийн бүлэгт зориулан төрөл бүрийн гарын авлага гаргадаг. Мөн эдгээр ААН-ийн бүлгийн хамруулан компанийн засаглалын асуудалд дүн шинжилгээ хийхдээ Instruction Sheet, Progression Matrix, Document Request List, Information Request List зэрэг хэрэгслийг ашигладаг.

Түүнчлэн гэр бүлийн компанийн засаглалыг бэхжүүлэх үүднээс засаглалын гарын авлага болосвруулан Монгол болон бусад хэлэнд орчуулсан байдаг. Энэ нь ААН-ийн том багаас үл

⁵⁶ Хэрэгжүүлдэггүй зүйл заалтын хувьд “мөрдөх үгүй бол тайлбар” гэсэн зарчмын дагуу шалтгааныг нь тайлбарладаг.

хамааран гэр бүлийн компанийн засаглалд байдаг асуудлууд болон тэдгээрийг шийдэх арга замыг санал болгосон өвөрмөц бүтээл бөгөөд доор дурьдсан агуулгыг багтаасан байна.

(i) Гэр бүлийн компанийн давуу ба сул тал

Гэр бүлийн компани нь үнэнч зүтгэх эрмэлзэл, залгамж халаа, найдвартай болон бахархал зэрэг талаараа санхүүгийн хувьд нэг салбарын бусад компаниас давуу талтай боловч нөгөө талаар өмчлөл ба ажил эрхлэлтийн нарийн төвөгтэй байдал, ялангуяа үйл ажиллагааны эхэн үеийн албан бус үйл ажиллагаа, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэх захирал томилох зэрэг асуудалд хангалттай анхаарал тавьдаггүй зэрэг сахилга сул байдлаас болж удаан хугацаагаар оршин тогтнодоггүй сул талтай байдаг. Эдгээр сул тал нь бүгд компанийн засаглалтай ямар нэгэн байдлаар холбогддог.

(ii) Бизнесийн засаглалд гэр бүлийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг ба болзошгүй ашиг сонирхолын зөрчил Гэр бүлийн компанид нэг хүн олон давхар үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээдэг тул асуудал илүү төвөгтэй болдог.

Эзэн: Гэр бүлийн гишүүд, жишээлбэл, эзэн ба менежер гэх мэт олон давхар үүрэг гүйцэтгэх нь түгээмэл байдаг. Гэвч гэр бүлийн бизнес өсөхийн хирээр эзэн ба менежер өөр өөр хөшүүргээр ялгаатай үүрэг гүйцэгдэг болох тул нөхцөл байдал хүндэрдэг.

Менежер: Гэр бүлийн ба гэр бүлийн бус менежерүүдэд тэгш бус харьцах хандлага нь түгээмэл байдаг. Ийм тэгш бус харьцаа нь гаднаас чадвартай болвсон хүчин авч ажилуулахад саад болдог.

ТУЗ-ийн гишүүд: Гэр бүлийн компанийн ТУЗ-ийн ихэнх нь гэр бүлийн гишүүд байдаг. Гэр бүлийн гишүүд ТУЗ-ийн гишүүн байна уу, менежер байна уу гэдгээс зөрчил үүсч эхэлдэг.

Гэр бүлийн гишүүд: Гэр бүлийн гишүүд хоорондын мэдээллийн тэгш бус байдал зөрчилд хүргэж болзошгүй байдаг.

(iii) Гэр бүлийн компанийн засаглалыг хэрхэн бий болгох вэ?

Гэр бүлийн бизнес үүсгэн байгуулагчийн үе шатанд байхад ихэнх шийдвэрийг үүсгэн байгуулагч өөрөө гаргаж, гэр бүлийн дуу хоолой нэгдмэл байдаг тул засаглалтай холбоотой асуудал бараг гардаггүй. Гэвч цаг хугацаа өнгөрөхийн хирээр бизнесийн үйл ажиллагаанд оролцдог гэр бүлийн гишүүдийн тоо нэмэгдэж засаглалын асуудал нэмэгддэг. Ийм үед гэр

бүлийн гишүүдийг сахилга баттай болгон, засаглалын тодорхой тогтолцоо бий болгох шаардлага гарч ирдэг. Зохицуулалт сайн хийж чадаж байгаа гэр бүлийн засаглалын тогтолцоо дараах зорилтыг хангахын төлөө байдаг.

- Гэр бүлийн бүх гишүүдэд гэр бүлийн эрхэмлэдэг үнэт зүйлс, эрхэм зорилго, алсын харааг танилцуулах.
- Гэр бүлийн бизнесийн томоохон шийдвэр, амжилт, бэрхшээлийн талаарх мэдээллийг гэр бүлийн гишүүдэд өгч байх.
- Гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлт, ногдол ашиг, бизнесээс авч байдаг бусад тусламж, дэмжлэгийн талаарх дүрэм, журмыг тогтоох.
- Гэр бүлийн гишүүдэд зориулсан албан ёсны харилцааны сувгийг бий болгох.
- Гэр бүлийн гишүүд нэг дор цугларан шаардлагатай шийдвэрийг гаргах нөхцөл бүрдүүлэх.

Гэр бүлийн засаглалын тогтолцоог гэр бүлийн үндсэн хууль ба гэр бүлийн байгууллагын хэлбэрээр бий болгодог.

Үүнээс гадна компаний засаглалын онооны картад (Corporate Governance Scorecards) ОУСК-ийн ажилтнууд хөрөнгө оруулах үед үнэлгээ хийдэг гэр бүлийн компанид зориулсан онооны картын загвар байдаг. Үүний агуулгыг хүснэгт 4.10 д харуулав.

Хүснэгт 4.10 Гэр бүлийн компаний засаглалын дүн шинжилгээ

№	Агуулга	Асуултын тоо
1	Компаний засаглалд үнэнч байдал	4
2	Гэр бүлийн компаний засаглал	5
3	Хувьцаа эзэмшигч ба хөрөнгө оруулагчдын эрх	3
4	ТУЗ-ийн үйл ажиллагаа	5
5	Хяналтын орчин	6
6	Нээлттэй, ил тод байдал	4

Эх сурвалж: ОУСК-ийн Компаний засаглалын онооны карт

4) Хонконгийн ЖДҮ-ийн компаний засаглалын гарын авлага

ЖДҮ-т зориулсан компаний засаглалын талаарх гарын авлага болон жишээ элбэг биш байдаг. Үүний шалтгаан нь компанийн засаглал нь хөрөнгийн зах зээлд гарахад шаардагдах нөхцөл гэж ойлгогддог бөгөөд хөрөнгийн зах зээлтэй холбоогүй ЖДҮ-ийн хувьд хэрэггүй, зардал ба үр ашгийн хувьд таардаггүй гэсэн ойлголт түгээмэл байдгаас болдог. Гэвч ЖДҮ-ийн хувьд ч гэсэн

компаний засаглалыг компаний өсөлт хөгжлийг дэмжих суурийг тавих хэрэгсэл болгон ашиглаж болно. Хонконгийн захирлуудын холбоо нь 2003 онд ЖДҮ эрхлэгч нарт зориулсан Компанийн засаглалын зааварчлага гаргаж компанийн стратеги чиглэл боловсруулах, бизнес хөгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх хэрэгсэл болгон ашиглахыг санал болгосон байна. 2009 онд шинэчлэн найруулсан 2 дахь хэвлэлийн агуулгыг доор харуулав.

(i) Компаний засаглалын үзэл баримтлал ба ач холбогдол

- Хонконг нь Америкийн загварыг хэрэглэж байгаад Английн загварыг авч хэрэглэж байгаа бөгөөд хууль эрх зүйн зохицуулалт ба өөрийн сайн дурын зохицуулалтыг хослуулдаг.
- Урьд өмнө гарсан компанийн засаглалын талаарх материал нь ихэвчлэн хувьцаат компаниудад зориулагдсан байдаг байна.
- Компанийн засаглал, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн хооронд уялдаа холбоо байдаг.
- Бүх төрлийн судалгаанаас харахад сайн засаглалтай компани хөрөнгө оруулагчдын сонирхолыг харьцангуй их татах бөгөөд хөрөнгийн зах зээл дээрх үзүүлэлт нь салбарын дундажаас дээгүүр байдаг.

(ii) ЖДҮ-т шаардлагатай засаглалын практик

- Компанийн өмчлөлийн хэлбэрийг үл харгалзан удирдлага, хяналтын үйл ажиллагаанд ашиглах компанийн засаглал шаардлагатай байна.
- Бичил ААН хүртэл зохистой систем бий болгон ашигласнаар бизнес эрхлэгч бизнесийг амжилтад хүргэх боломж дээшилнэ.
- Компанийн засаглалын практик нь томоохон компаниуд руу чиглэн хөгжиж ирсэн боловч энгийн хэлбэрээр бичил ААН-д ашиглахад ч үнэ цэнэ бий
- ААН-ийн хэмжээ, өмчлөлийн хэлбэр, уламжлал, хувийн шинж чанарын ялгаа зэрэг нь ААН-ийн менежментийн аргад томоохон ялгаа үүсгэх магадлал байх боловч цаашид оршин тогтнож, амжилтад хүрэх боломжийг нэмэгдүүлэх магадлал өндөр нийтлэг зарчим юм.

- Бүх ААН хамгийн наад зах нь дараах зүйлүүдийг даган мөрдөх шаардлагатай:
 - Хууль тогтоомжийг мөрдөх.
 - Оролцогч талуудаас хүндлэл хүлээх.
 - Нэр хүндээ өсгөх замаар санхүүжилт олох зардалыг бууруулна.
 - Эрсдлийг тодорхойлж, удирдах
 - Шийдвэр гаргалтын чанарыг дээшлүүлэх авч хэрэглэх, хөгжүүлэх.

(iii) 5 үе шаттай ЖДҮ ба үе шат тус бүр дахь компаний засаглалын чухал асуудлууд

“Үе шат -1”: Нэг хувьцаа эзэмшигчтэй бичил ААН. Бизнесийн үйл ажиллагааг 2-3 гэр бүлийн гишүүн явуулдаг.

- Бизнес үйл ажиллагааны хялбар төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө гаргаж, компанийн зорилго, зорилгод хүрэх чиглэлийг тодорхойлно. Төлөвлөгөө нь бизнес эрхлэгчийн гаргах шийдвэрийн чанарыг сайжруулах бөгөөд тууштай, ёс зүйтэй төлөвлөгөө нь банкны өмнө компанийн итгэл хүлээх найдвартай түнш болгож харагдуулна.
- Орон тооны ТУЗ-ийн гишүүн байх шаардлагагүй боловч татварын зөвлөх нягтлан бодогч зэрэг цагийн ажилтан зөвлөхтэй байх нь эзний зүгээс асуудлыг бодитоор харахад нэмэр болно.
- “Үе шат-2”: Гэр бүлийн гишүүн бус ажилтан авч ажиллуулдаг Үе шат -1- ээс арай том компани. Өмчлөгчид нь 2-3 гэр бүлийн гишүүн ба хөндлөнгийн хүмүүсээс бүрдэнэ.
- Үе шат -1-ээс арай илүү тодорхой төлөвлөгөө, материал шаардагдана
- Компани томрохын хирээр эзэн нь бүх үйл ажиллагааг харж байх боломжгүй болох тул өөрөө шууд хянах боломжгүй үйл ажиллагааг хянах албан ёсны систем шаардлагатай.
- Эрсдлийн хяналт шинжилгээ, менежментийн систем бий болгох шаардлагатай.
- Орон тооны ТУЗ-ийн гишүүн байх шаардлагагүй боловч компанийн эзэн урт хугацааны төлөвлөгөө боловсруулах ажилд зөвлөх урьж ажиллуулах шаардлагатай.

“Үе шат-3”: Хэд хэдэн хувьцаа эзэмшигчид болон хуулийн этгээд бус нөхөрлөлөөс бүрдэх дунд хэмжээний ААН.

Үе шат дээшлэх тутам оролцогч талуудын тоо нэмэгдэх тул харьцангуй ухаалаг засаглалын

бодлого, тухайлбал албан ёсны ТУЗ, жилийн санхүүгийн аудитийн тогтолцоо бий болгох шаардлагатай.

“Үе шат -4”: Дунд, том хэмжээний хаалттай эсвэл нээлттэй (Хувьцаа гаргасан ба гаргаагүй ААН) ААН.

“Үе шат-5”: Хонконгийн хөрөнгийн биржид хувьцаа гаргасан ААН.

(iv) Гэр бүлийн компаний тусгай нөхцөл байдал.

Олон тооны хувьцаа эзэмшигчидтэй ААН-ээс гэр бүлийн компаний давуу тал.

1. Зорилго тодорхой ба бусад шийдвэр гаргалт оновчтой.
 2. Хувь хүний сэдэл, хөшүүрэг маш хүчтэй.
 3. Гэр бүлийн компаний гишүүд компанидаа харьцангуй үнэнч
- Гэр бүлийн компанид тулгардаг 5 асуудал болон эдгээр асуудлыг хэрхэн шийдэж байна вэ гэдэг нь компаний менежементийн арга барилд ихээхэн нөлөөлдөг.
 1. Бизнесийн залгамж халаа
Эзэн компаниа хөндлөнгийн этгээдэд заралгүй гэр бүлийн гишүүдэд өвлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд бизнесийг залгамжлуулах тодорхой төлөвлөгөөг яаралтай боловсруулах шаардлагатай болно.
 2. Гэр бүлийн эрх ашиг ба компаний эрх ашиг
Гэр бүл ба компаний эрх ашиг ихээхэн зөрчилдөх тохиолдол байдаг тул доорхи асуудлуудыг харгалзан компаний дүрэм зэрэг албан бичиг баримтыг боловсруулах шаардлагатай.
 - Гэр бүлийн гишүүдэд хувьцаа хуваарилах (хэзээ, хэдэн ширхэг гэх мэт)
 - Ногдол ашиг: Компаний төлөө ажиллаж буй гэр бүлийн гишүүдэд цалин хөлс олгох зохицуулалт
 - Компаний төлөө ажиллах гэр бүлийн гишүүний нөхцөл
 - Санал зөрөлдөөнийг шийдвэрлэх механизм
 3. Хөндлөнгийн удирдлагын баг урьж ажиллуулж болно.
Гэр бүлийн гишүүн бус удирдлага гэр бүлийн гишүүдэд давуу эрхтэй гэж ойлгох юм уу эрх мэдлийн шат дараалал тодорхой бус гэж бодох юм бол гэр бүлийн компанид байх сонирхолгүй болох тул чадвартай гүйцэтгэх удирдлагыг урьж ажиллуулахын тулд тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

4. Хэтийн төлөвийг тодорхойлох

Эзэн давамгайлах байдалтай, санал хүлээж авдаггүй бол ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын аль аль нь саналаа илэрхийлж чадахгүй тул эзэнд зөвлөгөө өгдөг бие даасан ТУЗ байх нь үр нөлөөтэй. Иймд бүтээлч асуулт тавьж, эсрэг санал илэрхийлэх боломжтой засаглалын технологийг авч ашиглах шаардлагатай.

5. Өсөлт ба алдагдалын удирдлагад зориулагдсан хөрөнгө.

Хурдан өсөж дэвжихийн тулд зарим үед гэр бүлийн өмчлөлийн эрхийг золиосолж гаднаас хөрөнгө оруулалт хүлээн авах шаардлагатай болдог. Иймэрхүү ацан шалаанд орж хүнд шийдвэр гаргах тохиолдол гэр бүлийн амьжиргааны түвшинг хадгалах үүднээс компанийн нөөцийн ихэнхийг ашигладаг тохиолдолд эрт шатанд ажиглагдах магадлалтай.

(2) Одоогийн өөрийн үнэлгээний хуудас (гадаадын жишээ)

Өөрийн компаний засаглалын нөхцөл байдалд үнэлгээ өгөх зорилгоор боловсруулсан өөрийн үнэлгээний хуудас олон байдаг хэдий ч Тайланд улсын Худалдааны яамны Сайн засаглалын тэмцээнд зориулсан өөрийн тайлангийн хуудас, Японы татварт зориулсан сайн дурын үзлэгийн шалгах хуудас (Selfcheck sheet), монголын СЗХ-ны дүрэмд үндэслэсэн өөрийн үнэлгээний хуудас (Өөрийгөө шалгах хуудас, Selfcheck sheet) зэргийг авч үзье

1) Сайн засаглалын тэмцээнд зориулсан өөрийн үнэлгээний хуудас (Тайландын худалдааны яам)

Тайланд улсын Худалдааны яамны Бизнес хөгжлийн газар 2011 оноос жил бүр Сайн засаглалын тэмцээн зохион байгуулж байна. Энэ нь Тайландын ААН-үүд засаглалын асуудалд анхаарал хандуулан, бизнесээ явуулахад зориулан хэрэгжиж буй төсөл юм. Түүнчлэн дэлхийн хэмжээнд Тайландын компаниудын итгэл хүлээх чадвар, найдвартай байдлыг дээшлүүлэн гадны зах зээлд өрсөлдөх чадвартай болгох үүднээс “1 муж 1 засаглал” бодлогын дагуу Тайландын бүх мужийг хамруулан зохион байгуулагддаг. Тодорхой зорилгын хувьд ① хөрөнгө оруулагчид болон ард иргэдийн өмнө ААН-ийн итгэл хүлээх чадварыг дээшлүүлэн ASEAN бүс нутгийн ижил салбарын бусад компанитай өрсөлдөх, ② Ил тод, шударга бизнесийн үйл ажиллагаа явуулан хэрэглэгч болон энгийн иргэдэд тэгш шударга хандсанаар нийгмийн хариуцлагаа биелүүлэх, ③ ААН компанийн засаглалыг нэвтрүүлэн тогтвортой үйл ажиллагаа явуулах, ④ Шилдэг ААН-ийг зарласнаар ААН компанийн засаглалын ойлголтыг дээшлүүлэн,

компаний засаглалын сайн загвар болгох зэрэг юм. Сонгон шалгаруулалтын процедурын хувьд эхлээд оролцогч ААН өөрийн тайлангийн хуудсаа бөглөн ирүүлсний дараа мэргэжилтэн агуулгыг шалгаж, хяналтын хороо шагнал авах ААН-ийг тодорхойлдог. Оролцогчийн өөрийн тайлангийн хуудсанд 6 үзүүлэлттэй хүснэгт 4.11-д бичигдсэн агуулгыг багтаадаг.

Хүснэгт 4.11 “Сайн засаглалын тэмцээний” өөрийн тайлангийн хуудасны агуулга.

№	Агуулга	Асуултын тоо
1	Хууль дээдлэх	15
2	ААН-ийн ёс зүй, ёс суртахуун	15
3	Ил тод байдал	15
4	Оролцогч талуудтай харьцах	15
5	ААН-ийн хариуцлага	15
6	Үнэ цэнэ.	15

Эх сурвалж: Тайландын Худалдааны яамны Сайн засаглалын тэмцээнд зориулсан өөрийн тайлангийн хуудас.

Энэхүү өөрийн тайлангийн хуудсаны онцлог нь гэвэл зориулалт нь хөрөнгийн зах зээлд гарсан ААН-ээр хязгаарлагдахгүй тул ихэнх тохиолдолд чухалчлан үздэг хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ зэрэг институци, цөөнх хувьцаа эзэмшигчдийн хамгаалах, мэдээллийг ил болгох зэрэг асуудлуудыг багтаагаагүй явдал юм. Иймд энэ удаагийн судалгаагаар өөрийн үзлэгийн хэрэгсэлийг (Selfcheck sheet) боловсруулахад санаа авч ашигласан болно.

2) Сайн дурын үнэлгээний хуудас (Selfcheck sheet) (Үндэсний хуулийн этгээдүүдийн холбооны нэгдсэн эвлэл)

Японы үндэсний хуулийн этгээдийн холбооны нэгдсэн эвлэлээс Японы татварын нягтлан бодогч нарын холбооны хяналтын доор, Татварын ерөнхий газрын дэмжлэгээр боловсруулсан сайн дурын үзлэгийн шалгах хуудас нь компанийн засаглалыг бүхэлд нь биш гэхэд “Компанийн татварын нийцлийн түвшинг сайжруулах арга хэмжээний хувьд ААН-ийн дотоод хяналт, ня-бо бүртгэлтэй холбоотой сайн дурын үзлэг хийхийг зөвлөх 57 зорилготой юм. Сайн дурын үзлэгийн шалгах хуудас нь 83 зүйлтэй боловч ААН-ийн засаглалыг хангахад шаардлагатай 45 үндсэн зүйлээс бүрдсэн гарын авлагын хэсэг ч байдаг.

Тодорхой агуулгын тухайд бичиг баримт боловсруулалт, хадгалалтын байдал, санхүүгийн тайлангийн дансны үзүүлэлт тус бүрээр ня-бо бүртгэлийн арга болон бүртгэлийн үндэслэл болох материал, хэрэглээний татвар, тэмдэгтийн татвартай холбоотой зүйлүүд багтсан байдаг.

⁵⁷ Хуулийн этгээдийн холбооны цахим хуудас <http://tax-compliance.brain-server2.net/compliance/units/>

(3) Монголын жишээ

1) Компанийн засаглалын кодекс

2-р бүлэг болон энэхүү бүлгийн эхний хэсэгт өгүүлсэнчлэн 2014 оны 5 сард хүснэгт-2.4-д дурьдсан 10 зарчмаас бүрдэх нэмэлт өөрчлөлт оруулсан компаний засаглалын кодекс баталагдсан. Энэхүү компаний засаглалын кодексийг 2004 оны ЭЗХАХБ-ын компаний засаглалын зарчимуудыг үндэслэн, ОУСК-ийн санал, зөвлөгөө, бусад улс орны жишээ, мөн компаний засаглалын тогтолцооноос эдийн засагт үзүүлэх нөлөө болон зах зээл оролцогчдод үзүүлэх идэвхтэй нөлөө зэргийг тооцсоны үндсэн дээр монгол улсын нөхцөл ба өнөөгийн байдлыг харгалзан боловсруулсан байна. Тэрчлэн компаний засаглалын кодексийг хувьцаат компаниудад зориулан боловсруулсан боловч хөрөнгийн зах зээлд гараагүй хаалттай компаниуд болон төрөл бүрийн хуулийн этгээдүүд тус бүрийн онцлог нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр авч хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

2) Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ААН-д зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга”

2016 оны 1 сарын 29-ний өдрийн СЗХ-ны 34-р тогтоолыг үндэслэн МХБ-ээс Хөрөнгийн зах зээлд гарсан ААН-дэд зориулан Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн Компани өөрөө өөрийгөө үнэлэх маягтыг (Selfcheck List) боловсруулан МХБ-д бүртгэлтэй 1 ба 2-р ангиллын компаниудад уг хуудсыг бөглөж үр дүнг нь тайлагнах шаардлага тавиад байгаа юм.

Уг үнэлгээний хуудасны агуулгыг хүснэгт 4.12-т харуулсан бөгөөд нийт 100 зүйл заалттай компаний засаглалын кодексийн агуулгыг багтаасан байна.

Онооны дүнг нэгтгэж, 75 –аас дээш оноо авсан бол сайн засаглалтай, 50-74 оноо авсан бол менежмент асуудалтай, 25-49 оноо авсан бол засаглал хангалттай бус, 24-өөс бага оноо авсан бол засаглал асуудалтай бөгөөд ААН-ийн менежментийг шинэчлэх шаардлагатай гэсэн үг болно.

Хүснэгт 4.12 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн Компани өөрөө өөрийгөө үнэлэх маягтын агуулга

	Зүйл	Асуулт	Оноо
A	Хувьцаа эзэмшигчид ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх	20	20%
B	Хувьцааны хөрөнгө	10	10%
C	Оролцогч талууд	10	10%
D	Ил тод байдал	20	20%
E	ТУЗ	30	30%
F	Гүцэтгэх удирдлага	10	10%
Нийт		100	100%

Эх сурвалж: Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн Компани өөрөө өөрийгөө үнэлэх маягт

(4) Асуулга судалгаанаас гарсан асуудлууд

4.3-д өмнө өгүүлсэн ААН асуулга судалгааны үр дүнгээс Монголын хөрөнгийн бирж одоогийн байдлаар хангалттай арга хэмжээ авч чадахгүй байгаа дараах асуудалд анхаарал хандуулах үүднээс өөрийн үнэлгээний хуудсанд бичлээ.

- ТУЗ байгуулаагүй, компанийн гишүүн бус ТУЗ-ийн гишүүнийг томилоогүй, шийдвэр гаргалт ба ажлын гүйцэтгэлийг хооронд нь салгаагүй→Шийдвэр гаргалт.
- Бизнесийн залгамж халааг бэлдэх талаар арга хэмжээ аваагүй→ Гэр бүлийн бизнесийн менежмент (Залгамжлагчийг бэлтгэх)
- Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааны идэвхигүй байдлын талаарх хандлага.→ Тайлагнал, ил тод байдал
- Татварын хэлтэсийн ажилтанд хахууль өгөх→Ёс зүй
- Гүйцэтгэх удирдлага санхүүгийн мэдээлэлд анхаарал бага хандуулах→Төлөвлөлт ба хяналт

(5) Японы компанийн хөрөнгө оруулагчдын хэрэгцээнээс гаргаж ирсэн асуудлууд

Монголд үйл ажиллагаа явуулж буй Японы худалдаа аж үйлдвэрийн танхимийн гишүүн томоохон худалдааны компани, банкны төлөөлөгчийн газартай уулзаж ярилцсан. Томоохон худалдааны компаниуд төлөөлөгчийн газраа нээсэн байх бөгөөд Монгол дахь арилжааг монголын ААН болон Япон дахь төв компаний хооронд шууд явуулдаг байна. Хүндрэл бэрхшээл арилжааны түншээ хайж олохоос эхэлдэг. Монголын компаниуд цахим хуудастай байдаг хэдий ч Японы компаниуд арилжаа наймаа хийхэд тохиромжтой эсэх талаар дүгнэлт гаргахад шаардлагатай мэдээлэл, өөрөөр хэлбэл ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл,

санхүүгийн мэдээлэл нээлттэй бус байдаг байна⁵⁸. Иймд түнш болох магадлалтай тухайн компани руу утсаар ярьж мэдээлэл авах шаардлагатай болдог.

Томоохон компаниудын хувьд холбогдож ерөнхий шаардлагатай мэдээллээ авах боломжтой байдаг боловч ийм байдлаар олон компани дундаас түншээ сонгож авахад хугацаа шаардагдах төдийгүй Монгол талаа ч дэмий хүлээлгэх магадлалтай гэх мэтчилэн бие биендээ түвэг удаг байна Тэрчлэн уг компани өдий хүртэл хэрхэн өсөж хөгжиж ирсэн талаарх суурь мэдээллийг тодруулах хэцүү байдаг байна.

Үүнээс гадна арилжааны хэлэлцээрийн явцад Монголын ААН-ийн гол хүнтэй шууд ярилцахгүй бол болдоггүй. Гол хүн нь хэлэлцээрт орохгүй тохиолдолд хэлэлцээрийн явцад ярианы агуулга өөрчлөгдөх тал байдгаас гадна гол хүн хэлэлцээрт оролцсон ч байр суурь нь өөрчлөгдөж болох тул хэлэлцээр хийхэд их цаг хугацаа шаардагддаг байна. Тэрчлэн гэрээ байгуулсан ч гэрээний заалтуудыг биелүүлэхгүй, түнш гэсэн ойлголт байхгүйн дээр төлбөр цагтаа хийгдэхгүй зэрэг олон асуудал байдаг байна. Ерөнхийдээ хууль тогтоомж сахин мөрдөх явдал эхлэлийн шатандаа байгаа бөгөөд үүнийг цэгцлэхгүй бол дараагийн шатанд шатанд шилжих боломжгүй гэсэн ойлголт бүрэн тархаагүй байна гэж хэлж болно.

Хоккайдогаас ирсэн ААН-ээс авсан судалгаанаас үзвэл хэдэн жилийн өмнө цаг уурын хувьд төстэй болохоор хүйтэн бүсэд тохиромжтой орон сууц барих, газар тариалан эрхлэхээр Монголд ирэх ААН олон байсан байна. Зүүн японы газар хөдлөлтийн дараах сэргээн босгох ажлын нөлөөгөөр хөрөнгө мөнгөний хувьд боломжтой компаниуд ирж байсан бололтой. Гэсэн хэдий ч зах зээлийн судалгаа хангалтгүйгээс бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ байвч үнэ өндөр тул худалдан авахгүй байх, түнш тохиромжгүй байх зэрэг шалтгаанаар үндсэндээ ихэнхи нь нутаг буцсан бөгөөд одоогийн байдлаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй компани асуулгад оролцсон ААН-ийн дотор ганцхан байсан болно. Гэхдээ Япон талд хүн хүч хүрэлцээгүйгээс Монголоос дадлагажигч хүлээн авах хэрэгцээ өндөр, ажиллах хүчээр хангагч талын хувьд Монголын нэр хүнд өсөж байгаа гэсэн бодолтой хүн ч тааралдав. Хоккайдогийн жишээгээр аваад үзэхэд Монгол талын түншүүдэд хөрөнгийн хомсдол, гэрээ болон хууль тогтоомж үл мөрдөх зэрэг асуудал байсан хэдий ч Япон талын хувьд ч зах зээлийн шуугианд хөтлөгдөн хангалттай судалгаа хийлгүй, Монгол түнштэйгээ тогтоосон хүмүүнлэг харилцааг

⁵⁸ Яагаад ТУЗ-ийн гишүүд болон хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл хэрэгтэй вэ гэвэл тухайн ААН-ийн ТУЗ-д төрийн албан хаагч гэх мэт хүмүүс орсон байвал Японы Зөрчлийн хуулиар төрийн албан хаагчид хахууль өгөх журмыг зөрчих болно.

чухалчлан урьдчилсан мэдээллийг хангалттай авалгүй зах зээлд оролцох, гэрээ байгуулахгүй байх зэргээр бэлтгэл ажилдаа хангалттай анхаараагүй дутагдал түгээмэл байсан байна.

Японы ЭСЯ дээр хуулийн зөвлөгөө өгдөг өмгөөлөгч хууль тогтоомжийн нийцлийн талаарх Японы зарим компаний ойлголт хангалтгүй байгааг өгүүлж байлаа.

(6) Энэхүү судалгааны хүрээнд боловсруулсан өөрийн үнэлгээний хуудасны товч агуулга

(1) ба (2)-г өгүүлсэнчлэн одоогийн компаний засаглалтай холбоотой материал ба өөр ийн үнэлгээний хэрэгсэл нь өмчлөл ба менежментийн заагтай, олон хувьцаа эзэмшигч бүхий хөрөнгийн зах зээлд гарч буй ААН-д зориулагдсан байна. Гэр бүлийн компани болон ЖДҮ-ийн хувьд цөөн хувьцаа эзэмшигч байхгүй байх тохиолдол элбэг, мөн өмчлөгч ба менежмент нь нэг байх тул хөрөнгийн зах зээлд гарсан компанид зориулсан засаглал тохирохгүй байх нь элбэгээс Монголын ЖДҮ-ийн тохиолдолд асуулгаар тодруулсанчлан төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн мониторинг хийхэд хүндрэлтэй ААН олон байдаг гэсэн асуудал гарч ирж байгаа юм.

Дээр өгүүлсэнчлэн одоо байгаа материал, асуулга, судалгааны үр дүнг ашиглан Монголын ЖДҮ-т тохиромжтой гэж үзсэн өөрийн үнэлгээний хуудсыг боловсруулсан болно.

Энэ ажлын явцад ЖДҮ-г ч тохируулан боловсруулсан Тайландын Худалдааны яамны өөрийн тайлангийн хуудаснаас санаа авч, Монголын ААН-дэд тулгарч буй асуудлуудыг нэмж оруулан 40 зүйл заалттай эх боловсруулав. Үүний дараа Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн дэмжлэгээр 25 зүйл заалттай болгож цэгцлэв. Уг эхэд компанийн нийгмийн хариуцлагын тухай заалт байсан боловч өөрийнх нь компани оршин тогтнох гэж зүтгэсээр хаанаа ч хүрэлцэхгүй байгаа тул нийгэмд хувь нэмэр оруулах боломж алга гэх санал гарч байсан тул хассан болно. Тэрчлэн ёс зүй, хууль тогтоомжийг сахин мөрдөх асуудлын хувьд асуулт тавьсан ч өнгөц хариулт өгөх тул асуултаар дамжуулан ойлгуулах ач холбогдолтой гэж үзэн үлдээсэн болно.

Мөн үнэлгээний хуудсыг боловсруулахдаа ① компаний засаглалын талаар хангалттай мэдлэггүй компани ч өөрийн үнэлгээг хялбар хийх боломжтой байхаар асуултаа хялбар болгож, нийт 25 асуултаар хязгаарлан, ② өөрийн үнэлгээний үр дүнд компанийхаа сул талыг хэрхэн сайжруулахаа ойлгож авахуйцаар анхаарал хандуулсан.

Түүнчлэн санхүүгийн байгууллага болон том компаниуд арилжаа хийхдээ ЖДҮ-ээр үнэлгээний хуудас бөглүүлэн гаргуулж авдаг болсоноор компаний засаглал нэвтэрсэний үр дүнд арилжаа саадгүй явагддаг болно гэж үзсэн болно.

Ийнхүү судалгааны багаас боловсруулсан 11 үзүүлэлттэй өөрийн үнэлгээний хуудсыг хүснэгт-4.13-д харуулав.

Хүснэгт 4.13 Судалгааны хүрээнд боловсруулсан өөрийн үнэлгээний асуулгын агуулга

Асуулт	Ангилал	Тайлбар	Оноо
1 Компани Эрхэм Зорилго, Алсын Хараа, Үнэт Зүйлсээ тодорхойлж баримтжуулсан ба бүх ажилчид тэдгээрийг мөрдлөгө болгож ажилладаг.	Алсын хараа, эрхэм зорилго	Алсын хараа, үнэт зүйл, эрхэм зорилгоо тодорхойлох нь компанийн удирдлагад өдөр тутмын асуудлуудаас салж, урт хугацааны зорилгоо тодорхойлсны үндсэн дээр тэр зорилгодоо нийцүүлэн богино болон дунд хугацааны ажил дээрээ төвлөрөхөд нь тусалдаг.	4
2 Компани 3-5 жилийн бизнесийн төлөвлөгөөтэй.	Төлөвлөгөө, хяналт	Компанийн урт хугацааны амжилтад нэн шаардлагатай бичиг баримтууд (бизнесийн төлөвлөгөө, жилийн төсөв, компанийн бүтэц, г.м.)-ыг бэлдэх нь компани ирээдүйгээ төлөвлөхөд хэрэгтэй байдаг. Мөн эдгээр төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах хяналтын системтэй байх хэрэгтэй.	28
3 Компанийн бүтэц, зохион байгуулалт тодорхой.			
4 Удирдлага нь компанийн давуу, сул талууд, мөн тухайн салбарын чиг хандлагын талаар хангалттай мэдээлэлтэй байдаг.			
5 Гол ажилтнуудын орлох ажилтанг бэлддэг.			
6 Компанийн үйл ажиллагааны үр дүнг удирдлагын зүгээс хянах болон үнэлэх тогтолцоо бүрдсэн.			
7 Банкнаас мөнгө зээлэхээс өмнө бид заавал тухайн мөнгийг юунд хэрэглэх, эргэн төлөлтийг хэрхэн хийх талаар төлөвлөдөг.			
8 Манай компани нягтлан бодох бүртгэлийн програм ашигладаг.			
9 Шийдвэр гаргалт нэг хүн дээр төвлөрөөгүй.	Шийдвэр гаргах тогтолцоо	Компанийн гол шийдвэрүүд хэрхэн хийгддэг, эрх мэдэл ганц хүний гарт төвлөрсөн эсэх, удирдлагуудын эрх мэдлийн зааг ялгаа тодорхой эсэхээс компанийн үйл ажиллагааны үр ашиг болон үр дүн ихээхэн хамаарна.	8
10 Хувьцаа эзэмшигчид болон удирдлагын багийн гишүүдийн эрх мэдлийн хуваарилалт тодорхой.			
11 Хээл хахууль болон хууль зөрчсөн үйлдэл хийхээс зайлсхийдэг.	Хууль, журам	Хэрэгжиж буй хууль, журмыг мэдэж, дагаж мөрдөх нь компани урьдчилж таамаглаагүй торгууль, төлбөрт орохоос сэргийлдэг. Мөн ихэнхи томоохон байгууллагууд болон банк санхүүгийн байгууллагууд нь хуулийг дагаж мөрддөггүй компаниудтай харилцахаас зайлсхийдэг.	12
12 Татвар болон нийгмийн даатгалын шимтгэлээ үнэн зөвөөр мэдүүлж, цаг тухайд нь төлдөг.			
13 Үнэн зөв санхүү, татварын тайланг Татварын Ерөнхий Газар болон Сангийн Яам руу илгээдэг.			
14 Компанид ёс зүйн дүрэм, журам	Ёс зүй	Компанийн нийгмийн хариуцлага	4

	байгаа бөгөөд бүх ажилчид тэдгээрийг мөрдлөгө болгож ажилладаг.		илүү чухал болж байгаа өнөө үед, өндөр ёс зүйн зарчимтай компаниуд хөрөнгө оруулагч, харилцагч татахад илүү хялбар байдаг. Хэрэв та компани дотооддоо өндөр ёс зүйн зарчимтайгаар үйл ажиллагаа явуулдаг гэж бодож байвал, энэ талаар өөрийн цахим хуудас зэрэгтээ зарлах нь зохистой юм.	
15	Компанийн удирдлага дараа үеийн удирдлагын талаар төлөвлөгөөтэй.	Гэр бүлийн засаглал	Ихэнхи жижиг аж ахуйн нэгжүүд нь нэг хүн, эсвэл нэг гэр бүлийн хүчин чармайлтаар одоогийн амжилтандаа хүрсэн байдаг. Гэвч анхан үеийн бизнес эрхлэгчид ихэнхи нь нас өндөр болсон эсхүл бизнес нь өргөжин тэлж, бүх асуудалд ганцаараа ороод байх боломжгүй болсон тул одооноос дараа үеийн удирдлагын талаар төлөвлөгөөг боловсруулж эхлэх шаардлагатай юм. Одоо л төлөвлөж эхлэхгүй хойшлуулах юм бол хоцрох, бизнесээ эрсдэлд оруулах магадлалтай. Мөн, гэр бүлийн гишүүдийг ялгавартай нөхцөлтэйгээр ажилд авах, цалинжуулах нь бусад ажилчдын урмыг хугалах, чадварлаг ажилчид ажлаас гарах шалтгаан болдог тул гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлтийн талаар баримтлах бодлого, компанийн нийт ажилчдын гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг асуудлаар тодорхой бодлоготой байх хэрэгтэй.	12
16	Компанийн эзэд өөрийн хувийн санхүү болон компанийн санхүүг салгаж, тус тусад нь удирддаг.			
17	Компанийн удирдлагын хамаатан, гэр бүлийн гишүүдийг ажилд авахад дагаж мөрдөх бодлого нь тодорхой байдаг.			
18	Бүх ажилчид өөрийн ур чадварт нийцсэн үүрэг хариуцлага болон ажлын байртай.	Ажилчид	Ажилчид бол аливаа компанийн үнэтэй хөрөнгө билээ. Тиймээс, ажилчидтайгаа шударгаар харьцаж, мэдээлэл чөлөөтэй солилцож, үйл ажиллагааны талаар тэдний саналыг сонсож байх нь компанийн амжилтанд шууд нөлөөлдөг.	12
19	Үйл ажиллагааг сайжруулах талаар ажилчид саналаа удирдлагад хүргэх тогтолцоо байгаа.			
20	Компани хөдөлмөрийн журамтай, мөн бүх ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг.			
21	Бид оролцогч талуудынхаа сэтгэл ханамж болон харилцан ойлголцлыг эрхэмлэж ажилладаг.	Оролцогч талууд	Урт хугацаанд амжилттай үйл ажиллагаагаа явуулахын тулд, компани бүх оролцогч талуудтайгаа шударга, хүндэтгэлтэй байдлаар харьцах шаардлагатай. Оролцогч тал гэдэг нь компани үйл ажиллагаагаа явуулахад оролцдог бүх эдгээдүүдийг хэлнэ (үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч, банк, төрийн байгууллага, г.м.).	4
22	Бид тулгарч болзошгүй бүх эрсдлийг урьдчилан таамаглаж, үр нөлөөг нь бууруулах талаар арга хэмжээ авдаг.	Эрсдлийн удирдлага	Хэдий өөдрөг үзэлтэй байх нь сайн боловч, тулгарч болзошгүй бүх эрсдлүүдийг урьдчилан таамаглаж, боломжит хэмжээнд үр нөлөөг нь бууруулж байх хэрэгтэй.	4

23	Компанийн талаар мэдээллийг цахим хуудсандаа (эсвэл Facebook, Twitter, Аж үйлдвэрийн нэгдсэн систем г.м.) байршуулсан.	Ил тод байдал	Хэрэв танай компани нийгэмд хэрэгтэй зүйл хийж байгаа л бол үүнийг олон нийтэд мэдээлэх нь компанид хэрэгтэй юм. Энэ удаагийн ЖАЙКА-ийн судалгааг хэрэгжүүлж байхад, бидний ярилцлага хийсэн ихэнхи Япон компаниуд Монгол компаниудын талаар үнэн зөв мэдээлэл (санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшил, г.м.) олж авахад маш хэцүү байдаг талаар ярьж байсан.	8
24	Хэрэглэгч, нийлүүлэгч, банк, мөн төрийн байгууллагаас хүсэлт ирсэн тухай бүрт компани үнэн зөв мэдээллийг гаргаж өгдөг.			
25	Компани үйл ажиллагаагаа явуулахдаа ус, тогны хэрэглээ, бохирдол, хаягдал усыг аль болох бага байлгахад анхаарч ажилладаг.	Байгаль орчин	Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийн зүгээс компанийн байгаль орчинд үзүүлэх нөлөөн дээр илүү өндөр шаардлагуудыг тавьж байгаа билээ. Компани энэ чиглэлээр анхаарч ажилласнаар байгаль орчинд сайн нөлөө үзүүлэхээс гадна гадны хөрөнгө оруулалт татахад тустай байх болно.	4
				100

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны багын боловсруулсан өөрийн үнэлгээний асуулгын

ЖДҮ-үүд 66-аас дээш оноо авбал (томоохон компани 75 буюу түүнээс дээш оноо) сайн засаглалтай, 33-65 оноо дунд зэргийн засаглалтай. 32-оос доош оноотой бол засаглалаа сайжруулах шаардлагатай гэж дүгнэнэ.

(7) Воркшопын хэрэгжилт ба санал хүсэлт

2018 оны 6-р сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Компанийн засаглалын воркшоп нь ЖДҮ-ийг дэмжих сэдвийн доор ҮХГ-тай хамтран төлөвлөж “Баялаг бүтээгчдийг дэмжих цогц бодлого, экспортын арга замууд” чуулга уулзалттай хамтран хавсралтад тайлбарласны дагуу зохион байгуулсан. ҮХГ-тай хамтран зохион байгуулсан энэхүү семинарт нийслэл, орон нутгийн 200 гаран аж ахуй нэгжийн төлөөлөл оролцсон томоохон хэмжээний⁵⁹ семинар болсон.

Хөтөлбөрийн тухайд үдээс өмнө “Баялаг бүтээгчдийг дэмжих цогц бодлого, Монгол экспорт хөтөлбөрийн тухай илтгэл, хэлэлцүүлгийн дараа “Монгол улсын бизнесийн орчны суурь судалгаа, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийн тухай” илтгэл болон ЖДҮ-ийн компанийн засаглалтай холбоотой хэлэлцүүлгийг бүх оролцогч нарын дунд зохион байгуулсан.

Үдээс хойш 2 салбар хэлэлцүүлэгт хуваагдан явагдсан. Судалгааны баг хүснэгт 4.14-т үзүүлсэнчлэн судалгаанд холбоотой ЖДҮ-ийн компанийн засаглалын воркшоп, ҮХГ нь Аж үйлдвэрийн мэдээллийн сангийн систем, ЖДҮ-ийн хөгжүүлэхтэй холбоотой хэлэлцүүлгийг хийсэн. Судалгааны багийн воркшопд оролцсон оролцогчид (нөгөө хэсгийн семинарын

⁵⁹ ҮХГ-тай хамтран зохион байгуулсан тул ҮХГ-ын хэсгийн семинарт оролцсон зарим оролцогчдын тоог тодорхой авч чадаагүй болно.

оролцогчид орж гарч байсан) 50-60 хүн байсан ба эцсийн байдлаар өөрийн үнэлгээний асуулгыг 100% бөглөсөн 34 оролцогч байсан. Воркшопд оролцсон 56 оролцогчид “Тэрчилгээ” олгосон ба нэг аж ахуй нэгжээс олон хүн ирж оролцсон тохиолдлууд байсан ба нийлээд 1 өөрийн үнэлгээний асуулгыг бөглөсөн.

Воркшопд Улаанбаатар хот болон орон нутгийн ЖДҮ-үүд голчлон оролцсон ба зарим нэг ТББ, компанийн засаглалын холбогдох байгууллага болон Монголд үйл ажиллагаа явуулдаг Японы компаниуд оролцсон юм. ҮХГ-тай хамтран зохион байгуулснаар өргөн хүрээнд орон нутгийн ЖДҮ-үүд, аймгуудын худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөгч нар, компанийн засаглалд ихээхэн анхаарал хандуулдаг ОУСК, ГОУХАН, Монгол дахь Америкийн худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг олон улсын байгууллагуудын оролцоо нэмэгдэж, воркшопын (салбар хэлэлцүүлэг) оролцогчдоос гадна, семинарын бүх оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлэгт оролцсон 200 гаруй оролцогч нарт компанийн засаглалын талаар таниулан түгээж чадсан ба үүний үр дүнд үдээс хойших воркшопд оролцох сонирхлыг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөлсөн.

Хүснэгт 4.14 Компанийн Засаглалын воркшопын хөтөлбөр

Цаг	Агуулга
12:10-12:30	“Монгол улсын бизнесийн орчны суурь судалгаа, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийн тухай” ЖАЙКА-ийн судалгааны багийн ахлагч МАСАЮКИ ИШИДА Модератор: Ж.ҮНЭНБАТ - Монголын банкны холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Панелист: Б.БАЯРСАЙХАН - Үндэсний хөгжлийн газрын дарга Панелист: М.ИШИДА - ЖАЙКА судалгааны багийн ахлагч Панелист: Б.БАТБАЯР - Зээлийн батлан даалтын сангийн захирал Панелист: Д.ГАНБАЯР - Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Панелист: Ч.БОЛОРМАА - Сангийн яам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын Панелист: Х.ТУНГАЛАГМАА - Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Сургалт судалгааны менежментийн хорооны дарга
13:00-14:00	ҮДИЙН ЗООГ
Жич: Үдээс хойш Судалгааны баг, ҮХГ-ын хоёр салбар хэлэлцүүлэгт хуваагдан семинарыг үргэлжлүүлсэн. Доор зөвхөн судалгааны багаас зохион байгуулсан хэсгийг харуулав.	
14:00-14:10	Компанийн засаглал воркшопын нээлт, танилцуулга ИШИДА МАСАЮКИ Судалгааны багийн ахлагч
14:10-14:20	Компанийн засаглалын талаарх асуулга судалгааны явцын дүнгээс Г.ЭНХЖАРГАЛ ЖДҮ-ийн хөгжил хариуцсан зөвлөх
14:20-15:30	ЖДҮ-д тавигдах компанийн засаглалын шаардлага хэрэгцээ Модератор Э.ОЮУНБИЛЭГ Компанийн засаглалын хөгжлийн төв, Зөвлөх, ТУЗ-ийн гишүүн Панелист: Ж.ҮНЭНБАТ - Монголын банкны холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Панелист: Л.ГАНТӨМӨР - MCS Холдинг, Гүйцэтгэх захирал Панелист: Б.ҮНЭНБАТ - Мобиком корпораци, Санхүү эрхэлсэн дэд захирал Панелист: Г.БАТБААТАР - Оюу толгой ХХК, Худалдан авалтын газрын бодлого, стратегийн хэлтсийн менежер
15:30-15:50	ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА
15:50-16:50	Компанийн засаглалын “Өөрийн үнэлгээний асуулга” ашиглан үнэлгээ хийх ИНОУЭ КЭИТА - Бизнесийн орчны хөгжил хариуцсан зөвлөх
16:50-17:20	ЖДҮ-ийн компанийн засаглалын тухай Э.ОЮУНБИЛЭГ - Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Зөвлөх
17:20-17:30	Дүгнэлт, хаалтын мэндчилгээ ИШИДА МАСАЮКИ, Судалгааны багийн ахлагч

Эх сурвалж: ҮХГ

1) Хэлэлцүүлэг

Компаний засаглалын тухай хэлэлцүүлэг нь үдээс өмнө нийт оролцогчдыг хамарсан семинар хэлэлцүүлэг, үдээс хойш воркшоп хэлбэрээр 2 удаа зохион байгуулагдсан.

- (i) Өдрийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчид доор дурдсан санал бодлыг илэрхийлж байлаа.

Бизнесийн орчныг сайжруулах ба компанийн засаглал.

- Монголын ААН дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд орох зорилгыг биелүүлэх үүднээс IPO гаргах замаар хөрөнгө босгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд компанийн засаглалыг сайжруулах шаардлагатай. Мөн ААН-ийн зүгээс оролцогч талуудад эргэн мэдээлдэг (Feedback) тогтолцоог бий болгох шаардлагатай. Мэдээллийг харилцагчдад нээлттэй болгох нь ААН-ийн нийгмийн хариуцлагыг биелүүлэхэд хувь нэмэр болно. Иймэрхүү арга хэмжээг Үндэсний хөгжлийн газрын зүгээс дэмжиж ажиллах болно.

ЖДҮ-ийн компанийн засаглалын ач холбогдол

- Монголын ЖДҮ-үүд нь ихэнх тохиолдолд нэг хүний өмчлөлийн One man company байдаг тул компанийн засаглалын асуудал их гардаг. Гэхдээ зээлийн батлан даалтын сан зэрэг санхүүгийн байгууллагууд мэдээллийн ил тод байдлыг дэмжин хоёр давхар тайлан гаргахыг зөвшөөрөхгүй байх юм бол Монголын ЖДҮ-үүд дэлхийн зах зээлд гарах боломж нэмэгдэх болов уу.
- ЖДҮ-ийн хувьд Хэн, юуг, хэрхэн (Who, What, How) гэдэг нь хамгийн чухал асуудал бөгөөд төвөгтэй тогтолцоо шаардлагагүй. Харин хууль тогтоомжийг ягштал баримталж явах хэрэгтэй.
- Монголын ЖДҮ-ийн хувьд ч бизнесийг дараагийн үе залгамжлан авч явах цаг ирээд байна. Сайн засаглалтай байвал хурдан өсөж хөгжин зах зээлд эзлэх байр суурь өргөжнө. Дотоод аудит ба боловсон хүчний системийг бэхжүүлэх, баялаг туршлагатай зөвлөх авч ажиллуулах зэрэг арга хэмжээ нь бүгд компанийн засаглалтай холбогдоно. ЖДҮ-үүд хоорондын итгэлцэл тааруу байдаг. Мэргэжилтнээс үйлчилгээ, зөвлөгөө авах заншил

байдаггүй, итгэдэггүй зэргээс боломжийн зардал (opportunity cost) маш өндөр тусдаг.

- ЖДҮ-ийн хувьд мэдээллээ ил тод болгодоггүй асуудал нь зөвхөн Монголын онцлог бус Японд мөн байдаг. Мэдээллээ нээлттэй болгосноор өрсөлдөх чадвараа алдах айдастай байдаг хэдий ч ЖДҮ дараагийн шатанд ахихын тулд зайлшгүй ил тод байж боломжоо нэмэгдүүлэх шаардлагатай.

Давхар данс ба татвар төлөлт

- Сангийн яам нэлээд өмнөөс давхар дансны асуудлыг ЖДҮ-ийн хувьд хүндрэл багатайгаар шийдэх хүчин чармайлт гаргаж ирсэн. Сангийн яамны E-тайлангийн системд бүртгэлтэй ААН-үүдийн 95% нь ЖДҮ байна. Эдгээр ЖДҮ-дэд харьцангуй хялбар нягтлан бодох бүртгэлийн стандарт болох ЖДҮ-үүдэд зориулсан Олон улсын санхүүгийн тайлангийн стандартыг (IFRS for SMEs) авч хэрэглэхийг уриалж байгаа. Саяхан хүртэл улирал тутамд санхүүгийн тайлан гаргахыг шаарддаг байсан бол цаашдаа жилд 1 удаа гаргадаг болно. Давхар тайланг цөөрүүлэх үүднээс бүх оролцогч талууд нэг эх үүсвэртэй санхүүгийн тайлан гаргахыг шаардах шаардлагатай болох бөгөөд үүнийг Сангийн Яам хэрэгжүүлэх гэж байна.
- ЖДҮ нь татварын талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэн үнэн зөвөөр мэдүүлэх шаардлагатай боловч одоогийн байдлаар туйлын хангалтгүй байна. ЖДҮ-үүд үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжтой танилцан, түүнийг дагаж мөрддөг болох шаардлагатай.

Үдээс хойш болсон хэлэлцүүлэг дээр оролцогчид дараах санал бодлыг илэрхийлж байв.

ЖДҮ-ийн компанийн засаглалын талаар дараах зүйлд анхаарвал зохистой.

- Хөрөнгө оруулагчид болон банканд мэдээллээ нээлттэй болгож чаддаг, бизнесийн процесс нь ил тод, хяналт шинжилгээний тогтолцоотой, өмчлөгч нь хариуцлага хүлээдэг тогтолцоо байх нь зүйтэй юм. Хөрөнгийн зах зээлд гарсан компанид тавигддаг ТУЗ-тай байх зэрэг шалгуур ЖДҮ-т таарахгүй.

- Өнөөгийн байдалд Монголын арилжааны банкууд нийт харилцагчдын компанийн засаглалын үнэлгээг системтэй хийхгүй байгаа боловч хяналт шалгалтын шатанд албан бусаар компанийн засаглалтай холбоотой үнэлгээ багтсан байх нь элбэг. Түүнчлэн урт хугацаатай (1 жилээс дээш хугацаатай) тодорхой хэмжээнээс дээш зээл хүсэх (50 сая төгрөгөөс дээш) тохиолдолд бие даасан компанийн засаглалын үнэлгээ хийх нь түгээмэл байдаг.

Томоохон компаниуд ЖДҮ-ээс худалдан авалт хийх үеийн сонгон шалгаруулалтын үзүүлэлт

- Аюулгүй байдалтай холбоотой компанийн дотоод журам байдаг эсэх, хэрэгжүүлдэг эсэх. Бизнесийн ёс зүй, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил, худалдан авалтын гэрээ байгуулсан үед хариуцлагатайгаар ажил үүргээ гүйцэтгэж чадах эсэх гэсэн нөхцөл байх бөгөөд эдгээр нь компанийн засаглалтай холбогдоод явна. Сайн засаглал хэрэгжүүлж буй компани бол итгэж болох компани юм. Юуны өмнө дээрх агуулгатай уялдуулан компанийн дотоод журам боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.
- Чанар, зардал, санхүүгийн чадавхийг чухалчлан үздэг. Худалдан авалтын журмыг цахим хуудсанд байрлуулсан байх бөгөөд тендерийн процессийн талаар сэтгэл ханамжгүй асуудлыг дотоод аудитын хэлтэс, эсвэл эцэг компанид мэдэгдэх боломжтой.
- Чанар, зардал, итгэлийг чухалчлан үздэг. Итгэл гэдэг нь менежментийн багийн чанар, санхүүгийн чадавхи, хууль тогтоомж баримтлах зэргийг хэлнэ. Худалдан авалтын журам, гүйцэтгэгч компанид тавигдах нөхцөл, өөрийн компанийн ёс зүйн дүрэм зэргийг цахим хуудсанд тавьж, тендерт ялсан компанийн нэрийг ч бас цахим хуудсанд тавьдаг.

Монголын компанийн засаглалын одоогийн байдал ба асуудал.

- Засаглалын хэрэгцээ шаардлагын талаар ойлголт бий болоход хугацаа шаардагдаж байгаа боловч ахиц гарч байгаа.

- Олон улсын стандартын дагуу хэрэгжүүлэх шаардлагыг эрт ойлгосон тул богино хугацаанд өргөжүүлэн хэрэгжүүлж чадсан.
- Нийлүүлэлтийн сүлжээний хэмжээнд компанийн засаглалын хэрэгцээ шаардлагыг ойлгож чадвал туслан гүйцэтгэгч компанид хялбар нэвтрүүлж чадна.
- Компанийн засаглалын оронд “Итгэл” гэдэг үгийн хэлэлцүүлгийн хөтлөгч их ашигласан боловч ЖДҮ нь том компанийн итгэлийг олбол тухайн компанийн туслан гүйцэтгэгч нь болж цаашид өсөөд хөгжөөд явах боломж хангалттай бий.

2) Өөрийн үнэлгээний хуудсыг бөглөх ба дүгнэх

Өөрийн үнэлгээний хуудасны хувьд Workshop дээр цахим хуудсаар дамжуулан хариултыг цуглуулан авахаар болж, өөрийн үнэлгээний хуудасны зорилго ба дээр дурдсан 11 зүйл заалтын агуулгыг тайлбарласны үндсэн дээр 34 оролцогчоор бөглүүлж авсан болно. Өөрийн үнэлгээний хуудсыг бөглүүлсний үр дүнд дундаж оноо 69 оноо болж төсөөлж байснаас ихээхэн давж гарсан болно. (Гэхдээ хариултын хувьд өөрөө мэдүүлэх бөгөөд компанийн бодит байдалтай холбоогүй юм ч багтсан байх магадлалтай.) Асуулт тус бүрд хариулсан байдлыг хавсралтад харуулав.

4.5 ЖДҮ болон бичил аж ахуйн нэгжид “компанийн засаглал”-ыг нэвтрүүлж, сайжруулах ба түүний чиг хандлага.

Дээрх үр дүнгээс ЖДҮ-д “компанийн засаглал”-ыг дэлгэрүүлж, сайжруулах талаар дараах саналыг дэвшүүлж байна. 4.4.4-д тайлбарласны дагуу ЖДҮ-ийн “компанийн засаглал” гэдэг нь зөвхөн дотоод удирдлага, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах төдий бус гадаадын хөрөнгө оруулагч болон томоохон компанитай харилцаа үүсгэн, хамтран бизнес эрхлэхэд ач холбогдол бүхий зүйл юм. Энэхүү судалгааны хүрээнд зохион байгуулсан ЖДҮ-ийн “компанийн засаглал”-ын талаарх семинар нь Монгол Улсад олон зохиогддоггүй байж магадгүй юм. Цаашид ЖДҮ-ийн хэмжээнд ч компанийн засаглал бүрэн нэвтрэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр 4.2-д тайлбарласны дагуу Монголын Хөрөнгийн Бирж-д бүртгэлтэй компаниудын хувьд ч мөн адил “компанийн засаглал”-ын тухай ойлголт хангалттай бус байдалтай байгаа юм.

Иймд Монгол Улсад “компанийн засаглал”-ыг нэвтрүүлэхэд 10аад жил зарцуулагдаж магадгүй, “компанийн засаглал”-ыг нэвтрүүлэхэд урт удаан хугацаа зарцуулна гэдгийг бодолцон дунд болон урт хугацааны чиг хандлагын талаар дараах саналыг дэвшүүлж байна.

(1) ЖДҮ-ийн санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг хангах

Судалгааны явцад ЖДҮ-үүд нь Татварын алба болон Сангийн яамд зориулсан тайлан тооцоо болон компани дотоодоо хэрэглэдэг данс тооцоо гэсэн 2 төрлийн данс тооцоотой байх нь элбэг байсан. 2016 онд Татварын албанаас хэрэгжүүлсэн Эдийн засгийн өршөөл үзүүлэх тухай хууль болон Нэмүү өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд хэрэглэгч буюу хувь хүн худалдан авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тооцдог НӨАТ-ыг азтан шалгаруулах сугалаа зохион байгуулах замаар олгох урамшууллын систем болон тодорхой хувийг буцаан олгодог болсон. Мөн хэлэлцүүлгийн шатанд буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найрлагаар одоогийн нөхцөл байдлыг сайжрах магадлалтай хэдий ч ЖДҮ болон бичил аж ахуйн нэгжүүд 2 тайлантай байх эсвэл Татварын албанд тайлан тооцоогоо хийдэггүй байдалтай байна.

Нөгөөтэйгүүр 2010 онд шинэчлэгдэн батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (IFRS)-д нийцүүлнэ.” гэж зааж өгсөн байгаа ч Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад ЖДҮ-д (IFRS for SMEs) чиглэсэн стандартын нарийвчилсан дүрэм норм батлагдаагүй байгаа тул Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлж тайлан гаргах нөхцөл байдал мөн хоцрогдсон байдалтай байна. Мөн Аудитын хуулиндаа “үйлдвэрлэл” гэдэгт зөвхөн томоохон компанийг авч үзсэн байдаг учир ЖДҮ-ийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа эсэх талаарх ямар нэгэн баталгаа байхгүй.

Ийм нөхцөл байдалтай байгаа ЖДҮ-ийн санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг дээшлүүлэхийн тулд 4.15 хүснэгтэд дурдсанчлан бусад орны жишээг харгалзан үзэж, авч хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөг судлах хэрэгтэй.

Хүснэгт 4.15 ЖДҮ-ийн санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний жишээ

Бодлого, арга хэмжээ	Хэрэгжүүлж буй улс орон
Сангийн яамд E-Balance системээр дамжуулан хүргүүлсэн санхүүгийн бичиг баримтыг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг олон нийтэд нээлттэй болгох замаар санхүүгийн ил тод байдлыг хангах арга хэмжээ.	Сингапур, Тайланд
Компанийн нягтлан бодогчийн эзэмшсэн боловсрол, ажилласан жил нь шалгуур нөхцөлийг хангах тохиолдолд бүртгэлд хамруулах.	Хятад, Тайланд, Вьетнам
Аудитгүйгээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн бүртгэл.	Тайланд, Вьетнам, Мьянмар
Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн бүртгэл.	Лаос
Хууль, тогтоомжийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх хүрээг ЖДҮ хүртэл өргөтгөх.	Тайланд, Мьянмар
Бичил аж ахуйн нэгжид ашиглах нягтлан бодох бүртгэлийн стандартыг СТОУС-ыг бус худалдан авалтын зардал дээр үндэслэн хялбаршуулсан нягтлан бодох стандартыг хэрэглэх.	Япон, АНУ
Нягтлан бодох бүртгэлийн дэвтэртэй татвар төлөгчид татварын хөнгөлөлт үзүүлэх.	Япон
Компаниудад бүртгэл хөтлөлтийн талаар заавар зөвлөгөө өгөх.	Япон
Санхүүгийн байгууллагад хандан зөвхөн тухайн албанд санхүүгийн материалаа хүргүүлсэн компани-д зээлийн судалгаа явуулах боломжтой гэдэг тухай зааварлах.	Тайланд
Санхүүгийн мэдээллээ нэгтгэсэн компанид санхүүгийн байгууллагаас олгох зээлийн хүүг бууруулах.	Тайланд (төлөвлөлтийн шатанд буй)

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

(2) Санхүүгийн мэдээллийг ил тод болгохоос гадна компанийн засаглалын талаар сурталчлан таниулах

Өмнөх хэсгүүдэд дурдсанаас гадна хууль тогтоомжийг чанд мөрдөх, санхүүгийн мэдээллээс гадна бусад мэдээллийн ил тод байдал, зорилго, үзэл баримтлал, төлөвлөлт болон хяналт, шийдвэр гаргалт, эрсдэлийн удирдлага, ёс зүй, байгаль орчин гэх мэт тал дээр мөн адил компанийн засаглалыг сайжруулах шаардлагатай байна.

Эхлээд хууль тогтоомжийг чанд мөрдөх тухайд 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулиар хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд оногдуулах торгууль, шийтгэл тодорхой болсон. Ингэж нарийвчлан торгууль, шийтгэлийг зааж өгсөн тул бизнес эрхлэгчдэд хууль, тогтоомжийг зөрчихгүй байх талаар сануулж, зөрчсөн тохиолдолд авч хэрэгжүүлэх торгууль, шийтгэлийг шударгаар явуулах шаардлагатай.

Хүснэгт 4.16 Зөрчлийн тухай хуульд заагдсан торгууль шийтгэл

Хуулийн заалт	Агуулга
<p>11.18 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих</p>	<p>1.Аж ахуйн нэгж, байгууллага: 1.1.хуульд заасан бүртгэлийн стандартыг дагаж мөрдөөгүй; 1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтлөөгүй; 1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнаагүй; 1.4.аж ахуйн нэгж, байгууллага болон төлөөний газар нь санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөн тохиолдолд ажил, гүйлгээгээ гадаад валютаар бүртгэх, энэ тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлж тайлагнах үүргээ биелүүлээгүй; 1.5.гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах үүргээ биелүүлээгүй; 1.6.аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүргээ биелүүлээгүй; 1.7.санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авсан харилцагч санхүүгийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй; 1.8.харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлж байгаа санхүүгийн тайланг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, эсхүл ерөнхий нягтлан бодогч цахим гарын үсэг зурж баталгаажуулаагүй; 1.9.харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийх үүргээ биелүүлээгүй; 1.10.хуульд заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлээгүй; 1.11.нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн аж ахуйн нэгж, байгууллага нь жилийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд толгой компанийн харилцагч харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлээгүй; 1.12.нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архивын тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгалах үүргээ биелүүлээгүй; 1.13.нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын нийтлэг загвар, бүрдүүлэх аргачлал, удирдах байгууллагаар батлуулсан өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг мөрдөөгүй; 1.14.гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулах үүргээ биелүүлээгүй; 1.15.анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, эсхүл шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, /тэмдэг/ дарж баталгаажуулах, цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримтыг цахим гарын үсгээр баталгаажуулах үүргээ биелүүлээгүй; 1.16.анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэсэн, санхүүгийн тайланд тусгасан; 1.17.нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргаагүй; 1.18.нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтлөөгүй; 1.19.нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуульд заасан дарааллаар гүйцэтгээгүй, эсхүл заавал бүртгэх зүйлсийг бүртгээгүй; 1.20.аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгалах үүргээ</p>

	<p>биелүүлээгүй;</p> <p>1.21.нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах, уг залруулгыг зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулах, алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах үүргээ биелүүлээгүй;</p> <p>1.22.хуулиар эрх олгосон этгээдийн шаардсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаар нэмэлт тайлбар, тодруулгыг цаг тухайд нь, үнэн зөв гаргаж өгөөгүй;</p> <p>1.23.удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй;</p> <p>1.24.нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байх үүргээ биелүүлээгүй;</p> <p>1.25.ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p>11.19 дүгээр зүйл.Татварын ерөнхий хууль зөрчих</p>	<p>1. Татвар төлөгч хүн, хуулийн этгээд татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор:</p> <p>1.1.татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуун дарагдуулсан, эсхүл бусад хүн, хуулийн этгээдэд үндэслэлгүйгээр шилжүүлсэн, эсхүл нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулсан;</p> <p>1.2.татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийн тоо хэмжээ, үнийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд багасгаж тусгасан, эсхүл ийнхүү багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг үндэслэлгүйгээр өсгөсөн;</p> <p>1.3.нягтлан бодох, анхан шатны бүртгэл, татварын тайлан, холбогдох баримт бичгийг устгасан, эсхүл нуусан, эсхүл нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, холбогдох баримт бичгийг бүрдүүлэлгүй татварын тайлан гаргах боломжгүй болгосон;</p> <p>1.4.хуулийн этгээдийн нэр, хаяг, тамга, тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, эсхүл зөвшөөрөл, эд хөрөнгө, баримт бичгийг бусдад шилжүүлсэн, эсхүл ашиглуулсан бол татварыг нөхөн төлүүлж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Татварыг хугацаанд нь төлөөгүй бол хүн, хуулийн этгээдийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3.Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх үүрэг бүхий хүн, хуулийн этгээд харьяалах татварын албанд бүртгүүлж, гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн, эсхүл борлуулсан, эсхүл ажил гүйцэтгэсэн, эсхүл үйлчилгээ үзүүлсэн бол татварыг нөхөн төлүүлж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй, эсхүл ногдуулсан татварыг төлөөгүй бол татварыг нөхөн төлүүлж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэлгүй бараа үйлдвэрлэж, борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж тэдгээрт ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөөгүй бол татварыг нөхөн төлүүлж хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын дүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:</p> <p>6.1.хууль тогтоомжид заасан тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд гаргаж өгөөгүй;</p> <p>6.2.хуулиар татвар төлөх, суутгах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд</p>

	<p>татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлээгүй;</p> <p>6.3.хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд бүртгүүлж хувийн хэрэг нээлгээгүй;</p> <p>6.4.орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч, эсхүл эзэмшигч нь уг зүйлийг өмчилж, эсхүл эзэмшиж эхэлснээс хойш хуулиар тогтоосон хугацаанд мэдэгдэх, хувийн хэрэг нээлгэх, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх үүргээ биелүүлээгүй;</p> <p>6.5.Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>7.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:</p> <p>7.1.үл хөдлөх эд хөрөнгө худалдах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн өдрөөс хойш хуульд заасан хугацаанд харьяалагдах татварын албанд мэдэгдэх;</p> <p>7.2.хуулийн этгээдийн мэдээлэл, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрд өөрчлөлт орсноос хойш хуульд заасан хугацаанд татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;</p> <p>7.3.олгосон регистрийн дугаарыг татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан, мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн, эсхүл бусад шаардлагатай баримтуудад заавал тусгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>8.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:</p> <p>8.1.байнга, эсхүл түр оршин суугаа, аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаягаа буруу тодорхойлох;</p> <p>8.2.татварын албанаас дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;</p> <p>8.3.шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй алга болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаагаа үл мэдэгдэж татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн бол татварыг нөхөн төлүүлж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>9.Татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтны битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг:</p> <p>9.1.үрэгдүүлсэн;</p> <p>9.2.дур мэдэн бусдад шилжүүлсэн;</p> <p>9.3.гэмтээсэн;</p> <p>9.4.зөвшөөрөлгүйгээр худалдсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>10.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:</p> <p>10.1.шаардлагатай нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын мэдээ, холбогдох баримт бичгийг гаргаж өгөөгүй;</p> <p>10.2.байр, агуулахад нь нэвтрэн орох боломж олгоогүй;</p> <p>10.3.тооллого хийлгээгүй;</p> <p>10.4.ажлын зураг авалт, үзлэг, хөрөнгө барьцаалах, эсхүл битүүмжлэх үйл ажиллагааг хийлгээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>11.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд, аливаа банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж:</p> <p>11.1.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөөгүй;</p> <p>11.2.татвар төлөгч ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд ажил олгогч нь түүний гарсан өдрөөс хойш хуульд заасан хугацаанд татварын өрд</p>
--	---

	<p>суутгасан мөнгөний хэмжээ, хаана шилжсэнийг тэмдэглэж, төлбөрийн хуудсыг татварын албанд буцаах үүргээ биелүүлээгүй;</p> <p>11.3. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;</p> <p>11.4. татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах талаарх хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>12. Үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд нь бэлэн мөнгөний системийн хэрэглэгч гишүүнд бэлэн мөнгөний тасалбар олгоогүй, эсхүл олгохоос татгалзсан, эсхүл үнийн дүнгээс зөрүүтэй дүнгээр олгосон тохиолдолд:</p> <p>12.1. бэлэн мөнгөний бүртгэлийн тасалбар олгоогүй бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн хоёр хувь;</p> <p>12.2. бэлэн мөнгөний тасалбарыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>13. Хуульд тодорхойлсон аливаа системийг зохисгүй ашигласан, эсхүл албаны чиг үүрэгт хамаарах зорилгоос гадуур хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>14. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, хүнийг нөхөн төлүүлэх татварын 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Тайлбар: Энэ зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэгт заасан нөхөн төлүүлэх хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох ба уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.</p> <p>-Энэ зүйлийн 12 дахь хэсэгт заасан торгуулийг тухайн тайлант хугацаанд төлбөл зохих албан татвар дээр нэмж төлнө.</p>
--	--

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Санхүүгийн бус мэдээллийн ил тод байдал гэдэгт Япон болон бусад улс оронд хэрэглэгдэж буй Арилжааны бүртгэлийн системийг нэвтрүүлж, бүртгэлтэй компанийн мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй байхаар хууль тогтоомжид тусгаж өгөх хэрэгтэй. Эсвэл төрийн худалдан авалтыг ил тод байлгаж, засгийн газартай худалдаа хийх эрх бүхий бизнес эрхлэгчийн мэдээллийн санг боловсруулж тухайн компанийн мэдээллийг ил тод байлгах боломж бас бий. Нөгөөтэйгүүр, гадаадын улс орнуудад нэвтэрч буй Интеграцийн тайлангийн тухайд Монгол Улсад Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд ч авч хэрэгжүүлээгүй байгаа тул Монгол улсын ЖДҮ-д энэхүү систем нь нэвтэрч орж ирэхэд ихээхэн хугацаа зарцуулах болов уу гэж бодож байна.

Аж ахуй нэгжийн бүртгэлийн мэдээллээс гадна санхүүгийн бус мэдээлэл нь хуулиар тогтооход тохиромжгүй асуудал хөндөгдсөн байх талтай. Эдгээрийн талаар бизнес эрхлэгчид өргөн цар хүрээтэй мэдлэг өгөх, бизнес эрхлэгчидтэй зөвшилцсөний дээр компанийн засаглал төдийгүй тэдний шийдвэрт дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх нь тохиромжтой гэж бодож байна.

Гэхдээ энэ тал дээр банк, санхүүгийн байгууллага, томоохон компани болон гадаадын компанитай харилцагч ЖДҮ-дэд компанийн засаглал нэвтрүүлснээр үр шим хүртэх компаниудын тусламжтайгаар дангаар болон хамтарсан семинарыг зохион байгуулж болох юм. Түүнчлэн зөвхөн компанийн засаглалын зөвлөмж өгөх тохиолдолд бизнес эрхлэгчээс зардал гаргуулах боломжгүй тул мэргэшсэн нягтлан бодогч, татварын нягтлан бодогч, менежментийн зөвлөгч зэрэг бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгч хамтран ажилладаг мэргэжилтнүүдэд “компанийн засаглал”-ын сургалт явуулах (Training of Trainers) замаар бодит хэрэгжилтэд хүрэх боломжтой гэж бодож байна.

(3) Компанийн засаглалын хэрэгцээ, мэдээллээр хангах (Хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг гэх мэт)

“Компанийн засаглал” сайжруулснаар хүртэх үр өгөөжийг ЖДҮ эрхлэгчдэд тодорхой ойлгуулахын тулд 2 үе шаттай зээл, Монгол Улсын Засгийн газрын татаас болон хүүгийн хөнгөлөлттэй зээл авах, мөн Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслөөс экспортын санхүүжилтийн дэмжлэг авах шалгуур болгож, тодорхой хэмжээнд компанийн засаглалыг нэвтрүүлсэн эсэхийг шалгуур үзүүлэлт болгох талаар судалж үзэх боломжтой гэж үзэж байна. Энэ нь ЖДҮ-үүд “компанийн засаглал”-ыг бүрдүүлэхэд түлхэц болно гэж найдаж байна.

(4) Голлох байгууллагуудын хамтын ажиллагаа (Мэргэжлийн холбоод, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Олон улсын байгууллага гм)

Хүснэгт 4.4 дэхь “компанийн засаглал”-тай хамаарал бүхий холбоонуудаас гадна хүснэгт 4.17 д дурдагдсан мэргэжлийн холбоод байдаг ба хамтын ажиллагааны агуулгаас хамааран эдгээр байгууллагуудтай хамтрах боломж бий гэж бодож байна. “Компанийн засаглал”-ыг нэвтрүүлэхийн тулд цаг хугацаа ихээхэн зарцуулах боловч өргөн цар хүрээтэй байгууллагатай хамтран ажиллаж, “компанийн засаглал”-ыг нэвтрүүлэх орчныг бүрдүүлж, бага боловч сайжирна гэдэгт найдаж байна.

**Хүснэгт 4.17 Хүснэгт4.4-г зааснаас бусад “Компанийн Засаглал”-тай хамаарал
бүхий холбоо**

Ангилал	Нэр	Товчлол
Мэргэжлийн холбоо	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг	TM3H
	Монголын Өмгөөлөгчдийн холбоо	AMA
	Монголын үнэт цаасны шинжээчдийн холбоо	MSFA
	Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Холбоо	MMCI
Санхүү	Монголын Банкны Холбоо	MBA
	Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	ABTS NBFi
Боловсрол, сургалтын байгууллага	Монгол Япон Хүний нөөцийн хөгжлийн төв	MJC
	Санхүү, эдийн засгийн их сургууль	UFE
Худалдаа, үйлдвэр	Монгол дахь Японы Худалдааны танхим	
	Америкийн худалдааны танхим	AmCham Mongolia
Олон улсын хандивлагч байгууллага	Олон улсын санхүүгийн корпораци	IFC
	Азийн хөгжлийн банк	ADB
	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк	EBRD

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

5 Нэгдсэн дүгнэлт: Монгол улсын бизнесийн орчныг сайжруулах арга хэмжээ, зөвлөмж

Бизнесийн орчныг сайжруулахад зээлийн мэдээллийн хяналт, компанийн засаглал салшгүй холбоотой байдаг. Аль аль нь ЖДҮ, бичил аж ахуйн нэгжүүдийн хувьд хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бизнесийн өсөлтийн боломжийг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдын хувьд бизнесийн орчныг эрүүлжүүлж, хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах боломжийг олгодог. Зохистой компанийн засаглалтай аж ахуйн нэгжийн мэдээллийн найдвартай байдал хангагдаж, түүнд тулгуурлан зээлийн мэдээллийн үнэн зөв байдал сайжирна. Бизнесийн орчныг аж үйлдвэрийн бодит байдлаас эхлэн тогтвортой байдлыг бүрдүүлэхийн тулд зээлийн мэдээллийн хяналтын нэг болох ЗЭМС нэвтрүүлэхэд компанийн үйл ажиллагааг эрүүлжүүлэх асуудал туйлын ач холбогдолтой бөгөөд санхүүгийн тайлангийн хяналт бүхий компанийн засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь үйлдвэрлэлийн хөгжил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал үр дүнтэй гэж хэлж болно. Судалгааны үр дүнд тулгуурлан энэхүү хоёр чиглэлээр цаашдын чиг хандлагыг дараах байдлаар санал болгоно.

5.1 Зээлийн мэдээллийн хяналтын цаашдын чиг хандлага

(1) Монгол хувилбарын ЗЭМС-ын талаар авч хэлэлцэх нь

Энэ удаагийн судалгааны зээлийн мэдээллийн хяналтын салбарын хувьд ЗЭМС-ийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх семинар зохион байгуулж, хууль эрх зүйн байдлыг тодорхой болгохын зэрэгцээ банк санхүүгийн байгууллага болон бусад холбогдох байгууллагаас байгууллагын зээл, зээлийн судалгааны бодит байдалд түлхүү анхаарал хандуулан судалгаагаа явуулсан. Судалгаагаар 1999 оноос эхлэн нэвтрүүлсэн (одоогийн системийг 2009 оноос эхлэн нэвтрүүлсэн), Монголбанкны хяналтан дор явуулж байгаа нэр нь тодорхой зээлийн түүхийн мэдээллээс бүрдэх ЗМС нь байгууллага, иргэний зээлийн нийт мэдээллийг төв банкнаас банкуудыг хянах замаар нийт санхүүгийн салбарын үйл ажиллагааны нэг хэсэг болон хэрэгжиж ирсэн нь тодорхой болсон. Нөгөөтэйгүүр ЗЭМС-ийн хувьд арилжааны банк тус бүр дотоод үнэлгээ хийхдээ дээрх мэдээлэл дээр үндэслэн банкны дотоодын дүн шинжилгээгээр тооцоолон гаргасан үзүүлэлтүүдийг ашиглах тохиолдол болон банкны дотоод үнэлгээний загварт тоон үзүүлэлтийг нэвтрүүлэх тохиолдол, санхүүгийн салбар нийтээрээ нэгдсэн нэг мэдээлэлтэй түвшин, өөрөөр хэлбэл Японы ЗЭМС-ын бизнесийн орчинтой ижил биш хэдий ч банк тус бүрийн бодлогод нийцүүлэн эхний үе шатыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа нь

тодорхой болсон.

Семинар, уулзалт ярилцлагаар дамжуулан банк, санхүүгийн байгууллагууд ерөнхийдөө ЗЭМС-г шинээр нэвтрүүлэх сонирхолтой байгааг олж тогтоосон боловч Монголбанкны зарим удирдлагаас "Монгол бол жижиг улс, цөөн компанитайгаас гадна банкны зээлээс хамааралтай үнэмлэхүй тоо нь Японтой харьцуулахад маш бага, олон тооны регрессийн загварт тулгуурласан ЗЭМС үр дүнтэй ажиллах эсэхийг сайтар нягталж үзэх шаардлагатай. Монгол улсад тохирох ЗЭМС-г ямар хэлбэрээр нэвтрүүлэх боломжтой вэ гэдэг нь ч маш чухал асуудал" гэсэн санал тавьсан.

Үнэхээр байгууллагын зээлийн тоо Монгол улсын хэмжээнд жилд 6000 орчим, томоохон 4 арилжааны банкнаас олгогдож буй зээлийн тоо тус бүр 1000-1500 байдгийг харгалзан банк тус бүрийн өгөгдлийн мэдээллийн тоонд тулгуурласан банкны дотоодын ЗЭМС хязгаарлагдмал болохыг анхаарч үзэх шаардлагатай. Түүнчлэн томоохон 4 банкнаас бусад банк санхүүгийн байгууллагын хувьд ЗЭМС-ын олон тооны регрессийн дүн шинжилгээнд ашиглаж болохуйц мэдээллийг ганц мөр ч болов олж авахад хүндрэлтэй гэж үзэж байна.

Энэ утгаараа олон төрлийн өгөгдлийн мэдээллийг нэгдсэн байдлаар ашиглах Япон маягийн ЗЭМС нь Монгол улсад тэр тусмаа зайлшгүй байх ёстой тогтолцоо байх өндөр магадлалтай. Нөгөөтэйгүүр банк санхүүгийн салбар нийтдээ ихээр бодоход 300,000 мэдээллийн өгөгдлийг (6,000 ААН ×5 жил) дээд хязгаар гэж үзвэл Монголбанкнаас гарсан саналаас харагдаж байгаачлан хэсэг бүлэг мэдээлэлд тулгуурласан аж үйлдвэрийн салбарын дүн шинжилгээний шалгуур үзүүлэлтийг ашигласан мэргэжлийн загварт (expert model) тулгуурласан загварыг нэвтрүүлэх асуудлыг авч хэлэлцэхэд илүүдэхгүй болов уу. Аж үйлдвэрийн салбарын дүн шинжилгээний хувьд ХХААХҮЯ-ны ЖДҮ-ийн мэдээлэл, ҮХГ-ын Аж үйлдвэрийн мэдээллийн сан, МҮХАҮТ-ын гишүүн аж ахуйн нэгжийн мэдээлэл зэрэг хамтран уялдуулах бололцоотой мэдээллийн сан хэдийнээ байгаа бөгөөд байгууллага тус бүр ЗЭМС нэвтрүүлэх асуудлыг нэлээд сонирхож байгаа нь цаашдын хамтын ажиллагаа болон ЗЭМС-ын үйл ажиллагааны бүтцийг авч хэлэлцэхэд нэлээд дөхөмтэй гэж хэлж болно. Цаашид Монголын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон зээл авах, зээлийн эргэн төлөлтийн бодит байдлыг тусгасан Монголын орчинд хамгийн тохиромжтой шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, Монгол маягийн ЗЭМС-ийн талаар сайтар авч хэлэлцэх нь зүйтэй.

(2) Байгууллагын зээлийн хүүг оновчтой тогтоох арга хэмжээг хэлэлцэх нь

Энэ жилийн 5 сард УИХ-ын Эдийн засгийн Байнгын Хорооноос Монголбанкинд арилжааны банкны зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулах үүрэг болгосончлон жилийн 25-26%⁶⁰ түвшинд байгаа зээлийн хүүг бууруулах асуудал туйлын чухал асуудал болоод байна. Зээлийн хүүгийн асуудал нь үр дүнтэй, оновчтой байх гэсэн зээлийн шалгуурыг сайжруулах асуудал төдийгүй, хөрөнгийн эх үүсвэр татах зардлыг бууруулах, оновчтой барьцааны үнэлгээг тооцох, барьцаа хөрөнгө гаргах, арилжааны банкны үйл ажиллагааг үр дүнтэй болгох зэрэг хэд хэдэн асуудлыг давхар шийдэж байж шийдвэрлэгдэх асуудал бөгөөд ЗЭМС нэвтрүүлэх нь бас нэгэн хувь нэмэр болох бололцоотой гэдэг ойлголтыг дэлгэрүүлэхийн зэрэгцээ түүний арга хэлбэрийг сайтар авч хэлэлцэх нь зүйтэй.

Эргэн төлөлт хийгдэх бололцоогүй буюу дефолтын магадлалыг (Default Probability) тооцох ЗЭМС нь зээлийн эрсдэлийг бодитоор тооцоолж чадна. Ингэснээр хэт туйлширч хэлэх юм бол тооцоолон гаргасан дефолтын магадлал дээр тодорхой хувь (spread) нэмж зээлийн хүүг тооцвол эрдлийг бууруулан, арилжааны банкны үр ашиг тогтвортой байх бололцоотой болно. Бодит байдал дээр ЗЭМС нэвтрүүлэхэд амархан биш хэдий ч багаар бодоход зээл авах байгууллагын эрсдэл бүр дээр зээлийн хүүг хувирамтгай байдлаар тогтоох боломжтой болбол, зээлийн хүүг бууруулахад нэлээд их нэмэр болох нь дамжиггүй. Зээлийн мэдээллийн сан болон арилжааны банкуудын үнэлгээний шалгуур дээр тулгуурласан зээлийн шалгуур төдийгүй хөндлөнгийн тоон үзүүлэлт болох ЗЭМС нэвтрүүлэн зээлийн эрдлийг үнэлэх (scoring), зээлийн шалгуурт ашиглах шинэ тогтолцоог авч хэлэлцэх нь чухал.

(3) Үйл ажиллагааны журам буюу хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх

Өнөөгийн хууль эрх зүйн тогтолцоонд үндсэндээ ЗЭМС нэвтрүүлэхэд томоохон асуудал үүсэх зүйл байхгүй хэдий ч өгөгдлийн мэдээлэл авах, хянах, хувийн мэдээллийг хянах, үйл ажиллагаа явуулах институтийн хувьд нарийн дүрэм, журам тогтоох шаардлага үүснэ. Мэдээж Монгол маягийн ЗЭМС бий болгоход үйл ажиллагаа төдийгүй шинэ тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай шинэ институтийн үүрэг хариуцлага, төр хувийн хэвшлийн оролцооны гэрээний загвар зэрэг хууль эрх зүйн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. Засгийн газрын хувьд хууль эрх зүйн орчны зохицуулалт хийхээс гадна жишээ нь ЗЭМС нэвтрүүлэх тохиолдолд, одоогийн Зээлийн мэдээллийн сантай харилцан үр ашигтай ажиллаж байж хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх (тухайлбал, ЗБДС-ын батлан даалтын хувийг тооцоход

⁶⁰ Ерөнхийдөө 24-30% байгаа хэдий ч энд ярилцлага судалгаан дээр олон удаа давтагдсан дундаж хэмжээг оруулав.

ЗЭМС ашиглах гм) асуудлыг авч хэлэлцэх шаардлагатай. ААН-ийн хувьд компанийн засаглалыг нэвтрүүлэн, санхүүгийн тайланг үнэн бодитоор бүрдүүлэх асуудал чухал ач холбогдолтой бөгөөд эдгээрийн үр дүнд хөрөнгийн эх үүсвэр олоход амар болох, бизнесийн орчинг эрүүлжих, бизнесээ өргөжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлнэ. Засгийн газар энэ тал дээр түлхүү анхаарч, сурталчлах хэрэгтэй нь дамжиггүй.

(4) ЗЭМС нэвтрүүлэхэд чиглэсэн алхам

3 дугаар бүлэгт хэдийнээ ЗЭМС нэвтрүүлэхэд чиглэсэн ерөнхий зураглалыг авч хэлэлцсэн хэдий ч богино хугацаанд боломжийг авч хэлэлцэхэд тодорхой хэмжээний өгөгдөл мэдээлэлд тулгуурласан ЗЭМС-ын загварыг бодитоор турших анхан шатны чанарын судалгааг хийх зайлшгүй шаардлагатай.

Өмөн дурдсанчлан арилжааны банкууд хэдийнээ санхүүгийн тайлан болон хэрэгцээтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэн, зээлийн эрсдэлийн скоринг модель бий болгож эхлээд байна. Гэхдээ энэ удаагийн судалгаагаар арилжааны банк тус бүрийн мэдээллийн хяналтын журам болон тус бүрийн мэдээлэл ямар түвшинд, ямар өгөгдөлтэй мэдээллийг ямар хэлбэрээр нэгтгэж байгаа талаар нарийн тодруулж чадаагүй. Иймд Монголбанк голлон удирдан тодорхой нэг арилжааны банкнаас мэдээлэл авах орчныг бүрдүүлж, зээлийн харилцагч байгууллагын санхүүгийн тайлан болон холбогдох зээлийн мэдээллийг аван, ЗЭМС ашиглагдаж болох шалгуур үзүүлэлтэд хүрэх эсэхийг шалгаж үзэх анхан шатны чанарын судалгаа хийх нь чухал гэж үзэж байна. Анхан шатны чанарын судалгааг хийснээр тухайн үе шатанд үүсэх хууль эрх зүйн асуудал, менежмент явуулах институтийн асуудал зэрэг бодит туршилтаар ил болох асуудал байгаа нь тодорхой.

5.2 Компанийн засаглалын салбарын цаашдын чиглэл

Компанийн засаглал нь Компанийн үнэ цэнийг дээшлүүлэх урт хугацааны менежментийн тогтолцоо болохын тулд эхэн үеийн нэвтрүүлэх шатанд Менежментийн тогтолцоо, өөрөө хэлбэл удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, үйл ажиллагааны хяналтыг дээшлүүлэх замаар бизнесийг зөв гольдролд оруулах тал дээр анхаарал хандуулах тохиолдол элбэг. Тиймд менежментийн нөөц хязгаарлагдмал ЖДҮ-ийн хувьд компанийн засаглал нь дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх зардал гэсэн ойлголт нь түлхүү, үйл ажиллагаа болон бизнесийн асуудлыг нэн тэргүүнд тавих чиг хандлагатай нь маргаангүй. Өнөөг хүртэл олон улсын хандивлагч байгууллагын дэмжлэгийн ихэнхи нь томоохон компани руу чиглэсэн байдаг нь ЖДҮ нь цогц хэлбэрээр нь компанийн засаглалыг нэвтрүүлэхэд хэмжээний хувьд бага төдийгүй, иймэрхүү ойлголтын чиг хандлагаас дэмжлэг туслалцааны ач холбогдол эргэлзээ төрүүлдэг байсантай холбоотой. Энэ удаагийн судалгаагаар ЖДҮ талаас компанийн засаглалын давуу тал юу вэ, бизнес орчинд бодитой үр нөлөө үзүүлэх эсэх нь эргэлзээтэй гэсэн саналыг нэлээдгүй сонссон.

Гэхдээ энэ удаагийн судалгаагаар аж ахуйн нэгжүүдтэй хийсэн асуулга, ярилцлага судалгаа болон ялангуяа воркшоп дээр компанийн засаглал нь дотоод хяналт, удирдлагыг бэхжүүлэхийн зэрэгцээ гаднаас хөрөнгө оруулалт татах, томоохон аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, гадаадын компанитай түншлэл тогтоох, хамтрах зэрэг дээр найдвартай итгэл төрүүлэх ач холбогдолтой гэдэг ойлголтыг түгээж чадсан гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хамтран ажиллах хүсэлтэй хөрөнгө оруулагч (жишээлбэл, Японы компани) байгаа хэдий ч компанийн засаглал нь хангалтгүй байвал хамтран ажиллах шийдвэрт Японы төв оффис зөвшөөрөл өгөхгүй байх гэх мэт бизнесийн боломжоо алдах тохиолдол байдаг гэдэгт ЖДҮ эрхлэгчид анхаарал хандуулж эхэлсэн болов уу.

Ялангуяа, ЖДҮ эрхлэгчдээс гадна засаглалыг хөгжүүлэх, сурталчлах ажилд манлайлан оролцдог КЗХТ, КЗҮЗ, МҮХАҮТ зэрэг байгууллагатай нэгдсэн ойлголттой болохын сацуу ЖДҮ эрхлэгчдэд хандсан мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх тал дээр санал нэгдэж хамтран ажилласан нь энэхүү судалгааны нэг том үр дүн гэж үзэж байна. Түүнчлэн аль хэдийнээ эдгээр байгууллагуудтай хамтын ажиллагаа эхлүүлэн ажиллаж байгаа ҮХГ-тай хамтран ЖДҮ эрхлэгч буюу нийт баялаг бүтээгчдэд хандсан семинар зохион байгуулснаар ЖДҮ эрхлэгчдэд засаглалын талаар шинэ ойлголт, шинэ харах өнцөг төрүүлж чадсан гэж үзэж байна.

Цаашдын чиг хандлагын талаар 4 дүгээр бүлэгт тодорхой дурдсан байгаа хэдий ч дараах чиглэл, ялангуяа “Санхүүгийн тайлагналыг боловсронгуй болгох”, “Хууль эрх зүйг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээллийг түгээх”, “ААН-ийн мэдээллийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх”, “Холбогдох байгууллагууд хамтран мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх ” түүнчлэн ”Компанийн засаглалыг нэвтрүүлснээр хөрөнгийн эх үүсвэр, зээлжилтэд шууд нөлөөлөхүйц бүтэц, тогтолцоо бүрдүүлэх” зэрэг шийдвэрлэх нь чухал. Түүнчлэн Сангийн яамнаас санаачилж буй давхар тайланг халж хууль стандартад нийцсэн нэг санхүүгийн тайлан гаргадаг болгоход ч зээлийн мэдээллийн хяналт нэг талаасаа хэрэгцээтэй орчин бүрдүүлэх нэг хэсэг нь болох бөгөөд салгаж ойлгохын аргагүй тул цаашид эдгээрийг бодит ажил болгоно гэдэгт найдаж байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх, бэхжүүлэх бодлогын чиглэл

- Ил тод байдал болон бусад улсын туршлагаас нэвтрүүлэн санхүүгийн тайлагналыг боловсронгуй, найдвартай болгох
- Зөрчлийн тухай хууль гм хуулийн сурталчилгааг нэмэгдүүлэх
- Худалдааны бүртгэлийн тогтолцоо, төрийн худалдан авалтын шалгуур нөхцөл зэрэгтэй уялдуулах замаар ААН-ийн мэдээллийг нээлттэй болгох
- Мэргэжлийн нягтлан бодогч, татварын мэргэшсэн зөвлөх зэрэг зөвлөхүүдтэй хамтран мэдээлэл, сурталчилгааг түгээх, хамтран ажиллах
- Компанийн засаглалыг 2 шатны зээл гэх мэт хөнгөлөлттэй зээлийн шалгуур нөхцөл болгох

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт материал 1	Судалгааны хувиар
Хавсралт материал 2	Холбогдох хууль тогтоомж
Хавсралт материал 3	Компанийн засаглал

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1 СУДАЛГААНЫ ХУВААРЬ

Огноо	Гариг	Уулзалт хийсэн байгууллага
2018 оны 3 сар		
2018 оны 3-р сарын 6	Мягмар	МБ
2018 оны 3-р сарын 7	Лхагва	ЗБДС
2018 оны 3-р сарын 12	Даваа	МБ
2018 оны 3-р сарын 14	Лхагва	Арилжааны банк 1/ Арилжааны банк 2 /Арилжааны банк 3
2018 оны 3-р сарын 15	Пүрэв	Арилжааны банк 4 / ЖДҮХС
2018 оны 3-р сарын 16	Баасан	Арилжааны банк 5/ Арилжааны банк 6 / Лизингийн компани
2018 оны 3-р сарын 17	Бямба	
2018 оны 3-р сарын 18	Ням	
2018 оны 3-р сарын 19	Даваа	МБ хамтарсан ажлын хэсгийн уулзалт 1 / Арилжааны банк 1
2018 оны 3-р сарын 28	Лхагва	Хоккайдод байдаг Монголтой холбоотой компани 1 / ЖАЙКА Хоккайдо
2018 оны 3-р сарын 29	Пүрэв	Хоккайдод байдаг Монголтой холбоотой компани 2 / Хоккайдо Монголтой холбоотой компани 2
2018 оны 3-р сарын 30	Баасан	
2018 оны 3-р сарын 31	Бямба	Хоккайдод байдаг Монголтой холбоотой компани 4
2018 оны 4 сар		
2018 оны 4-р сарын 1	Ням	
2018 оны 4-р сарын 2	Даваа	Хоккайдод байдаг Монголтой холбоотой компани 4
2018 оны 4-р сарын 18	Лхагва	ББСБ 1
2018 оны 4-р сарын 19	Пүрэв	Арилжааны банк 7/ Арилжааны банк 8
2018 оны 4-р сарын 20	Баасан	ЖАЙКА / Арилжааны банк 9
2018 оны 4-р сарын 21	Бямба	
2018 оны 4-р сарын 22	Ням	
2018 оны 4-р сарын 23	Даваа	СЗХ / Арилжааны банк 10
2018 оны 4-р сарын 24	Мягмар	ХХААХҮЯ / ББСБ-ын холбоо
2018 оны 4-р сарын 25	Лхагва	Арилжааны банк 11/ МҮХАҮТ / СЯ/ МБ
2018 оны 4-р сарын 26	Пүрэв	МОНICPA/ МБ хамтарсан ажлын хэсгийн уулзалт 2
2018 оны 4-р сарын 27	Баасан	ҮХГ / Амрам / Хоккайдогын Монголтой холбоотой компани 4 / Арилжааны банк 12 /ТМЗН
2018 оны 4-р сарын 28	Бямба	
2018 оны 4-р сарын 29	Ням	
2018 оны 4-р сарын 30	Даваа	МБХ / Монгол Японы Хүний нөөцийн хөгжлийн төв

2018 оны 5 сар		
2018 оны 5-р сарын 2	Лхагва	Арилжааны банк 2
2018 оны 5-р сарын 18	Баасан	MITSUI & CO., LTD
2018 оны 5-р сарын 19	Бямба	
2018 оны 5-р сарын 20	Ням	
2018 оны 5-р сарын 21	Даваа	ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар
2018 оны 5-р сарын 22	Мягмар	СЯ-ны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар / Монгол дахь Япон улсын элчин сайдын яам (Хууль зүйн зөвлөгөө)
2018 оны 5-р сарын 23	Лхагва	ҮХГ
2018 оны 5-р сарын 24	Пүрэв	МБ хамтарсан ажлын хэсгийн уулзалт 3 / ХХААХҮЯ ЖДҮ-ийн газар /МБ-ны Дэд ерөнхийлөгч / МҮХАҮТ
2018 оны 5-р сарын 25	Баасан	МБ-ны Ганбаатар зөвлөх /О. Эрдэмбилэг Дэд ерөнхийлөгч / МБ-ны ХШГ-ын захирал Батсайхан / Монгол Базальт ХХК / Түмэн торго ХХК / Мицубиши корпораци Японы ХАҮТ / E-Mart LLC/
2018 оны 5-р сарын 26	Бямба	
2018 оны 5-р сарын 27	Ням	
2018 оны 5-р сарын 28	Даваа	Юүни газ ХК/ Метропласт ХХК / Говь ХК / Номин / MCS групп
2018 оны 5-р сарын 29	Мягмар	ЖДҮ-ийн хандивлагчдын уулзалт / CGDC / ЛІСА хээрийн судалгааны тайлан / АХБ
2018 оны 5-р сарын 30	Лхагва	Монгол Японы Хүний нөөцийн хөгжлийн төв (Бизнесийн маркетинг)
2018 оны 6 сар		
2018 оны 6-р сарын 12	Мягмар	Рендер ХХК / Монбакери ХХК
2018 оны 6-р сарын 13	Лхагва	
2018 оны 6-р сарын 14	Пүрэв	КЗҮЗ
2018 оны 6-р сарын 19	Мягмар	ББСБ 2
2018 оны 6-р сарын 20	Лхагва	КЗХТ / Мобиком ХХК
2018 оны 6-р сарын 21	Пүрэв	Монгол Японы Хүний нөөцийн хөгжлийн төв (Бизнесийн маркетинг) / МБ Ган-Очир захирал
2018 оны 6-р сарын 22	Баасан	МБ хамтарсан ажлын хэсгийн уулзалт 4
2018 оны 6-р сарын 27	Лхагва	Арилжааны банк 12
2018 оны 6-р сарын 28	Пүрэв	Арилжааны банк 2
2018 оны 6-р сарын 29	Баасан	ББСБ 3
2018 оны 6-р сарын 30	Бямба	

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 2 ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 1. Монголбанкны банкны хяналт шалгалттай холбогдох хууль
тогтоомжийн жагсаалт**
- 2. Зээлийн мэдээллийн тухай хууль**
- 3. Зээлийн мэдээллийн сангийн тухай журам (Монголбанкны
Ерөнхийлөгч 2005 оны 131 тоот тушаал)**
- 4. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах
журам**

1. МОНГОЛБАНКНЫ БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

Эрхзүйн акт	Нэр
Хууль	<ul style="list-style-type: none"> • Банкны тухай хууль • Зээлийн мэдээллийн тухай хууль • Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль • Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль
Журам	<ul style="list-style-type: none"> • Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам • Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам • Банкны нэгжийн журам • Хяналт шалгалтын зөвлөлийн ажлын журам • Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн батлах тухай • Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам • Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам • Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам • Банкны байгууллагын нягтлан бодох бүртгэл, төлбөр тооцооны зөвлөлийн ажиллах журам • Банкны дотоод хяналтын үйл ажиллагааны үлгэрчилсэн журам • Банкийг өөрчлөн байгуулахад баримтлах журам • Банкинд онцгой дэглэм тогтоох тухай журам • Банкнаас батлан даалт гаргахад мөрдөх түр журам
Зөвлөмж удирдамж	<ul style="list-style-type: none"> • Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж • Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги • Монголбанкны Хяналт шалгалтын газраас банкуудад явуулах газар дээрх шалгалтын нийтлэг удирдамж

	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны эрсдэлийг тооцох зөвлөмж • Зах зээлийн эрсдэлийг тооцоолох • Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зөвлөмж • Хүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зөвлөмж
<p>Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал</p>	<p>2016.12.13: Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах тухай</p> <p>2016.03.04: Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>2015.12.04: Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай</p> <p>2015.04.01: Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай</p> <p>2014.03.31: Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>2013.06.25: Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах тухай</p> <p>2012.06.07: Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай</p> <p>2011.12.30: Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд өөрчлөлт оруулах тухай</p> <p>2011.11.25: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны тухай</p> <p>2011.07.19: Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай</p>

2. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар сарын
20-ны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, хэрэглэгчид зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж

2.1.Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Төв Банк /Монголбанк/-ны тухай, Банкны тухай, Хувь хүний нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн хамрах хүрээ

3.1.Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон энэ хууль, гэрээнд заасан иргэн, төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдийн хооронд зээл, төлбөртэй холбогдон үүсэх мөнгөн төлбөрийн үүргийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавихад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“зээлийн мэдээлэл” гэж зээлдүүлэгчийн өмнө хууль, гэрээгээр хүлээсэн зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх мэдээллийг;

4.1.2.“зээлийн мэдээллийн сан” гэж Монголбанк болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн эзэмшиж байгаа зээлдэгчдийн зээлийн мэдээллийг;

4.1.3.“зээлдэгчийн зөвшөөрөл” гэж зээлдэгчээс энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд өгөхийг зөвшөөрсөн баримтыг;

4.1.4.“зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх” гэж зээлийн мэдээллийн санд хууль, гэрээнд заасан үндэслэлээр мэдээлэл цуглуулах, өөрчлөх, шинэчлэх, нэмэлт оруулах замаар зээлийн мэдээлэл боловсруулахыг;

4.1.5.“зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд” гэж Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.6.“зээлдэгч” гэж хууль, гэрээгээр төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өмнө зээл, төлбөрийн үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг;

4.1.7.“зээлдүүлэгч” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, түүнчлэн зээлдэгчээс гэрээ, эсхүл хуульд заасны дагуу зээл, төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий иргэн, хуулийн этгээдийг;

4.1.8.“мэдээлэл нийлүүлэгч” гэж зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зээлдэгчийн зээл, төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлж байгаа зээлдүүлэгч, төрийн байгууллагыг;

4.1.9.“хэрэглэгч” гэж зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр мэдээлэл авахыг хүссэн мэдээлэл нийлүүлэгч, иргэн, хуулийн этгээд, зээлдэгчийг;

4.1.10.“мэдээлэл өгөх, авах гэрээ” гэж зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх, уг сангаас мэдээлэл авах талаар мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн хооронд байгуулсан гэрээг;

4.1.11.“төрийн байгууллага” гэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, иргэн, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон татвар, нийгмийн даатгал, гааль, эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг;

4.1.12.“зээлийн лавлагаа” гэж зээлийн мэдээллийн сангаас цахим болон бичгийн хэлбэрээр хэрэглэгчид өгөх зээлийн мэдээлэл болон зээлийн түүхийн мэдээллийг;

4.1.13.“зээлийн түүх” гэж зээлдэгчийн хууль, гэрээгээр хүлээсэн зээл, төлбөрийн үүрэг, тэдгээрийн гүйцэтгэлийн талаарх цогц мэдээллийг.

5 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

5.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.хараат бус байх;
- 5.1.2.зээлдэгчийн зөвшөөрлийг заавал авсан байх;
- 5.1.3.мэдээллийг хууль болон гэрээний үндсэн дээр солилцох;
- 5.1.4.мэдээлэл үнэн зөв, тэгш, тэнцвэртэй байх;
- 5.1.5.мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ТҮҮНИЙГ БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ

6 дугаар зүйл.Зээлийн мэдээлэл

- 6.1.Иргэний зээлийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 6.1.1.овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар;
 - 6.1.2.оршин суугаа газрын хаяг;
 - 6.1.3.татвар төлөгч этгээд бол хувийн дугаар;
 - 6.1.4.ажил эрхлэлтийн байдал, ажлын газрын албан ёсны хаяг, утас, цахим шуудангийн хаяг;
 - 6.1.5.гэрлэлтийн байдал;
 - 6.1.6.зээл, төлбөрийн гэрээ байгуулсан он, сар, өдөр, гэрээний дугаар, төрөл, төлбөр гүйцэтгэх валютын нэр;
 - 6.1.7.зээл, төлбөр төлөх хугацаа, хуваарь, хүүгийн хэмжээ, хүлээгдэж байгаа хэвийн зээл, төлбөрийн дүн;
 - 6.1.8.гэрээний хугацааг хэтрүүлж гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгээгүй байгаа зээл, төлбөрийн дүн;
 - 6.1.9.барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаагаар хангагдсан, эсхүл хангагдах зээл, төлбөрийн дүн;
 - 6.1.10.эд хөрөнгийн улсын бүртгэлийн болон гэрчилгээний дугаар, он, сар, өдөр, эзэмшигч, өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, бусад шаардлагатай мэдээлэл;
 - 6.1.11.зээл, төлбөрийн үүргээс татгалзаж байсан бол татгалзсан шалтгаан;
 - 6.1.12.зээл, төлбөрийн үүрэг, түүнийг шаардах эрх гуравдагч этгээдэд шилжсэн бол шилжүүлсэн баримт бичгийн он, сар, өдөр, дугаар;
 - 6.1.13.зээл, төлбөрийн ангиллын талаарх мэдээлэл;

6.1.14.зээлдэгчийн зээлжих чадварын талаарх дүгнэлт;

6.1.15.зээл, төлбөрийн үүрэгтэй холбогдуулж Монголбанкнаас зээлийн мэдээлэлд хамруулах шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

6.2.Хуулийн этгээдийн зээлийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

6.2.1.оноосон нэр, монгол, англи хэл дээр болон товчилсноор;

6.2.2.улсын бүртгэлийн болон регистрийн дугаар;

6.2.3.оршин байгаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.2.4.татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

6.2.5.хувьцааны 25 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэх болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.2.6.толгой, хараат, охин компани болон тэдгээрийн Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан холбогдох этгээд, Компанийн тухай хуулийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, оршин байгаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.2.7.гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.2.8.бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрхэлсэн ажил;

6.2.9.энэ хуулийн 6.1.6-6.1.15-д заасан мэдээлэл.

6.3.Төрийн байгууллагын мэдэлд байгаа дараах мэдээллийг иргэн, хуулийн этгээдийн зээлийн мэдээлэлд хамруулна:

6.3.1.нийгмийн даатгал, татвар, гаалийн татварын төлөгдөөгүй, эсхүл хугацаа хэтрүүлж төлсөн өр, төлбөрийн дүн;

6.3.2.зээл, төлбөрийг албадан гүйцэтгүүлсэн бол албадан гүйцэтгэсэн зээл, төлбөрийн дүн, гүйцэтгэх ажиллагаа хийгдсэн он, сар, өдөр;

6.3.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэхээс санаатайгаар зайлсхийсэн, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэний улмаас эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолын он, сар, өдөр, дугаар;

6.3.4.улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусдад өгөхийг хуулиар хориглоогүй мэдээлэл.

6.4.Зээлийн мэдээллийн сантай солилцсон дараах мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд бүртгэнэ:

6.4.1.зээлийн мэдээлэл ирүүлсэн, шинэчилсэн, өөрчилсөн он, сар, өдөр, мэдээлэл өгсөн мэдээлэл нийлүүлэгч, зээлийн лавлагаа авсан хэрэглэгчийн тухай мэдээлэл;

6.4.2.хэрэглэгчийн зээлийн лавлагаа авсан зорилго, шалтгаан, бүртгэлийн дугаар.

7 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн эх сурвалж

7.1.Зээлийн мэдээллийн үнэн зөв эсэхийг дараах этгээд магадлана:

7.1.1.энэ хуулийн 6.1, 6.2-т заасан мэдээллийг зээлдэгч, мэдээлэл нийлүүлэгч;

7.1.2.энэ хуулийн 6.3-т заасан мэдээллийг холбогдох төрийн байгууллага;

7.1.3.энэ хуулийн 6.4-т заасан мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд.

7.2.Зээлдэгч, мэдээлэл нийлүүлэгч, төрийн байгууллага, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлийн мэдээллийг санаатайгаар буруу ташаа нийлүүлэх, бүрдүүлэх, мэдээлэхийг хориглоно.

7.3.Зээлийн мэдээллийн эх сурвалж буруу ташаа, бүрэн бус мэдээлэл агуулж байна гэж үзвэл зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд мэдээлэл нийлүүлэгчид нэн даруй мэдэгдэж шалгуулан, зөрчлийг арилгуулах үүрэгтэй.

8 дугаар зүйл.Зээлийн мэдээлэлд оруулахыг хориглох мэдээлэл

8.1.Зээлийн мэдээлэлд дараах мэдээлэл оруулахыг хориглоно:

8.1.1.зээлдэгчийн арьсны өнгө, нийгмийн гарал, шашин шүтлэг, улс төрийн нам, төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн байдал, эрүүл мэндийн тухай мэдээлэл;

8.1.2.зээлдэгчийн худалдаа, бизнесийн нууцлалтай холбоотой судалгаа, мэдээлэл.

9 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх

9.1.Зээлийн мэдээллийн сан бүрдүүлэхэд дараах журмыг баримтална:

9.1.1.зээлийн мэдээллийг зөвхөн зээлийн мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээд цуглуулах;

9.1.2.зээлийн мэдээллийг зээлдэгчийн зөвшөөрлийг үндэслэн мэдээлэл нийлүүлэгч зээлийн мэдээллийн санд өгөх;

9.1.3.зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэхэд мэдээлэл нийлүүлэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн хооронд мэдээлэл өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох;

9.1.4.зээлийн мэдээллийн санд зөвхөн энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цуглуулах;

9.1.5.зээлийн мэдээллийг энэ хуулиар зөвшөөрсөн арга, хэлбэрээр бүрдүүлэх;

9.1.6.зээлийн мэдээллийг тогтмол баяжуулан, шинэчилж байх;

9.1.7.банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох үүрэг хүлээх.

9.2.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл нийлүүлэгчээс бусад аливаа этгээдээс мэдээлэл авч зээлийн мэдээллийн санд оруулахыг хориглоно.

9.3.Зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг Монголбанкны зөвшөөрөлгүйгээр Монгол Улсаас авч гарах, гадаад улсад шилжүүлэхийг хориглоно.

10 дугаар зүйл.Зээлийн мэдээллийг ашиглах

10.1.Хэрэглэгч нь зээлийн мэдээллийг дор дурдсан зорилгоор ашиглана:

10.1.1.төрийн байгууллага нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг авч албан ажлын хэрэгцээнд ашиглах;

10.1.2.зээлдүүлэгч нь зээлийн эрсдэлийг үнэлэх зорилгоор зээлийн мэдээллийг авч ашиглах;

10.1.3.зээлдэгч зээл, төлбөрийн байдлаа хянах, санхүүгээ удирдан зохицуулах зорилгоор зөвхөн өөрт холбогдолтой зээлийн мэдээллийг авч ашиглах.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Зээлийн лавлагаа өгөх

11.1.Зээлдэгчийн сүүлийн зургаан жилийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд тусгах бөгөөд зээлийн лавлагааг гагцхүү хэрэглэгчид өгнө.

11.2.Хэрэглэгч зээлийн лавлагаа авах хүсэлтээ батлагдсан маягтын дагуу зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд гаргана.

11.3.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зөвхөн хууль, гэрээгээр зөвшөөрсөн хүрээнд зээлийн лавлагааг өгнө.

11.4.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлийн лавлагааг авах боломж бүрдүүлсэн компьютерийн программ хангамжийг ашигласан байна.

11.5.Хуулийн шаардлага хангасан итгэмжлэлийн дагуу зөвхөн хэрэглэгчээр бүртгэгдсэн этгээдэд зээлийн лавлагаа авах эрхийг шилжүүлж болох бөгөөд үүнээс бусад тохиолдолд уг эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

11.6.Мэдээллийг анх зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн мэдээлэл нийлүүлэгчийн нэр, оршин суугаа газрын хаяг, утас, цахим шуудангийн хаяг, мэдээлэл өгсөн он, сар, өдөр, мэдээлэл шинэчлэгдсэн хугацааг лавлагаанд заана.

11.7.Зээлийн мэдээллийн сангаас зээлийн лавлагаа өгөх тохиолдол бүрд зээлийн лавлагаа авагчийн нэр, зорилгыг мэдээллийн санд нэмж баяжуулна.

11.8.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс Компанийн тухай хуулийн 84.1-д заасан өөрийн эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигчийн талаарх зээлийн лавлагаа гаргаж өгөх журмыг Монголбанк тогтооно.

12 дугаар зүйл. Үйлчилгээний хөлс

12.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь үйлчилгээний хөлс авах эрхтэй бөгөөд үйл ажиллагааны зардал, эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан үйлчилгээний хөлсийг тогтоохдоо энэ хуулийн 23.4-т заасныг үндэслэнэ.

12.2.Зээлдэгч нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хандан зээлийн мэдээллийн сангаас өөрийн зээлийн лавлагааг жилд нэг удаа үнэ төлбөргүй авах эрхтэй бөгөөд үүнээс бусад тохиолдолд гэрээний үндсэн дээр үйлчилгээний хөлс төлнө.

13 дугаар зүйл. Гэрээний нөхцөл

13.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй байгуулах мэдээлэл өгөх, авах гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана:

13.1.1.мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн нэр, хаяг, банкин дахь харилцах дансны дугаар;

13.1.2.гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах, дуусгавар болгох, хүчингүй болгох нөхцөл;

13.1.3.зээлдэгчийн зөвшөөрлийг авсан эсэх;

13.1.4.зээлийн мэдээллийн төрөл, хэмжээ, хугацаа, зээлийн мэдээлэл нийлүүлэх, ашиглах талаар;

13.1.5.зээлийн мэдээллийг шинэчлэх, өөрчлөх талаар;

13.1.6.зээлийн мэдээллийн нууцлалыг хадгалах, эрх олгогдоогүй этгээдэд задруулахгүй байх, үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, хүлээх хариуцлагын талаар;

13.1.7.зээлийн лавлагаа өгөх, авах журам;

13.1.8.гэрээний талуудын эрх, үүрэг;

13.1.9.гомдол гаргах, маргаан шийдвэрлэх талаар.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ЭРХ, ҮҮРЭГ

14 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн эрхлэх үйл ажиллагаа

14.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

14.1.1.зээлдэгчтэй холбоотой энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цуглуулж зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх;

14.1.2.зээлийн мэдээллийн санд цуглуулсан зээлийн мэдээллийг боловсруулж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зээлийн лавлагаа, бусад бүтээгдэхүүн болгож борлуулах;

14.1.3.зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох;

14.1.4.зээлийн мэдээлэлд үндэслэн эдийн засаг, зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ хийх;

14.1.5.зээлийн мэдээлэлтэй холбоотой Монголбанкнаас зөвшөөрсөн бусад үйлчилгээ.

14.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь энэ хуулийн 14.1-д заасан болон Монголбанкны зөвшөөрснөөс бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

15 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хориглох үйл ажиллагаа

15.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

15.1.1.зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд, түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь зээлийн мэдээллийн санд хуримтлагдсан мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад тараах, задруулах, ашиглах;

15.1.2.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа явуулах, мэдээлэл өгөх.

16 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн эрх, үүрэг

16.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах эрхтэй:

16.1.1.зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасны дагуу зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах;

16.1.2.энэ хуулийн 22.1.1-д зааснаас бусад тохиолдолд зээлийн лавлагааг төлбөртэйгээр өгөх;

16.1.3.мэдээлэл нийлүүлэгчийн нийлүүлж байгаа мэдээллийн бүрдлийг хянаж, эргэлзээтэй, тодорхойгүй, бодитой бус байж болзошгүй мэдээллийг нягтлан шалгаж, шаардлага хангахгүй бол хүлээн авахаас татгалзах, дахин ирүүлэхийг шаардах;

16.1.4. тухайн этгээд нь мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч мөн эсэхийг гэрчлэх баримтыг шаардах, шалгах;

16.1.5. мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь зээлийн мэдээллийг хэрхэн ашиглаж байгаа талаар тайлбар авч, хянах замаар гэрээний хэрэгжилтийг шалгах.

16.2. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах үүрэгтэй:

16.2.1. зээлдэгчийн зээлийн мэдээллийг найдвартай хадгалах, хамгаалах, хуулийн дагуу шинэчлэх, боловсруулах;

16.2.2. өөртэй нь мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдэд зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхтэй болохыг гэрчилсэн баримт олгож, хэрэглэгчээр бүртгэх;

16.2.3. зээлийн лавлагааг зөвхөн энэ хуульд заасны дагуу хэрэглэгчид гаргаж өгөх;

16.2.4. зээлийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг тогтмол сайжруулах замаар эрх олгогдоогүй этгээдэд мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

17 дугаар зүйл. Зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээлэл нийлүүлэх

17.1. Мэдээлэл нийлүүлэгчээс зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээлэл нийлүүлэхэд дараах зарчмыг баримтална:

17.1.1. зээлийн мэдээлэл үнэн зөв, бодитой, тодорхой, бүрэн гүйцэд, ойлгомжтой байх;

17.1.2. хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн мэдээлэл байх;

17.1.3. зээлийн мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүр нь тогтмол, шинэчилж байх;

17.1.4. зөвхөн энэ хуульд заасан зорилгын дагуу ашиглагдах мэдээлэл байх;

17.1.5. нийлүүлэх зээлийн мэдээллийн нууцлалыг хамгаалж чадах техник хэрэгсэл, компьютерийн программ хангамжийг ашигласан байх;

17.1.6. зээлийн мэдээллийг зээлдэгчийн зөвшөөрлийг үндэслэн мэдээлэл нийлүүлэгч зээлийн мэдээллийн санд нийлүүлэх.

17.2. Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд мэдээлэл нийлүүлэгч зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэхийг хориглоно.

17.3. Мэдээлэл нийлүүлэгч цахим болон бичгийн хэлбэрээр, зөвшөөрөгдсөн компьютерийн программ хангамжийг ашиглан мэдээлэл өгөх, авах гэрээний дагуу зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд зээлийн мэдээлэл нийлүүлнэ.

17.4. Зээлийн мэдээллийг нийлүүлэх тухай бүрд нь мэдээлэл нийлүүлэгч болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд тухайн мэдээллийг хүлээлцэнийг баталгаажуулах баримтыг цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, баримтжуулна.

18 дугаар зүйл.Зээлийн мэдээллийг өөрчлөх, шинэчлэх, боловсруулах

18.1.Зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орсон бол мэдээлэл нийлүүлэгч нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг ажлын гурван өдрийн дотор зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хүргүүлнэ.

18.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь энэ хуулийн 18.1-д заасан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авсан даруйд мэдээллийн санд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, мэдээллийг шинэчилнэ.

18.3.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь боловсруулсан зээлийн мэдээллийг ангилж, хэрэглэгчид зээлийн лавлагаа, бусад бүтээгдэхүүн болгож борлуулахад бэлтгэн цэгцлэх, зээлийн мэдээллийн бодитой үнэн зөв байдлыг хянах ажлыг тасралтгүй зохион байгуулна.

19 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах, архивлах

19.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлийн мэдээллийн санд цуглуулсан зээлийн мэдээллийг уг санд хүлээн авсан өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална.

19.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлийн мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээллийн нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, баталгаажуулна.

19.3.Монголбанкнаас тогтоосон стандартын хэмжээнд зээлийн мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хангаж ажиллаагүйгээс учирсан хохирлыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд хариуцна.

19.4.Энэ хуулийн 19.1-д заасан хугацаа дуусахад зээлийн мэдээллийг Монголбанкинд шилжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

20 дугаар зүйл.Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг

20.1.Мэдээлэл нийлүүлэгч нь дараах эрхтэй:

20.1.1.зээлийн мэдээллийн нууцлалын аюулгүй байдал, хамгаалалтыг хангахыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах;

20.1.2.зээлийн мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлтийг эх сурвалжид тулгуурлан тухай бүрд нь хийж, зээлийн мэдээллийг баяжуулан боловсруулалт хийж байхыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах;

20.1.3.зээлийн мэдээллийн санд шилжүүлсэн мэдээлэлд худал, буруу ташаа нэмэлт мэдээлэл оруулахгүй байхад хяналт тавих;

20.1.4.нийлүүлсэн зээлийн мэдээллийн эх сурвалжид эргэлзээтэй байдал үүссэний улмаас уг мэдээллийг тодруулах, нягтлан шалгах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зээлдэгч болон холбогдох бусад байгууллагад хүсэлт гаргаж, хамтран ажиллах.

20.2.Мэдээлэл нийлүүлэгч нь дараах үүрэгтэй:

20.2.1.зээлийн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгаж, бодитой, тодорхой, эх сурвалжид нийцсэн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;

20.2.2.зээлийн мэдээллийг солилцоход энэ хуульд заасан шаардлагыг биелүүлэх;

20.2.3.зээлийн мэдээллийг дутуу, алдаатай нийлүүлсэн тохиолдолд түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй авах;

20.2.4.зээлдэгчийн нууцад хамаарах энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад мэдээллийг бусдад задруулахгүй байх.

21 дүгээр зүйл.Хэрэглэгчийн эрх, үүрэг

21.1.Хэрэглэгч нь дараах эрхтэй:

21.1.1.зээлийн лавлагаа үнэн зөв, бодитой, тодорхой, эх сурвалжид нийцсэн мэдээлэл агуулсан байхыг шаардах;

21.1.2.зээлийн мэдээлэл илт буруу бол түүнийг нэн даруй шинэчлэх, засварлахыг зээлдэгч, мэдээлэл нийлүүлэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах;

21.1.3.санаатайгаар буруу мэдээлэл өгсний улмаас хэрэглэгчид хохирол учирсан бол хохирлыг барагдуулахыг шаардах.

21.2.Хэрэглэгч нь дараах үүрэгтэй:

21.2.1.зээлийн лавлагааг зөвхөн хууль, гэрээгээр зөвшөөрсөн зорилгоор авч ашиглах;

21.2.2.зээлийн лавлагаанд тусгагдсан мэдээлэл буруу ташаа, бүрэн гүйцэд биш болохыг мэдсэн бол энэ талаар зээлдүүлэгч болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд нэн даруй мэдэгдэж, зээлийн лавлагаанд шаардлагатай өөрчлөлт оруулахыг шаардах;

21.2.3.зээлийн лавлагаанд тусгагдсан мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;

21.2.4.зээлийн лавлагаанд тусгагдсан мэдээлэл нь эргэлзээтэй, хуурамчаар үйлдэгдсэн байж болзошгүй, шалгаж тодруулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ тухай зээлдүүлэгч, мэдээлэл нийлүүлэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд мэдэгдэх.

22 дугаар зүйл.Зээлдэгчийн эрх, үүрэг

22.1.Зээлдэгч нь дараах эрхтэй:

22.1.1.өөрийн зээлийн лавлагааг зээлийн мэдээллийн сангаас хүссэн үедээ үзэж, хяналт тавих, тухайн лавлагааг жилд нэг удаа үнэ төлбөргүй авах;

22.1.2.зээлийн мэдээллийн сан дахь мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бус тохиолдолд мэдээллийг шинэчлэхийг мэдээлэл нийлүүлэгч болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс шаардах.

22.2.Зээлдэгч нь дараах үүрэгтэй:

22.2.1.зээлийн мэдээлэлд хамаарах энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг зээлдүүлэгчид үнэн зөв тайлагнах;

22.2.2.зээлийн мэдээлэлд хууль бусаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байвал энэ талаар хуулийн байгууллагад нэн даруй мэдэгдэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

23 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

23.1.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанк олгоно.

23.2.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[8] хуулийн 11.1.1, 11.1.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ:

23.2.1.зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагад ажиллах хүмүүсийн болон хувьцаа эзэмшигчдийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, утас, цахим шуудангийн хаяг;

23.2.2.тухайн хуулийн этгээдийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч тус бүрийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ;

23.2.3.зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагад ажиллах хүмүүсийн мэргэжил, боловсрол, ажлын дадлага туршлага, ял шийтгэлтэй байсан эсэх, хугацаа хэтэрсэн аливаа зээл, төлбөргүй болохыг нотлох баримт;

23.2.4.бизнес төлөвлөгөө;

23.2.5.зээлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хамгаалах бүх шаардлагыг хангахуйц мэдээллийн системийн программ хангамж, техник хэрэгслээр хангагдсаныг нотлох баримт;

23.2.6.хэрэглэгч зээлийн мэдээллийн санд хандаж мэдээлэл солилцох журам, түүний эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон гэрээний загвар;

23.2.7.байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагааны зарчим, хариуцлагыг тусгасан ёс зүйн дүрэм;

23.2.8.өөрийн хөрөнгийн доод хэмжээ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагад нийцэж байгааг нотлох баримт.

23.3.Монголбанк энэ хуулийн 23.2-т заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч ажлын 30 хоногийн дотор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.

23.4.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, үйлчилгээний хөлс тогтоох журмыг Монголбанк тогтооно.

23.5.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээд “зээлийн мэдээллийн сан” гэсэн нэр хэрэглэхийг хориглоно.

24 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл

24.1.Монголбанк дараах үндэслэлээр зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

24.1.1.ирүүлсэн өргөдөл, баримт бичиг нь энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

24.1.2.үүсгэн байгуулах гэрээ, дүрэм нь хууль тогтоомжтой зөрчилдсөн;

24.1.3.энэ хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж чадахуйц техник, тоног төхөөрөмж, компьютерийн программ хангамжаар хангагдаж чадаагүй, удирдлагад ажиллах хүмүүс нь шаардлага хангаагүй.

25 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

25.1.Монголбанк Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараах үндэслэлээр зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

25.1.1.хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг нийлүүлэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд уг үйл ажиллагааг дуусах хүртэл хугацаанд;

25.1.2.энэ хуульд заасан шаардлагыг хангах талаар Монголбанкнаас өгсөн үүргийг хэрэгжүүлээгүй бол зөрчлийг арилгах хүртэл хугацаанд.

26 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл

26.1.Монголбанк зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1-14.1.5-д зааснаас гадна дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

26.1.1.энэ хуулиар тавьсан шаардлагыг гурван сараас дээш хугацаанд хангаагүй;

26.1.2.тусгай зөвшөөрөл олгох үндэслэл болсон үүсгэн байгуулах болон бусад баримт бичиг хуурамч, бодит байдалд нийцэхгүй байгаа нь тогтоогдсон;

26.1.3.санаатайгаар буруу ташаа, бүрэн гүйцэд бус мэдээллийг тараасан, зээлийн мэдээллийн санд буруу ташаа засвар, өөрчлөлт оруулсан;

26.1.4.тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулж эхлээгүй;

26.1.5.зээлийн мэдээллийг хууль бусаар ашиглаж, энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн, бусдад ихээхэн хэмжээний хохирол учруулсан.

26.2.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шалтгааныг холбогдох шийдвэрт тодорхой тусгана.

26.3.Монголбанк нь зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд уг этгээдээс 6 сарын дотор дахин тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

27 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах

27.1.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болох бөгөөд энэ тохиолдолд Монголбанкны зөвшөөрлийг авна.

27.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл авахад дор дурдсан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ:

27.2.1.өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

27.2.2.үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан зээлийн мэдээллийн санг хэрхэн шийдвэрлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх үе шат, өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг;

27.2.3.өөрчлөн байгуулснаас гарах үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулагдсаны дараа эрх, үүргийг шилжүүлэн авах этгээд байгаа бол тухайн этгээдийн эхлэлтийн тайлан тэнцэл.

27.3.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг өөрчлөн байгуулагдахыг Монголбанк хүлээн зөвшөөрсөн тохиолдолд зээлийн мэдээллийн санг өөрчлөн байгуулагдсаны үр дүнд үүссэн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шилжүүлнэ.

27.4.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд татан буугдсан тохиолдолд зээлийн мэдээллийн санг Монголбанкинд шилжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

28 дугаар зүйл.Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох

28.1.Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллага, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага, төрийн байгууллага болон бусад аж ахуйн нэгжээс бүрдүүлсэн зээлийн мэдээллийн сантай байна.

28.2.Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, санхүүгийн түрээс /лизинг/-ийн компани, төрийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол өгнө.

28.3.Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй түүний бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн хууль болон гэрээний дагуу харилцан солилцоно.

28.4.Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй мэдээлэл солилцох журмыг Монголбанк тогтооно.

28.5.Монголбанк нь зээлийн мэдээллийн санг ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ
ХАРИУЦЛАГА

29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.3.Мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийн үнэн зөв эсэхийн талаар зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд, түүний ажилтан хариуцлага хүлээхгүй.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

30.1.Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төв Банк /Монголбанк/-ны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих

1.Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар зохицуулна.”

2/25³ дугаар зүйл:

“25³ дугаар зүйл.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх

1.Монголбанк нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа гомдлыг хянан шалгах, мэдээллийг засч, үнэн зөв болгох үүргийг холбогдох этгээдэд өгнө.

3.Монголбанк нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг жил бүр авч хянана.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зээлийн мэдээллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7.2.6 дахь заалт нэмсүгэй:

7.2.6.хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгсөн.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зээлийн мэдээллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуульд дор дурдсан агуулгатай 485 дугаар зүйл нэмсүгэй:

“485 дугаар зүйл. Зээлдэгчийн зээлийн мэдээлэл

“485.1.Зээл олголтыг хариуцлагатай болгож, эрсдлээ бууруулах зорилгоор хоршоо нь зээлдэгчийнхээ зээлийн мэдээллийг гэрээний үндсэн дээр зээлийн мэдээллийн санд өгөх буюу уг сангаас мэдээлэл авч болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зээлийн мэдээллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
Улаанбаатар хот

**ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН
БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмсүгэй:

“6.8.Зээлийн мэдээллийн сан дахь зээлийн мэдээлэлд зээлдэгчийн эд хөрөнгийн өмчлөлийн талаар эргэлзээтэй, бодит бус мэдээлэл орсон байж болзошгүй байвал уг мэдээллийг хянан шалгах зорилгоор зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд хүсэлт гаргасан тохиолдолд эрхийн улсын бүртгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үнэ төлбөргүй өгч болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зээлийн мэдээллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.3.9 дэх заалт нэмсүгэй:

“15.3.9.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зээлийн мэдээллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

**3. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТУХАЙ ЖУРАМ
(МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ 2005 ОНЫ 131 ТООТ
ТУШААЛ)**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005
оны 03 дүгээр сарын 29-ний өдрийн
13.1. тоот тушаалын хавсралт

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Журмын зорилго

1.1.1. Энэхүү журмын зорилго нь банк, банк бус санхүүгийн байгууллага (цаашид "ББСБ" гэх)-аас иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцааны талаарх мэдээлэл (цаашид "мэдээлэл" гэх)-ийг Зээлийн Мэдээллийн Сан (Цаашид "ЗМС" гэх)-д төвлөрүүлэн цуглуулах, боловсруулах, хадгалах, банк болон ББСБ-уудыг шаардлагатай мэдээллээр хангахад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зорилго

1.2.1 ЗМС-гийн үндсэн зорилго нь банк, ББСБ-ын зээлийн эрсдлийг бууруулахад оршино.

1.3 Мэдээлэл

1.3.1 ЗМС-гийн мэдээлэл нь зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгч, 3 сараас дээш хугацаагаар төлбөрөө гүйцэтгээгүй кредит карт эзэмшигч (цаашид "кредит карт эзэмшигч" гэх), зээлээр хийх төлбөр тооцооны эрх бүхий хэрэглэгч (цаашид "эрх нээлгэгчид" гэх)-ийн талаарх банк, ББСБ, Банкны өр барагдуулах газар (цаашид "БӨБГ" гэх), Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Эд хөрөнгийн бүртгэлийн алба (цаашид "ЭХБА" гэх), Үндэсний татварын ерөнхий газар (цаашид "ҮТЕГ" гэх), Гаалийн ерөнхий газар (цаашид "ГЕГ" гэх), Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв (цаашид "ИБМУТ" гэх), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (цаашид "ШШГЕГ" гэх), Хөрөнгийн бирж зэрэг байгууллагаас авсан мэдээлэл болон бусад мэдээллээс бүрдэнэ.

1.4 Зохион байгуулалт

1.4.1 ЗМС-г шаардлагатай мэдээллээр хангах, баяжуулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалт болон нууцлал, мэдээлэл түгээх үйл ажиллагааг Монголбанкны Хяналт Шалгалтын Газар (цаашид "ХШГ" гэх) эрхлэн гүйцэтгэнэ.

1.4.2 Орон нутаг дахь Монголбанкны салбар (цаашид "ЗМС-гийн салбар" гэх) нь Монголбанкны ЗМС (цаашид "ЗМС-гийн төв" гэх)-гийн салбарын үйл ажиллагааг эрхэлнэ.

1.5 ЗМС-гийн хэрэглэгч

1.5.1 ЗМС дахь мэдээллийг банк, ББСБ, тэдгээрийн салбар нэгж болон Монголбанкны газар, хэлтэс, БӨБГ, ЭХБА, ҮТЕГ, ГЕГ, ИБМУТ, ШШГЕГ, Хөрөнгийн бирж зэрэг ЗМС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан хэрэглэгчид /цаашид "Хэрэглэгч" гэх/ зөвхөн албан ажлын хэрэгцээнд ашиглана.

1.5.2 Хэрэглэгч нь ЗМС-тай харьцах итгэмжлэгдсэн ажилтныг томилж, түүний овог, нэр болон албан тушаалыг хэрэглэгч байгууллагын удирдлагын албан тоотоор баталгаажуулан ЗМС-гийн төвд ирүүлнэ. Итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдөх тухай бүрт хэрэглэгч энэ талаар Монголбанкинд ажлын 1 өдрийн дотор мэдэгдэнэ.

1.5.3 ЗМС нь өөрийн мэдээллийг хууль, хяналтын байгууллагуудад энэ журамд заасан нөхцөлөөр ашиглуулна.

1.6 ЗМС-гийн ажилтан, администратор

1.6.1 ЗМС-гийн ажилтан дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- ЗМС-гийн үйл ажиллагааг хянах,
- ЗМС-д хандах эрхийг зохицуулах,
- Тайлан мэдээ, лавлагааг боловсруулах,
- ЗМС-гийн тохиргоог хийх.

1.6.2 ЗМС-гийн администратор дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- ЗМС-гийн автомат ажилбаруудыг тохируулах,
- Тайлан мэдээг архивлах, архиваас сэргээх,
- ЗМС-гийн FTP сайтыг тохируулах,
- Зээлийн мэдээлэл нэгтгэх ажиллагааг тохируулах,
- Төрийн байгууллагуудаас мэдээлэл нийлүүлэх үйл ажиллагааг тохируулах.

Хоёр. ЗМС-гаас БАНК, ББСБ-тай ХАРИЛЦАХ

2.1 ЗМС-д Банк, ББСБ-аас ирүүлсэн мэдээллийг нэгтгэх

2.1.1 Банк, ББСБ нь шинээр зээл олгох, баталгаа гаргах, эх үүсвэргүй аккредитив нээх, кредит карт болон зээлээр хийх төлбөр тооцооны төлбөр хийх хугацааг 3-аас дээш сараар хэтрэх, бүрт мэдээллийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу бөглөж ЗМС-д ирүүлнэ.

2.1.2 Банк, ББСБ нь ЗМС-д бүртгэлтэй зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлэгч, кредит карт эзэмшигч, эрх нээлэгчийн талаарх мэдээлэлд дараахь өөрчлөлт орсон тохиолдолд энэхүү өөрчлөлтийн тухай мэдээллийг батлагдсан форматын дагуу ЗМС-гийн төвд тус тус ирүүлнэ. Үүнд:

- Зээл, баталгаа, аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцооны төлбөрт өөрчлөлт орох үеийн;
- Зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгч, карт эзэмшигч, эрх нээлгэгчийн нэр хаяг, эзэмшигч өөрчлөгдөх үеийн;
- Зээл, баталгаа, аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцооны төлбөрийн хугацаанд өөрчлөлт орох үеийн;
- Зээлийн ангилалд өөрчлөлт орох үеийн;

2.1.3 Банк, ББСБ нь зээл, баталгаа, аккредитивын үлдэгдлийн тайлан, үлдэгдлийн хураангуй тайлан, зээл олголт, төлөлтийн тайланг сар бүр журмын дагуу үнэн зөв боловсруулсан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн огноог тэмдэглэн, банкны гүйцэтгэх захирал, зээлийн газрын захирал нар гарын үсгээ зурж, тамга тэмдэг дарж дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлж байна.

2.1.3 Банк, ББСБ хариуцсан хянан шалгагч нь ЗМС-д нэгтгэсэн мэдээллийг тухайн банк, ББСБ-ын тэнцэл дэх зээлийн өрийн үлдэгдэл /ангилал тус бүрээр/ болон гаргасан баталгаа, аккредитивын дүнд нийцэж байгаа эсэхийг сар бүр шалгана.

2.1.4 Банк, ББСБ-аас авсан зээлээ төлөхөөс зайлсхийсэн, залилан мэхлэх зэрэг эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон иргэд, хуулийн этгээдийн талаарх сөрөг мэдээллийн санг 1 дүгээр хавсралтад заасны дагуу хөтөлнө. Сөрөг мэдээллийн сан нь тухайн иргэн, хуулийн этгээдийн талаарх банк, ББСБ болон ШШГЕГ-аас авсан мэдээлэл болон холбогдох бусад мэдээллээс бүрдэнэ.

2.1.5 Сөрөг мэдээллийн сангийн мэдээллийг банк, ББСБ нь улирал тутамд ирүүлнэ.

2.2 ЗМС-гаас Банк, ББСБ-д мэдээлэл өгөх

2.2.1 ЗМС-гаас мэдээлэл авахыг хүссэн банк нь Монголбанктай хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон "Хамтын ажиллагааны гэрээ"-г энэ журмын 2А хавсралтын дагуу, ББСБ нь "Хамтын ажиллагааны гэрээ"-г энэ журмын 2Б хавсралтын дагуу байгуулна. Хэрэглэгчээс хүссэн мэдээллийг гэрээнд заасны дагуу ЗМС-гаас олгох бөгөөд уг мэдээлэл нь Монголбанкны нууцын тухайн журмын дагуу нууцлан хамгаалагдсан байна.

2.2.2 ЗМС-гийн хэрэглэгч нь ЗМС-гаас мэдээлэл авахдаа дараахь мэдээллийг бөглөнө. Үүнд:

- ЗМС-д хандах хэрэглэгчийн нэр,
- Хэрэглэгчийн нууц үг.

2.2.3 ЗМС-гаас банк, ББСБ нь зээлдэгчийн талаарх дараахь мэдээллийг үзэх эрхтэй. Үүнд:

- Зээлдэгчийн мэдээлэл,
- Зээлийн мэдээ,

- Зээлдэгчийн талаарх БӨБГ-ын мэдээлэл,
- Барьцаа хөрөнгийн мэдээлэл,
- Зээлдэгчийн талаарх ГЕГ-ын мэдээлэл,
- Сөрөг мэдээллийн сангийн мэдээлэл,
- Зээлдэгчийн талаарх ҮТЕГ-ын мэдээлэл,
- Зээлдэгчийн талаарх ИБМУТ-ийн мэдээлэл,
- Зээлдэгчийн талаарх Хөрөнгийн биржийн мэдээлэл,
- Кредит карт эзэмшигчийн тухай мэдээлэл,
- Зээлээр хийх төлбөр тооцооны тухай мэдээлэл,

2.2.4 ЗМС-гаас бичгээр өгөх мэдээллийг 2 хувь үйлдэх ба нэг хувийг хэрэглэгчид өгч, нөгөө хувийг ЗМС-гийн архивт хадгална.

2.2.5 ЗМС нь зөвхөн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан банк, ББСБ-ын салбарт мэдээлэл өгнө.

2.2.6 ЗМС-гийн төв нь банк, ББСБ-аас ирүүлсэн мэдээллийг үндэслэн сар бүрийн эцэст системийн нэгтгэл хийж, давхардсан зээлтэй зээлдэгчдийн тухай мэдээллийг тухайн банк, ББСБ-ыг хариуцсан хянан шалгагчид өгнө.

2.2.7 ЗМС-гаас шаардлагатай тохиолдолд ЗМС-гийн итгэмжлэгдсэн ажилтанд мэдээллийг утсаар мэдээлэл өгч болно.

2.2.8 Энэ журмын 4.3.1-д зааснаас бусад тохиолдолд ЗМС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулаагүй байгууллагад ЗМС-гаас мэдээлэл өгөхийг хориглоно.

Гурав. ЗМС-гийн САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 ЗМС-гийн төв болон салбарын хооронд мэдээлэл солилцох

3.1.1 ЗМС-гийн төвд БӨБГ, ЭХБА, ҮТЕГ, ГЕГ, ИБМУТ, ШШГЕГ, Хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудаас нэгтгэгдсэн мэдээллээс ЗМС-гийн салбар мэдээлэл авч болно.

3.1.2 Орон нутаг дахь ЗМС-гийн салбар тухайн орон нутаг дахь банк, ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн талаар болон зээл төлүүлэх чиглэлээр хийж байгаа ажлын тайланг улирал бүр ЗМС-гийн төвд энэхүү журмын хавсралт 3-т заасны дагуу бөглөж ирүүлнэ.

Дөрөв. ЗМС-гаас БУСАДТАЙ ХАРИЛЦАХ

4.1 ЗМС-гаас Монголбанкны газар (хэлтэс)-тай харилцах

4.1.1 Монголбанкны газар, хэлтэс албан ажлын шаардлагаар ЗМС-гаас мэдээлэл авах тохиолдолд энэ тухай ХШГ-т албан бичгээр хүсэлт гарган, ХШГ-ын захирлын зөвшөөрлийг авна.

4.1.2 ХШГ-ын хянан шалгагчид албан ажлын шаардлагаар ЗМС-гаас мэдээлэл авах бол тухайн хэлтсийн захирал хүсэлт гаргана.

4.2 ЗМС-гаас БӨБГ, ЭХБА, ҮТЕГ, ГЕГ, ИБМУТ, ШШГЕГ, Хөрөнгийн биржтэй харилцах

4.2.1 ЗМС нь БӨБГ, ЭХБА, ҮТЕГ, ГЕГ, ИБМУТ, ШШГЕГ, Хөрөнгийн биржтэй "Хамтын ажиллагааны гэрээ"-г энэ журмын 2В хавсралтын дагуу байгуулна.

4.2.2 ЗМС нь гэрээнд заасны дагуу мэдээллийг эдгээр байгууллагатай харилцан солилцох бөгөөд уг мэдээлэл нь Монголбанкны нууцын тухай журмын дагуу нууцлан хамгаалагдсан байна.

4.3 ЗМС-гаас хууль, хяналтын байгууллагатай харилцах

4.3.1 Хууль, хяналтын байгууллага албан ажлын шаардлагаар ЗМС-гаас мэдээлэл авахаар бол Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөгдсөн мэдээллийг 2 хувь үйлдэх ба нэг хувийг ЗМС-д хадгалж, нөгөө хувийг хүсэлт гаргасан байгууллагад өгнө.

Тав. БУСАД

5.1 ЗМС-гийн аюулгүй байдал

5.1.1 ЗМС-гийн мэдээллийг нууцлан хамгаална.

5.1.2 ЗМС-гийн сүлжээний аюулгүй байдлыг Монголбанкны Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газар хариуцан ажиллана.

5.1.3 ЗМС нь зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгчийн тухай мэдээлэл, чанаргүй зээлийн тайлан болон ЗМС-гаас хэрэглэгчийн лавласан, тэдгээрт түгээсэн мэдээллийн талаарх тайланг сар бүр хийж, улиралд нэг удаа Захирлуудын зөвлөлд танилцуулна.

5.2 Хариуцлага

5.2.1 Банк, ББСБ-д зээлийн эрсдлээс учирсан аливаа хохирлыг ЗМС-гаас мэдээлэл өгсөн эсэхээс үл хамааран Монголбанк хариуцахгүй.

5.2.2 Банк болон ББСБ нь шинээр зээл олгосон, баталгаа гаргасан, аккредитив нээсэн, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцооны болон тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар ЗМС-д энэхүү журамд заасан хугацаанд мэдээлээгүй нь тогтоогдвол "Банкны тухай", "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуульд заасан захиргааны арга хэмжээ авна. Хэрэв мэдээллийг 3 сар болон түүнээс дээш хугацаагаар өгөөгүй тохиолдолд ЗМС-гаас мэдээлэл авах эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авч болно.

5.2.3 ЗМС-д ирүүлсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн банк, ББСБ хариуцна. Хэрэв худал, ташаа мэдээлэл өгсөн болон ЗМС-гаас авсан мэдээллийг энэхүү журамд

зааснаас бусад зориулалтаар ашигласан нь тогтоогдвол тухайн банкинд 500.000,0-аас 1.000.000,0 төгрөг хүртэлх, ББСБ-ыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулж, сангаас мэдээлэл авах эрхийг нь 6 сараас 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.2.4 ЗМС-гийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас бусдад хохирол учруулбал, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2.5 Энэхүү журмыг зөрчин зээлийн мэдээллийг хууль бусаар түгээсэн, ашигласан болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хавсралт 1. ЗМС-д хадгалагдах мэдээллийн тухай

1. Иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийн тухай

No	Мэдээлэл	Тайлбар
1.	Зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгчийн нэр	Иргэн, хуулийн этгээдийн нэр
2.	Регистрийн дугаар	Зээлдэгчийн регистрийн дугаар
3.	Иргэний үнэмлэхийн дугаар	Зээлдэгч иргэний үнэмлэхийн дугаар
4.	Улсын бүртгэлийн дугаар	Татварын байгууллагад бүртгэгдсэн улсын бүртгэлийн дугаар
5.	Оршин байгаа хаяг	Зээлдэгчийн албан ёсоор бүртгүүлсэн хаяг
6.	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагаа явуулж байгаа салбарын кодыг зээл, баталгаа, аккредитивын зориулалтын дагуу бөглөнө.
7.	Байгуулагдсан он	Зээлдэгч байгууллагын байгуулагдсан огноо
8.	Аж ахуйн нэгж, байгууллагын захирлын нэр	Зээлдэгч байгууллагын гүйцэтгэх захирлын овог, нэр
9.	Аж ахуйн нэгж, байгууллагын захирлын регистрийн дугаар	Захирлын регистрийн дугаар
10.	Иргэний үнэмлэхийн дугаар	Захирлын иргэний үнэмлэхийн дугаар
11.	Аж ахуйн нэгж, байгууллагын захирлын гэрийн хаяг	Аж ахуйн нэгж, байгууллагын захирлын гэрийн хаяг

2. Зээл, баталгаа, аккредитивын талаарх мэдээлэл

No	Мэдээлэл	Тайлбар	
1.	Зээл олгосон, баталгаа гаргасан, аккредитив нээсэн огноо	Зээл олгосон, баталгаа гаргасан, аккредитив нээсэн огноог бичнэ. Энэ мэдээлэл нь тухайн зээл ямар хугацаанд төлөгдөөгүй байгааг харуулна.	
2.	Зээл, баталгаа, аккредитивын төлөгдөх огноо	Зээл, баталгаа, аккредитивыг бүрэн төлж дуусгах хугацаа	
3.	Зээл, баталгаа, аккредитивын зориулалт*	Салбар	Зээлийн зориулалтыг дараахь тайлбарын дагуу бөглөнө.
		Дэд салбар	
4.	Анх олгосон зээл, баталгаа, аккредитивын хэмжээ	Зээл/ баталгаа / аккредитив тус бүрээр	
5.	Тухайн сарын төлбөр хийсэн хугацаа	Зээлдэгчээс тухайн сард төлбөр хийсэн сүүлчийн хугацаа	
6.	Үндсэн өрийн төлбөр	Зээлдэгчээс тухайн сард үндсэн өрийн төлбөр хийсэн хэмжээ	

7.	Валютын нэгж	Олгосон валютын нэр: Америк доллар-USD, Монгол төгрөг-MNT, Герман марк-DEM, Японы иен-JPY, Швейцарийн франк-CHF, Хятадын юань-CHY гэх мэт
8.	Зээл, баталгаа, аккредитивын эцсийн үлдэгдэл	Тухайн үеийн эцсийн үлдэгдэл
9.	Зээлийн ангилал	Зээл ямар ангилалд хамаарагдаж байгааг бичих
10.	Зээл, баталгаа, аккредитивын хугацаа сунгасан шийдвэр	... -ний өдрийн ... -ний шийдвэрийг үндэслэн сунгасан гэж бөглөх

Тайлбар: * - Зориулалт гэсэн хэсгийн салбар болон дэд салбарын кодыг доорх хүснэгтэд заасны дагуу оноох бөгөөд тухайн олгосон зээл ямар салбарт олгогдсоныг тодорхойлохдоо Үндэсний Статистикийн газрын дарга, Сангийн сайдын 2004 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 184/217 тоот хамтарсан тушаалын хавсралтыг ашиглана.

Салбарын код	Салбарын нэр	Дэд салбарын код	Дэд салбарын нэр
01	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загасны аж ахуй	01	Газар тариалан
		02	Мал аж ахуй
		03	Газар тариалан, мал аж ахуй хослон эрхлэх үйл ажиллагаа
		04	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулахад үйлчлэх үйл ажиллагаа
		05	Ан агнуурын үйл ажиллагаа
		06	Ойн аж ахуй, мод бэлтгэл
		07	Загас барилт, загас үржүүлэг
02	Уул уурхай, олборлох үйлдвэр	01	Нүүрс олборлолт
		02	Газрын тос, шатдаг хий олборлолт
		03	Уран, торийн хүдэр олборлолт
		04	Төмрийн хүдэр олборлолт
		05	Бусад ашигт малтмал олборлолт
03	Боловсруулах үйлдвэр	01	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл Тамхи үйлдвэрлэл Нэхмэлийн үйлдвэрлэл
		02	Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт
		03	Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл
		04	Мод модон эдлэл (тавилганаас бусад)
		05	Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

		06	Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа
		07	Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш
		08	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
		09	Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл
		10	Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл
		11	Төмрийн үйлдвэрлэл
		12	Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл
		13	Машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл
		14	Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл
		15	Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл
		16	Радио, телевизор, холбооны хэрэгсэл үйлдвэрлэл
		17	Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл
		18	Автомашин, чиргүүл үйлдвэрлэл
		19	Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл
		20	Мебель тавилга үйлдвэрлэл, бусад боловсруулах үйлдвэрлэл
		21	Хоёрдогч түүхий эд бэлтгэл
04	Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	01	Цахилгаан хий, дулаан үйлдвэрлэл
		02	Ус ариутгал, усан хангамж
05	Барилга	00	
06	Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ	01	Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ
		02	Машин мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа
		03	Машин мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ

07	Зочид буудал, зоогийн газар	00	
08	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	01	Хуурай замын тээвэр
		02	Усан замын тээвэр
		03	Агаарын тээвэр
		04	Тээврийн товчоо, жуулчдад үйлчлэх байгууллагын үйл ажиллагаа
09	Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	01	Холбооны үйл ажиллагаа
		02	Даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн зуучлал
		03	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, тэтгэврийн сангийн үйл ажиллагаа
10	Үл хөдлөх хөрөнгө түрээсийн бизнесийн үйл ажиллагаа	01	Санхүүгийн туслах үйл ажиллагаа
		02	Даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн зуучлал
		03	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, тэтгэврийн сангийн үйл ажиллагаа
		04	Үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох үйл ажиллагаа
		05	Машин, төхөөрөмж, гэр ахуйн бараа түрээслэл
11	Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалын үйл ажиллагаа	01	Компьютер, түүнд холбогдох үйл ажиллагаа
		02	Эрдэм шинжилгээний ажил
12	Боловсролын салбарын үйл ажиллагаа	03	Бизнесийн бусад үйл ажиллагаа
13	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	00	
14	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	01	Бохир ус, хаягдал цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ
		02	Олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа
		03	Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа
		04	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
15	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	01	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй
		02	Өрхийн хувийн хэрэгцээнд зориулж үйлдвэрлэсэн, тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл

		03	Өрхийн хувийн хэрэгцээнд зориулж үзүүлсэн, тодорхойлох боломжгүй үйлчилгээний үйл ажиллагаа
16	Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	00	

3. Сөрөг мэдээллийн сан

No	Мэдээлэл
1.	Төлбөрөөс зайлсхийсэн иргэн, хуулийн этгээдийн нэр
2.	Регистрийн дугаар
3.	Улсын бүртгэлийн дугаар /Иргэний хувьд иргэний үнэмлэхийн дугаар/
4.	Хуулийн байгууллагад нэхэмжилсэн огноо /цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл/
5.	Нэхэмжилсэн дүн
6.	Зөрчлийн угта
7.	Зээл, баталгаа, аккредитивын төлбөрөөс зайлсхийсэн эсэх
8.	Хуулийн байгууллагаас гаргасан шийдвэрийн огноо
9.	Хуулийн байгууллагаас гаргасан шийдвэрийн дугаар
10.	Хуулийн байгууллагаас гаргасан шийдвэрийн дүн
11.	Одоогоор ямар шатанд байгаа
12.	Тайлбар

4. 3 сараас дээш хугацаагаар төлбөр гүйцэтгээгүй кредит карт эзэмшигчийн талаарх мэдээлэл

Д/д	Мэдээлэл
1.	Кредит картын дугаар
2.	Зээлдэгчийн овог, нэр
3.	Дээд хязгаар
4.	Үлдэгдэл
5.	Валютын нэр
6.	Нээсэн огноо
7.	Дуусах огноо
8.	Хамгийн сүүлд төлбөр хийсэн огноо

5. Зээлээр хийх төлбөр тооцооны төлбөрийг 3 сараас дээш хугацаагаар гүйцэтгээгүй хэрэглэгчдийн талаарх мэдээлэл

Д/д	Мэдээлэл
1.	Дансны дугаар
2.	Зээлдэгчийн овог, нэр
3.	Дээд хязгаар
4.	Үлдэгдэл

5.	Валютын нэр
6.	Нээсэн огноо
7.	Эрх хаасан огноо

6. Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл**

No	Мэдээлэл		
1.	Барьцаа хөрөнгийн төрөл***	Бүлэг	Бүлгийн код
		Дэд бүлэг	Дэд бүлгийн код
2.	Барьцаа хөрөнгийн тухайн зээлд тавигдсан нийт барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнд эзлэх хувь		Үүнийг дэд бүлэг тус бүрээр хувиар тодорхойлно.
3.	Байршил		
4.	Барьцаа хөрөнгөд хийсэн үнэлгээний огноо		
5.	Барьцаа хөрөнгийн үнэлгээ		Хэрэв хэд хэдэн бүлэг, дэд бүлэгт хамаарах хөрөнгүүдийг барьцаалсан бол тухайн бүлэг, дэд бүлэг тус бүрт нь үнэлгээг нь бичнэ.
6.	ЭХБА-ны дугаар		
7.	Барьцаалсан гэрчилгээний улсын бүртгэлийн дугаар		

Тайлбар:

* -Барьцаа хөрөнгийн төрлийг дараахь байдлаар заана. Зээлдэгч, аккредитив нээлгэгч нь гуравдагч этгээдээр баталгаа гаргуулж, баталгаа гаргагчийн хөрөнгийг барьцаалаагүй бол 12.6 гэж бөглөнө. Баталгаа гаргагчийн тодорхой хөрөнгийг барьцаалсан бол 12.6-аас бусад бүлгийн дагуу барьцаа хөрөнгийн бүлгийг тодорхойлно. Хэрэв тухайн зээлд хэд хэдэн бүлэг, дэд бүлэгт хамаарах хөрөнгө барьцаалсан бол тухайн хөрөнгө тус бүрийн бүлэг, дэд бүлгийг тус тусад нь бичнэ.

Бүлгийн код	Бүлгийн нэр	Дэд бүлгийн код	Дэд бүлгийн нэр
01	Мөнгөн хөрөнгө	1	Банкин дахь харилцах
		2	Банкин дахь хадгаламж
02	Үнэт цаас, хөрөнгө оруулалт	1	Засгийн газрын үнэт цаас
		2	Төрийн эрх бүхий бусад байгууллагаас гаргасан үнэт цаас
		3	Компанийн хувьцаа
		4	Компанийн гаргасан өрийн бичиг
		5	Компанийн бусад үнэт цаас
		6	Гадаадын байгууллагын хувьцаа
		7	Гадаадын байгууллагаас гаргасан өрийн бичиг
		8	Гадаадын орны төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан үнэт цаас
		9	Бусад байгуулагад оруулсан хөрөнгө оруулалт

03	Авлага	1	Гадаадын байгууллагаас авах авлага
		2	Дотоодын байгууллагаас авах авлага
		3	Холбогдох этгээдээс авах авлага
		4	Борлуулалтын орлого
		5	Цалингийн орлого
		6	Тэтгэврийн орлого
		7	Хадгаламжийн хүүгийн орлого
		8	Ногдол ашгийн орлого
		9	Түрээсийн орлого
		10	Бусад тогтмол орлого
		11	Векселийн авлага
		12	Бусад авлага
04	Түүхий эд материал	0	
05	Дуусаагүй үйлдвэрлэл	0	
06	Бараа бэлэн бүтээгдэхүүн	0	
07	Хагас боловсруулсан үйлдэхүүн	0	
08	Мал амьтад	1	ХАА-н үйлдвэрлэлийн мал амьтад
		2	Бусад зориулалтын мал амьтад
		3	Мал амьтдаас авах ашиг шим
09	Газар	1	Газар өмчлөх эрх
		2	Газар эзэмших эрх
		3	Ашигт малтмалын орд газар ашиглах эрх
		4	Ашигт малтмалын хайгуул хийх эрх
		5	Тариалангийн талбай ашиглах эрх
		6	Бусад эрх
10	Барилга	1	Орон сууц
		2	Хувийн орон бууц
		3	Хашаа байшин
		4	Үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламж
		5	Үйлдвэрлэлийн бус зориулалттай барилга, байгууламж
		6	Дуусаагүй барилга
		7	Бусад
11	Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	1	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай тээврийн хэрэгсэл
		2	Автомашин
		3	Бусад тээврийн хэрэгсэл
		4	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж
		5	Бусад

12	Бусад	1	Патент
		2	Зохиогчийн эрх
		3	Барааны тэмдэг
		4	Бусад
		5	Баталгаа
		6	Бусад

БАТЛАВ.

Монголбанкны Тэргүүн
Дэд Ерөнхийлөгч

..... банкны гүйцэтгэх
захирал

.....

/ /

200... оны ... дугаар сарын ... өдөр

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

"Банкны тухай", "Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай" хуулийн холбогдох заалтууд, "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үндэслэн нэг талаас Монголбанкийг төлөөлж Монголбанкны Зээлийн мэдээллийн сан (Цаашид "ЗМС" гэх), нөгөө талаас банк (Цаашид "Банк" гэх)-ны хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1. Зээлийн эрсдлийг бууруулахад туслах үүднээс банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцаа хөрөнгөтэй холбоотой мэдээллийг харилцан солилцоход энэхүү гэрээний зорилго оршино.

2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулж батална.

3. ЗМС-д мэдээлэл хүлээн авах, өгөх эрх бүхий Монголбанкны ажилтны албан тушаал, нэр:

4. ЗМС-гаас мэдээлэл авах, өгөх эрх бүхий банкны итгэмжлэгдсэн ажилтны албан тушаал, нэр:

ХОЁР. ЗМС-гийн эрх, үүрэг

1. ЗМС нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1/ ЗМС-г бүрдүүлэх, банкны зээлийн эрсдлийг бууруулах, мөнгө, санхүүгийн зах зээлийн удирдлагыг оновчтой болгож, шуурхай зөв шийдвэр гаргахад нь туслах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцаа хөрөнгөтэй холбоотой мэдээллээр хангах,

2/ ЗМС-гаас шаардлагатай тохиолдолд ЗМС-гийн итгэмжлэгдсэн ажилтанд утсаар мэдээллийг өгөх,

3/ ЗМС-гийн нууцлал, байнгын ажиллагааг хангах талаар зохих арга хэмжээг байнга авч ажиллах бөгөөд зөвхөн итгэмжлэгдсэн, эрх бүхий ажилтанд мэдээллийг өгөх,

4/ "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ын дагуу ажиллаагүй гэж үзвэл, мэдээлэл өгөх эрхийг хаах,

5/ "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,

6/ Банкны тухай хууль тогтоомж болон Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх,

ГУРАВ. Банкны эрх, үүрэг

1. Банк нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1/ Банк нь шинээр зээл олгох, баталгаа гаргах, эх үүсвэргүй аккредитив нээх, кредит карт болон зээлээр хийх төлбөр тооцооны төлбөр хийх хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн хэрэглэгчид болон тэдгээрийн талаарх мэдээлэлд өөрчлөлт орсон ЗМС-д бүртгэлтэй зээлдэгчдийн талаарх мэдээлэлд "Зээлийн мэдээллийн сангийн журам"-д заасан аливаа өөрчлөлт ороход энэ өөрчлөлтийн талаар тухайн ажлын өдөрт багтаан сүлжээгээр санд яаралтай мэдэгдэж байх,

2/ ЗМС-тай харилцах итгэмжлэгдсэн ажилтныг томилох, солих,

3/ Эрх бүхий, итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдөх бүр энэ талаар мэдэгдлийг эрх бүхий итгэмжлэгдсэн шинэ ажилтны нэрийн хамт тухайн өдөрт багтааж ЗМС-д нууцын зэрэглэлтэй ирүүлэх,

4/ Банк нь өөрийн зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгч, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцооны эрх нээлгэгч болон шинээр эдгээр үйлчилгээг хийлгэхээр хүсэлт тавьсан харилцагчдын бусад банкуудаас авсан зээл, баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, төлбөрийн хугацаа 3 сараас дээш хугацаагаар хэтэрсэн кредит карт болон зээлээр хийх төлбөр тооцооны эрхийн талаарх мэдээллийг, өөрийн эрсдлийг тооцон, цаашид тэдэнтэй ажиллах чиглэлээ тогтооход ашиглах бөгөөд мэдээллийг үүнээс бусад зориулалтаар ашиглахгүй байх,

5/ "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,

6/ Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх,

ДӨРӨВ. Хариуцлага

1. Банкинд зээлийн эрсдлээс учирсан аливаа хохирлыг ЗМС-гаас мэдээлэл өгсөн эсэхээс үл хамааран Монголбанк хариуцахгүй.

2. Банк нь шинээр зээл олгосон, баталгаа гаргасан, аккредитив нээсэн, кредит картны төлбөр болон зээлээр хийх төлбөр тооцоог 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн хэрэглэгчдийн мэдээлэл, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар ЗМС-д энэхүү журамд заасан хугацаанд мэдээлээгүй нь тогтоогдвол Банкны хуульд заасан захиргааны арга хэмжээ авна. Хэрэв мэдээллийг 3 сар болон түүнээс дээш хугацаагаар өгөөгүй тохиолдолд ЗМС-гаас мэдээлэл авах эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авч болно.

3. ЗМС-д ирүүлсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн банк хариуцна. Хэрэв худал, ташаа мэдээлэл өгсөн болон ЗМС-гаас авсан мэдээллийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашигласан нь тогтоогдвол тухайн банкыг 500.000,0-аас 1.000.000,0 төгрөгөөр торгож, сангаас мэдээлэл авах эрхийг нь 6 сараас 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.

4. ЗМС-гийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас бусдад хохирол учруулбал, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5. Энэхүү журмыг зөрчин зээлийн мэдээллийг хууль бусаар түгээсэн, ашигласан болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны ХШГ-ын
БҮАХ-ийн захирал

Зээлийн хэлтсийн захирал

.....
/ /
Монголбанкны Зээлийн
мэдээллийн сангийн
ажилтан

.....
/ /
Итгэмжлэгдсэн эрх
бүхий ажилтан

.....
/ /

.....
/ /

БАТЛАВ.

Монголбанкны Тэргүүн
Дэд Ерөнхийлөгч

..... ББСБ-ын гүйцэтгэх
захирал

.....

.....

/

/

/

/

200... оны ... дугаар сарын ... -ны өдөр

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

"Банкны тухай", "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай", "Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай" хуулиудын холбогдох заалтууд, "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үндэслэн нэг талаас Монголбанкийг төлөөлж Монголбанкны Зээлийн мэдээллийн сан (Цаашид "ЗМС" гэх), нөгөө талаас Банк Бус Санхүүгийн Байгууллага (Цаашид "ББСБ" гэх)-ын хооронд энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1. Зээлийн эрсдлийг бууруулахад туслах үүднээс банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, төлбөр хийх хугацаа хэтэрсэн кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцаа хөрөнгөтэй холбоотой мэдээллийг харилцан солилцоход энэхүү гэрээний зорилго оршино.

2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулж батална.

3. ЗМС-д мэдээлэл хүлээн авах, өгөх эрх бүхий Монголбанкны ажилтны албан тушаал, нэр:

4. ЗМС-гаас мэдээлэл авах, өгөх эрх бүхий ББСБ-ын итгэмжлэгдсэн ажилтны албан тушаал, нэр:

ХОЁР. ЗМС-гийн эрх, үүрэг

1. ЗМС нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1/ ЗМС-г бүрдүүлэх, банкны зээлийн эрсдлийг бууруулах, мөнгө, санхүүгийн зах зээлийн удирдлагыг оновчтой болгож, шуурхай зөв шийдвэр гаргахад нь туслах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцоо, тэдгээрийн барьцаа хөрөнгөтэй холбоотой мэдээллээр хангах,

2/ ЗМС-гаас шаардлагатай тохиолдолд ЗМС-гийн итгэмжлэгдсэн ажилтанд утсаар мэдээллийг өгөх,

3/ ЗМС-гийн нууцлал, байнгын ажиллагааг хангах талаар зохих арга хэмжээг байнга авч ажиллах бөгөөд зөвхөн итгэмжлэгдсэн, эрх бүхий ажилтанд мэдээллийг өгөх,

4/ "Зээлийн мэдээллийн сан"-гийн журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,

5/ Банкны тухай хууль тогтоомж болон Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх,

ГУРАВ. ББСБ-ын эрх, үүрэг

1. ББСБ нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1/ ББСБ нь шинээр зээл олгох, баталгаа гаргах, аккредитив нээх, зээлээр хийх төлбөр тооцооны эрх нээх, хугацаа хэтэрсэн кредит картны төлбөрт өөрчлөлт орох, ЗМС-д бүртгэлтэй зээлдэгчдийн талаарх мэдээлэлд "Зээлийн мэдээллийн сангийн журам"-д заасан аливаа өөрчлөлт ороход энэ өөрчлөлтийн талаар тухайн ажлын өдөрт багтаан сүлжээгээр санд яаралтай мэдэгдэж байх,

2/ ЗМС-тай харилцах итгэмжлэгдсэн ажилтныг томилох, солих,

3/ Эрх бүхий, итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдөх бүр энэ талаарх мэдэгдлийг эрх бүхий итгэмжлэгдсэн шинэ ажилтны нэрийн хамт тухайн өдөрт багтааж ЗМС-д нууцын зэрэглэлтэй ирүүлэх,

4/ ББСБ нь өөрийн зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгч, кредит карт, зээлээр хийх төлбөр тооцооны эрх нээлгэгч болон шинээр эдгээр үйлчилгээг хийлгэхээр хүсэлт тавьсан харилцагчдын бусад банкуудаас авсан зээл, баталгаа, эх үүсвэргүй нээсэн аккредитив, төлбөрийн хугацаа 3 сараас дээш хугацаагаар хэтэрсэн кредит карт болон зээлээр хийх төлбөр тооцооны эрхийн талаарх мэдээллийг, өөрийн эрсдлийг тооцон, цаашид тэдэнтэй ажиллах чиглэлээ тогтооход ашиглах бөгөөд мэдээллийг үүнээс бусад зориулалтаар ашиглахгүй байх,

5/ ЗМС-гаас мэдээлэл авахаар захиалга өгөхдөө холбогдох журамд заасан шаардлагыг бүрэн хангах,

6/ "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,

7/ Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх,

ДӨРӨВ. Хариуцлага

1. ББСБ-д зээлийн эрсдлээс учирсан аливаа хохирлыг ЗМС-гаас мэдээлэл өгсөн эсэхээс үл хамааран Монголбанк хариуцахгүй.

2. ББСБ нь шинээр зээл олгосон, баталгаа гаргасан, аккредитив нээсэн, кредит картны төлбөр болон зээлээр хийх төлбөр тооцооны болон тэдгээрт орсон өөрчлөлт, тухай мэдээлэлд кредит картны төлбөр хийх хугацаа хэтэрсэн болон тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар ЗМС-д энэхүү журамд заасан хугацаанд мэдээлээгүй нь тогтоогдвол "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуульд заасан захиргааны арга хэмжээ авна. Хэрэв мэдээллийг 3 сар болон түүнээс дээш хугацаагаар өгөөгүй тохиолдолд ЗМС-гаас мэдээлэл авах эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авч болно.

3. ЗМС-д ирүүлсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн ББСБ хариуцна. Хэрэв худал, ташаа мэдээлэл өгсөн болон ЗМС-гаас авсан мэдээллийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашигласан нь тогтоогдвол тухайн ББСБ-д сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулж, сангаас мэдээлэл авах эрхийг нь 6 сараас 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.

4. ЗМС-гийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас бусдад хохирол учруулбал, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5. Энэхүү журмыг зөрчин зээлийн мэдээллийг хууль бусаар түгээсэн, ашигласан болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Хяналт
шалгалтын газрын
БҮАХ-ийн захирал

Зээлийн хэлтсийн захирал

.....
/ /

.....
/ /

Монголбанкны Зээлийн
мэдээллийн сангийн
ажилтан

Итгэмжлэгдсэн эрх
бүхий ажилтан

.....
/ /

.....
/ /

ЗМС-ГИЙН САЛБАРААС ТӨВД ИРҮҮЛЭХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

Д/д	Бүлэг	Хэвийн		Хугацаа хэтэрсэн		Хэвийн бус		Эргэлзээтэй		Муу		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗЭЭЛ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
БАТЛАН ДААЛТ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
АККРЕДИТИВ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
	Нийт дүн (MNT)												

2/ ЗМС-гийн нууцлал, байнгын ажиллагааг хангах талаар зохих арга хэмжээг байнга авч ажиллах бөгөөд зөвхөн итгэмжлэгдсэн, эрх бүхий ажилтанд мэдээллийг өгөх,

3/ "Зээлийн мэдээллийн сангийн журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,

4/ Банкны тухай хууль тогтоомж болон Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх,

ГУРАВ. -ын эрх, үүрэг

1. нь дор дурдсан эрх, үүрэгтэй:

1/ нь өөртөө бүртгэлтэй байгаа иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад заасны дагуу -ны байдлаар бичгээр болон файлаар гаргаж, -ний өдрийн дотор ЗМС-д мэдээлэх,

2/ ЗМС-гаас авсан зээлдэгч, баталгаа гаргагч, аккредитив нээлгэгч, кредит карт эзэмшигч, зээлээр хийх төлбөр тооцооны эрх нээлгэсэн хэрэглэгчийн талаарх мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах,

3/ Эрх бүхий, итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдөх бүр энэ талаар мэдэгдлийг эрх бүхий итгэмжлэгдсэн шинэ ажилтны нэрийн хамт тухайн өдөрт нь багтааж ЗМС-д нууцын зэрэглэлтэй ирүүлэх,

4/ ЗМС-гаас мэдээлэл авахаар захиалга өгөхдөө холбогдох журамд заасан шаардлагыг бүрэн хангах,

5/ Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх.

ДӨРӨВ. Бусад зүйл

1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

2. Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь хуулийн дагуу адил хүчин төгөлдөр байна.

ТАВ. Хариуцлага

1. Энэхүү гэрээг зөрчин зээлийн мэдээллийг хууль бусаар түгээсэн, хэрэглэсэн болон хуурамч мэдээлэл өгсөн гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Гэрээний явцад гарсан аливаа маргаантай асуудлаа талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд харилцан тохиролцож боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Хяналт шалгалтын газрын БУАХ-ийн захирал

..... Хэлтсийн захирал

.....
/ /

.....
/ /

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн ажилтан

Итгэмжлэгдсэн эрх бүхий ажилтан

.....
/ /

.....
/ /

ЗМС-ГИЙН САЛБАРААС ТӨВД ИРҮҮЛЭХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

Д/д	Бүлэг	Хэвийн		Хугацаа хэтэрсэн		Хэвийн бус		Эргэлзээтэй		Муу		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗЭЭЛ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
БАТЛАН ДААЛТ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
АККРЕДИТИВ /банк бүрээр/													
	Валютаар/ Үүнд:												
	MNT												
	USD												
	EUR г.м												
	Дүн (MNT)												
	Нийт дүн (MNT)												

4. АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ

2017 оны 06 дугаар сарын
30-ны өдөр

Дугаар А-193/228

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 5, 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх удирдлагад тус тус даалгасугай.
3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар (Ө.Баттулга)-г тус тус даалгасугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А-336/400 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны
06 дугаар сарын 30-ны өдрийн А.1.9.3.1/228.....
дугаар хамтарсан тушаалын хавсралт

**АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН
БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (МХТТЗХ)-ийн 27.1-д заасан зээл болон бусад активыг ангилах, Банкны тухай хуулийн 35.5 болон 35.6-д заасан зээл болон бусад актив төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулах, зарцуулахад тавигдах доод шаардлагыг Монголбанкнаас тогтоох, банкинд мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журам нь Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, МХТТЗХ, Зээлийн мэдээллийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3. Банк нь активыг хугацааны болон чанарын үзүүлэлтээр энэ журмын 2 дугаар бүлэг болон Хавсралт 1, Хавсралт 2-т заасан аргачлалаар ангилан, харгалзах эрсдэлийн санг энэ журмын 3 дугаар бүлэг болон Хавсралт 3-т заасны дагуу байгуулж Монголбанкнаас тогтоосон доод шаардлагыг хангах үүрэгтэй.
- 1.4. Банк нь нягтлан бодох бүртгэл болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ болон боловсронгуй байдалтай уялдуулан активыг ангилж, эрсдэлийн сан байгуулах, Активын эрсдэлийн удирдлагын талаар дотооддоо баримтлах бодлого, арга барил, заавар журам, аргачлал зэргийг боловсруулан мөрдөж ажиллана.
- 1.5. Банкнаас энэ журмын дагуу хийсэн активын эцсийн ангилал, байгуулсан эрсдэлийн сан нь Монголбанкны зүгээс энэ журмын дагуу холбогдох активт тогтоосон ангилал, харгалзах эрсдэлийн сангийн хэмжээ нь зөрүүтэй байх тохиолдолд банк нь Монголбанкны ангилал болон эрсдэлийн сангийн хэмжээг дагаж мөрдөнө.
- 1.6. Банк нь активын ангиллыг энэ журмын 2.1.1-д заасан үндсэн ангиллаас илүү олон төрлөөр дотооддоо хийж болох бөгөөд уг дотоод ангиллыг энэ журамд заасан ангилалд буцаан хөрвүүлэх боломжтой байхаар боловсруулна.
- 1.7. Энэ журамд заасан активын ангилал, эрсдэлийн сангийн доод шаардлагын хэрэгжилтийн тайланг Банк нь өөрийн дотоод ангилал, аргачлалын тооцооллын хамт энэ журмын 3.6.1-д заасан хугацаанд багтаан Монголбанкинд тайлагнана.
- 1.8. Банк нь активын ангиллыг үнэн зөв тогтоож, харгалзах эрсдэлийн сангийн түвшин, хэмжээг зохистойгоор тооцох үүрэгтэй бөгөөд энэ журмаар тогтоосон доод шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

- 1.9. Энэ журмын дагуу банкнаас хийсэн активын ангилал, байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээ нь энэ журмаар тогтоосон доод шаардлагыг хангасан эсэхийг Монголбанкнаас шалгаж, доод шаардлагыг хангаагүй активын ангиллыг өөрчилж, дутуу байгуулсан эрсдэлийн санг нэмж байгуулах арга хэмжээг тухай бүр авна.
- 1.10. Банкнаас энэ журмын 1.4-т заасан дотоод журам, аргачлалаар тогтоосон активын ангилал нь энэ журмаар тооцох ангиллаас доогуур байгаа тохиолдолд банкны дотоод аргачлалаар тогтоох ангиллыг мөрдөнө.
- 1.11. Энэ журмын 1.4-т заасан банкны дотоод аргачлалын дагуу тооцсон активын эрсдэлийн сангийн хэмжээ энэ журмын дагуу тооцсон эрсдэлийн сангаас их байгаа тохиолдолд банкны дотоод аргачлалаар тооцсон эрсдэлийн санг ашиглана.
- 1.12. Дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 1.12.1. “Актив” гэж зээл, зээлтэй адилтган тооцох бусад активыг;
- 1.12.2. “Зээл” гэж гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгийг;
- 1.12.3. “Бусад актив” гэж зээлтэй адилтган тооцохуйц зээлээс бусад тэнцэл дэх актив, Төв банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цааснаас бусад төрлийн үнэт цаас; тэнцлийн гадуурх баталгаа, батлан даалт, аккредитив, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хэлцлийн дагуу хүлээж болзошгүй үүрэг зэрэг банкны үйл ажиллагаатай холбоотойгоор ирээдүйд банкинд шаардах эрх, авлага буюу активын эрсдэл үүсгэхээр байгаа үүргийг;
- 1.12.4. “Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.8-д заасныг;
- 1.12.5. “Хамааралтай актив /Multiple facilities/” гэж энэ журмын 2.2.2-д заасан нөхцөлийг хангасан активыг;
- 1.12.6. “Активын эрсдэл” гэж төлбөр хариуцагчаас банктай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу хүлээн авсан активын төлбөрийг, харгалзах хүүгийн хамт заасан хугацаанд тодорхой хэсгийг эсвэл бүхэлд нь эргэн төлөхгүй байх магадлалыг; эсвэл тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа баталгаа, батлан даалт болон бусад үүргийг банкнаас биелүүлэх магадлал нэмэгдэхийг;
- 1.12.7. “Активын эцсийн ангилал” гэж активт энэ журмын Хавсралт 1-д заасан хугацааны хүчин зүйлээр тогтоосон ангиллыг Хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлээр тогтоосон ангилалтай харьцуулж, аль доогуур шатлалаар тогтоосон активын ангиллыг;
- 1.12.8. “Зээлтэй адилтган тооцох өртөг” гэж энэ журмын 3.2.1.2 эсвэл 3.2.1.7-д заасны дагуу тооцсон дүнг;
- 1.12.9. “Эрсдэлийн төлөв” /Risk Profile/ нь төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой тоон мэдээллийг ашиглан төлбөр хариуцагчийн эрсдэлүүдийг тооцсон банкны ерөнхий дүгнэлт, үнэлгээг;

- 1.12.10. “Багцалсан актив” /pooled assets/ гэж банкнаас энэ журмын 2.7-д заасны дагуу нэгдсэн байдлаар багцалж, энэ журмын дагуу нийтэд нь эрсдэлийн сан байгуулахаар бүлэглэсэн активуудыг;
- 1.12.11. “Нэгж актив” гэж багцалсан активт багтаж байгаа тухайлсан активыг;
- 1.12.12. “Төлбөр төлөгдөхгүй байх магадлал /PD/” гэж Нягтлан бодох бүртгэлийн зааврын Хавсралт1 -ийн 4.3.Г-д тусгасан PD үзүүлэлтийг ойрын 12 сарын хугацаанд зээл болон бусад активын хувьд үндсэн болон хүүгийн төлбөр 90-ээс дээш хоногоор хэтрэх (дефолт) тохиолдлоор тооцсоныг;
- 1.12.13. “Алдагдал үүсэх магадлал /LGD/” гэж Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д тусгасан LGD үзүүлэлтийг зээл болон бусад активын хэмжээнд тооцсоныг;
- 1.12.14. “Алдагдал тодорхойлох хүчин зүйл /LIP/” гэж Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д тусгасан LIP үзүүлэлтийг зээл болон бусад активын хэмжээнд тооцсоныг;
- 1.12.15. “Активын эрсдэлийн параметр” гэж энэ журмын 1.12.12, 1.12.13 болон 1.12.14-т заасан үзүүлэлтүүд болон банкнаас активын эрсдэлийг тооцоход ашиглаж буй үзүүлэлтүүдийн аль нэгийг эсвэл нийтэд нь;
- 1.12.16. “Тусгай эрсдэлийн сан” гэж төлбөр хариуцагчид хамаарах тухайн нэг болон нийт актив, эсвэл багцалсан активыг энэ журамд тусгасан шалгуурын дагуу чанар нь буурсан талаар дүгнэлтэд үндэслэн холбогдох ангилал хийж, харгалзах эрсдэлийн сангийн хувиар тооцож байгуулсан дүнг;
- 1.12.17. “Ерөнхий эрсдэлийн сан” гэж нийт санхүүгийн салбарын болон тухайн банкны үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй активын эрсдэлийн ерөнхий түвшинд үндэслэн, тэнцлийн болон тэнцлийн гадуурх нийт активын үлдэгдлээс холбогдох эрсдэлийн сангийн хувиар тооцсон мөнгөн дүнг;
- 1.12.18. “Активын хүлээгдэж буй алдагдал” /expected loss/ гэж активын урт хугацааны тоон үзүүлэлт болон бусад мэдээлэлд үндэслэн банкны ойрын 1 жилийн хугацаанд активаас гарахаар хүлээгдэж буй хохирол, алдагдлын дундаж үнэлгээ (арифметик, жигнэсэн болон статистикийн бусад дундаж хэмжигдэхүүн)-г банкнаас тогтоож тусгай эрсдэлийн сан байгуулахаар дотоод аргачлалдаа ашигласныг;
- 1.12.19. “Бүтэц өөрчлөгдсөн актив” гэж энэ журмын 2.4.1-т заасан шалгуурыг хангасан активыг;
- 1.12.20. “Ангилал буурсан актив” гэж активыг энэ журамд заасан хүчин зүйлсийн үнэлгээ эсвэл банкны дотоод журам, аргачлалаар үнэлэхэд гэрээнд заасан хугацаанд төлбөр нь бүрэн болон хэсэгчлэн эргэн төлөгдөх боломж буурсан активыг;
- 1.12.21. “Төлбөр хэтрэлт /дефолт/”-ийг дор дурдсан нөхцөлүүдийн аль нэг тохиолдсон үед тухайн нэг төлбөрийн хариуцагчид хамаарах активын хувьд үүссэн гэж үзнэ. Үүнд:
 - 1.12.21.1. Төлбөр хариуцагчаас эргэн төлбөл зохих актив нь материаллаг хэмжээгээр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн. Актив нь овердрафт бол төлбөр хариуцагчийн зүгээс банкнаас санал болгосон хязгаараас хэтрүүлж зарцуулсан эсвэл банкны зүгээс зарцуулж болох дээд хязгаарыг бууруулсан;

- 1.12.21.2. Хугацаандаа төлөгдөж байгаа эсвэл хугацаа хэтэрсэн эсэхээс үл хамаарч, төлбөр хариуцагчаас активын барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулахгүйгээр, активыг (үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлт зэрэг) анхны болон шинэ гэрээнд заасан нөхцлийн дагуу бүхэлд нь эргэн төлөх боломжгүй болсон талаар банкнаас дүгнэсэн.
- 1.12.22. “Хувьсах нөхцөлтэй актив” /revolving facility/ гэж банкнаас овердрафт, зээлийн эрхтэй төлбөрийн карт, зээлийн шугам зэрэг санхүүжилтийн хэмжээ, хугацаа, давтамж, дээд хязгаар болон бусад нөхцөлийг төлбөр хариуцагчийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан бусад активтай харьцуулахад уян хатан, тодорхой хязгаарт багтаан олон давтамжтайгаар олгохыг зөвшөөрсөн тухайн нэг эсвэл багцалсан активыг;
- 1.12.23. “Үр ашигт хүүгийн түвшин” гэж Банкны нягтлан бодох бүртгэлийн зааврын 1 дүгээр бүлэгт тодорхойлсныг;
- 1.12.24. “Өмчлөх бусад хөрөнгө” гэж Банкны нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5.Б-д тодорхойлсныг;
- 1.12.25. “Доогуур ангилал” гэж тухайн активт харгалзах ангиллуудын хамгийн доод ангиллыг;
- 1.12.26. “Давхар барьцаа хөрөнгө” гэж банкны төлбөр хариуцагчид олгосон активт хамаарах нэг болон түүнээс дээш барьцааны зүйлийг тухайн банкны өөр төлбөр хариуцагчид давхар барьцаалахыг;
- 1.12.27. “Нэг батлан даагч” гэж банкны төлбөр хариуцагчид олгосон активыг батлан даагч нь тухайн банкны өөр төлбөр хариуцагчид олгосон активыг давхар даахыг;
- 1.12.28. “Материаллаг байдал” гэж дор дурдсан нөхцлийг:
- 1.12.28.1. ямарваа зүйлүүдийг орхигдуулснаас эсвэл буруу тооцож, тайлагнасанаас шалтгаалан харилцагчдын эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх байдлыг (Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдалд орхигдуулсан, буруу тайлагнасан зүйлийн онцлог шинж, тоо хэмжээнээс шалтгаална.);
- 1.12.28.2. Активын үнэлгээнд тусгасан эсвэл орхигдуулснаас шалтгаалан активын чанар болон эцсийн ангилалд мэдэгдэхүйц байдлаар нөлөөлөх хэмжээ, түвшин эсвэл өөрчлөлтийн хувийн үзүүлэлтээр активын үнэлгээнд тусгах тохируулгыг.
- 1.12.29. “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар” гэж Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материалыг.

ХОЁР. АКТИВЫГ АНГИЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Нийтлэг үндэслэл

2.1.1. Банк нь энэ журмын 2.7.1.-д заасан Багцалсан активаас бусад активын ангиллыг энэ журмын Хавсралт 1-д заасан хугацааны болон Хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлд тулгуурлан дор дурдсан ангиллаар тус, тусад нь хийж, аль доогуур үнэлгээгээр эцсийн ангиллыг тогтооно:

2.1.1.1. Хэвийн

2.1.1.2. Анхаарал хандуулах;

2.1.1.3. Чанаргүй ангилал, үүнээс:

2.1.1.3.а. Хэвийн бус;

2.1.1.3.б. Эргэлзээтэй;

2.1.1.3.в. Муу.

- 2.1.2. Банк нь активын ангиллыг энэ журмын 2.1.1.-д заасан үндсэн ангиллаас илүү олон төрлөөр дотооддоо хийж болох бөгөөд уг дотоод ангиллыг энэ журамд заасан ангилалд буцаан хөрвүүлэх боломжтой байхаар боловсруулна.
- 2.1.3. Тэнцлээс гадуурх активаас бусад активын Зээлийн мэдээллийн санд шилжүүлэх ангиллыг зөвхөн хугацааны хүчин зүйлийн үнэлгээнд харгалзах ангиллаар тооцож хүргүүлнэ.
- 2.1.4. Тэнцлээс гадуурх активын эцсийн ангиллыг Зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ.
- 2.1.5. Чанарын хүчин зүйлээр хэвийн ангиллаар үнэлэгдсэн боловч хугацаа хэтэрсэн зээлийг төлбөр хариуцагчаас банкнаас үзүүлэх санхүүгийн дэмжлэггүйгээр хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэний хувьд 15 хүртэлх хоног, аж ахуйн нэгжийн хувьд 30 хүртэлх хоногт багтаан эргэн төлөх боломжтой талаар банкны зүгээс дүгнэвэл уг зээлийг хэвийн ангилалд бүртгэж болно. Энэхүү зээлийн эргэн төлөлт нь дээр заасан хоногоос хэтрэх тохиолдолд тус зээлийг энэ журамд заасан аргачлалын дагуу ангилал бууруулан тооцно.
- 2.1.6. Активын чанарын ангиллыг энэ журмын Хавсралт 2-г заасны дагуу тогтоохдоо журмын Хавсралт 5, Хавсралт 6-д заасан харгалзах хүчин зүйлсийн жагсаалтад өгсөн үнэлгээг ашиглана.
- 2.1.7. Банкнаас өөрийн дотоод аргачлалаар тогтоосон активын ангилал нь энэ журмын дагуу хийсэн ангиллаас доогуур бол уг дотоод үнэлгээгээр активын ангиллыг тогтооно.
- 2.1.8. Активын хугацааны болон чанарын хүчин зүйлийн үнэлгээнд орсон өөрчлөлтийг банкнаас тухай бүр тогтоож, энэ журмаар тогтоосон шаардлагын дагуу ангиллыг сард нэг удаа буюу тухайн сарын сүүлийн ажлын өдөрт багтаан хийнэ.
- 2.1.9. Банк нь дотоод аргачлалын дагуу активын ангиллыг энэ журмын 2.1.8-д зааснаас илүү давтамжтайгаар хийж болно.
- 2.1.10. Активын хэлбэрийг өөрчилсөн тохиолдолд хэлбэр өөрчлөгдөхөөс өмнөх ангиллыг хэвээр хадгалж, түүнд үндэслэн энэ журмын дагуу дараагийн ангиллыг хийнэ. Активыг төлүүлэх, худалдах зорилгоор өмчлөх бусад хөрөнгийг активын барьцаанд авсныг активын хэлбэр өөрчлөгдсөнд тооцохгүй бөгөөд өмчлөх бусад хөрөнгийг энэ журамд заасны дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.
- 2.1.11. Банк нь байгууллага, аж ахуйн нэгжид олгосон активын чанарын ангиллыг тогтооход ашиглах санхүүгийн тайланг улирал болгон гаргуулан авч судалгаа тооцоо хийх бөгөөд санхүүгийн тайланг оны эцэст аудитаар баталгаажуулсан байх шаардлагыг тавина.

2.2. Хамааралтай активууд (Multiple facilities)

2.2.1. Нэг төлбөр хариуцагч болон түүнтэй хамааралтай бусад төлбөр хариуцагчдад олгосон активт ангилал хийхдээ нийт хамааралтай активын үлдэгдлийн төлбөр барагдуулах магадлал, боломжийн хувьд ялгаатай байгаа хэсгээс бусад хэсэгт ижил ангилал тогтооно. Уг магадлал, боломж нь ялгаатай гэж үзсэн активын нийт хамааралтай активын үлдэгдэлд эзлэх дүн нь 25 хувиас дээшгүй байна.

2.2.2. Дараах нөхцөл бүрдсэн нэг болон хэд, хэдэн төлбөр хариуцагчид олгосон активыг нэгтгэн хамааралтай активт тооцно:

2.2.2.1. Нэг батлан даагчтай болон нэг батлан даалт, баталгаатай, давхар барьцаа хөрөнгөтэй эсвэл өөр хоорондоо батлан даалт, баталгаа гаргасан, санхүүгийн үйл ажиллагааны хувьд харилцан хамааралтай төлбөр хариуцагчид;

2.2.2.2. Хувь эзэмшлийн бүтэц, бүрэлдэхүүн болон материаллаг түвшинд төлбөр хариуцагчид хяналт тогтоох боломжтой гэж Монголбанк эсвэл банкнаас дүгнэсэн, удирдлагын хувьд хоорондоо холбоотой төлбөр хариуцагчид;

2.2.2.3. Тухайн төлбөр хариуцагчийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд хяналт тогтоох, нөлөөлөл үзүүлэх боломжтой талаар банк эсвэл Монголбанкнаас холбогдох баримтад үндэслэн дүгнэсэн бусад төлбөр хариуцагчид;

2.2.2.4. Төлбөр хариуцагчтай үйл ажиллагаа, борлуулалт, дамжуулалтын сувгаар дамжуулан нягт хамааралтай үйл ажиллагаа явуулдаг нь банкны зүгээс цуглуулсан баримт, мэдээ, мэдээллээр дүгнэсэн бэлтгэн нийлүүлэгчид;

2.2.2.5. Банк эсвэл Монголбанкнаас энэ журмын 2.2.2.1-2.2.2.4-т зааснаас бусад үндэслэлээр ижил төрлийн буюу нийтлэг нэг эрсдэл үүсгэхээр байна гэж дүгнэсэн активын төлбөр хариуцагчид.

2.2.3. Энэ журмын 2.2.2-д заасан хамааралтай активуудад дор дурдсанаас бусад тохиолдолд нэг ангилал тогтооно. Үүнд:

2.2.3.1. Төлбөр хариуцагчдад олгосон активууд нь давхар барьцаа хөрөнгөгүй эсвэл нэг батлан даагчгүй;

2.2.3.2. Давхар барьцаа хөрөнгө эсвэл батлан даагчтай боловч хамааралтай активын чанар муудахад харгалзах нийт үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай барьцаа хөрөнгөтэй буюу гуравдагч этгээдээр үүргийг гүйцэтгүүлэх боломжтой, мөн ижил барьцаа хөрөнгөөр үүргийг гүйцэтгэлийг хангуулахад тэргүүн ээлжинд хангагдах боломжтой талаар банк эсвэл Монголбанкнаас дүгнэсэн.

2.2.4. Нэг төлбөр хариуцагчид хамаарах хамааралтай активуудын материаллаг хэсгийг чанаргүй ангилалд үнэлэхээр байгаа тохиолдолд уг төлбөр хариуцагчид олгосон бусад активын эцсийн ангиллыг бүхэлд нь чанаргүй ангиллаар тогтооно. Энэ шаардлага нь иргэд болон өрх гэрт олгосон активт хамаарахгүй бөгөөд эдгээрт чанаргүй ангилал тогтоох эсэхийг актив тус бүрийн үнэлгээгээр шийдвэрлэнэ.

2.2.5. Нэгээс дээш төлбөр хариуцагчдад олгосон активууд нь хамааралтай активууд бөгөөд тэдгээрийн аль нэг активыг чанаргүйд ангилах нь уг хамааралтай активууд дахь бусад активыг

чанаргүйд ангилах үндэслэл болохгүй. Уг чанаргүй активыг хамааралтай активт харгалзах бусад төлбөр хариуцагчдын санхүүгийн чадамж, нөхцөл байдалтай харьцуулж, үнэлсний үндсэнд хамааралтай активын бусад хэсэгт чанаргүй ангилал тогтоох эсэхийг шийдвэрлэнэ.

2.2.6.Банкин дахь активуудын хамаарлыг төлбөр хариуцагчаар дамжуулан тогтоохдоо Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан “Холбогдох этгээд”-ийн тодорхойлолтын агуулга, зарчимтай уялдуулсан байна.

2.2.7.Банк нь бусад санхүүгийн байгууллагатай хамтран нэг төслийг санхүүжүүлэх зорилгоор хамтын санхүүжилтийн активыг нэг актив гэж тооцож, оролцогч банк тус бүрт бүртгэлтэй холбогдох активуудад нэг эцсийн ангилал тогтооно. Хамтын санхүүжилтийн активын хяналтыг аль нэг банк нь дангаараа хэрэгжүүлж болох бөгөөд энэ талаар холбогдох гэрээ, хэлцэлд тодорхой заасан байна. Уг гэрээнд хамтын санхүүжилтийн активтай холбоотой үүсэх эрсдэлийг оролцогч банк тус бүрээр тодорхой тусгасан байна.

2.3. Тэнцлийн гадуурх актив

2.3.1.Тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусад актив, (хүлээж болзошгүй) үүргийг энэ журмын хавсралт 2-т заасан чанарын хүчин зүйлээр үнэлж тогтооно.

2.3.2.Тэнцлийн гадуур бүртгэлтэй баталгаа, батлан даалт болон бусад хүлээж болзошгүй үүргийг банкаар хангуулахаар гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдэд Банк эсвэл Монголбанкнаас дараах нийтлэг нөхцөл байдал үүссэн талаар дүгнэсэн тохиолдолд холбогдох активын ангиллыг бууруулна. Үүнд:

2.3.2.1. Санхүүгийн болон төлбөрийн чадварын үзүүлэлт муудсан эсвэл сүүлийн үед эрчимтэй муудаж байгаа, үйл ажиллагаа эрхэлдэг салбарт аливаа хүндрэл, доголдол үүссэнээс банкнаас гэрээнд заасан болзошгүй үүргийг биелүүлсний дараа төлбөр хариуцагчаас шаардлагатай авлагыг хугацаанд нь, түргэн шуурхай төлүүлэх боломж багассан талаар дүгнэсэн;

2.3.2.2. Буцаан дуудахгүй (irrevocable) нөхцөлтэй зээлийн шугам болон түүнтэй адилтгах бусад активаар банкнаас санхүүжилт авах эрхтэй этгээдийн зээлжих чадвар, санхүү болон төлбөрийн чадвар муудсанаас ирээдүйд авах активын үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх боломж багассан талаар дүгнэсэн;

2.3.2.3. Банктай үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа хийх гэрээ, хэлцэл байгуулсан талын (counterparty) санхүүгийн болон төлбөрийн чадвар муудсан, муудах эрсдэл нэмэгдсэн, эсвэл зээлжих чадвар буурсан талаар зэрэглэл тогтоох олон улсын болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон зэргээс шалтгаалан банкнаас холбогдох арилжаанаас орох мөнгөн урсгалыг бүрэн хэмжээгээр авч чадахааргүй талаар дүгнэсэн.

2.3.3.Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн ангиллыг энэ журмын 2.3.1-д заасны дагуу тогтоохдоо холбогдох гэрээнд тусгасан хэлцлийн хэрэгжих хугацаа, холбогдох гэрээнд заасан бол болзошгүй үүргийг биелүүлсний дараах төлбөр хариуцагчаас авах авлагын эргэн төлөлтийн хуваарийг харгалзан үзнэ.

2.3.4.Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлсний дараа тэнцлийн доторх холбогдох активын төрөл, үлдэгдэл дүнгээр бүртгэж энэ журмын 2.1.10 болон активын ангилал, эрсдэлийн санг байгуулахтай холбоотой бусад шаардлагыг банкнаас мөрдөж ажиллана.

2.4. Бүтэц өөрчлөгдсөн актив

2.4.1. Төлбөр хариуцагчид учирсан санхүүгийн хүндрэлээс шалтгаалан банкны дүгнэлт эсвэл төлбөр хариуцагчийн хүсэлтийг харгалзан активын нөхцөлд хөнгөлөлт үзүүлсэн тэнцлийн болон тэнцлийн гадуурх активыг бүтэц өөрчлөгдсөн актив гэж үзнэ. Доорх болон түүнтэй адилтгах бусад нөхцөлүүдийг хөнгөлөлттэй нөхцөл гэж үзнэ:

2.4.1.1. Анхны гэрээнд заасан активын эргэн төлөгдөх хуваарьт хүүгээс чөлөөлөх хугацаа сунгах (grace period), зөвхөн хүү төлөх хугацааг сунгах, үндсэн төлбөрийг хугацааны сүүл хэсэгт их дүнтэйгээр төлүүлэхээр хуваарилах (balloon payment) эсвэл хугацааны эцэст бүхэлд нь төлүүлэх (bullet payment) зэрэг өөрчлөлт оруулсны үр дүнд сар, улирал, хагас жил, жил бүрийн болон түүнээс дээш давтамж бүрт төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмжээг өөрчлөн тогтоосон;

2.4.1.2. Зах зээлийн ерөнхий нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд хүүгийн түвшинг анх гэрээнд тохирсон түвшнээс өөрчлөн (хойшлуулах, цуцлах гэх мэт) тогтоосон;

2.4.1.3. Хуримтлагдсан хүүгийн авлагыг хүүг бүхэлд нь болон хэсэгчлэн хөнгөлөх, чөлөөлөх байдлаар бууруулсан;

2.4.1.4. Хүүгийн авлагыг бүхэлд нь болон хэсэгчлэн үндсэн төлбөрт шингээн шинэ үндсэн төлбөрийг тогтоосон буюу хүүг капиталжуулсан;

2.4.1.5. Эргэн төлөгдөх хугацаа эсвэл хуваарийг (хүү, үндсэн төлбөрийн давтамж) хойшлуулахдаа, хүүгийн түвшинг ижил эрсдэлийн төлөвтэй, шинээр олгож буй активын хүүгийн ерөнхий түвшингээс доогуур тогтоосон;

2.4.1.6. Эргэн төлөгдөх хугацаа болон хуваарийг (хүү, үндсэн төлбөрийн давтамж) сунгахдаа ижил эрсдэлийн төлөвтэй активын эргэн төлөгдөх хугацаанаас материаллаг түвшинд ялгаатайгаар буюу урт хугацаагаар сунгасан;

2.4.1.7. Барьцаа хөрөнгийг чөлөөлөх эсвэл Зээл-Үнэлгээний харьцаа (LTV) нь зөвшөөрөгдөх түвшнээс муудсан;

2.4.1.8. Төлбөр хариуцагчийн өрийг хувьцаанд хөрвүүлэх (хувьцаат капитал);

2.4.1.9. Үүргийн гүйцэтгэлийг хангуулах, төлбөр барагдуулах хугацааг сунгах;

2.4.1.10. Активын гэрээнд тусгасан нөхцөл (covenants)-ийг хөнгөлөх.

2.4.2. Активыг бүтэц өөрчлөгдсөнд тооцоход банк болон төлбөр хариуцагчийн хооронд активын шинэ нөхцөлийг харилцан тохиролцож, гэрээ байгуулна.

2.4.3. Бүтэц өөрчлөгдсөн актив тус бүрийн хувьд нөхцөл, хугацаа, хэмжээнд өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шалтгаан, төлбөр хариуцагчийн активыг эргэн төлөх чадвар нь шинэ нөхцөлтэй нийцсэн, эргэн төлөлт хийх боломжтой байгаа эсэхийг банкнаас өөрийн дотоод аргачлал, үнэлгээгээр баталгаажуулж, банкны удирдлагын түвшинд эсвэл түүнтэй адилтгах хорооноос активын бүтцийг өөрчлөх эсэх талаар шийдвэрлэнэ. Банк нь зөвхөн төлбөр хариуцагчаас бүтэц өөрчлөгдсөн активыг шинэ нөхцлийн дагуу хугацаанд нь, бүхэлд нь төлж барагдуулах боломжтой гэж үнэлсэн тохиолдолд активын бүтцийг өөрчилнө.

- 2.4.4. Активыг бүтэц өөрчлөгдсөн активт шилжүүлэхтэй холбоотойгоор одоогийн үүссэн болон ирээдүйд үүсэх алдагдал, үнэ цэнийн бууралтыг банкны санхүүгийн тайланд тухай бүрт тусгана.
- 2.4.5. Активын бүтцийг өөрчилсний үр дүнд тус активт тавигдах нөхцөл нь шинээр олгож буй ижил эрсдэлийн төлөвтэй активын нөхцөлтэй ижил бөгөөд активын бүтцийн өөрчлөлт нь төлбөр хариуцагчийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалаагүй бол уг активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй.
- 2.4.6. Банкнаас хэрэглээний зориулалттай олгосон активаас бусад активын төлбөр хариуцагч хуулийн этгээдийн зээлжих болон төлбөрийн чадвар найдвартай боловч үйл ажиллагаа эрхэлж буй салбар эсвэл өөрийн дотоод онцлогоос шалтгаалж түр хугацааны санхүүгийн хүндрэл учирсан ч төлбөр хариуцагчаас тухайн хугацаанд багтаан хэвийн үйл ажиллагаа эрхэлж, активын үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг анхны гэрээнд заасан нөхцөлөөр бүрэн хэмжээгээр эргэн төлөх чадвартайг өөрийн дотоод аргачлал, үнэлгээгээр тогтоож, баталгаажуулсан тохиолдолд активын эргэн төлөх хугацааг сунгахгүйгээр активын гэрээний эргэн төлөгдөх нөхцөлд 12 сараас дээшгүй хугацаагаар өөрчлөлт оруулсан активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй байж болно. Энэ хугацаанд төлбөр хариуцагчийн санхүүгийн байдал сайжрахгүй, эргэн төлөлтийн хоцролт үүссэн тохиолдолд гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан хугацаанаас эхлэн бүтэц өөрчлөгдсөн активт тооцож холбогдох ангилал, эрсдэлийн санг энэ журамд заасан бүтэц өөрчлөгдсөн активтай холбоотой заалтын хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 2.4.7. Хэвийн болон чанаргүй активыг бүтэц өөрчлөгдсөн ангилалд тогтоож болно. Чанаргүй активын бүтцийг өөрчлөх тохиолдолд тус активыг чанаргүй ангилалд хэвээр үлдэнэ. Хэвийн активын бүтцийг өөрчлөхөд, активт тавих шинэ нөхцлөөс үл хамаарч тус активыг чанаргүй активын нөхцлийг хангаж буй эсэхийг үнэлнэ. Хэрэв активын бүтцийг өөрчлөхөөс өмнө буюу хөнгөлөлттэй нөхцөл тавихаас өмнө уг актив нь чанаргүй ангилалд шилжихээр байгаа бол бүтэц өөрчлөгдсөн активыг чанаргүй ангилалд ангилна.
- 2.4.8. Нэг активын бүтцийг хэвийн болон ангилал буурсан хэсгүүдэд хэсэгчлэн хувааж, тусад нь ангилахыг хориглоно.
- 2.4.9. Активын бүтцийг төлбөр хариуцагчид учирсан санхүү, төлбөрийн чадварын хүндрэлийг нуун дарагдуулах, эргэн төлөгдөх төлбөрийн хэмжээг хойшлуулах, активын ангиллыг чанаргүй ангилалд шилжүүлэх болон банкнаас шаардлагатай эрсдэлийн сан байгуулахаас зайлсхийх зорилгоор өөрчлөхийг хориглоно.
- 2.4.10. Банкнаас зөвхөн энэ журмын 2.9.1-д заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан бүтэц өөрчлөгдсөн активт хэвийн ангилал тогтоож болно.
- 2.4.11. Дор дурдсан хоёр нөхцлийг зэрэг хангасан активыг бүтэц өөрчлөгдсөн ангиллаас хасч болно.
Үүнд:
- 2.4.11.1. Шинэ гэрээний нөхцлийн дагуу сүүлийн 6 сарын турш (тайлагнах доод шаардлага) төлбөл зохих активын төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлж байсан. Бүтэц өөрчлөх үед активын хэвийн эсвэл чанаргүй эцсийн ангилалд байгаагаас үл хамаарч эргэн төлөлтийн хоног тооцох хугацааг активын бүтцийг өөрчилснөөс хойш төлөгдөх анхны эргэн төлөлтөөс эхлэн тооцно.
- 2.4.11.2. Төлбөр хариуцагч нь санхүүгийн хүндрэлээ шийдвэрлэсэн.

- 2.4.12. Энэ журмын 2.9.1-д заасан өөрчлөлтийг бүтэц өөрчлөгдсөн активт нэг удаа хэрэгжүүлж болно.
- 2.4.13. Чанарын ангиллаас үл хамаарч, энэ журмын 2.9.1-д заасан шаардлага, нөхцөлийг активын бүтцийг өөрчилсөн болон түүнээс хойшх хугацаанд хангаагүй бүтэц өөрчлөгдсөн активын хугацааны ангиллыг анхны гэрээнд тусгасан эргэн төлөгдөх хуваарьт үндэслэн тооцно.
- 2.4.14. Банк нь төлбөр хариуцагч болон түүний холбогдох этгээдэд актив болон харгалзах хүүг нэмж актив олгох, эх үүсвэр байршуулах зэргээр төлүүлэхийг хориглоно.

2.5. Өмчлөх бусад хөрөнгө

- 2.5.1. Өмчлөх бусад хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн зааварт заасны дагуу худалдан борлуулах зориулалттай, банкны үйл ажиллагаанд ашиглагдахгүй үл хөдлөх хөрөнгө (цаашид үл хөдлөх хөрөнгө), хөдлөх хөрөнгө, үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгөнд төрөлжүүлэн, төрөл тус бүрт ангилал хийнэ.
- 2.5.2. Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөнд хамаарах өмчлөх бусад хөрөнгийн ангиллыг зөвхөн энэ журмын Хавсралт 1.б.-д заасан хугацааны хүчин зүйлээр ангилна.
- 2.5.3. Үл хөдлөх, хөдлөх хөрөнгөөс бусад өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын Хавсралт 1.а.-д заасан холбогдох активт харгалзах хугацааны, Хавсралт 2-т заасан чанарын үнэлгээгээр тооцож, эцсийн ангилалыг Хавсралт 3.а.-ын дагуу тогтооно.
- 2.5.4. Банк нь өмчлөх бусад хөрөнгийг дотоод хэрэгцээнд ашиглахаар төлөвлөж байгаа бол уг шийдвэрийг тухайн хөрөнгийг өмчлөлд авах үед гаргаж, Монголбанкнаас уг хөрөнгийг холбогдох дансанд бүртгэх зөвшөөрлийг авна. Банкны өмчлөх бусад хөрөнгөнд хамаарах үл хөдлөх хөрөнгө ашиглалтад ороод 5-аас ихгүй, хөдлөх хөрөнгийн хувьд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 1-ээс ихгүй жил өнгөрсөн бол энэ журмын 2.5.2-д заасан үнэлгээгээр тооцсон хэвийн активаас бусад активын эцсийн ангиллыг нэг ангиллаар нэмэгдүүлж болно.
- 2.5.5. Банкнаас ашиглах зорилгыг хараахан тодорхойлоогүй Өмчлөх бусад хөрөнгийг банкны эзэмшилд анх шилжүүлэхдээ үнэт цаасны хувьд Бусад санхүүгийн хөрөнгө, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн хувьд Бусад санхүүгийн бус хөрөнгө дансанд бүртгэнэ.
- 2.5.6. Өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын 2.5.5-т заасны дагуу банкны эзэмшилд бүртгэснээс хойш 1 сарын хугацаанд багтаан ашиглах зориулалтыг тодорхойлж, Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5.Г-д заасны дагуу Бусад хөрөнгийн харгалзах данснаас банкнаас ангилахаар шийдвэрлэсэн дансанд шилжүүлэх эсвэл шилжүүлэх боломжгүй гэж үзсэн активыг Бусад хөрөнгийн дансанд хэвээр үлдээж бүртгэнэ.
- 2.5.7. Үнэт цаас хэлбэрээр эзэмшиж байгаа Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын 2.5.5-2.5.6-д заасан зарчмаар бүртгэж энэ журмын үнэт цаасанд хийх ангилал, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой шаардлагыг дагаж мөрдөнө.
- 2.5.8. Банкнаас санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийг дотоод хэрэгцээнд ашиглах зөвшөөрлийг Монголбанкнаас авсан бол өмчлөх бусад хөрөнгийг уг хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшх 3 сарын хугацаанд багтаан Үндсэн хөрөнгө болон эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтойг

үндэслэн Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх бөгөөд эдгээр хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулахгүй.

- 2.5.9. Энэ журмын 2.5.8-д заасан хөрөнгийн холбогдох ангиллын шинж чанар болон ашиглалтын зорилго алдагдах тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийн холбогдох дансанд буцаан шилжүүлж, харгалзах эрсдэлийн санг байгуулах бөгөөд уг шилжүүлсэн гүйлгээг буцаахгүй.
- 2.5.10. Өмчлөх бусад хөрөнгөөс Үндсэн хөрөнгөнд шилжүүлэх хэмжээг “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан үндсэн хөрөнгийн зохистой харьцааг хангахуйц байдлаар тогтооно.
- 2.5.11. Худалдан борлуулах зорилготой буюу худалдан борлуулах магадлал өндөртэй Санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийг Борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэнэ. Уг дансанд хүлээн зөвшөөрч, бүртгэснээс хойш худалдааны хэвийн нөхцөлөөр нэг жилийн дотор худалдан борлуулах шаардлагатай бөгөөд энэ хугацаанд тус хөрөнгийн тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.5, 4.6-д заасны дагуу үнэ цэнийн бууралтаар тооцож энэ журмын Хавсралт 4.в.-д заасан Активын тусгай эрсдэлийн сангийн хүрэлцээний дэлгэрэнгүй тайлангийн Өмчлөх бусад хөрөнгөнд харгалзах хүснэгтэд холбогдох дүнг тусгана.
- 2.5.12. Энэ журмын 2.5.11-д заасан хөрөнгийг Борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэснээс хойш нэг жилийн хугацаанд худалдан борлуулаагүй бол Санхүүгийн бус Өмчлөх бусад хөрөнгөнд буцаан шилжүүлнэ. Буцаан шилжүүлсэн хөрөнгийг энэ журмын Хавсралт 1.б-д заасан хугацааны хүчин зүйлээр тооцох бөгөөд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.1-д заасан зээлийн барьцаанд байгаа орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө бол анх эзэмшилд авснаас хойших борлогдоогүй хоногт, бусад хөрөнгө бол буцаасан өдрөөс хойших борлогдоогүй хоногт тус тус үндэслэн холбогдох ангиллыг тодорхойлж, харгалзах тусгай эрсдэлийн санг Хавсралт 3.в.-д заасны дагуу байгуулна.
- 2.5.13. Энэ журмын 2.5.9 болон 2.5.12-д заасны дагуу Өмчлөх бусад хөрөнгөнд шилжүүлсэн хөрөнгийг дахин борлуулахад бэлэн эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төрөлд шилжүүлэхгүй.
- 2.5.14. Үл хөдлөх, хөдлөх хөрөнгөнд дотоод болон гадны нөлөөнөөс шалтгаалан эвдрэл учирсан, эсвэл цаашид ашиглах эсвэл борлуулах боломжгүй гэж мэргэжлийн үнэлгээний байгууллага эсвэл банкнаас дүгнэвэл дээрх хөрөнгийг хугацаа харгалзахгүй муу ангилалд шилжүүлнэ.

2.6. Үнэт цаас

- 2.6.1. Үнэт цаасыг зориулалт, банкны үнэт цаасны ангиллын бодлоготой уялдуулан Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу бүртгэнэ.
- 2.6.2. Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасыг банкны тэнцэл дээр болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байх хугацаанд үүссэн дараах тохиолдлуудад энэ журамд заасны дагуу ангилал тогтоож, холбогдох тусгай эрсдэлийн санг байгуулна. Үүнд:
- 2.6.2.1. Өрийн үнэт цаасны хуваарийн дагуу төлөгдөх хүү, үндсэн төлбөр хоцорсон эсвэл төлөгдөөгүй;

2.6.2.2. Өмчлөлийн үнэт цаасанд ногдол ашиг зарласан боловч заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилаагүй бол тухайн ногдол ашгийн дүнгээр;

2.6.2.3. Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар муудсан талаар банкнаас эсвэл эрх бүхий байгууллагаас мэдэгдсэн эсвэл татан буугдсан;

2.6.2.4. Холбогдох үнэт цаас нь банкинд активын эрсдэл үүсгэнэ гэж Монголбанк эсвэл банкнаас дүгнэсэн бусад үндэслэл.

2.6.3. Энэ журмын 2.6.2.3-т заасан нөхцөл өмчлөлийн үнэт цаасанд үүссэн тохиолдолд хугацааны хүчин зүйлийг Хэвийн ангилалд байхаар тооцож, чанарын хүчин зүйлийн үнэлгээтэй хослуулан үнэт цаасны эцсийн ангилал болон тусгай эрсдэлийн санг тогтооно.

2.6.4. Борлуулахад бэлэн ангилалд байгаа үнэт цаасны ангиллыг тогтоож, харгалзах тусгай эрсдэлийн санг байгуулахдаа энэ журмын 2.6.2.1-2.6.2.3, 2.6.3-д заасан шалгуурыг мөрдөнө.

2.6.5. Хугацааны эцэс хүртэл эзэмших болон Зээл, авлагын ангилалд буй үнэт цаасны ангиллыг энэ журамд заасан хугацааны болон чанарын хүчин зүйлээр тооцож, холбогдох тусгай эрсдэлийн санг Хавсралт 3.а.-д заасны дагуу тооцно.

2.6.6. Банкнаас охин, хараат болон хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтад ангилалд хийхгүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.2.-т заасны дагуу эрсдэлийн санг тооцож байгуулна.

2.6.7. Банк нь өмчийн үнэт цаасаар хөрөнгө оруулсан компанид Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.2-т заасны дагуу хяналт, мэдэгдэхүйц нөлөө эсвэл хамтын хяналт тогтоосон эсэхийг нотлох боломжгүй бол холбогдох үнэт цаасыг энэ журмын 2.6.4-д заасны дагуу ангилж, тусгай эрсдэлийн санг байгуулна.

2.6.8. Банк нь Хугацааны эцэс хүртэл эзэмших ангилалд байгаа үнэт цаасыг худалдан борлуулсан эсвэл уг ангилалд үнэт цаасыг бүртгэх эрхгүй болсон бол энэ талаар Монголбанкинд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

2.7. Багцалсан актив

2.7.1. Банкнаас дараах доод шаардлагыг нэгэн зэрэг хангасан активуудыг нэгтгэн багцалж болно. Үүнд:

2.7.1.1. Тухайн багцалсан активын үлдэгдэлд эзлэх нэг нэгж активын хувийн жин нь 2.0 хувиас ихгүй байх;

2.7.1.2. Багцын нэгж актив тус бүр нь бүтээгдэхүүний төрөл, шинж чанар, байршил, эргэн төлөлтийн хуваарь болон эрсдэлийн түвшин болон бусад нөхцөлийн хувьд хоорондоо ижил төстэй байх;

2.7.1.3. Багцын нэгж актив нь банкны 40 том зээлийн тоонд ороогүй эсвэл хамааралтай актив биш байх;

2.7.1.4. Банкны өөрийн ажилчдын орон сууцны зээл болон өөрийн ажилчдын цалингийн зээлээс бусад банкны холбоотой этгээдэд олгосон актив биш байх;

2.7.1.5. Нэг багцалсан активын нийт үлдэгдэл нь тухайн банкны 40 том зээлдэгчдэд олгосон активын нийлбэр дүнгийн 20 хувиас ихгүй байх.

2.7.2. Энэ журмын 2.7.1-д заасан шаардлагыг хангасан банкны үйл ажиллагааны хүрээнд жижиглэн, жижиг дунд үйлдвэрлэл эсвэл иргэнд олгосон актив гэж тодорхойлсон, бага дүнтэй, олон тооны активуудыг нэгтгэн багцалж болно.

2.7.3. Хувьсах нөхцөлтэй активуудыг нэгтгэн багцалсан активт тооцож болно.

2.7.4. Багцалсан актив дахь нэгж актив нэг бүрийн эцсийн ангиллыг хугацааны хүчин зүйлээр тусад нь хийх бөгөөд тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д заасан бүлгийн аргыг ашиглан нийт багцын хэмжээнд нэгтгэн үнэлнэ.

2.7.5. Багцын нэгж актив эргэн төлөгдсөн, эсвэл тэнцлийн гадуур бүртгэж багцаас хасагдсан бол энэ журмын 2.7.1-д заасан шаардлагыг хангасан активыг багцад нэмж оруулж болно.

2.7.6. Багцын нэгж актив тухайн багцын нийтлэг, ижил төстэй байдлыг агуулаагүй эсвэл алдагдсан, эсвэл өөрчлөгдсөн тохиолдолд уг нэгж активыг багцаас хасч активын эцсийн ангиллыг хугацаа болон чанарын хүчин зүйлээр тодорхойлно.

2.8. Банкнаас активыг ангилахтай холбоотой тавих шаардлага.

2.8.1. Активын эрсдэлийг удирдах, хянах үүргийг банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага хүлээх бөгөөд энэ журмын 1.4-т заасан активыг ангилах, активын эрсдэлийн дотоод удирдлагын бодлого, үйл явц, арга барил, журам, зааварт дараах асуудлуудыг зайлшгүй тусгасан байна.

2.8.1.1. Активын ангилал, эрсдэлийн сангийн бодлого, арга барил болон хяналтын үйл ажиллагааг банкны удирдлага, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагааны боловсронгуй байдал, цар хүрээ болон эрсдэлийн төлөвтэй уялдсан байхаар зохицуулах;

2.8.1.2. Активын ангилал, тусгай болон ерөнхий эрсдэлийн санг дотоод бодлого, нягтлан бодох бүртгэлийн заавар болон Монголбанкнаас энэ журмаар тогтоосон шаардлагатай нийцүүлэн хэрэгжүүлэх дотоод хяналтын нэгжийн ажил үүргийн хуваарь, эрх үүргийг нарийн тодорхойлох;

2.8.1.3. Активын эрсдэлийн удирдлагын нэгжийн үйл ажиллагааг банк, банкны нэгж нь активын эрсдэл, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн өөрчлөлттэй тухай бүр, цаг алдалгүй уялдуулж, тохируулах шаардлагатай бөгөөд активын эрсдэлийн удирдлагын бодлого, арга барилд дараах болон түүнтэй адилтгах бусад асуудлуудыг хэрэгжүүлэхээр тусгаж, баримтжуулсан байна. Үүнд:

- а. Активын чанарт хяналт тавих, тандах;
- б. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын чанарыг тухай бүр хэмжиж тооцох арга барил, үйл явц;
- в. Төлбөр хариуцагч, батлан даагчийн эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой үүсэх активын эрсдэлийн үнэлгээ;
- г. Барьцаа хөрөнгийн үнэлгээ;

- д. Чанар муудсан эсвэл эргэн төлөгдөх боломж багассан активын ангилал бууруулах, тэнцлээс гаргахад баримтлах арга барил;
- е. Активын ангилал болон эрсдэлийн сангийн үнэлгээг баталгаажуулах;
- ж. Активын эрсдэлийн сангийн хэмжээ нь банкинд активын үйл ажиллагаанаас бодитоор илэрсэн болон хүлээгдэж буй алдагдлыг барагдуулахад хангалттай байхаар тооцох аргачлалыг нэвтрүүлэх;
- з. Чанар муудсан, эрсдэлтэй активыг барагдуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой зохицуулалт, албадлагын арга хэмжээ;
- и. Активын эрсдэлийг тооцох статистик загварчлал болон бусад арга барилын үр дүнг буцаан шалгадаг, үр нөлөөг тооцох, баталгаажуулах аргачлалтай байх.

2.8.1.4. Активын эргэн төлөлтөд нөлөөлж болох хүчин зүйлс. Үүнд:

- а. Төлбөр хариуцагч эсвэл баталгаа гаргагч этгээдийн санхүү, төлбөрийн чадвар;
- б. Гэрээний нөхцөлийг зөрчих магадлал;
- в. Төлбөр хариуцагч (хуулийн этгээд) татан буугдах, дампуурах боломж эсвэл удирдлага, бүтэц өөрчлөгдөх нөхцөлүүд;
- г. Төлбөр хариуцагчид олгосон активын бүтэц, нөхцөлийг өөрчлөхөд тавигдах шаардлага, зөвшөөрөгдөх нөхцөлүүд;
- д. Активыг багцлан үнэлж байгаа бол тухайн багцад хамаарах активын төрлийн чанаргүй ангилалд шилжиж байсан хандлага, шилжилт хөдөлгөөнийг тооцох аргачлал;
- е. Барьцаа хөрөнгийн талаар баримтлах бодлого, активын чанарын үнэлгээг өөрчлөхөд нөлөөлөх барьцаа хөрөнгийн үнэлгээ, төрөл, хөрвөх чадвартай холбоотой нөхцөлүүд;
- ж. Төлбөр хариуцагч, төлбөр хариуцагчийн батлан даагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх бусад тохиолдол, нөхцөлүүд, тэдгээрт банкны зүгээс авах арга хэмжээ.

2.8.1.5. Банкны зүгээс активын чанарыг үнэлэхдээ тоон үнэлгээ болон активыг үнэлж байгаа мэргэжилтний ур чадварын хүрээнд өгсөн үнэлэлт дүгнэлтийг хэрхэн хослуулах, хязгаарлалт тогтоох нөхцөлүүдийг тодорхой тусгасан байна.

2.8.2. Төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан төлбөр хариуцагчид олгосон активын эцсийн ангиллыг эргэлзээтэй ангиллаас дээшгүй байхаар тогтооно.

2.8.3. Хууль хяналтын байгууллагаар гэмт хэргийн шинж чанартай үйлдлээс үүссэн байж болзошгүй шалтгаанаар шалгагдаж байгаа активын хугацааны эцсийн ангиллыг муу ангилалд тогтооно.

2.9. Ангилал буурсан активын ангиллыг дээшлүүлэх

2.9.1. Дараах нөхцөлүүд хамтдаа илэрсэн чанаргүй эцсийн ангилалтай актив болон бүтэц өөрчлөгдсөн активыг Хэвийн ангилал хүртэл нэмэгдүүлж болно:

2.9.1.1. Төлбөр хариуцагч нь 90-ээс дээш хоногоор хэтэрсэн материаллаг хэмжээний хугацаа хэтэрсэн төлбөргүй;

2.9.1.2. Сүүлийн 6 сар болон түүнээс дээш хугацаанд 3 удаагийн материаллаг хэмжээний эргэн төлөлтийг тогтмол хийсэн;

2.9.1.3. Төлбөр хариуцагчийн санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал сайжирснаар активыг анхны эсвэл шинэ гэрээний нөхцлийн дагуу бүхэлд нь төлж барагдуулах магадлал нэмэгдсэн;

2.9.1.4. Активт энэ журамд заасан төлбөр хэтрэлт (дефолт) болон нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан үнэ цэнийн бууралт үүсээгүй;

2.9.1.5. Монголбанкнаас хийсэн газар дээрх шалгалтын үнэлгээнд үндэслэн эцсийн ангиллыг дээшлүүлэхээр зөвшөөрсөн актив.

2.9.2. Энэ журмын 2.9.1-т заасны дагуу ангилал хийсэн активын эргэн төлөлтийг төлбөр хариуцагчаас активыг цаашид үргэлжлүүлэн авах, ангиллаа нэмэгдүүлэх сэдлээр хийсэн буюу активын чанар бодитоор сайжраагүй талаар банк эсвэл Монголбанкны зүгээс дүгнэвэл тус активын ангиллыг дээшлүүлэхгүй.

2.9.3. Энэ журмын 2.8.2 болон 2.8.3 заалтад хамаарах активт журмын 2.1.3, 2.9.1, 2.4.10-д заасан хөнгөлөлт болон ангилал дээшлүүлэх нөхцөл хамаарахгүй.

2.9.4. Одоогоор бүртгэлтэй байгаа чанаргүй активаас хэсэгчлэн тэнцлээс хассан (эргэн төлөгдөх боломжгүй гэж банкнаас үнэлсэн чанаргүй активын тодорхой хэсгийг тэнцлээс хассан зэрэг) бол уг активыг хэвийн ангилалд ангилахгүй.

ГУРАВ. АКТИВТ ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ

3.1. Активын эрсдэлийн сан байгуулах үндсэн шаардлага

3.1.1. Банкнаас байгуулах активын эрсдэлийн санг дор заасан төрлөөр зардлаар байгуулна. Үүнд:

3.1.1.1. Ерөнхий эрсдэлийн сан;

3.1.1.2. Тусгай эрсдэлийн сан.

3.1.2. Ерөнхий болон тусгай эрсдэлийн сангийн нийлбэрээр банкны нийт активын эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлно.

3.1.3. Активт байгуулах эрсдэлийн санг хүлээсэн (incurred) болон хүлээгдэж буй алдагдлуудыг барагдуулахад хангалттай хэмжээтэй байхаар банкнаас тогтооно. Банкны санхүүгийн тайланд тусгах активын эрсдэлийн сангийн дүнг энэ журмын дагуу тооцсон болон энэ журмын 1.4-т заасан дотоод аргачлалаар тооцсон активын эрсдэлийн сангийн дүнгийн аль ихээр тогтооно.

3.1.4. Активын эрсдэлийн санг энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

- 3.1.5. Банк нь удирдлагын үйл ажиллагааны зорилгоор өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлог болон бүтээгдэхүүн үйлчилгээний боловсронгуй байдалд тулгуурлан энэ журамд заасан активын эрсдэлийн сан байгуулах хувь, хэмжээг тооцох аргачлал болон эрсдэлийн сантай холбоотой бусад шаардлагаас ялгаатай байдлаар активын эрсдэлийн санг дотооддоо байгуулах аргачлалыг энэ журмын 1.4-т заасан баримт бичигт тусгаж, мөрдүүлж болно.
- 3.1.6. Банк нь активын эрсдэлийн сангийн тооцооллыг энэ журамд заасан доод шаардлагын дагуу хийхээс гадна өөрийн дотоод аргачлалын дагуу үнэн зөв гүйцэтгэж Монголбанкинд энэ журмын 3.6.1-т заасан хугацаанд тайлагнах үүрэгтэй.
- 3.1.7. Энэ журмын 1.4-т заасан дотоод аргачлалыг ашиглах болон активын ерөнхий болон тусгай эрсдэлийн санг Монголбанкинд тайлагнахдаа дараах хүчин зүйлсийг хангасан эсэхийг баталгаажуулна:
- 3.1.7.1. Активын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг сонгохдоо зөвхөн активын төрөл бус эдийн засгийн утга санаа, үзүүлэх нөлөөлөлд суурилах;
- 3.1.7.2. Загварчлал, статистик аргачлал зэрэг ил тод, үнэн зөв үнэлгээ, тооцоололд суурилсан байх;
- 3.1.7.3. Материаллаг алдаа, өөрчлөлт үзүүлэхээргүй байх;
- 3.1.7.4. Активын чанарыг үнэлэх дотоод аргачлалд тухайн хугацаанд активын эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх голлох хүчин зүйлсийг тусгах.
- 3.1.8. Банкнаас активт байгуулах эрсдэлийн санг нэг актив, хамааралтай активууд эсвэл багцалсан активын хувьд байгуулна.
- 3.1.9. Энэ журмын 2.2.2-д заасан хамааралтай активуудын нийлбэр үлдэгдлээс нэг эрсдэлийн сан байгуулна. Энэ журмын 2.2.3-д заасан нөхцөлийг хангасан хамааралтай активуудын салгаж ангилахыг зөвшөөрсөн хэсгээр тусад нь эрсдэлийн сан байгуулна.
- 3.1.10. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тэнцлийн гадуурх активаас бусад эрсдэлээр жигнэсэн активыг тооцохдоо зөвхөн энэ журамд заасан тусгай эрсдэлийн сангаар активаас хорогдуулсан дүнг ашиглана.
- 3.1.11. Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийг зээлтэй адилтган тооцож, энэ журамд заасан аргачлалын дагуу эрсдэлийн санг байгуулах бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд нэрийн данс нээж бүртгэнэ.
- 3.1.12. Энэ журмын 3.1.11-д заасны дагуу эрсдэлийн сан байгуулсан тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийг нь энэ журмын 2.1.10-т заасны дагуу өөрчилж тэнцлийн дотор бүртгэх тохиолдолд Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд байгуулсан сангийн хэлбэр өөрчлөгдөж, тэнцэл дотор шилжсэн активт харгалзах тусгай эрсдэлийн сангийн данс руу шилжүүлж тусгана.
- 3.1.13. Өмчлөх бусад хөрөнгөнд багтах үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн эрсдэлийн санг Хавсралт 3.в-д заасны дагуу, бусад санхүүгийн хөрөнгийг Хавсралт 3.а-д заасны дагуу байгуулна. Тэнцлийн гадуурх активыг Хавсралт 3.б-д заасны дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.

3.1.14. Банкнаас эрсдэлийн санг бүртгэх, зориулалтын дагуу ашиглах, зарцуулах гүйлгээг Монголбанкнаас баталсан Нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу хийж, бүртгэнэ.

3.2. Эрсдэлийн сан тооцох активын үлдэгдэл

3.2.1. Банкнаас ерөнхий болон тусгай эрсдэлийн санг дор дурдсан тохируулга хийсэн активын үлдэгдэлд байгуулна. Үүнд:

3.2.1.1. Хадгаламж барьцаалсан актив бол барьцааны төгрөгт хөрвүүлсэн дүнгээр активаас хорогдуулсан дүнгээс;

3.2.1.2. Эх үүсвэртэй тэнцлийн гадуурх аккредитив, баталгаа, батлан даалт болон түүнтэй адилтгах активаас тухайн эх үүсвэрийн дүнгээр хорогдуулсан дүнгээс;

3.2.1.3. Төв банкны үнэт цаасаар баталгаажсан активыг баталгааны дүнгийн 100%-иар хорогдуулсан дүнгээс;

3.2.1.4. Олон улсын зэрэглэл тогтоогч агентлагаас AAA зэрэглэл тогтоосон олон улсын олон талт хөгжлийн банк, санхүүгийн байгууллага (Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк гэх мэт)-аас гаргасан баталгаатай активын баталгааны 100%-иар хорогдуулсан дүнгээс;

3.2.1.5. Монгол болон гадаад улсын Засгийн газраас баталгаа, засгийн газрын бонд болон түүнтэй адилтгах үнэт цаасаар баталгаажсан актив бол, баталгааны хэмжээг энэ журмын Хавсралт 4.и-д заасан хувиар тооцсон дүнгээр активыг хорогдуулсан дүнгээс;

3.2.1.6. Хувьсах нөхцөлтэй актив нь овердрафт бол зөвхөн төлбөр хариуцагчаас зөвшөөрсөн хязгаарт тохируулан авсан дүнгээс; бусад тохиолдолд төлбөр хариуцагчаас эргэн төлөх шаардлагатай нийт авлагын дүнгээс;

3.2.1.7. Банкны тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа үүсмэл санхүүгийн хэрэгслийн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан аргачлалаар тооцсон зээлтэй адилтган тооцох өртөг болон Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.4.В-д заасны дагуу бодит үнэ цэнээр (Mark-to-Market) тооцоход эерэг дүн буюу авлага үүсгэхээр байгаа үнэлгээний аль ихээр;

3.2.1.8. Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай бус, идэвхтэй зах зээл дээр түргэн хугацаанд арилжаалагддаг болон бодит үнэ цэнийг тогтоох боломжтой талаар Монголбанкнаас гаргасан тусгай удирдамж, зөвлөмжийн дагуу Монголбанкны газар дээрх шалгалтын үнэлгээгээр хүлээн зөвшөөрсөн зарим барьцаа хөрөнгөөр баталгаажсан бол барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн 80 хүртэлх хувиар активын үнэлгээг хорогдуулсан дүнгээс.

3.2.2. Тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан зээл хэлбэрээр багцалсан активаас бусад үнэ цэнийн бууралтын аргачлалыг ашиглан банкнаас тооцохоор шийдвэрлэсэн активт энэ журмын 3.2.1-т заасан зохицуулалт үйлчлэхгүй.

3.2.3. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тэнцлийн гадуурх активаас бусад эрсдэлээр жигнэсэн активын

тооцоонд тухайн активыг зөвхөн тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлж тооцох бөгөөд ерөнхий эрсдэлийн санг нийт активын үлдэгдлээс цэвэршүүлэн тооцохгүй.

3.2.4. Тэнцлийн гадуурх активыг түүнд байгуулсан тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлж тооцохгүй.

3.3. Ерөнхий эрсдэлийн сан

3.3.1. Банкнаас эдийн засаг, санхүүгийн салбар болон өөрийн үйл ажиллагаанаас үүсч болох ерөнхий эрсдэлийн түвшинд үндэслэн тооцсон, ирээдүйд бодитоор илэрч болзошгүй алдагдлаас сэргийлэх зорилгоор тухайн активаас ерөнхий эрсдэлийн санг зардлаар байгуулж Монголбанкны Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.2.1.Г, 6.7.-д заасан эрсдэлийн сангийн нөөцөд бүртгэнэ.

3.3.2. Активт байгуулах ерөнхий эрсдэлийн санг активыг бүртгэснээс эхлэн эргэн төлөгдөх хүртэлх хугацааны турш байгуулж, зарцуулна.

3.3.3. Монголбанкнаас дор дурдсан активын нийт үлдэгдэлд тооцох ерөнхий эрсдэлийн сангийн хувь хэмжээг байгуулах доод шаардлагыг тавина. Үүнд:

3.3.3.1. Зээлийн үлдэгдэл;

3.3.3.2. Бусад актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүрэг.

3.3.4. Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, санхүүгийн салбарт гарсан томоохон өөрчлөлт, эрсдэлийн ерөнхий түвшинд суурилан энэ журмын 3.3.3-д заасан ерөнхий эрсдэлийн сангийн хувь хэмжээг энэ журмын 4.2-г заасан Монголбанкнаас тогтоосон доод шаардлагаас багагүй хувь, хэмжээгээр өөрчлөн тогтоож болно.

3.3.5. Банкнаас өмнөх хугацаанд тооцсон боловч илрэх нь тодорхойгүй алдагдал бодитоор үүсч, хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд эрсдэлийн сангийн нөөц дансанд бүртгэлтэй байгаа ерөнхий эрсдэлийн сангийн үлдэгдэл дүн болон нийт активаас үүссэн төлөвлөөгүй алдагдлын дүнд тохируулан тусгай эрсдэлийн санд шилжүүлэх эсвэл нэгдсэн байдлаар барагдуулна.

3.4. Тусгай эрсдэлийн сан

3.4.1. Банкнаас активт байгуулах тусгай эрсдэлийн сангийн доод хэмжээг энэ журмын Хавсралт 3.а., Хавсралт 3.б. болон Хавсралт 3.в.-д тус тус заасны дагуу тооцож, байгуулна.

3.4.2. Тусгай эрсдэлийн санг банк нь дотоод аргачлалд суурилан тооцож болох бөгөөд банкны санхүүгийн тайланд тусгах нийт эрсдэлийн сангийн хэмжээ нь энэ журмын дагуу тооцсон хэмжээнээс багагүй байна.

3.4.3. Тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн тусгай эрсдэлийн санг холбогдох гэрээнд тусгасан хэлцэл хэрэгжих хугацаа болон холбогдох гэрээнд заасан бол болзошгүй үүргийг биелүүлсний дараа төлбөр хариуцагчаас авах авлагын эргэн төлөлтийн хуваарийг харгалзан үзсэнээр энэ журмын Хавсралт 3.б.-д заасны дагуу байгуулж Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах нөөц дансанд бүртгэнэ.

3.4.4. Энэ журмаар зөвшөөрсөн багцалсан активын тусгай эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.3.Г-д заасан бүлгийн аргачлалын дагуу тооцох буюу багцын үнэ цэнэ буурсан болон буураагүй хэсгээс тооцсон эрсдэлийн сангуудын нийлбэрээр тооцно.

3.4.5. Тэнцлийн гадуурх актив, үнэ цэнийн бууралтаар эрсдэлийн сан тооцсон үнэт цаас болон өмчлөх бусад хөрөнгөнд багтах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөөс бусад активын ангиллыг энэ журмын 2.9, 2.5.4 болон энэ журамд заасан бусад үндэслэлээр-бууруулах эсвэл дээшлүүлсэн тохиолдолд тус активын хугацааны болон чанарын үнэлгээг ижил ангилалтай байхаар тооцож Хавсралт 3.а.-д тусгасан харгалзах эрсдэлийн санг байгуулна.

3.5. Активыг тэнцлээс хасах

3.5.1. Банкнаас дараах активыг одоогийн болон шинээр байгуулсан эрсдэлийн сангаас дор дурдсан нөхцөлд дараах үндэслэлээр улирал тутам хорогдуулж болно:

3.5.1.1. Активыг төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш 180 хоногийн дотор төлбөр хариуцагчаас төлбөрийг бүрэн хийгээгүй нөхцөлд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;

3.5.1.2. Төлбөр хариуцагчаас тодорхой хэсгийг гаргуулахаар шүүхийн шийдвэр гарсан боловч үлдэх хэсгийг төлбөр хариуцагч хариуцахгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр тухайн үлдэх хэсгийг;

3.5.1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шүүгчийн шийдвэр болон ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор холбогдох активын дүнг;

3.5.1.4. Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу ангилалтай активыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр;

3.5.1.5. Банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтанд олгосон активт энэ журмын 3.5.1.1, 3.5.1.4 дэх заалт хамаарахгүй.

3.5.2. Банкны хувь эзэмшигч тухайн банкинд дахь зээлээ төлж чадахгүй бол эхний ээлжинд барьцаа хөрөнгийг худалдаж орсон орлогоор, хэрэв зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр уг орлогоос давж байвал Банкны тухай хууль тогтоомжид заасан банкинд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээний хүрээнд тухайн банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийг худалдаж, орсон орлогоор зээлийг төлүүлнэ.

3.5.3. Банк энэ журмын 3.5.1, 3.5.6-д заасны дагуу активыг холбогдох сангаас хаасан болон активыг тэнцлээс хассан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийн хамт жил бүрийн 4 дүгээр сард багтаан Монголбанкинд ирүүлнэ.

3.5.4. Активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тохиолдолд тэнцлийн гадуурх дансанд бүртгэж, төлүүлж барагдуулах арга хэмжээг үргэлжлүүлнэ.

3.5.5. Эрсдэлийн сангаар хорогдуулж, тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн актив хэсэгчлэн эсвэл бүхэлдээ эргэн төлөгдсөн нөхцөлд тэр хэмжээгээр банкны үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

3.5.6. Банкнаас активыг худалдан борлуулах, шилжүүлэх тухай гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнд үндэслэн, банкны тэнцэлд бүртгэлтэй активыг доорх шалгуурыг хангасан тохиолдолд

үнэт цаасжуулах болон түүнтэй адилтгах бусад аргачлалыг ашиглах замаар тэнцлээс хасан тооцож, харгалзах активын ангилал, эрсдэлийн санг байгуулахгүй байж болно. Үүнд:

3.5.6.1. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 39 (IAS 39)-д заасан үл хүлээн зөвшөөрөх (Derecognition) шалгуур;

3.5.6.2. Санхүүгийн тайлагналын олон улсын (СТОУС)-ын холбогдох стандартад заасан үл хүлээн зөвшөөрөх (Derecognition) шалгуур;

3.5.6.3. Нягтлан бодох бүртгэлийн зааврын 8.7.7-д заасан шаардлага.

3.5.7. Энэ журмын 3.5.6.1-3.5.6.3-д заасан шалгуурыг хангаагүй активыг тэнцэлд үргэлжлүүлэн бүртгэж, холбогдох ангилал болон эрсдэлийн санг байгуулна.

3.6. Активыг тайлагнах

3.6.1. Банк активын ангилал хийж, эрсдэлийн санг байгуулсан, эрсдэлийн сангаас хорогдуулсан болон активт хийгдсэн шилжилт хөдөлгөөн болон эрсдэлийн сангийн задаргааны талаарх сар бүрийн тайланг энэ журмын Хавсралт 4-ийн дор дурдсан дэд хэсгүүдийн дагуу дараа сарын 5-ны ажлын өдрийн дотор Монголбанкны Хяналт шалгалтын газарт бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ. Үүнд:

3.6.1.1. Активын эрсдэлийн сан тооцох активын үлдэгдлийн тайланг Хавсралт 4.а.-р;

3.6.1.2. Активын үлдэгдэл, эрсдэлийн сангийн хүрэлцээ, хангамжийн нэгдсэн тайланг Хавсралт 4.б.-р;

3.6.1.3. Активын тусгай эрсдэлийн сангийн хүрэлцээний дэлгэрэнгүй тайланг активын төрөл тус бүрийн хувьд Хавсралт 4.в.-р;

3.6.1.4. Өмчлөх бусад хөрөнгийн шилжилтийн тайланг Хавсралт 4.г.-р;

3.6.1.5. Бүтэц өөрчлөгдсөн активын шилжилтийн тайланг Хавсралт 4.д.-р;

3.6.1.6. Үнэт цаасны үлдэгдлийн задаргаа, эрсдэлийн сангийн байгуулалтын задаргааны тайланг Хавсралт 4.е.-р;

3.6.1.7. 20 том хамааралтай активын тайланг Хавсралт 4.ж.-р;

3.6.1.8. Багцалсан активын параметр үзүүлэлтийн тайланг Хавсралт 4.з.-р.

3.6.2. Банк нь активыг тэнцлээс хасч, эрсдэлийн сангаар хорогдуулан тэнцлийн гадуур бүртгэсэн тухай бүрт Монголбанкны зээлийн мэдээллийн санд тусгана.

3.7. Багцалсан активт тусгай эрсдэлийн сан тооцох аргачлалыг ашиглах

3.7.1. Багцалсан активт байгуулах эрсдэлийн санг дор дурдсан аргачлалын аль нэгийг эсвэл холимог байдлаар ашиглан байгуулна:

3.7.1.1. Банк, банкны нэгжээс олгосон активын алдагдлын дотоод мэдээллийн арга (internal loss experience);

3.7.1.2. Зэрэглэл тогтоогч байгууллага болон бусад гадаад эх үүсвэрээс гаргасан зээл, активын зэрэглэлийн тоон мэдээлэлтэй уялдуулах (mapping to external data);

3.7.1.3. Активын алдагдлын статистик загварчлал (statistical loss model).

- 3.7.2. Банк нь энэ журмын 3.7.1-д заасан аргачлалаар багцалсан активт эрсдэлийн сан байгуулан дотооддоо ашиглаж болох бөгөөд уг аргачлал нь энэ журамд тавигдах доод шаардлага, зээлийн эрсдэлийн параметрийг тооцох, баталгаажуулахад мөрдөх олон улсын стандарт болон Монголбанкнаас тогтоосон заавар зөвлөмжид нийцүүлсэн байна.
- 3.7.3. Монголбанкнаас энэ журмын 3.7.1-д заасан банкны эрсдэлийн сан тооцох аргачлал нь дараах шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулна. Үүнд:
- 3.7.3.1. Активаас үүссэн алдагдлын тоон мэдээг төвлөрүүлэх, боловсруулах, цуглуулах чадамж бүхий удирдлагын мэдээллийн системтэй байх;
- 3.7.3.2. Тооцоолол хийхээр сонгосон түүвэр мэдээлэл нь эрсдэлийн үнэлгээ хийх багцалсан активтай бүтэц, нөхцөл, эрсдэлийн түвшин болон бусад шинж чанараар адилхан эсвэл харьцуулах боломжтой байх;
- 3.7.3.3. Үнэлгээнд ашиглаж байгаа тоо, мэдээлэлд харгалзах актив, зээл олгоход тавигдах шаардлага, стандарт нь банкнаас үнэлж буй багцалсан активтай ижил эсвэл харьцуулах боломжтой байх;
- 3.7.3.4. Сонгосон түүвэр мэдээлэл нь банкнаас эрсдэлийн сан тооцохоор багцалсан активын чанарыг оновчтой илэрхийлж, одоогийн болон ойрын ирээдүйн эдийн засаг болон зах зээлийн хүчин зүйлсийг илэрхийлэх боломжтой, нийцтэй байх;
- 3.7.3.5. Тооцоололд сонгосон түүвэр нь активын тоо ширхэг, түүврийн хамрах хугацааны хувьд банкны зүгээс багцалсан активт харгалзах эрсдэлийн сан болон алдагдлын түвшинг статистик аргачлалаар зохистой итгэх түвшний хувьд оновчтой, үнэн зөв үнэлэх боломжтой байх;
- 3.7.3.6. Аргачлалыг энэ журмын 2.8-д заасан ерөнхий шаардлагатай нийцүүлсэн байх.
- 3.7.4. Активын алдагдлыг тооцоолоход ашиглаж байгаа аргачлал болон параметруудийн утгыг активын талаарх шинэ мэдээлэл буюу энэ журмын Хавсралт 2-6-д заасан активын чанарын үнэлгээний мэдээлэлд үндэслэн холбогдох тохируулгыг тухай бүрт тусгах боломжтой байхаар боловсруулна.
- 3.7.5. Энэ журмын 3.7.4-д дурдсан тохируулгыг хамгийн багадаа жилд нэгээс доошгүй удаа хийнэ.
- 3.7.6. Энэ журмын 3.7.1-д заасан аргачлалуудын алиныг сонгохоос үл хамаарч, банкны активын эрсдэлийн параметруудийг үнэлэх түүврийн түүхэн мэдээлэл нь хамгийн багадаа 5 жилийн хугацааг хамарсан байна. Таван жилээс дээш ажиглалтын утга олдох боломжтой бол илүү хугацааны түүврийг ашиглана.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

- 4.1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь активын ангиллын үнэлгээ, активаас хүлээж болзошгүй алдагдал, тусгай болон ерөнхий эрсдэлийн сангийн хэмжээг үнэн зөвөөр тооцож, Монголбанкинд энэ журмын 3.6.1-т заасан хугацаанд тайлагнаж байх үүрэгтэй.

- 4.2. Монголбанк тухайн банкинд энэ журмын 3.1.1–д заасан ерөнхий болон тусгай эрсдэлийн сангийн хувь хэмжээг банкны эрсдэлийн төлөв, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын түвшинд суурилан өөрчлөн тогтоож болно.
- 4.3. Монголбанкнаас шаардлагатай гэж үзвэл багцалсан активт байгуулах тусгай эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлох активын эрсдэлийн параметруудийн (PD, LGD, LIP болон бусад) доод болон дээд хязгаарыг тухайн нэг банк эсвэл нийт банкны салбарын хэмжээнд тогтоон, мөрдүүлж болно.
- 4.4. Энэ журамд заасан активт ангилал хийх, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой зохицуулалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн активын төрөл, хэмжээ болон активын гэрээнд тусгасан нөхцөлийн хувьд өөрчлөн тогтоож болно.
- 4.5. Банкнаас олгосон тухайн актив, багцалсан актив эсвэл нэг төсөл санхүүжүүлэх зорилгоор олгосон активууд болон нэг төлбөр хариуцагчтай холбоотой нийт активуудын чанар ойрын хугацаанд муудаж, улмаар төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд сөргөөр нөлөөлөх дүгнэлт гарсан тохиолдолд банкны зүгээс яаралтай Монголбанкнд мэдэгдэнэ.
- 4.6. Банкны дотоод аудит хариуцсан нэгж нь банк активын эрсдэлийг хэрхэн оновчтой үнэлж, активын ангиллыг үнэн бодитой хийж байгаа болон холбогдох эрсдэлийн санг хэрхэн байгуулж, зарцуулж байгаад хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж байх үүрэгтэй. Банкны дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны хамрах хүрээнд энэ журам болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор боловсруулсан банкны дотоод аргачлал тусгасан байна.
- 4.7. Монголбанк банк активын эрсдэлийг үнэлж, дүгнэн активыг ангилж, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зохистой эсэх, ангиллыг үнэн зөв хийж байгаа эсэх, эрсдэлийн санг бүрэн гүйцэд байгуулж, зохистой зарцуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж, зайнаас хяналт тавина. Уг хяналт шалгалтын үйл ажиллагааны хамрах хүрээнд энэ журам болон удирдлагын үйл ажиллагааны зорилгоор боловсруулсан банкны дотоод аргачлал тусгасан байна.
- 4.8. Банк нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд ирүүлэх активын төлбөр хариуцагчийн талаарх мэдээлэлд тухайн активын ангиллыг сар бүр эсвэл ангилалд өөрчлөлт орсон тухай бүр үнэн зөв тусгана.
- 4.9. Монголбанкнаас хийх газар дээрх болон зайны хяналт шалгалтаар банкны үйл ажиллагааг шалгах явцад Монголбанкны хянан шалгагч тухайн банк аливаа хөрөнгийг буруу ангилсан, эсвэл хөрөнгийн эрсдэлийн санг дутуу байгуулсан, сангаас үндэслэлгүйгээр хорогдуулсан гэж үзэж, үндэслэлийг тодорхойлсон тохиолдолд тухайн активын ангиллыг өөрчилж, эрсдэлийн санг нэмж байгуулахыг хууль тогтоомжийн дагуу шаардана.
- 4.10. Монголбанк банкны үйл ажиллагааг шалгах явцад хөрөнгийг энэ журмын дагуу ангилаагүй, холбогдох эрсдэлийн санг тогтоосон хувь хэмжээгээр байгуулаагүй, буруу зарцуулсан нөхцөлд банк, түүний удирдлага, холбогдох ажилтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХАВСРАЛТ 1

ХАВСРАЛТ 1.а.

АКТИВЫН ХУГАЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР ДҮГНЭЖ АНГИЛАХ ХҮСНЭГТ

Ангилал	ӨР ТӨЛБӨР ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ХОНОГООР				
	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл*	$\leq 15^{\dagger}; \leq 30^{\dagger}$	≤ 90	91-180	181-360	≥ 361
Хувьсах нөхцөлтэй актив**	≤ 15	15-90	91-180	181-270	≥ 271
Үнэт цаас***	-	≤ 30	31-60	61-90	≥ 91
Авлага болон бусад актив	≤ 30	31-60	61-90	91-120	≥ 121

\dagger - Журмын 2.1.5-т заасны дагуу

*Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөр

**Хувьсах нөхцөлтэй актив, хүүгийн эргэн төлөлтөөр

***Үнэт цаас, хүүгийн эргэн төлөлтөөр

ХАВСРАЛТ 1.б.

ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨД БАГТАХ ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ АНГИЛЖ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХ ХҮСНЭГТ

Ангилал	ӨМЧЛӨЛД АВСНААС ХОЙШ БОРЛОГДООГҮЙ ХОНОГООР				
	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Үл хөдлөх хөрөнгө	≤ 60	61-100	101-160	161-220	≥ 221
Хөдлөх хөрөнгө	≤ 30	31-60	61-90	91-120	≥ 121

АКТИВЫГ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР АНГИЛАХ ЕРӨНХИЙ ХҮСНЭГТ

Ангилал ¹	Чанарын үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлт			Банкнаас активыг холбогдох чанарын ангилд тогтоох болсон үндэслэл ⁵	Монголбанкны хэрэгцээнд ⁶
	Төлбөр хариуцагчийн ерөнхий нөхцөл байдал ²	Эдийн засгийн болон төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдал ³	Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл ⁴		
<i>Хэвийн</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээний хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулахад санхүүгийн болон бусад аливаа хүндрэл, эрсдэл үүсэхгүй буюу эрсдэл багатай актив.	Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын нөхцөл байдал болон төлбөр хариуцагчийн санхүүгийн байдал сайн.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг хангалттай байгаа.		
<i>Анхаарал хандуулах</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээний дагуу хуваарьт заасан хугацаандаа төлж байгаа боловч ирээдүйд хуваарьт төлбөрийг төлж барагдуулахад хүндрэл үүсч болзошгүй шинж тэмдэг илэрч буй актив.	Доорхын аль нэг нөхцөл байдал үүссэн: а) Төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын эдийн засгийн байдал хямрал, хүндрэлтэй байгаа б) Төлбөр хариуцагчийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал богино хугацаанд доройтсон боловч цаашид дунд болон урт хугацаанд сайжрах төлөвтэй.	Төлбөр хариуцагчийн зарим мэдээлэл, баримт бичиг дутмаг боловч тухайн мэдээлэл нь төлбөр хариуцагчийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэхэд материаллаг түвшинд сөрөг нөлөө үзүүлэхгүй.		
<i>Хэвийн бус</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж барагдуулахад эргэлзээтэй болсон актив. Эсвэл өмнө нь активын чанарыг муутгаж байсан түүхтэй төлбөр хариуцагчийн актив. Эдгээр нөхцөлийг хангаж буй тохиолдолд барьцаа хөрөнгө бий эсэх, түүний чанар, хамрах хүрээ зэрэг нь зээлийг энэ ангилалд ангилахгүй байх үндэслэл болохгүй.	Төлбөр хариуцагчийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц хүндрэл үүсч, санхүүгийн гол үзүүлэлтүүд муудсан ба цаашид муудах хандлагатай. Үүнд: а) Төлбөрийн чадвар болон бэлэн мөнгөний орлого буурсан эсвэл сөрөг утгатай болсон б) Өрийн хэмжээ ихэссэн буюу эздийн өмчийн хөрөнгөд эзлэх хувь өссөн в) Барьцаа хөрөнгө хангалтгүй эсвэл барьцаа хөрөнгийн борлогдох боломж нь төлбөр хариуцагчийн салбарын үйл ажиллагаатай нягт холбоотой, эсвэл хөрвөх чадвар багатайн	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг хангалтгүй, эсвэл эдгээрийн үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй.		

		улмаас активыг төлүүлэхээр худалдан борлуулахад бэрхшээлтэй байх магадлалтай.			
		г) Ашигт ажиллагаа буурсан эсвэл сөрөг утгатай болсон			
<i>Эргэлзээтэй</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах боломжгүй болсон актив.	Төлбөр хариуцагчийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хэвийн бус ангилалд ангилагдсан үеэс илт доройтсон.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл хангалтгүй буюу байхгүй, эсвэл мэдээлэл нь үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй.		
<i>Муу</i>	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийн маш бага хувийг төлж барагдуулахаар байгаа актив.	Төлбөр хариуцагч активын үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг хийж чадахааргүй болтлоо санхүүгийн байдал нь доройтсон.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл байхгүй, эсвэл байгаа мэдээлэл нь хуурамч.		

ТАЙЛБАР: 1-Үнэлж буй активт олгосон чанарын ангилал

2-Хавсралт 5, Хавсралт 6-ын 1-3 дахь бүрэлдэхүүн хэсгүүд (хувийн хэргийн бүрдэл, санхүүгийн үзүүлэлт болон бусад) болон активын эргэн төлөгдөх хуваарийн мэдээлэлд үндэслэн нийтэд нь дүгнэх

3-Хавсралт 5, Хавсралт 6-ын 2 дахь (санхүүгийн үзүүлэлт) бүрэлдэхүүн хэсгийн үр дүнд үндэслэн дүгнэх

4-Хавсралт 5, Хавсралт 6-ын 1 дэх (хувийн хэргийн бүрдэл) хэсгийн үр дүнд үндэслэн дүгнэх

5-Үнэлж буй активыг холбогдох чанарын ангиллаар тодорхойлсон үндэслэл, тайлбарыг банкны зүгээс тодорхой, үндэслэлтэйгээр тусгах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргахад ашигласан бүх мэдээлэл, тоон мэдээ, тайлан, бусад судалгааг уг хүснэгтэд хавсаргасан байх.

6- Банкнаас гаргасан тайлбарыг хүлээн зөвшөөрөх эсэх талаарх тайлбар, дүгнэлтийг Монголбанкнаас тусгах. Монголбанкны санал давамгайлна.

Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар: Дээрх хүснэгтэд тусгасан чанарын ангилал тогтоох 3 бүрэлдэхүүн хэсгээс давамгайлж байгаа үнэлгээний дагуу активыг харгалзах ангилалд бүртгэнэ. Харин онцгой тохиолдолд бусад бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ эцсийн ангилал тогтооход хэрхэн материаллаг түвшинд нөлөөлж буй талаар тодорхой үндэслэл, тайлбарыг тусгана. Холбогдох баримт, материал, нотолгоог энэхүү үнэлгээний хуудаст хавсаргасан байна.

ХАВСРАЛТ 3.а.

АКТИВЫН АНГИЛАЛ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХ ХУВЬ, ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ

Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хэвийн	Хэвийн 0.5%	Анхаарал хандуулах 1%	Хэвийн бус 15%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Анхаарал хандуулах	Анхаарал хандуулах 1%	Анхаарал хандуулах 5%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 35%	Муу 75%
Хэвийн бус	Хэвийн бус 5%	Хэвийн бус 15%	Хэвийн бус 25%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Эргэлзээтэй	Эргэлзээтэй 15%	Эргэлзээтэй 25%	Эргэлзээтэй 35%	Эргэлзээтэй 50%	Муу 100%
Муу	Муу 50%	Муу 50%	Муу 75%	Муу 100%	Муу 100%

Тайлбар: Активын ангиллыг хугацааны болон чанарын хүчин зүйлээр тооцсон үнэлгээний аль доогуур ангиллаар тогтоож, дээрх матрицад харгалзах эрсдэлийн сангаар байгуулна. Тухайлбал: Актив нь хугацааны үзүүлэлтээр “Анхаарал хандуулах”, чанарын үзүүлэлтээр “Эргэлзээтэй” ангилалаар үнэлсэн бол активыг “Эргэлзээтэй” ангилалд бүртгэж, эрсдэлийн санг 25 хувиар байгуулна.

ХАВСРАЛТ 3.б.

ТЭНЦЛИЙН ГАДУУРХ АКТИВ, ХҮЛЭЭЖ БОЛЗОШГУЙ ҮҮРГИЙН АНГИЛАЛ, ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХУВЬ

Чанарын ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Гэрээгээр хэрэгжих боломжтой хугацаа					
1 жилийн дотор	0%	5%	25%	50%	100%
1 жилээс дээш хугацааны дараа	0%	1%	15%	35%	75%

ХАВСРАЛТ 3.в.

САНХҮҮГИЙН БУС ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙГ АНГИЛЖ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХ ХҮСНЭГТ

Ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Эрсдэлийн сангийн доод хувь	0%	25%	50%	75%	100%

АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН ТООЦОХ АКТИВЫН ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН											
№	Активын төрөл	Үлдэгдэл	Баталгаа, барьцаа хөрөнгийн хасагдуулга хийх хэмжээ							НИЙТ	Цэвэр үлдэгдэл
			Хадгаламж (100%)	ТБҮЦ (100%)	ОУХБ (ОУВС, Дэлхийн банк, гм) (100%)	МУ ЗГ-ын баталгаа (...%)	Гадаад улсын ЗГ-ын баталгаа (...%)	Тэнцлийн гадуурх үүрэгт хамаарах эх үүсвэр	Бусад		
			(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)		
1	Зээл* (нийт)	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэвийн										
	Анхаарал хандуулах										
	Чанаргүй	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэвийн бус										
	Эргэлзээтэй										
	Муу										
2	Баталгаа, баглан даалт (нийт)	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Тендерийн										
	Гүйцэтгэлийн										
	Урьдчилгаа төлбөрийг буцаах										
	Векселийн										
3	Аккредитив	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Гадаад худалдааны аккредитив										
	Стэндбай										
4	Зээлийн шугам										
5	Авлага болон бусад актив										
6	НИЙТ	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тайлбар: * - Зээлээр багцалсан актив, хувьсах нөхцөлтэй актив болон хамааралтай активуудыг багтаана. ** - Энэ журмын хавсралт 4.и.-д заасан хувиар тохируулна. (1) –Активын хасагдуулгын өмнөх дүн, (2) -Журмын 3.2.1.1-д заасан тохируулга, (3) -Журмын 3.2.1.3-д заасан тохируулга, (4) -Журмын 3.2.1.4-д заасан тохируулга, (5), (6) -Журмын 3.2.1.5-д заасан тохируулга, (7) -Журмын 3.2.1.2-д заасан тохируулга, (8) -Журмын 3.2.1.8-д заасан тохируулга.

АКТИВЫН ҮЛДЭГДЭЛ, ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Дд	АКТИВЫН ТӨРӨЛ	Зээл	Үнэт цаас	Өмчлөх бусад хөрөнгө	Авлага болон бусад актив	Нийт тэнцлийн эрсдэлтэй актив	Тэнцлийн гадуурх үүрэг	Нийт эрсдэлтэй актив
		(1)	(2)	(3)	(4)	(5)=(1)+...+(4)	(6)	(7)=(5)+(6)
1	Үлдэгдэл* (1.1+1.2)	-	-	-	-	-	-	-
1.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцох					-		-
1.2.	Актив ангиллын журмаар тооцох					-		-
2	Тусгай эрсдэлийн сан (2.1+2.2)	-	-	-	-	-	-	-
2.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон					-		-
2.2.	Актив ангиллын журмаар тооцсон (2.2.1+2.2.1+2.2.3)	-	-	-	-	-	-	-
2.2.1	Хэвийн:					-		-
2.2.2	Анхаарал хандуулах					-		-
2.2.3	Чанаргүй зээл (а+б+в)	-	-	-	-	-	-	-
	а/ Хэвийн бус					-		-
	б/ Эргэлзээтэй					-		-
	в/ Муу					-		-
3	Ерөнхий эрсдэлийн сан (а+б+в)	-	-	-	-	-	-	-
	Активийн төрөл	Сангийн хувь***	=(1)*(3а)		=(4)*(3б)		=(6)*(3в)	
	а/ Зээл	0%	-			-		-
	б/ Тэнцлийн гадуурх үүрэг	0%				-	-	-
	в/ Бусад актив	0%				-		-
4	НИЙТ ЭРСДЭЛИЙН САН [(2)+(3)]	-	-	-	-	-	-	-
5	БАНКНААС БАЙГУУЛСАН САН							
6	Илүү (+) / Дутуу (-) [(4)-(5)]	-	-	-	-	-	-	-

Тайлбар: *- Барьцаа хөрөнгийн хасагдуулгаар цэвэршүүлсэн дүн

**-Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралтын дүн

***-Журмын 3.3.3-д заасны дагуу тогтоосон хувь хэмжээ.

АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Зээл

/мянган төгрөгөөр/

Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	НИЙТ	-	-	-	-	-	-	-

Хувьсах нөхцөлтэй актив

/мянган төгрөгөөр/

Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	НИЙТ	-	-	-	-	-	-	-

Тайлбар: *- Журмын 2.8.2, 2.8.3-д заасан тохируулга.

АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Авлага болон бусад актив

/мянган төгрөгөөр/

Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	НИЙТ	-	-	-	-	-	-	-

Үнэт цаас

/мянган төгрөгөөр/

Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	Үнэ цэнийн бууралтаар тооцсон**							-
8	НИЙТ	-	-	-	-	-	-	-

Тайлбар: *- Журмын 2.8.2, 2.8.3-д заасан тохируулга

** - Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан үнэ цэнийн бууралтын дүн.

АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Өмчлөх бусад хөрөнгө - Үл хөдлөх, Хөдлөх хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Дд	Ангилал	Үлдэгдэл	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
	Эрсдэлийн сангийн доод хувь		0%	25%	50%	75%	100%	
1	Үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэл	-						
	Харгалзах эрсдэлийн сан		-	-	-	-	-	-
2	Хөдлөх хөрөнгийн үлдэгдэл	-						
	Харгалзах эрсдэлийн сан		-	-	-	-	-	-
3	НИЙТ		-	-	-	-	-	-
4	Худалдан борлуулах зориулалттай Үл хөдлөх хөрөнгө*							
5	Үнэ цэнийн бууралтаар тооцсон**							

Өмчлөх бусад хөрөнгө - Санхүүгийн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Дд	Хугацааны Чанарын	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	Тохируулга*	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
1	Хэвийн							-
2	Анхаарал хандуулах							-
3	Хэвийн бус							-
4	Эргэлзээтэй							-
5	Муу							-
6	Үнэ цэнийн бууралтаар тооцсон**							-
8	НИЙТ	-	-	-	-	-	-	-

Тайлбар: * -Нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан хөрөнгө, ** -Худалдан борлуулах зориулалттай Үл хөдлөх хөрөнгийн Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралт.

АКТИВЫН ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тэнцлийн гадуурх үүрэг

/мянган төгрөг/

Дд	Чанарын ангилал Гэрээний хэрэгжих хугацаа	Зээлтэй адилтган тооцох дүн	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	НИЙТ ТУСГАЙ ЭРСДЭЛИЙН САН
2	Үлдэгдэл	-						
3	Эрсдэлийн сан		-	-	-	-	-	
4	1 жилээс дээшх		0%	1%	15%	35%	75%	
5	Үлдэгдэл	-						
6	Эрсдэлийн сан		-	-	-	-	-	
7	НИЙТ		-	-	-	-	-	0

Багцалсан актив

/мянган төгрөгөөр/

Дд	Багцалсан активын төрөл	Нийт багцын дэд төрлийн тоо	Нийт багцын тоо	Нийт гишүүн активын тоо	Сан тооцох үлдэгдэл		Тусгай эрсдэлийн сан	
					Үнэ цэнэ буураагүй хэсэг	Үнэ цэнэ буурсан хэсэг	Үнэ цэнэ буураагүй хэсэг	Үнэ цэнэ буурсан хэсэг
1	Зээл							
2	Зээлээс бусад хувьсах нөхцөлтэй актив							
3	Авлага болон бусад актив							
4	НИЙТ	-	-	-	-	-	-	-
5								-

ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАН

Дд	Өмчлөх бусад хөрөнгө	Өмнөх сарын үлдэгдэл	Үүнээс дараах ангилалд шилжүүлсэн:				Шилжүүлсэн данснаас Буцаагдсан****	Шинээр нэмэгдсэн	Тайлант сарын үлдэгдэл (9)= =(1)-[(2)+(3)+.....+(6)]+(7)+(8)
			Үндсэн хөрөнгө	ХОУХХ*	БЗХ*	ББУЦ**			
		(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)
1	Санхүүгийн бус хөрөнгө (1.а+1.б)								
	а/ Үл хөдлөх хөрөнгө:								
	а.1./ Орон сууцны зориулалттай†								
	а.2./ Бусад үл хөдлөх хөрөнгө								
	б/ Хөдлөх хөрөнгө								
2	Санхүүгийн хөрөнгө (2.а+2.б)								
	а/ Үнэт цаас								
	б/ Бусад								
3	НИЙТ ҮЛДЭГДЭЛ (1+2)								

Тайлбар:

†- “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.1-д заасан зээлийн барьцаанд байгаа орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө

*-Хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглах үл хөдлөх хөрөнгө

**-Борлуулах зориулалттай хөрөнгө

***-Борлуулахад бэлэн үнэт цаас

****- Журмын 2.5.12-д заасан тохируулга

Бүтэц өөрчлөгдсөн актив

/мянган төгрөг/

№	Активын төрөл	Өмнөх сарын үлдэгдэл	Эргэн төлөгдсөн	Шинээр БО* ангилалд шилжсэн	Хэвийн ангилалд хэвээр байгаа эсвэл шилжсэн**	Бусад тохируулга***	Тайлант сарын үлдэгдэл
		(1)	(2)	(3)	(4)	(5)	(7) =(1)-(2)+(3)-(4)+(5)
1	Зээл (Нийт)						
	Хэвийн:						
	Анхаарал хандуулах						
	Чанаргүй зээл (а+б+в)						
	а/ Хэвийн бус						
	б/ Эргэлзээтэй						
	в/ Муу						
2	Үнэт цаас						
3	Авлага болон бусад актив						
4	Бусад						
5	НИЙТ						

*БО – Бүтэц өөрчлөгдсөн

ҮНЭТ ЦААСНЫ ҮЛДЭГДЭЛ, ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАЛТЫН ЗАДАРГААНЫ ТАЙЛАН

Үнэт цаасны үлдэгдэлийн задаргаа

/мянган төгрөг/

Дд	Үнэт цаасны төрөл	АААБҮЦ*		Хугацааны эцэс хүртэлх	Борлуулахад бэлэн	Зээл, Авлага	Охин, Хараат компани, Хамтын өмчлөлд оруулсан хөрөнгө оруулалт	Нийт
		Арилжааны	Бодит үнэ цэнээрх					
1	Үлдэгдэл (1.1+1.2)							
1.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон							
1.2.	Актив ангиллын журмаар тооцсон							
2	Тусгай эрсдэлийн сан (2.1+2.2)							
2.1.	Үнэ цэнийн бууралт**-аар тооцсон							
2.2.	Актив ангиллын журмаар тооцсон (2.2.1+2.2.2+2.2.3)							
2.2.1	Хэвийн:							
2.2.2	Анхаарал хандуулах							
2.2.3	Чанаргүй зээл (а+б+в)							
	а/ Хэвийн бус							
	б/ Эргэлзээтэй							
	в/ Муу							
3	Банкнаас байгуулсан сан							
4	Илүү (+) / Дутуу (-) [(2)-(3)]							

Тайлбар: *- Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас; **-Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу тооцсон үнэ цэнийн бууралтын дүн.

20 ТОМ ХАМААРЛТАЙ АКТИВЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Активын ангилал	Активын ангилал	Активын тоо*	Төлбөр хариуцагчийн тоо*			Хамааралтай активын үлдэгдэл*	Хамааралтай активт ангилах үндэслэл**			Үүнээс: Өөр ангиллаар ангилсан хэсэг***	Барьцаа хөрөнгийн хэмжээ	Тусгай эрсдлийн сан	ӨХ-д эзлэх хувь
			Нийт.	Үүнээс:			1	2	3				
				Хуулийн этгээд	Иргэн								
Хамааралтай Актив1			-										
Хамааралтай Актив2			-										
Хамааралтай Актив3			-										
Хамааралтай Актив4			-										
Хамааралтай Актив5			-										
Хамааралтай Актив6			-										
Хамааралтай Актив7			-										
Хамааралтай Актив8			-										
Хамааралтай Актив9			-										
Хамааралтай Актив10			-										
Хамааралтай Актив11			-										
Хамааралтай Актив12			-										
Хамааралтай Актив13			-										
Хамааралтай Актив14			-										
Хамааралтай Актив15			-										
Хамааралтай Актив16			-										
Хамааралтай Актив17			-										
Хамааралтай Актив18			-										
Хамааралтай Актив19			-										
Хамааралтай Актив20			-										
НИЙТ													

Тайлбар: *-Журмын 2.2.2-д үндэслэн тооцсон актив, **- Хамааралтай актив гэж үзсэн голлох 3 үндэслэлийг сонгоно: Журмын 2.2.2.1-ны дагуу бол 1, журмын 2.2.2.2-ны дагуу бол 2, журмын 2.2.2.3-ны дагуу бол 3, журмын 2.2.2.4-ны дагуу бол 4, журмын 2.2.2.5-ын дагуу бол 5-ыг тус тус бичнэ. *** - Журмын 2.2.3-д заасны дагуу.

БАГЦАЛСАН АКТИВЫН ПАРАМЕТР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

Дд	Багцын төрөл	Параметрийн тооцоо*			Хамгийн их - Хамгийн бага**						Тооцсон аргачлал***	Хамрах хугацаа		Нийт ажиглалтын тоо (observations)	Мэдээллийн давтамж**** (сар, улирал, хагас жил, жилээр гэх мэт)
		PD	LGD	LIP	PD		LGD		LIP			Эхлэх огноо	Дуусах огноо		
					max	min	max	min	max	min					
1	Орон сууцны...														
2	Жижиглэн...														
3	Төлбөр картын...														
4	Бичил санхүү...														
5	Хэрэглээний ...														
....															
	Гэх мэт...														

Тайлбар: *-тэгээс цааших гурван орны нарийвчлалтай

** - Параметрийг тооцох хугацааны туршид тооцож байсан хамгийн их болон хамгийн бага утга

*** - Журмын 3.7.1-д заасан аргачлалаас сонгох (ILM-internal loss experience; MED - Mapping to external data; SLM - Statistical Loss Model)

**** - Жилийн давтамжтай бол 1, хагас жилийн -2, улирлын -3, сарын - 4-ийг тус тус бичнэ.

ХАВСРАЛТ 4.и.

(тайлан хүлээж авах загвар)

ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН БАТАЛГАА, БАТЛАН ДААЛТЫН ХАСАГДУУЛГЫГ ТООЦОХ ХҮСНЭГТ

Урт хугацааны

ЗЭРЭГЛЭЛ/ РЕЙТИНГ*	Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	CCC+- түүнээс бага	РЕЙТИНГГҮЙ
	Фич						
	Муудиз	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	Саа1- түүнээс бага	
ХЭТИЙН ХАНДЛАГА*							
ЭЕРЭГ		100%	100%	90%	80%	20%	80%
ТОГТВОРТОЙ		100%	100%	90%	70%	20%	
СӨРӨГ		90%	90%	80%	60%	20%	

Тайлбар:

*- Засгийн газрын рейтингийг 2 болон түүнээс дээш байгууллагаас тогтоосон бол аль доогуур рейтинг болон хэтийн хандлагыг ашиглана.

Богино хугацааны

ЗЭРЭГЛЭЛ/ РЕЙТИНГ*	Стандарт энд Пурс	A-1+	A-1	A-2/A-3	B	C-түүнээс доош	РЕЙТИНГГҮЙ
	Фич						
	Муудиз	F1+	P-3	F3	B	C-түүнээс доош	
Хасагдуулгын хувь		100%	100%	80%	40%	20%	80%

Тайлбар:

*- Засгийн газрын рейтингийг 2 болон түүнээс дээш байгууллагаас тогтоосон бол аль доогуур рейтингийг ашиглана.

*Иргэнд олгосон активыг чанарын үзүүлэлтээр ангилахад харгалзах
хүчин зүйлсийн жагсаалт*

Дд	Үнэлгээний хүчин зүйлс	Үнэлгээ	Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтийн тайлбар*	Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
1.	Активын хувийн хэргийн бүрдэл*	Тийм/үгүй		
1.1.	Банкны мөрдөж буй дотоод дүрэм, журмын дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр бий эсэх, төлбөр хариуцагчийн талаарх банкны дүгнэлт			
1.2.	Актив олгохыг хүссэн өргөдөл			
1.3.	Активын гэрээ болон холбогдох бусад гэрээ, гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт			
1.4.	Төлбөр хариуцагчийн ажлын газрын тодорхойлолт (ажилласан жил, цалингийн хэмжээ)			
1.5.	Цалингаас өөр орлоготой бол бусад орлогын эх үүсвэр, нотлох баримт			
1.6.	Хадгаламж болон бусад хуримтлалыг 2-оос дээш жилийн хугацаагаар тогтвортой хуримтлуулж байгаа талаар нотлох баримт			
1.7.	Шаардлагатай тохиолдолд өрхийн орлогын бүрдлийн эх үүсвэр, нотлох баримт			
1.8.	Барьцаа хөрөнгө			
1.8.1.	Тодорхойлолт ⁴			
1.8.2.	Үнэлгээний баримт бичиг			

	1.8.3.	Үл хөдлөх хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ					
	1.8.4.	Шалгасан баримт					
	1.8.5.	Гадны хараат бус үнэлгээ					
1.9.	Барьцааны гэрээ, батлан даалттай бол батлан даалтын гэрээ						
2.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүд		Үзүүлэлт/харьцуулалт***			Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах	Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
			Утга ¹	Δ% ²	Бүлгийн дундаж ³		
2.1.	Төлбөр хариуцагчийн өр, орлогын харьцаа						
2.2.	Төлбөр хариуцагчийн өр, орлогын харьцааны өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага						
2.3.	Өрхийн өр, орлогын харьцаа						
2.4.	Өрхийн өр, орлогын харьцааны өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага						
2.5.	Зээл/Үнэлгээний харьцаа (LTV) - Ипотек болон бусад хөрөнгө барьцаалсан зээл						
3.	Бусад		Тийм/үгүй			Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**	
3.1.	Барьцаа болон батлан даалт						
	3.1.1.	Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай эсэх					
	3.1.2.	Барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлт					

3.1.2.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулж, активыг төлүүлэх эрх нь банкд бүрэн шилжиж ирсэн эсэх			
3.1.3.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулах салбарын нөхцөл байдал			
3.1.3.	Гуравдагч этгээдээс гаргасан батлан даалт			
3.1.4.	Актив нь батлан даалттай бол батлан даагчийн төлбөрийн чадварын байдал			
3.2.	Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл			
3.2.1.	Төлбөр хариуцагчийн активын эргэн төлөлтийн түүх			
3.2.2.	Хугацаа хэтэрсэн ямарваа нэгэн активын болон бусад хэлбэрийн өртэй эсэх			
3.2.3.	Тухайн сард төлбөр хариуцагчийн аливаа нэг активын ангилал буурсан эсэх			
3.3.	Бусад мэдээлэл			
3.3.1.	Төлбөр хариуцагчийн ажил эрхлэлтийн байдал /тогтвор суурьшилтай ажилласан, хувиараа ажил эрхэлсэн/			
3.3.2.	Бусад төр, хууль хяналтын эрх бүхий болон төрийн бус байгууллагаас авсан лавлагаанд төлбөр хариуцагчийн талаар сөрөг мэдээлэл агуулаагүй			
3.3.3.	Банкнаас төлбөр хариуцагчийн санхүүгийн байдлыг аливаа хүндрэлгүйгээр үнэлж, дүгнэж байгаа			
3.3.4.	Эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдлийн түвшин, төлбөр хариуцагчийн ажил эрхэлж буй салбарын нөхцөл байдал төлбөр хариуцагчийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж байгаа, ирээдүйд нөлөөлөх хандлага эерэг			

3.3.5.	Төлбөр хариуцагчтай холбоотой үүсэх активын эрсдэлийг бууруулах аливаа даатгалд хамрагдсан			
3.3.6.	Төлбөр хариуцагчийн талаар банкинд төвлөрүүлсэн дотоод мэдээлэлд зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэл байхгүй			

Тайлбар:

*- Үнэлгээний хүснэгтээс зөвхөн хангалтгүй үнэлгээ авсан үзүүлэлтэд тайлбар бичих

** - Чанарын ангилалд мэдэгдэхүйц өөрчлөлт орохоор байгаа талаар үндэслэл, тайлбарыг бичиж, шаардлагатай баримт материалыг хавсаргана.

***-Холбогдох төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтийг 1-2 жил болон мэдээллийн хүрэлцээтэй байдлаас шалтгаалан түүнээс дээш жилийн хугацаатайгаар, сар, улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулж энэхүү хүснэгтэд хавсаргах бөгөөд үзүүлэлтийг тогтмол шинэчилнэ.

1-Санхүүгийн үзүүлэлтийн тайлант хугацааны утгыг тусгана.

2-Санхүүгийн үзүүлэлтийн өмнөх хугацааны хандлагыг тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар Өссөн /Ө эсвэл↑/, Буурсан /Б эсвэл↓/ эсвэл Тогтвортой /Т эсвэл ~ / гэсэн тэмдэглэгээг хийнэ.

3-Санхүүгийн үзүүлэлтийг ижил төстэй төлбөр хариуцагч бүлгийн эсвэл үйл ажиллагаа явуулах салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулж тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар дундаж үзүүлэлттэй харьцуулахад үзүүлэлт сайжирсан бол Сайжирсан /С эсвэл↑/, муудсан бол Муудсан /М эсвэл↓/ эсвэл онцын өөрчлөлтгүй бол Төстэй /Т эсвэл ~ / гэсэн тэмдэглэгээг хийнэ. Салбар болон бүлгийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас салбар, бүлгийн талаарх тоон мэдээллийн товхимол, цахим мэдээллийн сан болон банкнаас дотооддоо цуглуулсан тоон мэдээллийг ашиглаж болох ба мэдээлэл авсан эх сурвалжаа тусгасан байна. Салбар, бүлгийн дундаж үзүүлэлтийн мэдээг, санхүүгийн үзүүлэлтийн хандлагын мэдээтэй нэгтгэн энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

4- МХТТЗХуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3/; 23.4-т заасан тодорхойлолт.

Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар: Дээрх хүснэгтэд хангалтгүй үнэлгээтэй буюу материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөх үзүүлэлтүүдэд банкны зүгээс үндэслэл, тайлбарыг харгалзах баганад тусгах ба хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлт нь активын чанарын нийт үнэлгээнд мэдэгдэхүйц эсвэл ихээхэн нөлөөлөл үзүүлэх боломж, эрсдэл байгаа эсэхийг тодорхой тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд үндэслэлээ нотлох танилцуулга, баримт, материалуудыг энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

Хуулийн этгээдэд олгосон активыг чанарын үзүүлэлтээр ангилахад харгалзах хүчин зүйлсийн жагсаалт

Дд	Үнэлгээний хүчин зүйлс	Үнэлгээ	Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтийн тайлбар*	Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
1.	Активын хувийн хэргийн бүрдэл	Тийм/үгүй		
1.1.	Тухайн банкны мөрдөж буй дотоод дүрэм, журмын дагуу шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр бий эсэх, төлбөр хариуцагчийн талаарх банкны дүгнэлт			
1.2.	Актив олгохыг хүссэн өргөдөл			
1.3.	Активын төлбөр болон холбоотой бусад гэрээ, гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт			
1.4.	Төлбөр хариуцагчийн үүсгэн байгуулсан гэрээ, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ			
1.5.	Санхүүгийн тайлан			
1.6.	Барьцаа хөрөнгө			
	1.6.1. Годорхойлолт ⁴			
	1.6.2. Үнэлгээний баримт бичиг			
	1.6.3. Үл хөдлөх хөрөнгө бол улсын бүртгэлийн гэрчилгээ			

	1.6.4.	Шалгасан баримт				
	1.6.5.	Гадны хараат бус үнэлгээ				
1.7.	Батлан даалт болон барьцааны гэрээ					
1.8.	Активаар санхүүжигдэх төсөл					
	1.8.1.	Шаардлагатай бол эрх бүхий байгууллагаар батлуулсан эсэх				
	1.8.2.	Үйл ажиллагааны талаарх баримт бичиг				
	1.8.3.	Төслийн санхүүгийн тооцоолол				
	1.8.4.	Төсөлтэй холбоотой төлбөр тооцооны баримт бичиг				
	1.8.5.	Төсөл болон төлөвлөсөн ажлын гүйцэтгэл				
	1.8.6.	Холбогдох гэрээ				
1.9.	Активын ашиглалт шалгасан материал					
1.10.	Зээлийн мэдээллийн сан болон бусад эрх бүхий байгууллагуудын лавлагаа мэдээлэл					
1.11.	Банк төлбөр хариуцагчийн санхүүгийн байдлыг үнэлж, дүгнэхэд мэдээлэл хангалттай, аливаа томоохон хүндрэл учраагүй					
2.	Төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтүүд		Үзүүлэлт/харьцуулалт**			Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**
			Утга ¹	Δ% ²	Бүлгийн дундаж ³	Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах
2.1.	Төлбөрийн чадвар					

	2.1.1.	Эргэлтийн хөрөнгө /Богино хугацаат өр төлбөр, түүний өөрчлөлт, ирээдүйн хандлага					
	2.1.2.	(Мөнгөн хөрөнгө+Богино хугацаат хөрөнгө оруулалт+Авлага)/Богино хугацаат өр төлбөр, түүний өөрчлөлт, ирээдүйн хандлага					
	2.1.3.	Үндсэн үйл ажиллагааны орлого/богино хугацаат өр төлбөр, өөрчлөлт, ирээдүйн хандлага					
2.2.	Ашигт ажиллагаа						
	2.2.1.	Нийт ашиг /Нийт орлого, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)					
	2.2.2.	Нийт зардал/Нийт орлого, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)					
	2.2.3.	Активын өгөөж ROA, сүүлийн 3 жилийн хандлага (жил, хагас жилийн давтамжтай)					
	2.2.4.	Эзэмшигчдийн өмчийн өгөөж ROE, сүүлийн 3 жилийн хандлага (жил, хагас жилийн давтамжтай)					
2.3.	Хөрөнгийн удирдлага						
	2.3.1.	Авлагын эргэлт /сүүлийн 12 сарын дундаж/					
	2.3.2.	Авлагын эргэлт /тайлант үеийн эцэст/					
	2.3.3.	Бараа материалын эргэлт /сүүлийн 12 сарын дундаж/					
	2.3.4.	Бараа, материалын эргэлт /тайлант үеийн эцэст/					
	2.3.5.	Үндсэн хөрөнгийн эргэлт /тайлант үеийн эцэст/					

	2.3.6.	Нийт активын эргэлт /тайлант үеийн эцэст/					
2.4.	Хөшүүрэг ба өрийн үйлчилгээ						
	2.4.1.	Татвар болон хүү төлөхийн өмнөх ашиг /Хүүгийн зардал сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)					
	2.4.2.	Өр төлбөр/Хүүгийн, татварын болон элэгдлийн зардлыг хасахаас өмнөх ашиг, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)					
	2.4.3.	Эзний өмч /Хөрөнгө (leverage), өөрчлөлт, сүүлийн 1 жилийн хандлага (улирал, сарын давтамжтай)					
3.	Бусад		Тийм/үгүй			Материаллаг түвшинд сөрөг нөлөөтэй эсэх**	
3.1.	Барьцаа болон батлан даалт				Шалгуур үзүүлэлт бүрт тайлбар оруулах		
	3.1.1.	Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хангалттай эсэх					
	3.1.2.	Барьцаа хөрөнгийг худалдан борлуулж, активыг төлүүлэх эрх нь банкид бүрэн шилжиж ирсэн эсэх					
	3.1.3.	Барьцаа хөрөнгийн үнэлгээний өөрчлөлт, сүүлийн 3 сарын хандлага					
	3.1.4.	Төлбөр хариуцагч нь гуравдагч этгээдээс гаргасан батлан даалттай эсэх					
	3.1.5.	Актив нь батлан даалттай бол батлан даагч нь төлбөрийн чадвар сайтай					

		эсэх			
3.2.	Зээлийн мэдээллийн сангаас авсан мэдээлэл				
3.2.1.	Төлбөр хариуцагчийн түүх				
3.2.2.	Хугацаа хэтэрсэн ямарваа нэгэн активын болон бусад хэлбэрийн өртэй эсэх				
3.2.3.	Тухайн сард төлбөр хариуцагчийн аливаа нэг активын ангилал буурсан эсэх				
3.3.	Бусад мэдээлэл				
3.3.1.	Зэрэглэл тогтоогч байгууллагаас авсан мэдээлэл, төлбөр хариуцагчид болон төлбөр хариуцагчийн гаргасан үнэт цаасад оноосон зэрэглэлийн түүхэн болон одоогийн мэдээлэлд зэрэглэл бууруулах талаар тусгаагүй, сануулга /warning, negative watch/ гаргаагүй				
3.3.2.	Аудитын компаниас авсан мэдээлэл, хязгаарлалттай дүгнэлт гаргаагүй, удирдлагын захидалд дурдсан анхаарах зүйлс нь төлбөр хариуцагчид материаллаг байдлаар сөргөөр нөлөөлөхөөргүй				
3.3.3.	Бусад төр, хууль хяналтын эрх бүхий болон төрийн бус байгууллагаас авсан лавлагаанд төлбөр хариуцагчийн талаар сөрөг мэдээлэл агуулаагүй				
3.3.4.	Эдийн засгийн нөхцөл байдал, төлбөр хариуцагчийн үйл ажиллагаа эрхэлж буй салбарын нөхцөл байдал төлбөр хариуцагчийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж байгаа, ирээдүйд нөлөөлөх хандлага эерэг				
3.3.5.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад сувгаар төлбөр хариуцагчийн нэр хүнд болон санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр мэдээлэл цацагдаагүй				
3.3.6.	Төлбөр хариуцагчтай холбоотой үүсэх активын эрсдэлийг бууруулах аливаа даатгалд хамрагдсан эсэх				

3.3.7.	Төлбөр хариуцагчийн талаар банкинд төвлөрүүлсэн дотоод мэдээлэлд одоо болон ирээдүйд гарах зээлийн эрсдэл байхгүй			
--------	---	--	--	--

Тайлбар:

*- Үнэлгээний хүснэгтгээс зөвхөн хангалтгүй үнэлгээ авсан үзүүлэлтэд тайлбар бичих

** - Чанарын ангилалд мэдэгдэхүйц өөрчлөлт орохоор байгаа талаар үндэслэл, тайлбарыг бичиж, шаардлагатай баримт материалыг хавсаргана.

***-Холбогдох төлбөр хариуцагчийн санхүүгийн үзүүлэлтийг 1-2 жил болон мэдээллийн хүрэлцээтэй байдлаас шалтгаалан түүнээс дээш жилийн хугацаатайгаар, сар, улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулж энэхүү хүснэгтэд хавсаргах бөгөөд үзүүлэлтийг тогтмол шинэчилнэ.

1-Санхүүгийн үзүүлэлтийн тайлант хугацааны утгыг тусгана.

2-Санхүүгийн үзүүлэлтийн өмнөх хугацааны хандлагыг тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар Өссөн /Ө эсвэл↑/, Буурсан /Б эсвэл↓/ эсвэл Тогтвортой /Т эсвэл ~/
гэсэн тэмдэглэгээг хийнэ.

3-Санхүүгийн үзүүлэлтийг ижил төстэй төлбөр хариуцагч бүлгийн эсвэл үйл ажиллагаа явуулах салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулж тусгах бөгөөд сүүлийн үеийн байдлаар дундаж үзүүлэлттэй харьцуулахад үзүүлэлт сайжирсан бол Сайжирсан /С эсвэл↑/, муудсан бол Муудсан /М эсвэл↓/ эсвэл онцын өөрчлөлтгүй бол Төстэй /Т эсвэл ~/
гэсэн тэмдэглэгээг хийнэ. Салбар болон бүлгийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас салбар, бүлгийн талаарх тоон мэдээллийн товхимол, цахим мэдээллийн сан болон банкнаас дотооддоо цуглуусан тоон мэдээллийг ашиглаж болох ба мэдээлэл авсан эх сурвалжаа тусгасан байна. Салбар, бүлгийн дундаж үзүүлэлтийн мэдээг, санхүүгийн үзүүлэлтийн хандлагын мэдээтэй нэгтгэн энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

4- МХТТЗХуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3/; 23.4-т заасан тодорхойлолт.

Активын чанарын ангилал тогтоох үндсэн заавар: Дээрх хүснэгтэд хангалтгүй үнэлгээтэй буюу материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөх үзүүлэлтүүдэд банкны зүгээс үндэслэл, тайлбарыг харгалзах баганад тусгах ба хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлт нь активын чанарын нийт үнэлгээнд мэдэгдэхүйц эсвэл ихээхэн нөлөөлөл үзүүлэх боломж, эрсдэл байгаа эсэхийг тодорхой тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд үндэслэлээ нотлох танилцуулга, баримт, материалуудыг энэхүү хүснэгтэд хавсаргасан байна.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 3 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- 1. Компанийн засаглалын нөхцөл байдлын судалгааны үр дүнгийн тайлан (туслан гүйцэтгэгчээр)**
- 2. Компанийн Засаглалын семинар хийсэн өөрийн үнэлгээний хуудасны хариулт**
- 3. Компанийн Засаглал- Өөрийн үнэлгээний хуудасны асуулт**

**1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (ТУСЛАН
ГҮЙЦЭТГЭГЧЭЭР)**

2018 оны 7-р сарын 24

Монголын компанийн санхүү болон компанийн
засаглалын талаарх асуулга судалгаа

Эцсийн тайлан

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

Гарчиг

1 Судалгааны агуулга

- Судалгааны нөхцөл байдлын агуулгын талаарх тайлан
- Судалгаанд хамрагдсан компанийн ¹ талаар
- Судалгаанд хамрагдсан компанийн гэр бүлийн байдлын талаар

2 Компанийн засаглалын талаар

- Компанийн засаглалын талаарх ойлголтын талаар
- Компанийн мэдээллийн нээлттэй байдлын талаар
- Монголын компанийн ёс зүйн талаар
- Компанийн засаглалын талаарх бодлогын санал

3 Компанийн санхүүгийн талаар

- Судалгаанд хамрагдсан компанийн хөрөнгийн нөхцөл байдлын талаар
- Компанийн нягтлан бодох бүртгэлийн нөхцөл байдлын талаар
- Арилжааны банкнаас зээл авахтай холбоотой хүндрэлтэй зүйлийн талаар
- Зээлийн батлан даалтын сангийн талаар
- Компанийн санхүү болон зээлтэй холбоотой бодлогын санал

4 Компани дээр очиж авах судалгааны талаар

(дуусаагүй байгаа, эцсийн тайлантай хамт өгнө)

5 Судалгааны үр дүнгийн нэгтгэл

(дуусаагүй байгаа, эцсийн тайлантай хамт өгнө)

6 Хавсралт материал

- Компани дээр очиж авсан судалгааны уулзалтын тэмдэглэл (дуусаагүй байгаа, эцсийн тайлантай хамт өгнө)
Үр дүнгийн тэмдэглэл (дуусаагүй байгаа, эцсийн тайлантай хамт өгнө)

¹ Энд судалгаанд хамрагдсан компани гэж энэ удаагийн асуулга судалгаанд хамрагдсан бүх компанийг хамруулан нэрлэж байгаа.

1. Судалгааны агуулга:

Судалгааны зорилго:

“Монголын компанийн санхүү болон компанийн засаглал” судалгаа нь Монгол улсын аж ахуйн нэгж, компаниудын зээлийн мэдээллийн хяналт болон компанийн засаглалын өнөөгийн байдал, тулгарч буй асуудлыг тодорхойлон, цаашид аж үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн бодит арга хэмжээний зөвлөмж гаргах зорилготой.

Судалгааны аргачлал:

Судалгааг 2018 оны 4 сарын 17 өдрөөс 5 сарын 25 өдөр хүртэл цахимаар авсан. Монгол Япон төвийн бизнесийн сургалт төгсөгчдийн цахим шуудангийн мэдээллийн сангаар нийт 10 гаруй мянган хүнд судалгааны мэдээллийг хүргүүлж нийт 586 компани сайн дурын үндсэн дээр судалгаан хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан компаниудын мэдээллийг шалгаж үзээд чанарын шаардлага хангахгүй 33 компанийн мэдээллийг хасаж сүүлийн байдлаар 553 компанийн мэдээллийг нэгтгээд байна. Энэхүү судалгаанд ЖАЙКА-ийн хоёр үе шатлалтай зээлд хамрагдсан компанийн мэдээллийг тусад нь цуглуулах төлөвлөгөөтэй байсан боловч тус мэдээллийн санд компанийн холбоо барих мэдээлэл байгаагүй тул энэхүү судалгаанд тусгаж чадаагүйд болно. Гэвч судалгаан хамрагдсан компани дунд ЖАЙКА-ийн хоёр үе шатлалтай зээлд хамрагдсан компани тодорхой хэмжээгээр орсон байгаа болно.

Мөн түүнчлэн 5 сарын 25 өдрөөс 6 сарын 26 өдөр хүртэл тус 553 компани дундаас түүврийн аргаар 30 компани дээр биечлэн очиж Монголын бизнесийн орчин болон тухайн компанийн санхүү, засаглалын талаар дэлгэрэнгүй ярилцаж мэдээллийг авсан.

Судалгаанд хамрагдсан компаниудын товч танилцуулга

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (МУҮСХ)-ны мэдээллээс үзэхэд 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар 158,800 компани бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр компаниас 81,000 компани идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр компанийг нийт ажилтны тоогоор нь авч үзвэл:

Нийт ажилтны тоо 10 хүртэлх: 85.5%


Нийт ажилтны тоо 10-20 хүртэлх: 6.4%

Нийт ажилтны тоо 20-50 хүртэлх: 5.0%

Нийт ажилтны тоо 50-аас дээш: 3.1%

(Доорх харьцуулсан хүснэгтийг харна уу.)

Нийт ажилтны тоонд суурилсан бизнесийн цар хүрээ
2018 оны нэгдүгээр улирал



- Нийт ажилтны тоо 10 хүртэлх
- Нийт ажилтны тоо 10-20 хүртэлх
- Нийт ажилтны тоо 20-50 хүртэлх
- Нийт ажилтны тоо 50-аас дээш

Нийт ажилтны тоо	Статистикийн хороо	Судалгаа
20 хүртэлх	91.9%	69%
20-50 хүртэлх	5.0%	12%
50-аас дээш	3.1%	19%

МУҮСХ-ны үзүүлэлтэд нийт ажилтны тоо 20 хүртэлх жижиг аж ахуйн нэгж² 90-ээс дээш хувийг эзэлж байгаа бол энэ удаагийн судалгаагаар 70% нь жижиг аж ахуйн нэгж эрхлэгч, үлдсэн 30% (дотор 12 хувьцаат компани багтсан) нь 20-оос дээш хүнтэй дунд аж ахуйн нэгж хамрагдсан болно. МУҮСХ-ны үзүүлэлттэй харьцуулвал Монголын бизнес эрхлэгчийн статистик дүнгээс бага зэрэг их байгаа шалтгаан нь судалгаанд хамрагдсан компаниудын гуравны нэг нь Монгол-Японы төвийн сургалтын төгсөгч компани буюу харьцангуй эдийн засгийн хувьд боломжтой компаниуд, өөрөөр хэлбэл жижиг дунд аж ахуйн нэгжүүд судалгаанд олноор хамрагдсан тул ийм үр дүнд хүрсэн болно.

Тийм учраас дүн шинжилгээнд жижиг аж ахуйн нэгж болон дунд аж ахуй нэгжийн ойлголтын ялгааг харьцуулах шаардлага тулгарч байна.

Тийм учраас, дүн шинжилгээнд жижиг аж ахуйн нэгж болон дунд аж ахуйн нэгжийн ойлголтын ялгааг харьцуулах шаардлага тулгарч байна.


Үргэлжлүүлэн доорх диаграмд судалгаанд хамрагдсан компаниудыг үйл ажиллагааны салбараар нь болон ДНБ-д эзлэх салбараар нь харьцуулсан болно. Энэ удаагийн судалгаагаар үйлдвэрлэлийн салбар, барилгын салбарын харьцаа бага зэрэг их байгаа

² Жижиг аж ахуйн нэгж - Нийт ажилтны тоо 20 хүртэлх компани
Дунд аж ахуйн нэгж эрхлэгч- Нийт ажилтны тоо 20-оос дээш компани


бөгөөд Монголын голлох салбаруудын нэг болох хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь бага боловч тус диаграммыг нийтэд нь харвал ДНБ-ий аж үйлдвэрлэлийн салбарын харьцаатай хол зөрүүгүй гэж хэлж болно.

Мөн тус судалгаа нь Монголын аж үйлдвэрлэлийн аль нэг салбар руу хэт давамгайлаагүй тул Монголын нөхцөл байдлыг бүхэлд нь таамаглаж дүгнэх боломжтой гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан компаниудын үйл ажиллагааны салбар



Монголын аж үйлдвэрлэлийн салбар (ДНБ салбараар)



Судалгаанд хамрагдсан компаниудын гэр бүлийн бизнесийн байдал

Хоёрдугаар хэсгийн 6-р асуултад 21% нь хувьцаа эзэмшигч байхгүй гэж хариулснаас үзэхэд судалгаанд оролцогчид асуултыг буруу ойлгосон байгаа нь харагдаж байна. Үнэндээ бол үүсгэн байгуулагчийг хувьцаа эзэмшигч³ гэж үздэг. Өөрөөр хэлбэл 62% нь хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч нь нэг хүн гэж ойлгож болно. Мөн 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй 26 компани байгаа бөгөөд 12 нь хувьцаат компани байна.

Хувьцаат компани биш ч Монголын томоохон компаниуд болох Номин Холдинг, Эрдэнэт хивс гэх мэт компани нь 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байгаа хэдий ч хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын ихэнх нь гэр бүлийн бизнес гэж хэлж болно.

Мөн хоёрдугаар хэсгийн 5-р асуултад ТУЗ-д гэр бүлийн бус гишүүд байдаг гэж хариулсан 76 (Нийт оролцогчдын 13,7%) компани байна.

Үүнээс үзэхэд судалгаанд оролцсон компанийн ойролцоогоор 86% нь гэр бүлийн бизнес эрхэлж байна гэж хэлэхэд буруудахгүй.

2. Компанийн засаглалын талаар

= Компаниудын компанийн засаглалын талаарх ойлголтын талаар =

Хоёрдугаар хэсгийн 2-р асуултын тухайд, 12 хувьцаат компаниас компанийн засаглалын талаар ямар нэгэн дүрэм, стандарттай гэж хариулсан 10 компани байгаа ба хувьцаат компани хэдий ч компанийн засаглалын дүрэм, стандарт боловсруулаагүй

³ Хувьцаа эзэмшигч гэдэг нь хязгаарлагдмал хувьцаат компанийн хувьд хөрөнгө оруулагчтай утга дүйх бөгөөд хувьцаа гаргадаггүй хязгаарлагдмал компанийн хувьд хөрөнгө оруулалтын харьцаагаар нь хувьцаа эзэмшигч гэсэн үгийг ашигладаг.

компани оршсоор байна.

Хувьцаат компанитай харьцуулахад жижиг дунд аж ахуйн нэгжүүд компанийн засаглалын ямар нэг дүрэм стандарт хэрэгжүүлж байгаа гэсэн нь нийт компаниудын 43%-ийг эзэлж байгаа нь компанийн засаглалын хэрэгцээ Монголд нэвтрээгүй гэж хэлэхэд хүндрэлтэй үр дүн гарч ирэв.

Гэвч ихэнх нь

“Өөрийн гэсэн компанийн засаглалын үндсэн бодлого боловсруулсан (140 компани, 25%)”

“Компанийн засаглалын бүтцийг боловсруулсан (75 компани, 14%)”

“Дотоод болон хөндлөнгийн аудит хяналт хийгддэг (69 компани, 12%)”

гэж хариулсан байсан ч,

“ТУЗ-ийн гишүүн гаднаас авч ажиллуулдаг (24 компани, 4%)”

“Шийдвэр гаргагч хэсэг болон хэрэгжүүлэгч хэсгийг салгах журам боловсруулсан (33 компани, 6%)”

гэсэн хариулт цөөн байгаа бөгөөд ихэнх компанийн удирдлага, захирлын засаглалын тухай бодлого нь мөрдөгдөхгүй компаниуд олон байна.

Мөн Монголд өмнөх хэсэгт дурдсанчлан жижиг аж ахуйн нэгжүүд гэр бүлийн компани байх нь нийтлэг бөгөөд бизнесээ үргэлжлүүлэн авч явахад асуудлууд тулгардаг. Хоёрдугаар хэсгийн хариултын үр дүнг харахад, бизнесийн залгамжлалтай холбоотой ямар нэгэн арга хэмжээ хэрэгжүүлж буй компани 17% хүрэхгүй байна. Энэ нь Японы захирлуудын дундаж нас 61,194-тэй харьцуулахад, Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжээд харьцангуй удаагүй тул энэ судалгаагаар тодорхой тоогоор илэрхийлэгдээгүй ч, доогуур гэсэн хүчин зүйл нь бизнес тогтвортой үргэлжлэхэд саад болсон хэвээр байна.

Хоёрдугаар хэсгийн 4-р асуултад нийт компанийн 76% нь ТУЗ байхгүй гэж хариулсан ба 6-р асуултад хувьцаа эзэмшигчийн тоо 1-ийг сонгосон компани 62% буюу нийт компанийн гуравны хоёрыг эзэлж буйгаас харахад ч, компанийн бизнесийн тасралтгүй байдлын нэгээхэн хэсгийг удирдлагын менежменттэй холбон тайлбарлаж болохоор байна. Монгол улсын компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 2-т, Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно гэж заасан байна. Мөн 75 дугаар зүйлийн 4 дэх заалтад, хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заажээ. Түүнчлэн, 75 дугаар зүйлийн 8-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна гэж заажээ. Энэ мэт нөхцөл байдлыг харьцуулаад харахад, Японд ТУЗ-ийг байгуулахдаа төлөөлөн удирдах зөвлөл нь гурав буюу түүнээс дээш байдаг тул хувьцаат компанийн засаглалтай холбогдох хуулийн заалтаар Японыхоос

⁴ Токиогийн ХАҮТанхимын судалгаа “2016 оны Япон орон даярх захирлуудын дундаж насны талаарх судалгаа” (Нийтэд зарласан огноо 2017.02.03) -аас ишлэв.

хатуу чанга байна.

Энэхүү нөхцөл байдлыг эргэцүүлбэл, компанийн засаглал болоод компанийн засаглалаас улбаатай бизнесийн тасралтгүй үргэлжлэх асуудлын тухайд, хувьцаат компанийн засаглалыг хуулийн заалтын дагуу тодорхой хүрээнд зааж өгсөн байдаг ч, жижиг аж ахуйн нэгжийн компанийн засаглалын тухай хуулийн зохицуулалтгүй, хэт чөлөөт байгаа нь бодит байдал юм.

Нөгөөтэйгүүр жижиг аж ахуйн нэгж эрхлэгчийн тухайд, компанийн засаглалын бүтцийг хадгалах, мэдээллийг нээлттэй болгох нь төсөөллийн төдий зүйл бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй компани болон дотоод гадаадын хөрөнгө оруулалт хүсч буй компанийн хувьд тийнхүү компанийн засаглалыг тогтвортой байлгахыг хүсдэг, үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж буй аж ахуй нэгжүүд ч цөөнгүй бий. Гэвч компанийнхаа засаглалыг хэвээр хадгалж, мэдээллийг нээлттэй болгоход тэр хэмжээний зардал гарах нь компанийн санхүүгийн нөхцөл байдлыг дордуулах талтай ба үйл ажиллагааны далайцаас хамаараад компанийн засаглалын тогтолцоог бий болгох нь компанийн хэвийн үйл ажиллагааг хязгаарлах магадлалтай гэдгийг бас бодож үзэх шаардлагатай. Тиймээс өнөөгийн хувьцаат компаниуд болон бусад гэсэн ангиллаар хэмжээ тогтоох бус, хязгаарлагдмал хариуцлагатай компани ч тэрхүү хүрээнд хамрагдаж, компанийн засаглалын талаарх журмыг үе шаттайгаар бий болгох нь бас нэгэн сонголт байж болох юм.

==Компанийн мэдээллийг нээлттэй болгох талаар==

Монголын ихэнх компани мэдээллээ нээлттэй болгох тал дээр идэвхгүй гэж боддог.

Энэ удаагийн асуулгын үр дүнгээр ч цахим хуудастай компани нийт компанийн гуравны нэгийг л эзэлж, тэр дундаа IR⁵-тай холбоотой мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгосон 47 компани байгаа нь нийт компанийн дөнгөж 10%-д ч хүрэхгүй байна. Мөн компанийн засаглалтай холбоотой тайлан мэдээгээ гаргасан нь хувьцаат компаниудаас зөвхөн Говь ХК бөгөөд бусад Номин Холдинг, Эвридэй зэрэг гадаадын компанитай хамтарч ажилладаг компаниуд өөрсдийн цахим хуудсан дээрээ компанийн засаглалын тайланг нээлттэй болгосон гэж хариулжээ.

Үүний цаана, Монгол компанийн онцлог, техник, худалдааны ноу-хауг хамгаалахын тулд бизнесийнхээ дэлгэрэнгүйг гадагш задруулахгүй гэх компаниа хамгаалах бодлогыг зөвтгөх Монголын компанийн нийгмийн гадарга харагдана.

Өдөр тутмын амьдралд ч, тухайлбал, ресторан болон жижиглэн худалдааны дэлгүүрт зураг авахыг дургүйцдэг, хэрэгцээт мэдээллийг гадагш задруулахгүй гэх нийгмийн нийтлэг хандлага байдгаас мэдээллийг ил тод болгох тал дээр идэвхгүй ханддаг хэмээн таамаглаж болохуйц байна.

Улмаар, Хоёрдугаар хэсгийн 20-р асуулт болох “Та Монголын компаниудын олон нийтэд дэлгэдэг санхүүгийн тайланг үнэн зөв гэдэгт итгэлтэй байж чадах уу” гэсэн асуултад нийт компанийн гуравны хоёр нь “Үгүй” гэж хариулсан нь өнөөгийн Монголд мэдээллийг нээлттэй болголоо ч итгэдэггүй, эсвэл идэвхгүй болгодог нэгэн хүчин зүйл байдаг гэдгийг таамаглаж болохоор байна. Үүний цаад шалтаантай холбогдох Гуравдугаар хэсгийн 16-р асуулт болох “Банкны зүгээс зээлийн шийдвэрт хамгийн их

⁵ Энд IR гэдэг нь Investor relations-г хэлж буй

анхаардаг зүйл юу гэж үзэж байна вэ” гэсэн асуултад нийт компанийн 46% нь барьцаа, 36% нь санхүүгийн нөхцөл байдлыг бүхэлд нь, өөрөөр хэлбэл, хөрөнгө, бэлэн мөнгө, үнэт цаас зэрэг биет зүйлийг чухалчилна гэсэн бол дансны гүйлгээ, чухалчилна гэсэн хариулт ердөө 12% байсан нь компанийн засаглалын нөхцөл байдал болон итгэлцэл гэсэн биет бус зүйлээс илүү бодит зүйлийг илүүд үзэх хандлага Монголын санхүүгийн байгууллагуудад байгааг мэдэж болно.

Гэвч, Гуравдугаар хэсгийн 17-р асуулт буюу “Зээл авах тохиолдолд банкны зүгээс танай компанийн засаглалын байдлыг үнэлэх эсвэл анхаарч үздэг гэж бодож байна уу” гэсэн асуултад 38% нь “Үгүй” гэж хариулсан тул компанийн засаглалын талаарх ойлголт дээшлэх хандлагатай байгааг харж болно. Иймд цаашид гадны итгэлийг олж авахын тулд компанийн ямар засаглал бий болгох тухай аргачлалыг эрэлхийлэх шаардлага тулгарч байна.

=Монгол компанийн компанийн ёс зүйгийн талаар =

Өмнөх хэсэгт дурдсаны дагуу энэ удаагийн судалгаанд оролцсон нийт компанийн гуравны хоёр нь компаниудын талаарх нээлттэй мэдээллийн найдвартай байдалд итгэхгүй гэж хариулсан. Хэрэгтэй чухал мэдээллийг нууцлах нь энгийн ойлголт болсон өнөөгийн Монголын нийгэмд олон нийтэд дэлгэсэн мэдээлэлд итгэх нь бага гэдгийг харуулж байна.

2 дугаар хэсгийн 18-р асуулт

Ер нь Монголын компаниуд ашигладаг тайлан, зээл авахын тулд банкинд өгдөг тайлан болон Татварын хэлтэст өгдөг тайлан гэх мэт тухайн зориулалтаас хамаарч санхүүгийн тайланг өөр өөрөөр бэлтгэх тохиолдол байдаг гэж бодож байна уу?

254 компани (46%) нь “Тийм”

2 дугаар хэсгийн 19-р асуулт

Монголд компаниуд татвараа бага төлөхийн тулд Татварын байцаагчид хахууль өгөх байдлаар ажилладаг асуудал байдаг уу?

157 компани (28%) нь ”Тийм”

2 дугаар хэсгийн 20-р асуулт

Та Монголын компаниудын олон нийтэд дэлгэдэг санхүүгийн тайланг үнэн зөв гэдэгт итгэлтэй байж чадах уу?

341 компани (62%) нь “Тийм”

Дээрх асуултын үр дүнд харуулж байгаачлан компаниуд олон нийтэд нээлттэй мэдээлэлд итгэх нь бага. Мөн одоо ч гэсэн хахууль өгдөг хүмүүс байгаа гэж бодож буй компанийн удирдлагууд олон байна.

Монголын компаниуд хамтын ажиллагаа эхлэх гэж буй хамтрагч байгууллагын итгэлийн судалгааны тухайд гуравдугаар хэсгийн 23-р асуултын 33% нь судалгаа хийдэггүй, 16% нь бэлэн мөнгөөр гүйлгээ хийдэг тул онц шаардлагагүй, 31% нь янз бүрийн танилуудын үнэлгээг сонсдог гэж хариулсан байна. Судалгаа шаардлагагүй гэж үздэг компани 49%-ийг эзэлж байгаа нь итгэж болох материалыг бэлдэх, материалыг гаргаж өгөх хэрэгцээ, боломж байхгүй гэсэн бизнесийн хандлага

ажиглагдаж байна.

Монголын ийм бизнесийн орчин өөрчлөгдөөгүй цагт компаниудын компанийн засаглалын талаарх ойлголт дээшлэх, компанийн ёс зүй дээшилнэ гэж харагдахгүй байна.

= Компанийн засаглалын талаарх бодлогын санал =

Дээрх асуулга судалгаа, ярилцлагын судалгаанаас Монголын захирал, удирдлагууд компанийн засаглалын талаар мэдлэг хэрэгтэй гэж үздэг ч хэрэгжүүлж чаддаггүй гэсэн үр дүн тодорхой болж байна. Өөрөөр хэлбэл, компанийн засаглал, бизнесийн орчин бүрэлдсэнээр бий болох идеал төлөв нь:

- Бизнесийн саадгүй үйл ажиллагаа
- Гэрээ, хамтын ажиллагааны бичиг баримт бүрдүүлэлтийн хялбар болгох
- Боломжит нөхцөлтэй санхүүжилт
- Компанийн дүр төрх сайжирснаар бизнесээ өргөжүүлэх гэх мэт тал дээр давуу тал бий болох

Компанийн засаглалыг бэхжүүлж, мэдээллийг нээлттэй болгож мэдээллийн нийцэмжтэй байдлыг дээшлүүлэх хүсэлтэй байдаг ч, бодит байдал дээр тодорхой ашиг гарахгүй тул компанийн засаглалыг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үздэг компаниуд олон болов уу.

Мөн хоёрдугаар хэсгийн 19-р асуултад татварын байцаагчид хахууль өгөх байдлаар ажилладаг уу гэсэн асуултад 28% нь тийм гэж хариулсан. Бодит байдал дээр хахууль өгөх энэхүү үзүүлэлт өөр байж болох ч хуульд тусгагдсан агуулгыг биелүүлэх ёстой төрийн байгууллагуудад итгэх итгэл бага байна гэдгийг харуулж байна. Тиймээс төрийн байгууллага, төрийн албан хаагчийн нийгмийн үнэлгээг дээшлүүлэх бодлого хэрэгтэй.

Дээрх нөхцөл байдлыг сайжруулж, цаашид гадаадын хөрөнгө оруулалт болон олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүжилтийн арга барилаар байгууллагын бизнесийг эрүүлээр өргөжүүлэхэд зөвхөн нэг компанийн хүчин чармайлтаар биелүүлэх нь маш хэцүү. Төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтдаа компанийн засаглалын талаарх асуудалд оролцохгүй бол үр дүн гарах боломжгүй.

Тиймээс Монгол улсын нийт компанийн засаглалын нөхцөлийг сайжруулахад доорх бодлогууд хэрэгтэй болов уу.

1. Хуулинд компанийн засаглалын тухай нөхцөл нэмэх, өөрчлөх, чангаруулах
2. ХХК-ийн хувьд, тухайн бизнесийн цар хүрээнээс хамаарч шатлалтай дүрмийг нэвтрүүлэх
3. Мөн компанийн засаглал, компанийн мэдээллийн нээлттэй байдлын хуулинд тогтоосон агуулгыг биелүүлж, мөрдөх ёстой төрийн байгууллага, төрийн албан хаагчийн мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, ажлын ёс зүйг дээшлүүлэх, гүйцэтгэх тогтолцоог бэхжүүлэх
4. Компанийн засаглал болон мэдээллийн нээлттэй байдлын хэрэгцээ, ашигтай

байдал болон төрд итгэх итгэлийг бий болгох төрийн байгууллагын сурталчилгааг бэхжүүлэх

5. Компанийн засаглалын нөхцөл байдлаас хамааран бодит, тодорхой давуу эрхэт систем⁶ийг бий болгох

⁶ Давуу эрхэт систем нь Арилжааны банк болон компаниудад чиглэсэн зээлийн байгууллагуудын зээлийн хүүг бууруулах, татварын хөнгөлөлт, топ компаниудыг шалгаруулж өргөмжлөл, урамшуулал олгох үед компанийн засаглалын үнэлгээний нэвтрүүлэлт зэрэг нөхцөлүүд багтана.

3. Компанийн санхүүгийн байдлын талаар

= Судалгаанд хамрагдсан компаниудын хөрөнгийн нөхцөл байдлын талаар=

Нэгдүгээр хэсгийн 9-р асуултын үр дүнгээс үзэхэд энэ удаагийн судалгаанд хамрагдсан компанийн 51% нь 200,000,000₮(83,000 орчим ам.доллар) хүртэлх үндсэн хөрөнгөтэй байна.

Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан компанийн тал нь барьцаа болохуйц хөрөнгөтэй байгаа ч барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнгээс хамаарах санхүүжилтийн чадвар нь хэдэн арван мянган доллар орчим гэж үнэлэгдэн томоохон тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт авах хэмжээнд хүрэхгүй байна. Үүнд гуравдугаар хэсгийн 16-р асуултын үр дүнгээс харахад гол санхүүжихэх үүсвэр болох банк нь зээлийн төлөлтийн түүх гэх мэтийн найдвартай байдлын мэдээллийг эх сурвалж болгохгүйгээр барьцаа гэх мэтийн бодит зүйлийг чухалчлах хандлагатай гэсэн хариулт олон байна.

Энэ хариултын үр дүнгээс үзэхэд жижиг аж ахуйн нэгжийн эрхлэгчид бизнесийн амжилттай эсэхээс хамааралгүйгээр ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт авахад зээлийн хэмжээнээс хэд дахин их барьцаа хөрөнгө юм уу, ижил хэмжээний бэлэн мөнгө эсвэл бэлэн мөнгөтэй дүйцэхүйц эргэлтийн хөрөнгийг барьцаа хөрөнгө болгох шаардлага гардаг тул жижиг аж ахуйн нэгжид ихээхэн хэмжээний хөрөнгө оруулах нь маш хүнд хэцүү байдалтай байна.

=Компанийн нягтлан бодох бүртгэлийн нөхцөл байдлын талаар=

Хоёрдугаар хэсгийн 8, 9-расуултын хариултад үндэслэн бодит нөхцөл байдлыг харахад энэ удаагийн судалгаанд хамрагдсан компанийн 68% нь өөрсдөө нягтлан бодох бүртгэл тооцоогоо хийх нь түгээмэл бөгөөд үндсэн нягтлан бодогчгүй компанийн хувьд ч гэрээт нягтлан бодогч хөлслөн, бүртгэлийн ажлаа мэргэжлийн хүнд даатгах хандлага ихээхэн харагдаж байна. (“Үгүй” гэж хариулсан компанийн 153 нь буюу 86% нь гэрээт нягтлан бодогч хөлсөлдөг, 8 компани буюу 4% нь аудитын компаниар хийлгэдэг, 18 компани буюу 10% нь бусад гэж хариулсан байна.)

Гуравдугаар хэсгийн 5-р асуултын санхүүгийн нөхцөл байдлыг тайлбарлах санхүүгийн мэргэжилтэн нягтлан бодогч байдаг уу гэсэн асуултын ихээхэн хувийг буюу 43%-ийг “Үгүй” гэсэн хариулт эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Энэ мэдээллээс үзэхэд

- Удирдлагын түвшний хувьд санхүүгийн тайлангаас олж авах боломжтой мэдээллийн талаарх сонирхол бага
- Эсвэл байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаас санхүүгийн мэдээллийг олж авч чаддаг

гэдгийн аль нэг нь боловч, дараагийн асуултын хариултаас авч үзэхэд удирдлагууд санхүүгийн мэдээллийн талаарх сонирхол бага гэсэн хандлага ихээхэн ажиглагдаж байна.

Гуравдугаар хэсгийн 2-р асуулт болох орлогын тайлангийн ямар үзүүлэлтийг чухалчилдаг вэ гэсэн асуултын хувьд 442 компани буюу нийт хамрагдсан компанийн 80% нь борлуулалтын орлогыг чухалчлж дараачаар нь үйлдвэрлэлийн өртгийг харьцангуй бага 242 компани буюу 44% нь чухалчилдаг гэж хариулсан байна. Эндээс

үзэхэд Монголын компаниуд борлуулалтын нийт ашгийг чухалчлах хандлага ажиглагдаж байна. Энэ үзүүлэлтээс арай буурсан үзүүлэлт болох үндсэн үйл ажиллагааны ашиг гэсэн хариулт нийт хариултын гуравны нэг болох 33%, үндсэн бус үйл ажиллагааны ашиг гэсэн хариулт 35% байгаагаас үзэхэд ашгаас илүү борлуулалтын орлогыг чухалчлах хандлагатай байна. Мөн гуравдугаар хэсгийн 3-р асуулт болох чухалчилдаг санхүүгийн үзүүлэлт байгаа эсэх гэсэн асуултад дөрөвний нэг нь хариулсан байгаа нь санхүүгийн тайлангийн менежментэд үзүүлэх нөлөө бага гэж судалгаанд хамрагдсан байгууллагууд үзэж байна.

Тухайн 147 компанийн дотор ROA-ийг чухалчилдаг гэсэн хариулт (51 компани, Тийм гэж хариулсан компанийн 35%, нийт судалгаанд хамрагдсан компанийн 9%) хамгийн их байна. 41 компани ROE гэсэн үзүүлэлтийг чухалчилдаг гэж хариулсан бөгөөд 100-аас дээш хувьцаа эзэмшигчтэй 2 компани, 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй 1 компани, маш олон хувьцаа эзэмшигч компани 3 байна. Үлдсэн 38 компани ROE гэж хариулсан ч ихэнх нь 1 болон 2 хувьцаа эзэмшигчтэй байна. ROE нь хувьцаа эзэмшигч ногдол ашгийн мэдээллийг олохын тулд цэвэр хөрөнгөөс харах үзүүлэлт тул дунд эсвэл жижиг аж ахуйн нэгж эрхлэгчийн хувьд ерөнхийдөө ROA үзүүлэлтийг чухалчилдаг. Эндээс Монголын компаниудын удирдлагын түвшний хүмүүс санхүүгийн хангалттай мэдлэггүй гэж үзэж байна.

Дүгнэхэд

- Удирдлагын түвшний хүмүүс санхүүгийн тайланд хандах ойлголт буюу мэдлэгийг дээшлүүлснээр санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, итгэлт байдал, ашигтай байдал дээшилнэ.
- Удирдлагын түвшнийхэн тохиромжтой санхүүгийн мэдээлэл, санхүүгийн үзүүлэлтийг хянаснаар компанийн санхүүгийн эрүүл байдлыг нэмэгдүүлэн, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж дээшлэнэ гэж таамаглаж байна.

=Арилжааны банкнаас зээл авахад тулгардаг асуудлын талаар=

Энэ удаагийн судалгааны үр дүнгээс Монголын компаниуд арилжааны банкнаас зээл авахад хамгийн их хүндрэлтэй асуудал гэж 40%-иас илүү хариулсан сонголтуудыг жагсаавал

- Хүү өндөр 445 компани (80%)
- Барьцаа хөрөнгөний үнэлгээ доогуур 367 компани (66%)
- Бүрдүүлэх баримт олон 294 компани (53%)
- Буцаан төлөх хугацаа богино 238 компани (43%)
(Гуравдугаар хэсгийн 20 дугаар асуултын хариултаас)

дээрх үр дүн гарсан юм. Буцаан төлөх хугацаа богино гэсэн хариултад арилжааны банкнаас заасан хугацаа богино гэсэн утга болон хүү өндөр тул буцаан төлөх хугацааг богино байлгахгаас өөр аргагүй гэсэн утга хариултад нь агуулагдаж байна гэж үзэхийн зэрэгцээ зөвхөн арилжааны банкны талын асуудал гэж үзэж болохгүй болохыг анхаарах шаардлагатай юм.

Энэ удаагийн судалгаагаар ямар байгууллагаас зээл авдаг тухай судалгааг авсан.

Гуравдугаар хэсгийн 8, 10 дугаар асуултын хариулт болох үйл ажиллагааны санхүүжилт босгосон байгууллагын тухайд

- Банк бус санхүүгийн байгууллага болон ломбард зэргээс санхүүжилт босгож байсан. 103 компани буюу 19% нь “тийм”
- Хувь хүнээс санхүүжилт босгож байсан гэж 191 компани буюу 35% нь “тийм”

гэж хариулсан байна. Банк бус санхүүгийн байгууллага болон ломбардны хувьд банкнаас авах санхүүжилттэй харьцуулахад зээл авах хүү өндөр. Гэвч судалгаанд оролцсон компанийн 80% нь хүү өндөр гэж сэтгэл дундуур байгаагай хамааралгүйгээр банкнаас бусад санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах шалтгаан нь “санхүүжилттэй холбоотой судалгаа нь банктай харьцуулахад хялбар” гэсэн л зүйл байна. Мөн танил, найз нөхдөөсөө зээл авч санхүүжилт босгодог нь “хүү бага”, “санхүүжилттэй холбоотой судалгаа гэсэн нь ч томоохон шалтгаан болох ч эдгээр нь компанийн эрүүл санхүүжилт босгохыг зөв арга зам гэж үзэхгүй байна.

Банкнаас зээл авахад хүндрэлтэй санагддаг зүйлсээс хүү өндөр гэдэг сонголт маш их хувийг эзэлж байна. Мөн барьцаа хөрөнгөний үнэлгээ доогуур гэсэн сонголтын хувьд гуравны хоёр буюу маш их байгаагаас цаашид Монголд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дараах 3 зүйлийг сайжруулах нь ихээхэн чухал гэж бодож байна.

1. Хүү бууруулах
2. Барьцаа хөрөнгөний үнэлгээг тохиромжтой болгох
3. Зээлийн хяналт болон компанийн үнэлгээг хялбарчлах, оновчтой хурдан болгох

Монголд тулгамдаж буй зээлийн хүү өндөр гэсэн асуудлын хувьд санхүүжилт авах үеийн асуудлыг шийдвэрлэх болон санхүүжилт авах үеийн эрсдэлийн хяналтын асуудлыг шийдвэрлэх гэсэн 2 зүйлийг шийдвэрлэхгүйгээр үндсэн асуудал шийдвэрлэгдэхгүй.

Санхүүжилт босгоход тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд доорх асуудлуудыг шийдвэрлэх нь нэн чухал бөгөөд эдгээр нь дан ганц арилжааны банк болон зээл горилогчийн хүчээр шийдвэрлэх боломжгүй асуудлууд юм.

1. Монголын хувьцааны үнэлгээний зэрэглэл нь В болон В- байдаг тул гадаадаас орж ирэх санхүүжилтийн өртөг өндөр байдаг.
2. Монгол улсын валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэл болон инфляцийн эрсдэлээс зайлсхийхийн тулд хүүгээ өндөр байлгахад өөр аргагүй байдаг.

гэсэн хэдий ч зээл авах үед гардаг асуудлуудыг өөрсдийн хүчээр бүрэн шийдвэрлэх боломжгүй ч, асуудлыг багасгахад нөлөөлнө гэж бодож байна.

==Зээлийн батлан даалтын сангийн талаар==

Гуравдугаар хэсгийн 6-р асуултын хариултаас үзвэл, өнөөг хүртэл банкнаас зээл авч байсан 301 компани байна. Үүний дотроос гуравдугаар хэсгийн 9-р асуултын хариултаас харахад, Монголын зээлийн батлан даалтын сангаар дамжуулан банкнаас зээл авч байсан 20 компани байгаа нь дээрх 301 компанийн 6.6%-аас хэтрэхгүй юм. Зээлийн батлан даалтын санд нийт зээлийн үнийн дүнгийн 6%, 500 сая хүртэлх төгрөгийг зээлийн батлан даалтын сангийн батлан даалтаар зээлэх боломжтой. Ийм боломж байхад зээл горилогч цөөн байгаа нь дараах шалтгаантай.

- Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээ нь хэрэглэгчийг татах чадваргүй
- Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээ нь хэрэглэгчийг татах чадвартай ч олонд танигдаагүй
- Зээлийн батлан даалтын сангийн хяналт шалгалтын процесст ямар нэгэн асуудал байгаа (хүндрэл, хяналт шалгалтын хугацаа, хяналт шалгалтын чадвар)
- Зээлийн батлан даалтын сангийн зээлийн баталгааны хураамж нь өндөр хэдий ч хураамжиндаа тохирсон үр дүн гардаггүй(Зээлийн хугацаа 1 жил хүртэл 1%, 1-2 жил бол 2%, 3-аас дээш жил 3%)
- Зээлийн батлан даалтын санд компаниуд итгэхгүй байгаагай холбоотой гэсэн агуулгууд шалтгаанууд таамаглагдаж байна.

Өмнөх болон түүний өмнөх хэсгүүдийн судалгааны дүнтэй харьцуулаад дүн шинжилгээ хийж үзвэл, эдийн засгийн орчинг сайжруулахад чиглэсэн компанийн бизнесийн хүрээгээ тэлэх үндэс болсон зээлийн асуудалд компаниас гаргасан санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлын барьцаа, зээлийн батлан даалтын сангийн зар сурталчилгаа, боловсруулалтын үйл явцыг хялбаршуулах, арилжааны банкны шинжилгээ, үнэлгээний үйл явцын үнэнч зөв байдал зэрэг шаардлагатай байна гэж харагдаж байна.

=Компанийн санхүүжилт болон зээлд хамаарах хэрэгжүүлэхүйц чиглэл=

Асуудлыг бууруулахад авч хэрэгжүүлж болохуйц дараах чиглэлийг гаргаж байна.

1. Арилжааны банк болон зээл олгогч байгууллага, аж ахуйн нэгж нь компанийн санхүүгийн үнэлгээг үнэн зөвөөр хийснээр зээлийн эрсдэлд тохирсон эргэн төлөлтийн хүүг өөр өөр түвшнээр тогтоох боломжтой болно.
2. Арилжааны банк болон зээл олгогч байгууллага, аж ахуйн нэгж нь барьцааны үнэлгээг үнэн зөвөөр хийснээр барьцааны үнэ цэнэ болон зээлийн гүйцэтгэлийн дүнгийн тэнцвэргүй байдлаас сэргийлж чадна.
3. Компаниас гаргадаг санхүүгийн тайланд хатуу чанга, зохих арга хэмжээг авч компанийн олон нийтэд дэлгэдэг санхүүгийн тайланд итгэх итгэлийг дээшлүүлснээр зээл олгох үеийн эрсдэлийг бууруулж, компани тус бүрт хүүг тогтоох болон барьцааны үнэ цэнийг зөв үнэлэх боломжтой болно.
4. Компанийн удирдах түвшний хүмүүс санхүүгийн тайлангаас харж болохоор санхүүгийн мэдээлэл болон түүнээс гарах санхүүгийн индекст үндэслэн санхүүгийн нөхцөл байдлыг эрүүл болгох мэдлэгийг дээшлүүлснээр компанийн санхүүгийн нөхцөл байдлыг эрүүлжүүлэх, олон нийтэд дэлгэх мэдээллийн үнэн зөв байдлыг дээшлүүлэх боломжтой болно.
5. Зээл олгох процедурыг хялбаршуулах болон зээлийн хяналтын системийг хялбаршуулах, үр ашгийг сайжруулснаар зээл олгох

процедурын өртгийг багасгах боломжтой болно.

5 Судалгаа дуусахад хүлээлгэн өгөх материал

Монголын компанийн санхүү болон засаглалын талаарх асуулга судалгааг хэрэгжүүлэгч байгууллага болох Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс судалгаа дууссаны дараа дараах материалыг захиалагч талд хүлээлгэн өгснөөр тус судалгаа дууссан гэж үзнэ. Уг сүүлийн тайлангийн загварыг өгөх үед доорх материалаас 1,2,4-г хамт хүлээлгэн өгнө.

1. Явцын тайлан болон цахим хувилбар
2. Туршилтын эцсийн тайлангийн загвар болон цахим хувилбар
3. Эцсийн тайлан болон цахим хувилбар
4. Асуулга судалгааны нэгдсэн дүн болон түүний эксел хувилбар

2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СЕМИНАР ХИЙСЭН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАСНЫ ХАРИУЛТ

Асуулт	салбар	Хариулт		
		Тиймээ	Үгүй	Цаашид анхаарах болно
1	Алсын хараа, эрхэм зорилго	19	2	12
2	Төлөвлөгөө, хяналт	20	5	8
3		28	1	4
4		24	1	8
5		13	7	13
6		19	6	8
7		29	3	1
8		19	8	6
9		18	9	6
10	Шийдвэр гаргах тогтолцоо	23	6	4
11	Хууль, журам	28	2	3
12		24	3	6
13		27	4	2
14	Ёс зүй	20	6	7
15	Гэр бүлийн засаглал	9	17	7
16		16	8	9
17		11	16	6
18		24	6	3
19	Ажилчид	17	5	11
20		23	4	6
21	Оролцогч талууд	26	0	7
22	Эрсдэлийн удирдлага	17	4	12
23	Ил тод байдал	15	13	5
24		28	3	2
25	Байгаль орчин	31	1	1

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулан нэгтгэсэн

3. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ- ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАСНЫ АСУУЛТ

	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА	Тийм	Үгүй	Цаашид анхаарах болно	Асуултын ангилал
		(4оноо)	(0 оноо)	(1 оноо)	
1	Компани Эрхэм Зорилго, Алсын Хараа, Үнэт Зүйлсээ тодорхойлж баримтжуулсан ба бүх ажилчид тэдгээрийг мөрдлөг болгож ажилладаг.				Алсын хараа, эрхэм зорилго
2	Компани 3-5 жилийн бизнесийн төлөвлөгөөтэй.				Төлөвлөгөө, хяналт
3	Компанийн бүтэц, зохион байгуулалт тодорхой.				
4	Удирдлага нь компанийн давуу, сул талууд, мөн тухайн салбарын чиг хандлагын талаар хангалттай мэдээлэлтэй байдаг.				
5	Гол ажилтнуудын орлох ажилтныг бэлддэг.				
6	Компанийн үйл ажиллагааны үр дүнг удирдлагын зүгээс хянах болон үнэлэх тогтолцоо бүрдсэн.				
7	Банкнаас мөнгө зээлэхээс өмнө бид заавал тухайн мөнгийг юунд хэрэглэх, эргэн төлөлтийг хэрхэн хийх талаар төлөвлөдөг.				Шийдвэр гаргах тогтолцоо
8	Манай компани нягтлан бодох бүртгэлийн програм ашигладаг.				
9	Шийдвэр гаргалт нэг хүн дээр төвлөрөөгүй.				
10	Хувьцаа эзэмшигчид болон удирдлагын багийн гишүүдийн эрх мэдлийн хуваарилалт тодорхой.				Хууль, журам
11	Хээл хахууль болон хууль зөрчсөн үйлдэл хийхээс зайлсхийдэг.				
12	Татвар болон нийгмийн даатгалын шимтгэлээ үнэн зөвөөр мэдүүлж, цаг тухайд нь төлдөг.				
13	Үнэн зөв санхүү, татварын тайланг Татварын Ерөнхий Газар болон Сангийн Яам руу илгээдэг.				Ёс зүй
14	Компанид ёс зүйн дүрэм, журам байгаа бөгөөд бүх ажилчид тэдгээрийг мөрдлөг болгож ажилладаг.				
15	Компанийн удирдлага дараа үеийн удирдлагын талаар төлөвлөгөөтэй.				Гэр бүлийн засаглал
16	Компанийн эзэд өөрийн хувийн санхүү болон компанийн санхүүг салгаж, тус тусад нь удирддаг.				
17	Компанийн удирдлагын хамаатан, гэр бүлийн гишүүдийг ажилд авахад дагаж мөрдөх бодлого нь тодорхой байдаг.				
18	Бүх ажилчид өөрийн ур чадварт нийцсэн үүрэг хариуцлага болон ажлын байртай.				Ажилчид
19	Үйл ажиллагааг сайжруулах талаар ажилчид саналаа удирдлагад хүргэх тогтолцоо байгаа.				
20	Компани хөдөлмөрийн журамтай, мөн бүх ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг.				
21	Бид оролцогч талуудынхаа сэтгэл ханамж болон харилцан ойлголцлыг эрхэмлэж ажилладаг.				Оролцогч талууд
22	Бид тулгарч болзошгүй бүх эрсдэлийг урьдчилан таамаглаж, үр нөлөөг нь бууруулах талаар арга хэмжээ авдаг.				Эрсдэлийн удирдлага
23	Компанийн талаар мэдээллийг цахим хуудсандаа (эсвэл Facebook, Twitter, Аж үйлдвэрийн нэгдсэн систем г.м.) байршуулсан.				Ил тод байдал
24	Хэрэглэгч, нийлүүлэгч, банк, мөн төрийн байгууллагаас хүсэлт ирсэн тухай бүрд компани үнэн зөв мэдээллийг гаргаж өгдөг.				
25	Компани үйл ажиллагаагаа явуулахдаа ус, тогны хэрэглээ, бохирдол, хаягдал усыг аль болох бага байлгахгаар анхаарч ажилладаг.				Байгаль орчин

